

**ПРОБАЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны захиалагч: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Судалгааны багийн ахлагч:

Б.Алтангэрэл Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн доктор /Ph.D/, дэд профессор, хурандаа

Судалгааны багийн нарийн бичгийн дарга:

Ц.Очгэрэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга, хууль зүйн доктор /Ph.D/, дэд профессор, хурандаа

Судалгааны багийн гишүүд:

Дотоод хэргийн их сургуулиас:

Г.Баттулга Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сургуулийн Нийгэм, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, хурандаа

М.Хүрэлбат Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хошууч

Агуулга

Өмнөх үг	3
Товчилсон үгийн жагсаалт	4
Нэр томъёоны тайлбар	5-6
Зураг, хүснэгтийн жагсаалт	7-8
Удиртгал	9-16
НЭГ. ПРОБАЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНОЛЫН АСУУДАЛ	
1.1. Пробацийн үйл ажиллагааны ойлголт, хэлбэр	17-39
1.2. Пробацийн үйл ажиллагаанд хамаарах олон улсын хэм хэмжээ	40-60
ХОЁР. ДЭЛХИЙН УЛС ОРНЫ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СИСТЕМ ДЭХ ПРОБАЦИЙН ТОГТОЛЦООНЫ ОНЦЛОГ	
2.1. Дэлхийн улсуудын эрүүгийн эрх зүйн системийн шинж, ангилал	61-63
2.2. Англи-Америкийн эрүүгийн эрх зүйн систем дэх пробацийн үйл ажиллагааны онцлог	64-74
2.3. Эх газрын (Ром-Германы) эрүүгийн эрх зүй дэх Пробацийн үйл ажиллагааны онцлог	75-100
2.4. Мусульманы эрүүгийн эрх зүйн онцлог	101-104
2.5. Хосолсон буюу холимог эрүүгийн эрх зүйн систем дэх Пробацийн үйл ажиллагааны онцлог	105-140
ГУРАВ. МОНГОЛ УЛСАД ПРОБАЦИЙН АЛБЫГ БАЙГУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ	
3.1. Монгол Улсын пробацийн үйл ажиллагааны төрөл, хэлбэрт хамаарах эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ	141-156
3.2. Хоригдлыг суллагдасны дараах хяналт-нийгэмшүүлэх ажилд хийсэн дүн шинжилгээ	157-168
3.3. Тэнсэн суллагдсан, ял хойшлуулсан этгээдэд тавиж буй хяналт-нийгэмшүүлэх ажилд хийсэн дүн шинжилгээ	169-174
3.4. Монгол Улсад хөгжүүлэх пробацийн тогтолцооны загвар	175-187
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ-ЗӨВЛӨМЖ	
4.1. Дүгнэлт	188-190
4.2. Зөвлөмж	190-191
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	192-193
ХАВСРАЛТ	194-199

Өмнөх үг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын захиалгаар Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн судлаачид, практик алба хаагчидтай хамтран “Пробацийн үйл ажиллагааны харьцуулсан судлал” судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Судалгааны ажлын хүрээнд гадаадын зарим орны хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны үндсэн арга хэлбэр болох Пробацийн албаны хяналтын тогтолцооны чиглэлээр судалгаа хийн та бүхэнд толилуулж байна.

Пробацийн үйл ажиллагааны ойлголт, уламжлал, онолын урсгал, тус албаны чиг үүрэг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд гүйцэтгэх үүргийн талаар энэхүү судалгааны ажилд оруулахыг зорьсон ба гадаад хэлнээс орчуулж хийгдсэн болно.

Судалгааны тайланд Монгол Улсад хорихгүйгээр ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, өөрийн орны онцлогт тохирсон пробацийн үйл ажиллагааны загварыг бий болгох оролдлогыг хийж өглөө.

Судалгааны ажил нь бидний хувьд орчуулгын материалд үндэслэн, анх удаа хийгдэж буй тул алдаа мадаг байхыг үгүйсгэхгүй бөгөөд уншигч та бүхэн мэргэн оюундаа тунгаан үзэхийг хүсч байна.

Энэ удаагийн судалгааны тайлан нь цаашид судлаачдын хувьд онолын чухал материал болохоос гадна практик алба хаагчдын ширээний ном болно хэмээн итгэж судалгааны ажилд үнэтэй санал, зөвлөмжөө өгнө гэдэгт судалгааны багийн гишүүдийн өмнөөс найдаж байна.

Хүндэтгэсэн,

Б.АЛТАНГЭРЭЛ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ,
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР, ХУРАНДАА

Товчилсон үгийн жагсаалт:

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ШГА	Шийдвэр гүйцэтгэх алба
УДШ	Улсын Дээд Шүүх
ХЯЭА	Хорих ял эдлүүлэх алба
ХӨТЯЭА	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба
ХАДЖ	Хорих ангийн дотоод журам
НААЗ	Нийгмийн ажлын аргачилсан заавар
НСЗХ	Нийгэм, сэтгэл зүйн хэлтэс
ГХУСТХ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЦАТХ	Цагдаагийн албаны тухай хууль
ИБУТЭТОУП	Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын факт
ТББ	Төрийн бус байгууллага

Нэр томъёоны тайлбар

(Пробацийн үйл ажиллагаанд хамаарах зарим нэр томъёог тайлбарлав.)

Албадан эмчлэх	
	сэтгэцийн болон согтуурах мансуурах донтой, халдварт өвчтэй болох нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчлэх ажиллагаа.
Албан тушаалтан	
	улс төрийн, тусгай, захиргааны болон үйлчилгээний удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан.
Гэмт хэрэг	
	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй.
Гэм буруу	
	бусдын өмнө хийсэн алдаа дутагдал, гэм буруу нь санаатай, эсхүл болгоомжгүй хэлбэртэй байна.
Дэглэм	
	хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үүсч бий болсон эрхийн хязгаарлалт, ял эдлүүлэх нөхцөл, журам, хоригдлыг нийгэмшүүлэх болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон өөр хоорондоо ялгаа, өвөрмөц байдал бүхий үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээний нийлбэр юм.
Зарчим	
	Нийгмийн амьдралын эрх зүйн бодит байдлыг ханган, түүний харилцааг зохицуулахад баримтлах хууль зүйн үндсэн чиглэмж.
Итгэмжлэл	
	өөрийн нэрийн өмнөөс хууль ёсны тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх бүрэн эрхийг нөгөө этгээдэд бичгээр тодорхойлсон баримт.
Мэргэжлийн боловсрол, сургалтад хамруулах	
	тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэргэжлийн үр чадвар олгох, дээшлүүлэх, давтан сургах, дадлагажуулах, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх, аж ахуй эрхлэх мэдлэг олгох үйл ажиллагаа.
Мэргэжлийн дадлага олгох	
	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын үйл явц.
Нээлттэй, хаалттай хорих анги	
	хорих ял эдлүүлэх дэглэмийн төрөл.
Нээлттэй, хаалттай хорих ангийн энгийн зэрэглэл	
	хорих ял эдлүүлэх дэглэмийн ангилал
Нээлттэй, хаалттай хорих ангийн тусгай зэрэглэл	
	хорих ял эдлүүлэх дэглэмийн ангилал
Нийгэмшүүлэх ажил	
	хоригдлыг хорих байгууллагад хүлээн авахаас эхлэн ял эдлэх бүхий л хугацааг хамран, суллахад бэлтгэх, сулласны дараах үйл явцаар дуусгавар болдог сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх, анагаах, хууль зүй,

	нийгэм, эдийн засгийн зохион байгуулалттай нөлөөллийн цогц арга хэмжээ.
Хорих ял	
	иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, хоригдолд эрхийн хязгаарлалтаар дамжуулан цээрлэл амсуулах, дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг гаргуулахгүй байх, нийгмийн дотор байгаа гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүст урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлдэг төрийн албадлагын онцгой төрөл юм.
Хорих байгууллага	
	эрүүгийн ял гүйцэтгэх тогтолцооны төрөлжсөн байгууллага.
Хорих ял эдлүүлэх ажиллагаа	
	хорих ялаар шийтгэгдсэн этгээдийг суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх зан үйлийг төлөвшүүлэн нийгэмшүүлэхэд чиглэгдсэн хуулиар эрхийн хязгаарлалт тогтоон, тодорхой дэглэм, журмын хүрээнд аюулгүй байдлыг ханган хорьж буй арга хэмжээ.
Хоригдол	
	хорих ял эдэлж байгаа ялтан
Хорих анги	
	шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага
Сахилгын зөрчил	
	мөрдөгдөж буй хууль тогтоомжид сахилгын хариуцлага хүлээлгэхээр заасан үйлдэл.
Пробаци /Probation/	
	Тэнсэн харгалзах ажиллагаа.
Парол /Parole/	
	хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан этгээдэд хяналт тавих ажиллагаа.

Зураг, хүснэгтийн жагсаалт:

Зураг 1.	Давтан гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж буй хоригдлын хэдэн удаагийн ял шийтгэлтэй талаарх судалгаа (2020 оны байдлаар)
Зураг 2.	Судалгаанд хамрагдагсдын насны байдал
Зураг 3.	Судалгаанд хамрагдагсдын зүйл ангийн судалгаа
Зураг 4.	Судалгаанд хамрагдагсдын оршин суух газрын харьяалалын судалгаа
Зураг 5.	Судалгаанд хамрагдагсдын ял шийтгэлд хийсэн судалгаа
Зураг 6.	Судалгаанд хамрагдагсдын хорих ял эдэлсэн хугацаа
Зураг 7.	Нийгэм-олон нийтэд тулгуурласан ялын үндсэн зарчим
Зураг 8.	Ял эдлүүлэх ажиллагааны бүтэц, загвар
Зураг 9.	Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан этгээдүүдийн судалгаа /2014-2021 оны байдлаар/
Зураг 10.	Хугацаанаас өмнө суллагдсан өсвөр насны хүний судалгаа /2017-2021 он/
Зураг 11.	Хугацаанаас өмнө суллагдаад дахин гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн судалгаа /2017-2021 он/
Зураг 12.	Зураг 12. Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн этгээдүүдийн судалгаа /2017-2021 он/
Зураг 13.	Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн өсвөр насны хүний судалгаа /2017-2021 он/
Зураг 14.	Шинээр ял тэнсэгдсэн этгээдүүдийн судалгаа /2017-2021 он/
Зураг 15.	Тэнсэгдсэн этгээдүүдээс гэмт хэрэг үйлдсэн талаарх судалгаа /2017-2021 он/
Зураг 16.	Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан этгээдүүдийн судалгаа /2017-2021 он/
Зураг 17.	Зураг 17. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны этгээдүүдийн судалгаа /2017-2021 он/
Зураг 18.	Шинээр ирсэн шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны этгээдүүдийн судалгаа /2017-2021 он/
Зураг 19.	Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан этгээдүүдээс үйлдсэн гэмт хэргийн судалгаа /2017-2021 он/
Зураг 20.	Хугацаа дуусч суллагдсан хоригдлын судалгаа /2017-2021 он/
Зураг 21.	Хорих ял эдлэгсдээс давтан гэмт хэрэг үйлдэн ял эдлэгсдийн судалгаа /2017-2021 он/
Зураг 22.	Судалгаанд хамрагдагсдын мэргэжлийн судалгаа
Зураг 23.	Судалгаанд хамрагдагсдын хөдөлмөр эрхлэлтийн судалгаа
Зураг 24.	Давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдээс хөдөлмөр, халамж үйлчилгээний төвд хөдөлмөр эрхлэхээр бүртгүүлсэн талаарх судалгаа
Зураг 25.	Судалгаанд хамрагдагсдын хорих ангид мэргэжил эзэмшсэн талаарх судалгаа
Зураг 26.	Давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдээдүүс хорих ангид эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах талаар судалгаа
Зураг 27.	Хорих ангиас суллагдсаны дараа төрөөс үзүүлж буй халамжид хамрагдсан эсэх талаарх судалгааны дүн

Зураг 28.	Хорих ангиас суллагдан гарсны дараа учирсан хүндрэлийн талаарх асуулгын дүн
Зураг 29.	Судалгаанд хамрагдагсдын гэмт хэрэг үйлдэхээс өмнө амьдарч байсан орчны судалгаа
Зураг 30.	Суллагдан гарсны дараа амьдрах орон байртай эсэх талаарх судалгааны дүн
Зураг 31.	Хорих ангиас суллагдаад амьдрах оронгүй тохиолдолд амьдрах газрын судалгаа
Зураг 32.	Давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэр бүлийн судалгаа
Зураг 33.	Суллагдан гарсны дараа гэр бүлийн гишүүдийн хүлээн авсан байдлын судалгаа
Зураг 34.	Найз, нөхөд, хамт олны харьцааны талаарх судалгааны дүн
Зураг 35.	Давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн амьжиргааны түвшний судалгаа
Зураг 36.	Банк болон бусад санхүүгийн байгууллагад хадгаламжтай эсэх талаарх асуулгын дүн
Зураг 37.	Гэмт хэргийн төлбөртэй эсэх талаарх судалгааны дүн
Зураг 38.	Давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хорих ангиас суллагдахад тулгардаг бэрхшээлийн судалгаа
Зураг 39.	Халамжийн үйлчилгээнд хамрагдсан эсэх талаарх судалгааны дүн
Зураг 40.	Ар гэрийнхтэйгээ холбоотой байдаг талаарх судалгааны дүн
Зураг 41.	Хорих ангид мэргэжил эзэмшсэн талаарх судалгаа
Зураг 42.	Хорих ангид эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах талаар судалгаа
Зураг 43.	Хорих ангиас суллагдаад төрийн үйлчилгээг авах чадварын судалгаа
Зураг 44.	Суллахад бэлтгэх ажиллагааны чиглэлээрх асуулгын дүн
Зураг 45.	Суллагдсаны дараа амьдралын зорилгын талаарх судалгаа
Зураг 46.	Суллагдсан иргэнд үзүүлэх төрийн үйлчилгээний санал

УДИРТГАЛ

Дэлхийн зарим улс орны эрх зүйн практикт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр хяналт, хязгаарлалт тогтоох замаар ял эдлүүлэх нь хамгийн түрүүнд сонгон хэрэглэвэл зохих ял шийтгэлийн үндсэн хэлбэр гэж үзэж байгаа бөгөөд хорих ялыг зөвхөн хохирогчийн аюулгүй байдалд заналхийлсэн, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн зэрэг цөөн тооны тохиолдолд хэрэглэх учиртай гэсэн үзэл, зарчим давамгайлж байна.

Ял эдлүүлэх ажиллагааны үр дүнд дүн шинжилгээ хийж үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагаа нь өндөр хэмжээний зардлыг үүсгэж байгаагийн зэрэгцээ хорих ял эдлээд суллагдсан хүмүүс нийгмийн орчинд буцаж очих, дахин гэмт хэрэг үйлдэхээс үл эмээх хандлагатай байгаагаас үүдэн хорих ял хамгийн үр дүн багатай ялын төрөл хэмээн тооцогдож байна.

Хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн явцад нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт хэрэг, түүнийг төрүүлдэг шалтгаан, нөхцөл, тэдгээрийн үйлчлэлийг хэрхэн саармагжуулах талаар гүн ухаантан, хуульч, нийгэм судлаач, хүн судлаач, криминологчидын олон жилийн турш боловсруулан хөгжүүлсэн эрүүгийн эрх зүй, криминологийн шинжлэх ухааны онолын сэтгэлгээ, сургаал, номлол нь гэмт хэрэг, ялын мөн чанар, тэдгээрийн нийгмийн учир холбогдол, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг түүхийн үүднээс танин мэдэхэд онол, практикийн гүн гүнзгий ач холбогдолтой¹ хэмээн тодорхойлсон.

Аливаа улс орон амгалан тайван нийгмийг бүрдүүлэх явдлыг төрийн эрүүгийн бодлогын нэн тэргүүнд тавьж, түүнд хүрэхийг байнга эрмэлздэг хэдий ч бэрхшээлтэй тулгарсаар байдаг нь үнэн билээ. Гэмт хэрэг, зөрчлөөс ангид амар амгалан нийгэмд хөтлөх нэг үндэс бол гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх, нийгэмдээ аюулгүй этгээд болгон хүмүүжүүлэх явдал байдаг. Монгол Улсын Эрүүгийн хуульд "Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино."² гэж хуульчилсан.

Монгол Улсад Пробацийн албыг байгуулах чиглэлээр дараах эрх зүйн баримт бичигт тусгалаа олжээ. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан "АЛСЫН ХАРАА-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд "ял шийтгэгдсэн хүнийг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх, нийгмээс тусгаарлахгүйгээр ялын

¹ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол УБ., 2009.910 дахь тал

² Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйл.

бодлогыг хангах зорилгоор “Цахим хяналтын төв”-ийг байгуулж, **“Пробацийн тогтолцоог хөгжүүлнэ”**;

2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно”, **“ялын бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах, ялтныг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах замаар гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулалтыг нэмэгдүүлнэ”**;

3. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/22 дугаар тушаалаар батлагдсан “ХЗДХСайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний 3 дугаар зүйлийн 1.5 дахь хэсэгт **“Пробацийн тогтолцоог хөгжүүлэхтэй холбогдсон суурь болон хавсрага судалгаа хийх”** зэрэг ажлыг гүйцэтгэхээр тус тус тусгажээ.

Пробаци (probation) гэсэн нэр томъёо нь “probation” гэсэн латин үгнээс гаралтай, туршилт, ажиглалт явуулах гэсэн утга бүхий гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шүүхийн шийдвэрийн үндсэн дээр тодорхой хөтөлбөрөөр нийгэмшүүлэх үйл ажиллагаа юм. Анх 18 дугаар зууны дунд үеэс Английн эрүүгийн хуульд анх тусгагдсан Пробацийн үйл ажиллагаа нь дэлхийн олон орны шүүхийн болон хууль сахиулах үйл ажиллагаанд хэдийнээ өргөнөөр ашиглагдах болжээ.

Дэлхийн улс орнуудын шүүх, хууль сахиулах үйл ажиллагааны практикт пробацийн үйл ажиллагааг хорих ял эдлүүлэх үйл ажиллагааны явцад гэмт хэрэгтэн бие хүн болж өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн харилцаанаас тусгаарлахгүйгээр гэмт зан үйлийг өөрчлөх, нийгмийн амьдралд дасан зохицох, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх үйл явц гэж нийтлэг байдлаар тодорхойлсон байна.

Иймээс ч олон улсад пробацийг туршилтийн хугацаа, тэнсэн харгалзах, батлан даалт гэсэн нэршлээр тодорхойлж иржээ.

Пробацийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь:

- Гэмт хэрэг үйлдсэн хүнд аль болох хорих ял оногдуулахгүйгээр тэнсэн харгалзах ялаар шийтгэн, шийтгэл эдлэх үйл явцад хяналт тавих;

- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хор уршгийг ойлгуулах, ажил хөдөлмөр эрхлүүлэн, учирсан хохирлыг бүрэн төлүүлэх;

- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорих ангиас суллагдахын өмнө болон суллагдсаны дараа нийгмийн амьдралд дасан зохицоход тусламж үзүүлэх зэрэг байна.

Пробацийн үйл ажиллагааны ач холбогдлыг тодорхойлохдоо гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорих ял оногдуулахгүйгээр хүмүүнлэг нийгмийг бүтээх, гэмт хэрэгтнийг албадан хөдөлмөрлүүлж нийгмийн хөгжилд хувь нэмрийг оруулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорихоос өөр төрлийн ял оногдуулж эдийн засгийн хувьд харьцангуй бага зардал гарган гэж үздэг байна.

Дэлхийн улс орнууд өөрийн эрх зүйн тогтолцоо, нийгмийн хөгжлийн онцлогт нийцүүлэн пробацийн албыг нэршил, чиг үүрэг, харьяаллын хувьд өөр өөр хэлбэрээр байгуулан ажиллуулж байна. Тухайлбал, АНУ, Англи, Швед, Латви, Гүржид бие даасан алба, Норвеги, Финлянд, Дани, Япон, Чех, Эстонид Хууль зүйн яамны харьяаны алба, Герман, Унгарт Шүүх байгууллагын харьяаны алба, Голландад Прокурорын байгууллагын харьяа алба, Казакстанд Хорих байгууллагын харьяа алба, Сингапурт Спорт, нийгмийн хөгжлийн яаманд тус тус харьяалагдан үйл ажиллагаагаа явуулдаг байна.³

Гадаад орнуудын пробацийн үйл ажиллагааг судлан үзэхэд дараах 3 хэлбэрээр зохион байгуулж байна. Үүнд:

1. Гэмт хэрэг сэжиглэгдэж эхлэх үеэс тусламж үзүүлэх хэлбэр: /гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг тодорхойлох, хууль зүйн туслалцаа үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдох хүртэл ар гэр, хамт олны батлан даалтанд авах/


2. Нийгмийн хяналтын хэлбэр: /гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорихгүйгээр нийгэмд засах, хүмүүжүүлэх, ар гэр, хамт олны хяналтанд авах, чөлөөтэй зорчин явах эрхийг хязгаарлах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах/

3. Хорих эдэлсэн этгээдийг нийгмийн хэвийн амьдрал ороход туслалцаа үзүүлэх хэлбэр: /нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагаар дамжуулан ажилд зуучлах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран түр амьдрах орон байраар хангах/ зэрэг байна.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн судалгаагаар нийт 2017 онд 2942, 2018 онд 3522, 2019 онд 3933, 2020 онд 4489 хоригдол хорих ял эдэлж байжээ. Хорих ял эдэлж байсан нийт хоригдлуудын 40-50 орчим хувь нь урьд гэмт хэрэг үйлдэн ял эдэлж байсан этгээдүүд байх ба зөвхөн 2020 онд 2 удаа ял шийтгүүлсэн 1008, 3 удаа ял шийтгүүлсэн 548 хоригдол, 4 удаа ял шийтгүүлсэн 299, 5 удаа ял шийтгүүлсэн 205 хоригдол, 6 удаагийн ял шийтгүүлсэн 144 хоригдол, 7 удаагийн ял шийтгүүлсэн 79 хоригдол, 8 удаагийн ял шийтгүүлсэн 43 хоригдол, 9 удаагийн ял шийтгүүлсэн 24 хоригдол, 10 удаагийн ял шийтгүүлсэн 11 хоригдол, 11 дээш удаа ял шийтгүүлсэн 10 хоригдол тус тус ял эдэлж байжээ.

³ Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны харьцуулсан судлал. Уб., 2018. 188 дах тал

Зураг 1. Давтан гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж буй хоригдлын хэдэн удаагийн ял шийтгэлтэй талаарх судалгаа (2020 оны байдлаар)⁴



Дээрх судалгаанаас харахад 2020 онд нийт ял эдэлсэн 4489 хоригдлын 2371 буюу 52.8% нь урьд ял эдэлж байсан этгээдүүд байна. Хорих ял эдэлж буй **1200 орчим** хоригдлоос суллагдсаны дараах зорилгын талаарх судалгаа авахад **1071** буюу 85% нь ажил хөдөлмөр эрхлэх, **120** буюу 9% нь сургуульд суралцах, **76** буюу 6% нь мэдэхгүй гэж хариулсанаас үзэхэд дийлэнхи нь ажил хөдөлмөрт зуучлуулах хүсэлтэй байгаа нь харагдаж байна.

Жилд дунджаар хорих ял эдлээд **1800-2000** орчим хүн суллагддагаас **1000** орчим хүн хугацаанаас өмнө нь суллагдаж төрийн байгууллагын хяналтад орж байна. Түүнчлэн суллагдан гарсны дараа дахин гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан, нөхцлийг судлан үзэхэд хорих ангиас суллагдсан иргэнд тавих хяналт сул, тэдэнд үзүүлэх нийгэмшүүлэх болон халамжийн үйлчилгээний зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт муутай байгаа нь харагдаж байна.

Хорихоос суллагдсан этгээдэд тавих хяналт нь хоёр үндсэн зорилго агуулдаг. Нэгдүгээрт: гэмт хэрэг үйлдээд ял шийтгэлээ эдэлсэн хүн нийгэмд эргээд нэгдэх үйл явцад туслах нь буюу нийгэмшүүлэх явдал байдаг бол хоёрдугаарт: тэрхүү этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой. Хэрвээ нэгдүгээр зорилгыг биелүүлж чадвал хоёрдугаар зорилго аяндаа биелэх боломжтой. Өөрөөр хэлбэл, нэгэнтээ нийгэмшсэн хүн хяналт тавиагүй байсан ч гэмт хэрэг үйлдэхгүй гэсэн логик аяндаа үүснэ.

Тиймээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдлыг нэн тэргүүнд тавихаас илүүтэйгээр гэмт этгээдийг нийгэмшүүлэх ажиллагааг эрчимжүүлэх нь зохистой ажээ. Дэлхийн улс орнуудын Criminal Justice system буюу эрүүгийн хариуцлагын тогтолцоонд “нийгэмшүүлэх” гэсэн тусдаа бүтэц байх нь элбэг

⁴ ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны 2020 оны тайлан мэдээ.

байдаг. Тухайлбал: Япон Улсын Хууль зүйн яам “Нийгэмшүүлэх алба” гэсэн тусдаа бүтэцтэй бөгөөд дотроо хорихоос суллагдсан болон тэнссэн этгээдэд хяналт тавих чиг үүрэг бүхий институттэй байна.

Гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэх, нийгэмшүүлэх зорилтыг биелүүлэх үүднээс олон улсад үндсэн 3 хөтөлбөрийг иж бүрэн хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үздэг. Үүнд:

1. Хорих ангид хоригдлыг нийгэмшүүлэх хөтөлбөр;
2. Гэмт хэрэгтнийг хорихоос суллагдсаны дараагаар эргэн нэгтгэх, халамжлах хөтөлбөр;
3. Гэмт хэрэгтэнд хорихоос өөр төрлийн ял оногдуулах буюу нийгэмд суурилсан хөтөлбөр юм.⁵

Судалгааны ажлын зорилго, зорилт:

Бидний энэхүү судалгаагаар пробацийн онол, үйл ажиллагааны чиглэлээрх харьцуулсан судалгааг хийн, Монгол Улсад хорих байгууллагаас суллагдсан иргэнд тавиж буй хяналт-нийгэмшүүлэх ажлын эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, судалгааны дүнг үндэслэн Монгол Улсад тохирох “ПРОБАЦИЙН АЛБАНЫ ЗАГВАР”-ыг бий болгохтой холбоотой дүгнэлт-зөвлөмж гаргах зорилгыг өмнөө тавин ажиллалаа.

Зорилгоо хангах хүрээнд дараах дэд зорилтуудыг дэвшүүлсэн болно.

1. Гадаадын зарим улс орны пробацийн үйл ажиллагааны хэлбэр, чиглэлийг онолын хүрээнд тодорхойлох;
2. Монгол Улсад хорих байгууллагаас суллагдсан иргэнд тавиж хяналт, нийгэмшүүлэх ажлын тогтолцоо, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;
3. Өөрийн орны эрх зүйн тогтолцоотой уялдуулан “ПРОБАЦИЙН АЛБАНЫ ЗАГВАР”-ыг боловсруулах зэрэг болно.

Судалгааны ажлын арга зүй:


Бид судалгааны ажилдаа нийгмийн шинжлэх ухааны нийтлэг аргууд болох харьцуулах, түүхчлэх, дүн шинжилгээ хийх болон анкетын болон ярилцлагын зэрэг аргыг өргөнөөр ашигласан. Түүнчлэн хорих ял эдэлж байгаад дахин гэмт хэрэг үйлдэн хоригдож буй 503 хоригдлоос дахин гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөл болон суллагдсаны дараах хүндрэл, бэрхшээлийн талаарх судалгаа, хорих ангийн 31 нийгмийн ажилтнаас хоригдлыг сулласны дараах нийгэмшүүлэх ажлын чиглэлээр санал, асуулга авч дүнг судалгааны ажилдаа ашигласан болно.

Судалгаанд хамрагдсан давтан гэмт хэрэг үйлдсэн 503 хоригдлын 25 буюу 4.9% нь 18-24 настай, 115 буюу 22.8% нь 25-34 настай, 74 буюу 14.7%

⁵ НҮБ-ын Хар тамхи, Гэмт хэрэгтэй тэмцэх алба, “Рецедивизмээс урьдчилан сэргийлэх ба гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэх” Вена хот, 2018 он, 5 дахь тал.


нь 35-39 настай, 29.6% нь 40-44 настай, 77 буюу 15.3% нь 45-49 настай, 63 буюу 12.5% нь 50 дээш настай байлаа.

Зураг 2. Судалгаанд хамрагдагсдын насны байдал:




Судалгаанд хамрагдсан 503 хоригдлын 70 буюу 13.9% нь ЭХ-н 10.1, 27 буюу 5.3% нь ЭХ-ийн 11.1, 34 буюу 6.7% нь ЭХ-ийн 11.2, 23 буюу 4.5% нь ЭХ-ийн 12, 4 буюу 0.7% нь ЭХ-ийн 13, 2 буюу 0.3% нь ЭХ-ийн 14, 12 буюу 2.3% нь ЭХ-ийн 27.1, 186 буюу 36.9% нь ЭХ-ийн 17.1, 62 буюу 12.3% нь ЭХ-ийн 17.2, 29 буюу 5.7% нь 17.3, 5 буюу 0.9% нь ЭХ-ийн 17.4, 10 буюу 1.9% нь ЭХ-ийн 20.7, 2 буюу, 0.3% нь ЭХ-ийн 21.1, 2 буюу, 0.3% нь ЭХ-ийн 18 дугаар зүйл ангиар тус тус хорих ял шийтгүүлсэн байна.

Зураг 3. Судалгаанд хамрагдагсдын зүйл ангийн судалгаа:




Судалгаанд хамрагдсан 503 хоригдлын 191 буюу 37.9% нь Улаанбаатар хот, 7 буюу 1.3% нь Хэнтий, 33 буюу 6.5% нь Хөвсгөл, 5 буюу 0.9% нь Ховд, 7 буюу 1.3% Увс, 23 буюу 4.6 хувь нь Төв, 19 буюу 3.7% нь Сэлэнгэ, 8 буюу 1.5% нь Сүхбаатар, 7 буюу 1.3 хувь нь Өмнөговь, 31 буюу 6.1% Орхон, 9 буюу 1.7% нь Завхан, 15 буюу 2.9% нь Дундговь, 20 буюу 3.9% нь Дорнод, 15 буюу 2.9% нь Дорноговь, 14 буюу 2.7% нь Дархан-Уул, 12 буюу 2.3% нь Говьсүмбэр, 9 буюу 1.7% нь Говь-Алтай, 22 буюу 4.3% нь Булган, 14 буюу 2.7% нь Баянхонгор, 7 буюу 1.3% нь Баян-Өлгий, 16 буюу 3.1% нь Архангай аймагт тус тус оршин сууж байсан байна.

Зураг 4. Судалгаанд хамрагдагсдын оршин суух газрын харьяаллын судалгаа:




Судалгаанд хамрагдсан 503 хоригдлын 173 буюу 34.3% нь 2 удаа, 174 буюу 34.5% нь 3 удаа, 156 буюу 31% нь 4 ба түүнээс дээш удаа хорих ял шийтгүүлсэн.

Зураг 5. Судалгаанд хамрагдагсдын ял шийтгэлд хийсэн судалгаа:



Зураг 6. Судалгаанд хамрагдагсдын хорих ял эдэлсэн хугацаа:



Түүнчлэн энэхүү судалгааны ажилдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын албан ёсны тайлан мэдээ, судалгааг ашигласан болно.

НЭГ. ПРОБАЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНОЛЫН АСУУДАЛ

1.1. Пробацийн үйл ажиллагааны ойлголт, хэлбэр

Ялын бодлого нь төрөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хүрээнд ялын оновчтой төрөл, хэлбэрийг хуульчлан тогтоон, сонгон хэрэглэх тухай үзэл баримтлал юм.

Орчин цагийн эрүүгийн эрх зүй бол 1980-аад оны үеэс дэлхий дахинд бий болсон нийгэм, улс төр, эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлтийн үр дүн гэж хэлж болно. 1990-ээд оноос эхлэн дэлхийн 50 гаруй улс шинэ эрүүгийн хуультай болж, хуучин социалист улсуудын эрүүгийн хуульд ихээхэн өөрчлөлт оржээ. 1990-ээд оны үеэс эхлэн 50 гаруй улс шинэ эрүүгийн хуультай болжээ (Монгол Улс, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан бүх улс, Австри, Англи г.м). Болгар, Боливи, Унгар, БНАСАУ, Куба зэрэг улсын эрүүгийн хуульд ихээхэн өөрчлөлт орсон. Англи, Аргентин, Индонез зэрэг улс шинэ эрүүгийн хуулийн боловсруулалт дээр ажиллаж байна.

Улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарууд, тэр дундаа хууль сахиулах салбарт хийгдэж буй тогтолцооны болон эрх зүйн шинэчлэл, өөрчлөлтүүд нь хүний хөгжлийг, улмаар нийгмийн зөв тогтолцоог дэмжин хөгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстойг салбарын эрдэмтэд хүлээн зөвшөөрч байна.

Монгол Улс дахь ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдлаас харахад гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдлэгсдийн тоо жилд дунджаар 8.3-15.2 хувиар өссөн үзүүлэлттэй⁶, хорих ял эдлээд суллагдсан иргэдийн зүгээс давтан гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй⁷, хорихоос өөр төрлийн ялын бодит биелэлт харилцан адилгүй байна.⁸

Энэхүү статистик үзүүлэлтээс гадна ял эдэлж буй хоригдлыг хорих байгууллагаас суллагдсаны дараа үзүүлэх нийгэмшүүлэх ажлын тогтолцоо байхгүй, хууль сахиулах байгууллагуудын хэмжээнд эрх зүйн зохицуулалтын хувьд хүлээсэн чиг үүрэг бүрэн тодорхойлогдоогүй, түүнчлэн хорихоос өөр төрлийн ялыг олон талт хэлбэрээр хэрэгжүүлэх нэгдсэн тогтолцоогүй байгаа нь бие даасан эрх зүйн зохицуулалтын болон бүтцийн шинэлэг арга хэлбэр шаардлагатайг илэрхийлж байгаа юм.

Өөрөөр хэлбэл, ял эдлүүлэх ажиллагааны тогтолцоо, хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын өсөлт, гэмт хэргийн гаралт, нөхцөл байдалтай холбон өөрчлөх, гадаадын бусад орны

⁶ ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны 2009-2015 оны тайлангаас үзэхэд жилийн эцсийн байдлаар нийт 5069-7083 ялтан ял эдэлж байжээ.

⁷ 2016 оны жилийн эцсийн дүнгээр нийт ял эдэлж буй хоригдогсдын 32 хувь нь 2-3 удаа гэмт хэрэг үйлдсэн, 16 хувь 4-ээс дээш удаа давтан гэмт хэрэг үйлдсэн байна.

⁸ ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны 2017 оны жилийн эцсийн статистик мэдээллээр торгох ялын гүйцэтгэх хуудасны биелэлт 72.9 хувь, мөнгөн дүн буюу торгуулийн хэмжээ 60.0 хувийн гүйцэтгэлтэй, нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн нийт ялтны 50.8 хувийн ялыг эдлүүлж, цагийн гүйцэтгэл 64.2 хувьтай байна.

ижил чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааны туршлагад суурилан, олон улсын чиг хандлага, загварт нийцүүлэн хөгжүүлэх нь зүйтэй гэж дүгнэж болно.

Гэмт явдлыг саармагжуулах, яваандаа арилгах алс хэтийн зорилгыг хэрэгжүүлэхэд ялын болон улс төр, нийгэм, эдийн засаг, эрх зүйн иж бүрэн арга хэмжээг төрийн эрүүгийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлдэг (С.Жанцан, 2014, х.20) талаар судлаачид тэмдэглэсэн байх бөгөөд ялангуяа шинэчлэн батлагдсан зарим хуулиудад эрүүгийн хариуцлагыг шинэчлэн тодорхойлж, шинэ төрлийн ялыг үр дүнтэй хэрэгжүүлэх асуудалд анхаарал хандуулж байгаа энэ цаг үед нийгэм, олон нийтэд тулгуурласан ял эдлүүлэх ажиллагаа, түүний онолын ойлголт, хэрэгжүүлэх хэлбэр, онцлогийг талаар тоймлон авч үзье.

Нийгэм-олон тулгуурласан ял нь (community sentence, community based sentence)⁹ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэж буй сонгох ял (alternative sentence) буюу өнөөгийн бидний өдөр тутмын хэллэгт тогтмол хэрэглэгдэж буй хорихоос өөр төрлийн ял (non-custodial sentence)-ын нэгэн адил хэрэглэгдэх нэгдмэл нэршил бүхий ойлголт¹⁰ юм.

Энэхүү ял нь гэмт хэрэгтнийг шинэчлэн өөрчлөх буюу нийгэмшүүлэх, түүнчлэн үйлдсэн гэмт үйлдлийг засаж залруулах боломжийг илүү олгодог бөгөөд ялын уламжлалт онолын хандлага буюу зөвхөн цээрлэл үзүүлж шийтгэх “хариу үйлдэл” үзүүлэх явдлыг эрс шүүмжилсэн, нийгэм-олон нийтэд ил тод, нээлттэй байх, тэдний оролцоо, дэмжлэг тусламжид тулгуурласан хэлбэртэй байхын зэрэгцээ эдийн засаг, нийгмийн үр өгөөжтэй ял эдлүүлэх тогтолцооны шинэ хэлбэр гэж үзэж байна.

Түүнчлэн дэлхийн улс орнуудад хэрэглэгдэж буй нийгэм-олон нийтэд суурилсан ял нь тухайн улсын ялын бодлого, эрүүгийн эрх зүйн зохицуулалт, түүнчлэн хүн ам, нийгэм эдийн засгийн үзүүлэлт, ажил хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээл болон нийгмийн халамжийн бодлого зэргээс хамааран харилцан адилгүй нэршил бүхий төрөл хэлбэрээр хэрэгжиж байгаа ч нийтлэг байдлаар дараах тогтолцооны идэвхтэй хэлбэрүүд үйлчилж байна. Үүнд:

- Цалин хөлсгүй ажил;
- Түр баривчилгаа;
- Хөл хорио тогтоох;
- Эрх хасах;
- Цахим хяналтын хэрэгсэл зүүх;
- Албадан эмчилгээ, хөтөлбөрт хамруулах;
- Хохирогчоос уучлал гүйх;
- Эвлэрүүлэн зуучлах;

⁹ Зарим судлаачдын үзсэнээр “нийгэмд үйлчлэх ял”, “нийтийн тусын тулд үйлчлэх ял” зэргээр нэрлэх нь бий.

¹⁰ <https://www.gov.uk/community-sentences>


- Шүүхийн тусгайлсан захирамж; (архи, согтууруулах ундаа хэрэглэх, зарим хүмүүстэй уулзахыг хориглох г.м)
- Тодорхой төрлийн алба хаагчийн тогтмол хяналтад байх;
- Бие махбодын шийтгэл гэсэн хэлбэрүүд үйлчилж байна¹¹.

Түүнчлэн зарим судлаачдын үзэж буйгаар тухайн ялыг хэрэгжүүлж буй цаг хугацаа, ялын зорилгыг хангахад гэмт хэрэгтний хийж буй үйлдэл, ялын зарчмаас хамааран шүүхээс оногдуулж буй ялыг түдгэлзүүлэхгүй байх зэрэг шинжээр ялын төрлийг идэвхтэй болон идэвхгүй гэж ангилсан байна.

Идэвхгүй ял шийтгэлийн төрөлд үндсэн 2 төрлийн буюу нийгэм-олон нийтийн оролцоонд тулгуурласан (community punishment), хөндлөнгийн оролцоонд тулгуурласан (завсрын-intermediate punishment) ял шийтгэлийг оруулан тодорхойлсон бөгөөд пробагийн алба, оршин суугаа газартаа хөтөлбөрт хамрагдах, цахим хяналтад бүртгүүлэх, өдөр бүрийн хяналтын төвд харьяалагдах зэрэг ялын төрлүүд хамаарах бөгөөд нийт ял шийтгэлийн 44 хувийг эзэлж байгаа үзүүлэлт байна¹².

Онолын хувьд авч үзвэл нийгэм, олон нийтэд суурилсан ял нь дараах үндсэн тулгуур зарчмыг хүрээнд хэрэгжих ёстой гэж үзсэн бөгөөд харьцаа, тэнцвэрт байдлыг хадгалан хэрэгжүүлэх ёстой гэж үздэг нь ялын үндсэн агуулгыг илэрхийлж байгаа юм.

Зураг 7. Нийгэм-олон нийтэд тулгуурласан ялын үндсэн зарчим:



Гэмт хэрэгтэн хүн нийгэмд тодорхой хэмжээнд хариуцлага үүрснээр нийгмийн нэг "гишүүн" мөн гэдгийг "нийгэм" хүлээн зөвшөөрч байгааг илтгэх үзүүлэлт төдийгүй ялын суурь зарчмын дагуу хохирлыг барагдуулах, нөхөн төлөх, улмаар ял эдлэх процесс нь нийгэмшүүлэх хөтөлбөрт суурилснаар тухайн гэмт хэрэгтэн өдөр тутмын амьдралдаа бодитоор хандах боломжтой болдогт тус ялын үндсэн философи агуулагдаж байна.

Түүнчлэн АНУ-ын судлаачдын¹³ үзсэнээр ялын зорилгын үндсэн асуудал болох цээрлүүлэх, нөхөн сэргээх агуулга нь зөрчилтэй мэт боловч эдгээр ойлголтын харилцан хамаарлын хэм хэмжээг нарийн тогтоож, хэрэгжүүлэх нь ялын үр нөлөөг нэмэгдүүлдэг гэж үзсэн бөгөөд "шийтгэлийн зохист хэмжүүр" гэсэн ойлголтыг гаргажээ.

Дэлхийн улс орнуудын ял шийтгэлийн бодлого нь нийгэм олон нийтийн аюулгүй байдлыг хангаж, гэмд явдлыг тогтоон барих, гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хууль зөрчихгүй,

¹¹ Larson, Aaron. "Sentencing in Criminal Cases - Fines, Probation and Jail". *ExpertLaw*. Retrieved 7 September 2017.

¹² G.S. 15A-1340.11(6)

¹³ Leanna F.Alarid, Philip L.Reichel, Corrections_third edition, USA_2017

дагаж мөрддөг байх, нийгмийн эсрэг зан үйлийг өөрчлөх агуулгаттайгаараа олон оронд хэрэгжиж байгаа бөгөөд зарим улс оронд ялын бодлого, философидоо өөрчлөлт оруулсан жишээгээ тоо баримтаар тайлбарласан нь бий. Тухайлбал, Сингапурт 1965 онд баримталж байсан ялын бодлого нь зөвхөн гэмт хэрэгтэнд оногдуулах шийтгэлийн хариу арга хэмжээ¹⁴ гэж үзэж байсан бөгөөд энэ нь дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг өндөр түвшинд хүргэсэн туршлага¹⁵ гэж үзсэн байдаг.

Тус улсын Шүүхийн шинэчлэлийн нэг асуудал нь нийгэм, олон нийтийн оролцоонд тулгуурласан ялын төрлийг ашиглах явдлыг дэмжсэнд оршиж байгаа ба 2006 оны 6 сард байгуулагдсан “Олон нийтийн шүүх” нь шүүх хуралдааныг өргөжүүлэх, оролцогсдын тоог нэмэгдүүлэх, нээлттэй явуулах боломж нөхцөлийг нэмэгдүүлсэн байна.

Энэхүү шинэчлэлийн үзэл баримтлал нь шүүн таслах ажиллагааны болон гэмт хэрэгтэн – хохирогч - олон нийт гэсэн загварын тэнцвэрт байдлыг хадгалахад чиглэгдэж, ялын бодлогын нөхөн сэргээх ба хариуцлага үүрүүлэх, гэмт хэрэгтний эрх ба хохирогчийн зөрчигдсөн хэрэгцээг хангах, гэмт хэрэгтнийг үүрэгжүүлэх болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах зэрэг асуудлын тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн гэж үзэж болно.

Олон нийтийн оролцоонд тулгуурласан ял эдлүүлэх шинэ хандлага нь гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх төдийгүй хохирогчдын эрхийг хангасан бодлого болохыг Засгийн газраас болон иргэдийн зүгээс дэмжиж, тус Улсын Хууль зүйн яамнаас нийгэм-олон нийтэд тулгуурласан ял оногдуулах хувилбарыг нэмэгдүүлж, хэд хэдэн чиглэлээр ажиллах болсноо мэдэгдсэн байна. Тухайлбал:

-Шаардлагатай эмчилгээ хийх; (бэлгийн хүчирхийлэл, садар самуунтай тэмцэх ажлыг хэрэгжүүлэхэд сэтгэцийн эмчилгээ хийх асуудлыг хүн амын бүлгийн дунд хэрэгжүүлэх шаардлагатай);

-Богино хугацаанд цагдан хорих; (гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, эрхэлж буй ажлаас нь түдгэлзүүлэхгүйгээр долоо хоногоос илүүгүй хугацаагаар хорих);

“Day reporting center”-т хамруулах; (гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийн өдөр тутмын үйл ажиллагаа, тогтмол мэдээлэл авч байх ба шаардлагатай тохиолдолд цахим хяналтыг хэрэгжүүлдэг бөгөөд гэмт хэрэгтэнд гарч өөрчлөлтийг үнэлэх боломжийг бүрдүүлдэг нэгж);

Олон нийтийн ажил хийлгэх; (онцлог шинж нь үйлдсэн гэмт хэрэгтэй нь холбогдсон ажлыг хийлгэх 40 хүртэлх цагаар хийлгэх, тухайлбал, бусдын бие, эрхтэнд гэмтэл учруулсан бол тухайн өвчтөний хагалгааг хийлгэхэд шаардлагатай үйлчилгээний ажил оролцуулах);

¹⁴ Peter English, “Sentencing in Singapore” (1981) 23 Mal.L.R. 1, at p.24


¹⁵ “Our History”, Singapore Prison Service, http://www.prisons.gov.sg/our_history.html

Олон нийтийн үйлчилгээнд хамруулах шийдвэр гаргах; (16-аас дээш насны гэмт хэрэгтнүүдэд “нийгэмд төлбөр төлөх”-ийг шаардаж, сайн дурын үйлчилгээний байгууллагуудад ажиллуулах 40-340 цагаар ажиллуулах);

Тусгайлсан хөтөлбөрт хамруулах: (шүүхээс оногдуулсан хугацаанд тухайн хүний зан үйл, хандлагыг өөрчлөх, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн 12-24 сарын хөтөлбөрт хамруулах) зэрэг ажлыг хэрэгжүүлж байна.

Ял эдлүүлэх ажиллагааны буюу гүйцэтгэлийн менежмент нь ялын зорилгыг хангахад чиглэгдсэн удирдлага, зохион байгуулалт, эрх зүй, нийгэм хамгааллын зэрэг цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх үзэл баримтлал бөгөөд дэлхий нийтэд дараах үндсэн 2 чиглэл байгааг харж болно.

Зураг 8. Ял эдлүүлэх ажиллагааны бүтэц, загвар:



Энэхүү загвар, хандлага нь ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг нийгэм, олон нийтэд тулгуурласан олон талт хэлбэрээр хэрэгжүүлэхэд анхаарч байгаагийн илрэл бөгөөд ял шийтгүүлсэн хүнийг хууль сахин биелүүлэгч - иргэн (a law-abiding citizen) болгон төлөвшүүлж, нийгмийн амьдралд эргэн оруулах асуудал нь ялын үндсэн зорилго болон хэрэгжиж байгаагийн илрэл юм.

Харин манай улсын хувьд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх тогтолцоо нь зөвхөн хуульд заасан торгох, нийтэд тустай ажил хийлгэх, эрх хасах, эд хөрөнгө хураах ял болон албадлагын зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх төдийгөөр хязгаарлагдаж, нийгэм олон нийтэд тулгуурласан бусад төрлийн ял эдлүүлэх ажиллагааны төрөл, хэлбэрийг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

Пробацийн үйл ажиллагааны тухай

Дээр дурдсан нийгэм-олон нийтэд тулгуурласан ял эдлүүлэх ажиллагааны төрлүүдээс хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд харилцан хамаарах төдийгүй манай улсын нийгэм, соёлын онцлогт нийцүүлэн хөгжүүлэх, хууль сахиулах ажиллагаанд нэвтрүүлэн хэрэгжүүлэх боломжтой Пробацийн албаны талаар авч үзье.

Пробац (probation) гэсэн нэр томъёо нь “probatio” гэсэн латин үгнээс гаралтай, туршилт, ажиглалт явуулах үндсэн зорилгоос үүдэлтэй гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр засч, залруулах өөр хэлбэл нийгэмд аюулгүй болсныг нотлох хугацаа гэсэн утга бүхий нэршил юм.

Пробацийн үйл ажиллагааг гэмт хэрэг үйлдсэн хүнийг олон нийтийн харилцаанаас тусгаарлахгүйгээр гэмт болон нийгмийн эсрэг зан үйл (deviance and antisocial behavior)-ийг өөрчлөх, нийгмийн амьдралд дасан зохицуулах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд болон хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад ялтныг гэмт хэрэгтэн бие хүн болж өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор европын улс орнуудад 19 дүгээр зууны сүүлчээр нэвтрүүлж эхэлжээ.

Тодруулбал, анх 1872 онд Англи, 1887-1930-д оны хооронд Бельги, АНУ-д хэрэгжүүлэн хөгжүүлж ирсэн байна. Дэлхийн улс орнуудад хэдийгээр Пробацийн албаны талаар нэгдсэн нэг тогтсон ойлголт байхгүй хэдий ч явуулж буй үйл ажиллагаа, зорилго, ач холбогдлын хувьд ижил төстэй байдлаар хөгжиж ирсэн дүгнэж болох юм.

Нийтлэг байдлаар буюу гадаад улс орнуудад хэрэгжүүлж буй байдлаас авч үзвэл авч үзвэл пробацийн албаны гол зорилго нь:

- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмийн зүй зохистой, зөв амьдралд ороход туслалцаа үзүүлэх;

- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэх зан үйлээс татгалзуулах, урьдчилан сэргийлэх;

- Гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийг нийгмийн харилцаа, орчноос тусгаарлахгүй байх;

- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг хууль сахин биелүүлэх, бусадтай зөв харилцаанд орох чадварт сургах, хөгжүүлэх явдал юм.

Пробацийн албаны үйл ажиллагааг хэрэгжүүлж буй олон улсын практикаас үзвэл чиглэл болон агуулга нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

- Тэнсэн харгалзах ял шийтгэгдсэн этгээдэд тавих хяналт (Англи, АНУ, Латви, Швед г.м);

- Албадан хөдөлмөрлүүлэх ялын хэлбэрээр (АНУ, Финлянд, Япон);

- Хорих ял хойшлуулсан бөгөөд шүүхээс тодорхой төрлийн эрхийн хязгаарлалт тогтоосон нөхцөлд;

- Зорчих эрхийн хязгаарлах ялын хэлбэрээр (ОХУ, Канад г.м);

- Хорих газраас суллагдсан хүмүүст нийгмийн амьдралд ороход туслалцаа үзүүлэх, нийгэмшүүлэх;

- Насанд хүрээгүй этгээд гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд;

- Гэмт хэрэгт шалгагдаж байгаа хүнд туслалцаа үзүүлэх;

- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг хохирогчтой эвлэрүүлэх, зуучлах (Молдав, Латви) зэрэг чиглэлээр ажиллаж байна.

Түүнчлэн Пробацийн албаны үйл ажиллагаа нь хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн, хөнгөн гэмт хэрэг үйлдсэн, хорих ял эдлүүлэх байгууллагаас суллагдах дөхсөн, түүнчлэн ял эдлээд суллагдсан иргэдэд

туслалцаа үзүүлэхээс гадна ажилд зуучлах, санхүүгийн ухаанд суралцуулах, нийгэмшүүлэх зорилго бүхий тодорхой туршилтад хамруулах, боловсрол болон мэргэжлийн чиг баримжаа олгох зэрэг, сургалт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг төдийгүй хөдөлмөрийн биржтэй холбож өгөх, тэдэнд өөрсдийнх нь тодорхойлолт, CV бичиж өгөх, ярилцлагад орох зэрэгт арга зүйн туслалцаа үзүүлж, хувийн бичиг баримттай болоход туслах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэх зан үйлээс татгалзуулах, урьдчилан сэргийлэх, нийгмийн зохист амьдралд ороход туслалцаа үзүүлэхэд голлон чиглэгдэж, ихэвчлэн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, социологич зэрэг мэргэжлийн хүмүүсийг албандаа ажиллуулдаг байна.

Тус албаны үйл ажиллагааны талаарх эрх зүйн зохицуулалтаар жишиг болохуйц Япон¹⁶, Англи, АНУ¹⁷ зэрэг орны туршлага нь хорих ял эдлүүлэхэд гарах зардлаа хэмнээд зогсохгүй ял шийтгэгдэгсдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх ажилд тулгамдаж буй олон сөрөг асуудлыг шийдэж чадсан байна.

Пробацийн үйл ажиллагааг хорих ял эдлүүлэх үйл ажиллагааны явцад хоригдлыг гэмт хэрэгтэн бие хүн болж өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх, улмаар нийгмийн харилцаанаас тусгаарлахгүйгээр гэмт зан үйлийг өөрчлөх, нийгмийн амьдралд дасан зохицох, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжиж эхэлсэн гэж үзэж болно.

Олон улсын практикт анх хэрэглэгдэж эхлэхдээ пробаци нь хорихгүйгээр хянан харгалзах шийтгэлийг хэрэгжүүлэх суурь нөхцөл дээр Пробацийн алба үүсч бий болсон бөгөөд хорих ялын сөрөг үр дагавар бүхий нөхцөл байдлыг өөрчлөх чиг хандлага бүхий эрх зүйн тогтолцооны өндөр хөгжил бүхий улс орнуудад XVIII зууны хоёрдугаар хагаст үүсч бий болжээ. Тухайн цаг үед эрүүгийн ял, шийтгэлийн зорилго дахь хууль зөрчигчийг нийгэмд эргэн нэгтгэх, засан сайжруулах зорилтууд хэрэгжихгүй байгаа талаар эрдэмтэн судлаачдын болон олон нийтийн зүгээс хурц шүүмжлэлүүд гарч эхэлсэн байдаг. Энэхүү нөхцөл байдал нь нийгмийн хор аюул багатай, онц хүндээс бусад гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шууд хорихгүйгээр хоёр дахь боломж олгох үзэл санааг эрүүгийн эрх зүйн салбарт оруулж ирсэн.

Анх 1872 онд Лондонд анх удаа зохион байгуулагдсан Олон улсын хорих байгууллагын конгрессийн үеэр хэлэлцсэн бөгөөд улмаар 1985 онд Римд, 1889 онд Брюссельд хэлэлцэж байсан түүхэн баримт бий бөгөөд 1890 онд

¹⁶ Япон улсад 1995 онд “Гэмт хэрэг, зөрчил гаргагчийг нийгэмшүүлэх тухай” хууль, 1996 онд “Сайн дурын пробацын албаны тухай” хуулийг тус тус баталсан бөгөөд тус улсын Хууль зүйн яамны харьяанд Нийгэмшүүлэх буюу нийгмийн ажлын товчоо ажилладаг.

¹⁷ АНУ-д Halfway house байгууллага нь хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх, суллагдсаны дараа эргэн нийгэмшихэд нь дэмжлэг үзүүлдэг бөгөөд хагас хяналттай, хууль сахиулах байгууллагын туслалцааг авах хэлбэрээр хамтран ажилладаг, тусгайлан институт байна.

Санкт-Петербург хотноо зохиогдсон Олон улсын хорих байгууллагуудын IV их хурал дээр хорих ялыг урт хугацаагаар бус харин хяналтын өөр хэлбэр бүхий ял, хязгаарлалтаар орлуулан хэрэглэх талаар тусгайлан хэлэлцжээ¹⁸.

Судлаачдын үзэж байгаагаар хорих газарт хорихгүйгээр тодорхой нөхцөлд нийгэмд нь хянан харгалзах ял нь 1869 онд хойд Америк, 1820 онд Англи, 1884 онд Франц, 1888 онд Бельги зэрэг улсад хууль тогтоомжид тусгалаа олон хэрэгжиж эхэлсэн гэж үздэг. Хөгжлийн үе шатны явцад пробацн нь анхны хувилбараас илүү олон сонголт бүхий хэлбэрээр өргөжин хөгжсөөр хянан харгалзахаас өөр хэлбэрүүд бүхий бие даасан ял шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл болон хөгжжээ.

Дээрх улс орнуудын хувьд 1940-өөд оныг хүртэлх хугацаанд пробацн албаны үйл ажиллагаа нь зөвхөн тэнсэн хянан харгалзсан этгээдэд хяналтыг өндөр түвшинд тавих замаар дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой хэмээн үзэж байсан боловч өнөөдрийн байдлаар гэмт хэрэгтэн бие хүнийг олноор бий болгохоос зайлсхийх, улмаар нийгэмд эргэн нэгтгэх зэрэг цөөнгүй шинжийг агуулан хөгжиж байна.

Норвегийн нэрт криминологч Н.Кристи өөрийн бүтээлдээ пробацн албаны хөгжлийн талаар “XX зууны хоёрдугаар хагас гэхэд ихэнх иргэншсэн улс орнууд хэт их шоронжсон эрүүгийн бодлогын хямралыг хүлээн зөвшөөрсөн юм”¹⁹ гэж үзсэн байдаг бөгөөд дэлхийн бусад улсын судлаачид пробацн албаны үүсэл нь хорих ялын сөрөг үр дагавраас үүдсэн нийгмийн хөгжлийн зайлшгүй хэрэгцээнд суурилсан талаар авч үзсэн байдаг.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний хуралдаанаар хэлэлцэн баталсан “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм” (Токиогийн дүрэм)-ийн 1.5-д “Гишүүн орнууд нь хорих ялыг хэрэглэх явдлыг багасгах замаар бусад боломжийг хангах, эрхийн зөрчил гаргагчийг нийгэмд хэвийн амьдралд эргэж орох хэрэгцээ, нийгмийн шударга ёсны шаардлага, хүний эрхийг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан эрүүгийн байцаан шийтгэх салбар дахь бодлогыг оновчтой болгох зорилгоор өөрийн эрхийн системийн хүрээнд хорихоос өөр төрлийн арга хэмжээг боловсруулна”²⁰ хэмээн пробацн үйл ажиллагааг хэлбэршүүлэн тунхагласан байна.

Харин Европын холбооны Сайд нарын 1992 оны хуралдаанаас баталсан “Эрх зүйн хариуцлагын болон шийтгэлийн арга хэмжээний тухай дүрэм”-р эрх зүйн зөрчил гаргагч этгээдийг нийгэмшүүлэх, хорихоос өөр төрлийн хяналт,

¹⁸ <http://www.zakon.kz/4598354-otdelnye-voprosy-probacii-akkulev-a.sh..html> 2018.10.17

¹⁹ Нильс Кристи. Причиняя боль. Роль наказания в уголовной политике. Норвегия., 2011

²⁰ Д.Баярсайхан, Т.Золбоо. Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. УБ., 2012. 159 дэх тал

хязгаарлалтыг хөгжүүлэх чиглэлийг баталсан бөгөөд 1997, 1999, 2003 оны хуралдааны зөвлөмжөөр дэмжсэн байдаг

Дэлхийн улс орнуудын эрх зүйн практикт өнөөдрийн байдлаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр хяналт, хязгаарлалт тогтоох замаар ял эдлүүлэх нь хамгийн түрүүнд сонгон хэрэглэвэл зохих ял шийтгэлийн үндсэн хэлбэр гэж үзэж байгаа бөгөөд хорих ялыг зөвхөн хохирогчийн аюулгүй байдалд заналхийлсэн, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн зэрэг цөөн тохиолдолд хэрэглэх учиртай гэсэн үзэл, зарчим давамгайлж байна.

Түүнчлэн улс орнуудын ял эдлүүлэх тогтолцоонд дүн шинжилгээ хийж үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагаа нь өндөр хэмжээний зардлыг үүсгэж байгаагийн зэрэгцээ хорих ял эдлээд суллагдсан хүмүүс гэмт хэрэг үйлдэж ял эдэлж байсан орчиндоо буцаж очих, дахин гэмт хэрэг үйлдэхээс үл эмээх хандлагатай байгаагаас үүдэн хорих ял хамгийн үр дүн багатай ялын төрөл хэмээн тооцогдож байна.

Судлаачдын үзсэнээр 2015 оны байдлаар АНУ-д жилд нэг хоригдолд гарч буй зардлыг тооцож үзвэл 25,000 орчим доллар зарцуулж байгаа бол хорихоос өөр төрлийн хяналт, хязгаарлалтыг ашиглавал 1,500 доллар байх тооцоо гарсан байна²¹. Харин МУ-ын хувьд нэг хоригдолд өдөрт зөвхөн урсгал зардалд 7477, жилд 2,729,105 төгрөгийн зардал гарч байгаа талаар холбогдох тайланд дурджээ. Энэ тоог нийт ял эдлэгсдийн тоонд шилжүүлэн тооцвол бага бус хариу гарах нь ойлгомжтой юм.

Эндээс үзвэл пробацийн үйл ажиллагаа нь эрүүгийн бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн илүү уян хатан болгохоос гадна улс орны эрх зүйн тогтолцооны болон эдийн засгийн хөгжил, хувь хүний хөгжилд илүү бодит эерэг нөлөөллийг авчирдаг болох нь харагдаж байна.

Дэлхийн улс орнууд өөрсдийн эрх зүйн тогтолцоо, нийгмийн хөгжлийн онцлогт тохируулан пробацийн албыг нэршил, чиг үүрэг, харьяаллын хувьд өөр өөр хэлбэрээр байгуулан ажиллуулж байна. Тухайлбал, АНУ, Англи, Швед, Латви, Гүрж гэх мэт улсад Пробацийг алба, Норвеги, Финлянд, Дани, Эстони зэрэг улсад Хяналтын алба гэсэн нэршилтэйгээр ажиллуулж байгаа бол харьяаллын хувьд Англи, Дани, Япон, Финлянд, Норвеги, Латви, Чех, Эстони зэрэг улсад пробацийн алба нь Хууль зүйн яаманд, АНУ, ХБНГУ, Унгар зэрэг улсад шүүхэд, Голланд улсад прокурорын байгууллагад, Швед, Казакстан зэрэг улсад хорих байгууллагад, Сингапур улсад Спорт, нийгмийн хөгжлийн яаманд тус тус харьяалагддаг.

²¹ <http://www.zakon.kz/4598354> 2018.10.15

1990-д оноос хойш хуучин социалист тогтолцоо бүхий улс орнуудад үүссэн нэг хүндрэл нь хорих ял эдлэгсдийн тоо их, түүнд гарах төсвийн зардал их байсны зэрэгцээ, шоронжсон буюу гэмт зан авир, төлөвшил бүхий нийгмийн давхарга, томоохон бүлэг хүмүүс гарч ирсэн явдал юм. Тиймээс гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг шоронжуулахгүй байх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн улс орнууд европын улс орнуудаас пробацийн албаны үйл ажиллагааг нэвтрүүлж эхэлсэн байдаг.

Дэлхийн улс орнуудад эрх зүйн тогтолцоо өөр хэдий ч пробацийн албаны талаар явуулж байгаа үйл ажиллагаа, зорилго, ач холбогдлын хувьд ижил төстэй байдлаар хөгжиж ирсэн.

Ихэнх улс орнуудад пробацийн албаны үйл ажиллагааг төрийн бусад байгууллага, орон нутгийн засаг захиргааны нэгж, хувийн хэвшлийн болон сайн үйлсийн байгууллагууд, иргэд, сайн дурын ажилтнуудын өргөн оролцоонд тулгуурлан зохион байгуулдаг бөгөөд энэ нь тухайн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх, түүнчлэн пробацийн албанаас чиглэл болгосон эрх хязгаарласан үүргийг хэрэгжүүлэх үр дүнг бий болгох гол нөхцөл болдог.

Дэлхий улс орнуудад хорих газраас суллагдсан хүмүүст чиглэсэн төрийн бодлого үндсэн хоёр хэлбэртэй байна. Үүнд: /нийгмийн хяналтын хэлбэр/ Social control of criminals нөгөө нь /нийгэмд амьдрахад нь дэмжлэг үзүүлэх хэлбэр/ Rehabilitation of criminals.

Энэхүү хоёр хэлбэр нь тухайн улсын нийгмийн хөгжлийн чиг баримжаатай холбоотой хандлагаар илэрхийлэгддэг. Жишээ нь: Нийгмийн хяналт нь хорих газраас суллагдсан хүмүүсийг “засрашгүй хүмүүс” гэж үзээд “даван, рецидив гэмт хэрэгтэн” хэмээн нэрлэж, түүнтэй хийх тэмцлийг чангатгадаг. Хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэж байгаа нь хууль тогтоомжийг үл ойшоож, засарч хүмүүжихийг хүсэхгүй байгааг илтгэн харуулах шалгуур гэж үзэж суллагдсан хүмүүст нийгмийн зүгээс тавих хяналт илүү чанга байх ёстой бөгөөд ингэснээр тэднийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж чадна гэж үздэг. Нөгөө хандлага нь либерал баримжаатай барууны гэгдэх орнуудад хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн сэтгэл зүйг эмчлэх, нийгмийн туслалцаа үзүүлэх ажлын онолын үндэслэл 1970-аад оноос эхлэн ул суурьтай хөгжиж эхэлжээ. Энэ нь гэмт хэрэгтнийг нийгэмд дахин засаж, хүмүүжүүлж болдог, ингэхийн тулд шоронгоос суллагдсан хүмүүст туслалцаа дэмжлэг хэрэгтэй гэсэн хүмүүнлэг үзэлд тулгуурладаг.

Ялын бодлогын шинэчлэлийн нэг хэсэг болох тэнсэх, албадлагын арга хэмжээ хэрэглэх нь: хорих ял биечлэн эдлэх явдлыг багасгах, гэмт хэрэг үйлдсэн хүний гэм бурууг өөрөөр ухамсарлуулах, хохирол нөхөн төлүүлэх,

цаашид гэмт хэргийн карьер ахиж, мэргэшсэн гэмт хэрэгтэн бий болгохгүйн тулд авч байгаа шинэлэг арга хэмжээ юм.

Орчин үед Европын холбоо зэрэг Бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудаас ардчилсан хүмүүнлэг иргэний нийгмийг баримжаалан хөгжиж байгаа улс орнуудад шоронгоос суллагдсан хүмүүст дэмжлэг үзүүлэх төрийн бодлого илүү үр дүнтэйг зөвлөж, гишүүн улс орнууддаа энэхүү ажлын стандартыг тогтоох шаардлага тавьж байгааг бид анхаарлын гадна орхиж болохгүй юм²². Хорих байгууллагад ял эдэлж байгаа хүмүүсээс суллагдаж гарсны дараа учрах бэрхшээлүүдийн талаар асуухад ялтнуудын ихэнх нь “хорихоос суллагдахад учрах бэрхшээл ихтэй байдаг, нэн ялангуяа тэднийг амьдралд хүлээн авах хэн нэгэнтэй үл ойлголцох байдал бий болно, ажил олдохгүй байх” гэсэн айдастай байхад, иргэд эсрэгээр шоронгоос суллагдсан хүмүүсийн талаар сөрөг төсөөлөл, хандлагатай байдаг нь ажиглагдлаа.

Хорих байгууллагаас суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх, нийгмийн хариуцлагатай аж ахуйн нэгж, байгууллагаар дамжуулан ажилд зуучлах ажлыг нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг захиргааны болон төрийн бус байгууллагуудын хамтын идэвх санаачилгаар идэвхжүүлж ажиллах ёстой.

Нэгтгэн дүгнэж үзвэл, хорих төдийгүй хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд нийгэм-олон нийтийн оролцоонд тулгуурласан хэлбэрийг түлхүү сонгож, эрх зүйн зохицуулалт, тогтолцооны эх үндсийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд Пробацийн үйл ажиллагааг жишиг хэлбэрээр бий болгон хөгжүүлэх, энэ үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийг татан оролцуулах боломжтой гэж үзлээ.

Пробацийн үүсэл, хөгжил

Дундад зууны Английн эрүүгийн хуулиас пробацийн үүсэл, хөгжлийг харж болох ба тухайн үед насанд хүрсэн болон насанд хүрээгүй этгээдийг ноцтой шинж чанартай биш гэмт хэрэгт хатуу шийтгэл оногдуулдаг байв. Нутаг заах, хорих, ташуурдах, зэрэмдэглэх, цаазаар авах ял оногдуулдаг байсан байна. Жишээлбэл, VIII Генрих хааны үед 200-аас доошгүй гэмт хэрэгт цаазаар авах ял оноодог байсны ихэнх нь хөнгөн гэмт хэрэг байжээ.

Түүний энэ хатуу байдал эцэстээ шударга ёсны тогтолцооны хувьсал гарахад нөлөөлсөн бөгөөд Английн нийгмийн дэвшилтэт хэсгийн дургүйцлийг ихээхэн хүргэж эдгээр хүнлэг бус шийтгэлийг хөнгөвчлөхийн тулд аажмаар

²² ХЗҮХ. Судалгааны тайлангийн эмхэтгэл. УБ., 2012. т.663

боловч шийдэмгий байдлаар олон янзын арга хэмжээг боловсруулж хааны өршөөлийг яллагдагч этгээд худалдаж авах боломж олгодог байсан.

Англи Улсын шүүх хулгайлагдсан эд хөрөнгийг үнэлэх аргачлалыг боловсруулж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг үнийн дүнгээр яллах, лам хуврагын тусламжтай хөдөлмөр хийлгэх, ажлаас халах зэрэг аргууд нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хатуу ял оногдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ болж байв.

Эцэст нь шүүх “сайн зан авирыг заавал дагаж мөрдөх” практикийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд өршөөл үзүүлэх эсвэл хөнгөн ял оногдуулах арга хэмжээ авч маргаантай байгаа гэмт хэргийн ялыг хойшлуулж эхэлсэн нь пробацын үйл ажиллагаа үүсэх гол шалтгаан болж өгчээ.

Английн Улсын иргэн гутлын үйлдвэрийн эзэн Жон Августус 1841 онд өөрийн гутлын үйлдвэрт архинд донтох өвчтэй, архийг хэтрүүлэн хэрэглэдэг этгээдүүдийг 3 долоо хоногийг хугацаатайгаар батлан даалтаар авч ажиллуулан шүүхэд хүлээлгэн өгсний дараа архинд донтох өвчтэй этгээдүүдийн гадна төрх, зан авир өөрчлөгдөж эерэг үр дүн өгч байсан тул энэхүү үйл ажиллагааг 18 жилийн хугацаанд олон зуун эрэгтэй, эмэгтэй, насанд хүрээгүй этгээдэд туршиж батлан даалтаар хариуцан эерэг зан үйл гарч буй этгээдүүдийг ар гэрт нь хүлээлгэн өгдөг байсан нь Пробацийн үйл ажиллагааны үндэс суурь болж дэлхийн улс орнууд хэрэгжүүлж эхэлсэн байна.

АНУ-ын Массачусетс мужид 1859 онд анхны Пробацийн журам батлагдаж Пробацийн үйл ажиллагаа нь АНУ даяар аажмаар тархаж Английн хуульч Мэттью Дэвенфорт Хилл нь орчин үеийн пробацийн хөгжилд хувь нэмэр оруулсан гэж түүхэнд тэмдэглэгдэж үлджээ.

Пробацийн ажилтнууд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн амьдралыг шинэчлэх, өөрчлөх, өөрчлөн байгуулах, сайн сайхан, шударга, иргэдийн дагаж мөрдөх хуулийг өөрийн улс орны нийгэм, эдийн загийн хөгжилд тохируулан гаргаж дэлхийн 2 дугаар дайны дараа АНУ, Европ тивд өргөн тархаж гэмт хэрэг үйлдсэн хүнд тэнсэн харгалзах ялыг оногдуулж эхэлсэн нь орчин үеийн хөгжилд хүргэх алхам хийгджээ.

1950 оноос пробацийн ажилтнууд бусад арга, техникийг ашиглаж, үүнд бүлгийн ажил, олон нийтийн ажил, даалгавартай ажил, гэр бүлийн эмчилгээ, зан үйлийн гэрээ, бодит байдал эмчилгээ, зан үйлийг өөрчлөх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорихгүйгээр, зохих шийтгэл оногдуулж, нийгмийн дунд хүмүүжүүлэх ажил 1960-аад гэхэд өргөжин тэлсээр хамгийн дээд цэгтээ хүрч үр дүнгээ өгч байсан байна.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний хуралдаанаар хэлэлцэн баталсан “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм” (Токиогийн дүрэм)-ийн 1.5 дугаар зүйлд “Гишүүн орнууд нь хорих ялыг хэрэглэх явдлыг багасгах замаар бусад боломжийг хангах, эрх зүйн зөрчил гаргагчийг хэвийн амьдралд эргэж орох хэрэгцээ, нийгмийн шударга ёсны болон хүний эрхийг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан эрүүгийн байцаан шийтгэх салбар дахь бодлогыг оновчтой болгох зорилгоор өөрийн эрх зүйн системийн хүрээнд хорихоос өөр төрлийн арга хэмжээг боловсруулна”²³ хэмээн пробацийн үйл ажиллагааг хэлбэршүүлэн тунхагласан байна.

Токиогийн дүрмийг хэрэгжүүлэх нь зөвхөн тэнсэн харгалзах ял оногдуулж байгаа улс орнуудад төдийгүй ийм системийг сонирхдог улс орнуудад Токиогийн дүрмийг хэрэгжүүлэхэд улс орнуудад туслах зорилгоор НҮБ-ын Гэмт хэрэг, шударга ёсны судалгааны хүрээлэнгээс 1998 оны 3 дугаар сард “Пробацийн үйл ажиллагааны гарын авлага”-ыг гаргасан.

Дэлхийн улс орнуудын эрх зүйн практикт Пробацийн үйл ажиллагааг хорих ял эдлүүлэх үйл ажиллагааны явцад гэмт хэрэгтэн бие хүн болж өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх, улмаар нийгмийн харилцаанаас тусгаарлахгүйгээр гэмт зан үйлийг өөрчлөх, нийгмийн амьдралд дасан зохицох, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх үйл явц гэж тодорхойлж болохоор байна. Олон улсад (Probation and Parol) буюу туршилтийн хугацаа, тэнсэн харгалзах, батлан даалт гэсэн нэршлээр томъёолдог.

Пробацийн үйл ажиллагаанд хамаарах онолын зарим урсгал

Зөрчсөн зан үйлийн эхний хариу арга хэмжээ нь торгууль төлөхөөс эхлээд тулалдаанаар шүүх, албадан хэрэг хүлээлгэх, эрүүдэн шүүж үхэх хүртэл байв. Гэр бүл, овог аймаг, нийгэм бүр өөрийн оршин тогтнохыг бичмэл хууль тогтоомжид хандахгүйгээр хадгалахыг эрэлхийлснээр өс хонзонгийн анхдагч тогтолцоо болох **Lex talionis** (нүдийг нүдээр) гэсэн онол бий болж үеэс үед уламжлагдан ирсэн түүхтэй.

Одоогоос 4000 орчим жилийн өмнө эртний Вавилоны хаан Хаммурапи 12 метр өндөр, тойрог нь 7.5 метр орчим гантиг чулуун дээр хууль зохиож сийлж байсан. Хэдийгээр бичгээр бичсэн ч түүний хуулиуд нь **lex talionis** (нүдийг нүдээр) хэмээх хатуу ширүүн уламжлалыг үргэлжлүүлж байсан бөгөөд хүнийг алах, хулгай хийх, оргосон боолыг нуух зэрэг олон гэмт хэргийг цаазаар авах ялаар шийтгэж, хариуцлага хүлээлгэх тогтолцоо үүссэн байна²⁴.

²³ Д.Баярсайхан, Т.Золбоо. Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. 2012., Уб. 159 дэх тал

²⁴ Howard Abadinsky. Probation and Parole. 2012 он., 2 дахь тал

Сонгодог онол

Шударга ёсыг тогтоох ялгаатай практикийг XVIII зуунд сонгодог үзэл гарч ирснээр хүчтэй эсэргүүцсэн. Сонгодог үзэл бол 18-р зууны Европын гэгээрлийн үеийн (заримдаа “Ухааны эрин үе” гэж нэрлэдэг) үр дүн бөгөөд түүний шүтэн бишрэгчид нь сүнслэг үзлийг үгүйсгэж, гэмт хэргийн зан үйлийн шашны тайлбарыг үгүйсгэдэг. Энэ эрин үед Монтескье (1689-1755), Вольтер (1694-1778) зэрэг философичид Францын эрүүгийн хууль, хүнлэг бус, тэгш бус шийтгэлийг эсэргүүцэж байв. Жан Руссо (1712-1778), Чезаре Беккариа (1738-1794) нар тэгш эрхэд суурилсан шударга ёсны үзэл баримтлалын талаар үзэл баримтлал дэвшүүлсэн²⁵.

Хууль, хууль сахиулах байгууллага шударга бус, харилцан адилгүй, шийтгэл нь ихэвчлэн харгис хэрцгий байсан энэ үед тэд эрх тэгш байдалд суурилсан шударга ёсыг шаардаж, хүнлэг, гэмт хэрэг үйлдсэнтэй дүйцэхүйц шийтгэл оногдуулахыг шаардсан. Энэхүү хувьсгалт сургаал буюу тэгш байдал нь “бүх хүмүүс тэгш бүтээгдсэн” гэсэн тунхаглалаараа Америкийн хувьсгал, Үндэсний ассамблей нь “Хүн ба иргэний эрхийн тунхаглал” 1789 онд баталсан Францын хувьсгалд нөлөөлсөн²⁶.

Бүх иргэдийн тэгш байдал нь энэхүү хууль эрх зүй, улс төрийн философийн үндэс нь нийгмийн гэрээ ба байгалийн эрхийн тухай ойлголтоос олж болно.

Нийгмийн гэрээ бол хүн бүр гэрээ байгуулахыг зөвшөөрсөн үлгэр домогт нөхцөл байдал бөгөөд түүний үндсэн заалт нь бүх хүмүүс тэгш эрхтэй байхын тулд хуулийн нөхцөл нь бүгдэд ижил байна: “Нийгмийн гэрээ нь иргэдийн дунд тэгш байдлыг тогтоодог. Ийм шинж чанартай бөгөөд хүн бүр бусадтай адил нөхцөлийг дагаж мөрддөг бөгөөд ингэснээр бусад бүх хүмүүсийн адил эрх эдлэх эрхтэй”²⁷

Нийгмийн гэрээний сонгодог ойлголт нь бүх хүмүүс тэгш байдлаар бүтээгдсэн тул хуулийн нөхцөл нь бүгдэд ижил байна гэж заасан байдаг. Тиймээс Руссо “Хүн алуурчны золиос болохгүйн тулд өөрөө алуурчин болсон тохиолдолд үхэхийг зөвшөөрдөг” гэж хэлсэн. Гэмт хэргээс аюулгүй байхын тулд бүх хүмүүс гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд шийтгэхийг зөвшөөрсөн. Энэ нь хамгийн олон тооны хувьд хамгийн их сайныг бүрдүүлдэг; нийгмийн гэрээ нь оновчтой бөгөөд аминч үзлээр өдөөгддөг.

Хуулийн хэрэгжилтийн арга барилаас ялгаатай нь сонгодог үзэл нь хууль нь зэрэг дэв, албан тушаалын аль алиныг нь хүндэтгэх ёсгүй - бүх хүмүүс ижил

²⁵ Howard Abadinsky. Probation and Parole. 2012 он., 6 дахь тал

²⁶ Howard Abadinsky. Probation and Parole. 2012 он., 7 дахь тал

²⁷ Howard Abadinsky. Probation and Parole. 2012 он., 7 дахь тал

тэгш бүтээгдсэн - шийтгэлийг төгс нэгдмэл байдлаар, гэмт хэргийн харьцаатай байх ёстой гэж үздэг.

Энэ үндэслэлд Беккариа түлхэц өгсөн бөгөөд тэрээр "Гэмт хэрэг ба шийтгэлийн тухай номдоо хуулиудыг бүх ангиллын эрчүүдэд адил тэгш хэрэглэх шийтгэлтэй уялдуулан нарийн гаргах ёстой гэж хэлсэн. Хуульд тодорхой гэмт хэрэг бүрт тодорхой шийтгэл ногдуулах ёстой бөгөөд шүүгчид нэг гэмт хэрэг үйлдсэн бүрт ижил ял оноох ёстой гэж тэр үзэж байна. Энэ нь шударга ёсыг оновчтой болгодог, харин хуулийг өгөгдсөний дагуу шүүмжилдэггүй. Шийтгэл нь урьдчилан сэргийлэх зорилготой бөгөөд "хуулиар тогтоосон гэмт хэрэгт пропорциональ, тухайн нөхцөл байдалд байж болох хамгийн бага хэмжээ" байх ёстой гэж үзэж байв²⁸.

Шүүгдэгчдийг яллах ажиллагааг эрүүдэн шүүхгүйгээр гүйцэтгэх ёстой бөгөөд энэ нь энэ хугацаанд нийтлэг тохиолддог. Эрүүдэн шүүх нь хүмүүнлэг бус төдийгүй маш их зүйл юм гэм бурууг тодорхойлоход найдваргүй. Өмнө дурьдсан Руссогийн байр сууринаас ялгаатай нь Беккариа цаазаар авах ялыг эсэргүүцсэн.

Сонгодог байр сууринаас үзэхэд нийгмийн гэрээг зөрчсөн гэмт хэрэгтнүүд ухаалаг, хүсэл зоригтой байдаг тул шийтгэл нь үндэслэлтэй байдаг. Библийн гарал үүсэлтэй энэхүү үзэл баримтлал нь хүн бүр зөв бурууг ялгаж, сонгох, хууль сахиулах ба гэмт хэргийн аль алиныг нь сонгох чадвартай өөрөөр хэлбэл, хууль зөрчсөн зан үйл нь эрх зүйн үүднээс дур зоргоороо хүний хийсэн оновчтой сонголт юм. Гэсэн хэдий ч сэтгэцийн болон социопатуудын ноцтой гэмт хэргийн зан үйлийг тархины хэвийн бус байдалтай холбосон нотолгоо байдаг.

Сонгодог сургууль нь хүмүүс таашаал ханамжийг эрэлхийлж, өвдөлтөөс зайлсхийх хандлагатай байдаг тул шийтгэлээс эмээж, хууль бус таашаал авчрах үйлдлүүдийг хязгаарлах ёстой гэж үздэг. Иймээс эрүүгийн хуулийн зорилго нь зүгээр нэг хариу арга хэмжээ авах бус, таслан зогсоох бөгөөд "хүн өөрийн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээдэг бөгөөд ямар ч зэрэглэлээс үл хамааран хуулийн өмнө тэгш эрхтэй" байх ёстой хэмээн үзэж байв.

Хэрэв хууль нь урьдчилан сэргийлэх зорилготой бол түүнийг зөрчигч нь үр дагавраас айдаг байх ёстой. Энэхүү айдас нь тодорхой байдлыг шаарддаг бол зан үйлийн анхдагч хэлбэр дээр үндэслэсэн шуурхай байдал нь үйлдлийг шийтгэлтэй холбож, илүү удаан үргэлжлэх сэтгэгдэл төрүүлэхэд шаардлагатай байдаг.

²⁸ Howard Abadinsky. Probation and Parole. 2012 он., 8 дахь тал

Сонгодог хандлага нь эрх ямбатай язгууртны ангитай хууль эрх зүйн тэгш байдлыг шаардаж, доод давхаргын эдийн засгийн идэш тэжээлээс хамгаалахыг шаардаж байсан 18-р зууны өсөн нэмэгдэж буй арилжааны ангийн ашиг сонирхлыг дэмжиж байв.

Эрх тэгш байдлыг хамгаалах, эд баялаг, өмчийн тэгш бус хуваарилалтыг хадгалахыг онцлохын хооронд зөрчилдөөн байсаар байна. Гэмт хэрэг нь эд баялаг, боломжийн эрс ялгаатай байдлын оновчтой хариу үйлдэл байж болох юм.

Хүний нийгэм дэх байр суурь нь гэмт хэрэг үйлдэх сонголтын түвшинг тодорхойлдог учраас чөлөөт хүсэл зориг нь хэт хялбарчлах явдал юм: "Ийм журмын сонгодог шударга ёсны тогтолцоо нь зөвхөн өмч хөрөнгийг тэгш хуваарилсан нийгэмд л үйлчилдэг" гэж хүн бүр тэгш хувь эзэмшдэг.

Сонгодог үзлийн найман үндсэн зарчим байдаг²⁹. Үүнд:

1. Хүн бол ухаалаг.
2. Бүх хүмүүс тэгш эрхтэй бүтээгдсэн.
3. Нийгэмд хүн бүр тэгш оролцоотой байх тул гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд тэгш оролцоотой байна.
4. Чөлөөт хүсэл зориг нь хүн бүрт хууль сахиулах, гэмт хэрэг үйлдэх эрхийг өгдөг.
5. Хүмүүс гедонизмд хандах хандлагатай байдаг.
6. Шийтгэлийн зорилго нь таслан зогсоох явдал юм.
7. Шийтгэлийг шударгаар, үнэмлэхүй тэгш эрхтэйгээр, гэмт хэрэг үйлдсэнтэй нь тэнцүүлэх ёстой.
8. Шийтгэл нь шуурхай бөгөөд тодорхой байх ёстой гэсэн зарчмыг баримталж байжээ.

Неоклассикализм онол

Сонгодог байр сууринаас үзэхэд нийгмийн гэрээг зөрчсөн гэмт хэрэгтэн нь ухаалаг, дур зоргоороо хангагдсан, тиймээс ямар ч зэрэглэлээс үл хамааран өөрийн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээдэг тул шийтгэлийг зөвтгөдөг. Байгаль дээр бус хууль, эрх зүйн тогтолцоонд анхаарлаа хандуулдаг

Эрүүгийн хуулийг төгс тэгш эрхтэйгээр хэрэгжүүлэх нь боломжгүй юм. 1791 оны Францын хууль нь Беккариагийн шинэчлэлийг хэрэгжүүлэхийг оролдох үед энэ асуудал тодорхой болсон. Тэгш байдал ба пропорциональ байдал нь онолоос илүү практикт хэцүү болж, францчууд неоклассикизм хэлбэрээр шүүгчийн үзэмжийн эрх мэдлийг улам бүр нэмэгдүүлсэн.

Неоклассикизм нь чөлөөт хүсэл зоригийн үндсэн итгэл үнэмшлийг хадгалж, гурван чиглэлийг авч үзэх замаар ялыг хөнгөвчлөх (дараа нь

²⁹ Taylor, Wolstan, Young. *Classicalism* 1973 он., 23 дахь тал

хүндрүүлэх) эрүүгийн эрх зүйд орох замыг засдаг. Гэмт хэргийг чөлөөтэй сонгосон, санаатай, оновчтой, өөрөөр хэлбэл үндэслэлтэй зан үйлтэй тохиолдолд л шийтгэлийг зөвтгөж болно.

Неоклассик үзэл баримтлал нь хууль бус мэргэжилтнүүд, ялангуяа сэтгэцийн эмч, сэтгэл судлаачдыг шүүхэд өгөх боломжийг бий болгосон. Эдгээр шинжээчид сулруулж байгаа эсэхийг тодорхойлдог бөгөөд систем нь хүсэл зоригийн итгэл үнэмшлээ үргэлжлүүлэн хадгалах боломжтой юм. Гэмт хэрэгтнүүдийн хооронд ялгаатай байх боломжийг олгох нь детерминизмын төсөөллийг бий болгодог бөгөөд энэ нь гэмт хэрэгтний сонголт янз бүрийн хэмжээгээр хязгаарлагдмал гэсэн үг бөгөөд энэ нь позитивизмын үндсэн суурь юм³⁰.

Позитивизм онол

Август Комте (1798-1857)-ийн томъёолсон позитивизм нь нийгмийн зан үйлийг судлах, ойлгох аргыг хэлдэг. Комте байгалийн шинжлэх ухааны арга, логик хэлбэр болох шинжлэх ухааны арга нь хүнийг нийгмийн шинжлэх ухааны салбарыг бий болгож, нийгмийн оршихуй болгон судлахад хэрэглэгдэх боломжтой гэж үзсэн. Нийгмийн үзэгдлийг түүний социологи гэж нэрлэсэн шинэ шинжлэх ухаанд ажиглалт, таамаглал, туршилтаар судалж, ойлгох ёстой гэж Комте хэлэв.

Сонгодог онол нь философи, хууль эрх зүйд тулгуурладаг бол позитивист үзэл нь эмпиризмд тулгуурлан гэмт хэргийн шалтгааныг тогтоох оролдлого юм.

Гэмт хэргийг судлах позитивист хандлага нь Венецийн эмч Чезаре Ломброзо (1835-1909)-ийн анхны хүчин чармайлтыг криминологи гэж нэрлэх болсон. Ломброзо 1876 онд анх хэвлэгдсэн *L'uomo delinquente* ("Гэмт хэрэгтэн") номондоо гэмт хэрэгтэн бол гэмт хэрэгтэн бус хүн аль хэдийн туулсан хөгжлийн өмнөх үе шатуудад "анхан шатны ухралт" гэж үздэг - нийгмийн дарвинизмын нөлөө нь илэрхий юм.

Ломброзогийн физиологийн шинж чанарт төвлөрсөн судалгаа нь гэмт хэргийн шинж тэмдэг гэж үздэг байсан ч гэмт хэрэг үүсгэхэд хүрээлэн буй орчны хүчин зүйлс чухал болохыг тэмдэглэсэн байдаг. Позитивистууд гэмт хэргийн зан үйлийг оновчтой гэж онцлохын оронд үүнийг биологийн, сэтгэлзүйн эсвэл нийгмийн эмгэгийн зарим хэлбэрийн шинж тэмдэг гэж үзэх хандлагатай байдаг.

Чарльз Дарвин, Герберт Спенсер нар хүний хувьслын ерөнхий бүтэц, түүний нийгэмд үзүүлэх нөлөөний талаар санаа зовж байсан бол Ломброзогийн бүтээлээр үүсгэсэн эрүүгийн антропологи нь гэмт хэргийн зан

³⁰ Howard Abadinsky. *Probation and Parole*. 2012 он., 9 дэх тал

үйлийг тайлбарлахын тулд хувьслыг ашигласан. Ломброзо шинжлэх ухааны арга хэрэгслийг нэлээд төгс бус ч гэсэн ашиглаж, судалгааны талбарыг хууль, гүн ухаанаас эмпиризмд шилжүүлснээр гэмт хэргийн судалгаанд хувь нэмэр оруулсан.

Позитивист үзэл нь гэмт хэрэг биш харин гэмт хэрэгтнийг онцолдог. Энэ нь позитивистууд харилцан уялдаатай шалтгаануудын гинжин хэлхээг орлуулсан чөлөөт хүсэл зоригийн онолтой зөрчилдөж, хамгийн туйлдаа бол гэмт хэргийн зан үйлийн детерминист үндэс суурь болж байна.

Гэмт хэргийн зан үйл нь физиологийн биш юмаа гэхэд нийгэм, сэтгэл зүйн нөхцөл байдлын үр дагавар бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хяналт багатай эсвэл огтхон ч байхгүй, гэм буруугүй (хуулийн хэллэгээр бол эрэгтэйчүүдийн хүчин чадал дутагдалтай) тул шийтгэх нь зохисгүй гэсэн хэдий ч гэмт хэрэгтнүүд нийгэмд заналхийлж байгаа тул тэднийг “эмчлэх”, “засах” “зан үйлд нөлөөлөх” ёстой хэмээн үзэж байв.

Дарвины байгалийн шалгарлын онол нь баячуудын зовлон зүдгүүр нь нийгмийн хөгжил дэвшлийн зайлшгүй үнэ гэж хэлж, ядууст туслахгүй гэсэн баячуудын бухимдлыг намжаасан үзэл суртлын (хожим нь нийгмийн дарвинизм гэж нэрлэгдсэн) үзэл баримтлалын зэвсгийг хангасан юм. Энэ нь гагцхүү оршин тогтнохын төлөөх тэмцлээр хамгийн сайн нь амьд үлдэж, тохиромжгүй нэг нь устгаж дуусдаг хэмээн хэлж байв.

Спенсер “Хэрэв зохисгүй хүмүүсийг өсгөхөд нь тусалж, тэднийг зохисгүй байдлаас нь үүдэлтэй мөнх бус байдлаас хамгаалж чадвал үр дагавар нь үеийн үед улам их зохисгүй байдлыг бий болгох болно”, “Сайн сайн сайхныг урьтал болгож өсгөх нь туйлын харгислал юм. Энэ бол хойч үедээ зориудаар гай гамшиг хуримтлуулах явдал юм. Үр удамд өвлүүлэн үлдээхээс илүү хараал байхгүй. Тэдэнд тэнэг, завхай, гэмт хэрэгтнүүдийн тоо нэмэгдэж байна” гэсэн үзлээр сургаж байсан.

Пробацийн түүх нь библийн цаг үе хүртэл үргэлжилсэн эртний түүхтэй боловч Америкийн түүх нь 19-р зуунаас эхэлдэг. Пробаци хэмээх ойлголт шүүгдэгчид ялыг түр хугацаагаар түдгэлзүүлэх зорилгоор Английн шүүхүүдэд хэрэглэгдэж байсан шүүхээр ялаас чөлөөлөх практикаас үүссэн өршөөл юм. Шүүгдэгчид биеэр эдлэх ялыг түр хугацаагаар хойшлуулах зорилготой байсан.

Шийтгэлийн хувьд энэ нь эцэстээ тэнсэн харгалзах ял болж хувирсан ба үүгээр ялыг бодитоор оногдуулаагүй. АНУ-д тэнсэн харгалзах ялыг 1830 онд Бостонд хэрэглэж, АНУ-ын шүүхүүдэд өргөн тархсан байсан ч ийм төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хуулиар олгогдоогүй байв. Шүүгчид эхэндээ “хүлээж авах” буюу “батлан даалтад гаргах” арга хэрэглэж, цаашдын арга хэмжээ авч чадаагүй.

Харин 19-р зууны дунд үе гэхэд олон шүүх ялыг түдгэлзүүлэхийн тулд шүүхийн хойшлуулшгүй арга хэмжээг хэрэглэж байсан бөгөөд энэ нь хууль эрх зүйн маргаан үүссэн.

“Шүүгч ямар нэг шалтгаанаар шүүх хурал буруу болсон гэж үзвэл ялыг түдгэлзүүлэх эрхтэй байсан. Гэхдээ шүүгчид шударга шүүх хурал хийсний дараа шүүгдэгчид хоёр дахь боломж олгохын тулд ялыг бүхэлд нь түдгэлзүүлэх асуудлыг шүүхээр хэлэлцсэн бөгөөд шүүх энэ эрхийг хууль тогтоогчоос олгосон үед л эрүүгийн шүүхүүдэд ялыг түдгэлзүүлэх эрх мэдэлтэй болохыг тогтоожээ.

1916 онд АНУ-ын Дээд шүүх зөвхөн холбооны шүүхийг хамарсан нэгэн хэрэгт шүүгчид ялыг түдгэлзүүлэх бүрэн эрхгүй гэж үзсэн. Харин шүүх шийдвэртээ, Конгресс ялыг түр болон тодорхойгүй хугацаагаар хойшлуулахыг зөвшөөрсөөр орчин үеийн Пробацийн үйл ажиллагааны үндэс суурь тавигджээ.

Орчин үеийн Пробацийг үндэслэгч Жон Августус гэмт хэрэгтнүүдийг шүүхээс гадуур батлан даалтад гаргах практикт хэрэглэсэн бөгөөд дараа нь нийгмийн хяналтанд амьдрах хугацаа юм хэмээн тодорхойлжээ.

Августын ашигласан системийн хэд хэдэн давуу тал нь орчин үеийн туршилтын үндсэн хэсэг хэвээр байна. Август тусалъя гэж үзсэн хүн бүрийг, тэр дундаа “хүний өмнөх зан чанар, түүний нас, ирээдүйд түүнийг хүрээлэх нөлөөллийг” сайтар судалж, шүүгдэгч бүрийг хянаад зогсохгүй шүүхэд өгсөн хэргийн бүртгэлийг сайтар хөтөлдөг байв. Август 1859 онд нас барсан; 1878 он хүртэл Массачусетс мужид туршилт явуулах нь сайн дурынхны ажил хэвээр байв.

1859 онд Массачусетс мужид батлагдсан анхны туршилтын журам нь түүний хүчин чармайлттай холбоотой байв.

Энэхүү анхны дүрмийг баталсны дараа туршилтын хугацаа АНУ даяар аажмаар тархав. Насанд хүрээгүй хүмүүсийн шүүх хөдөлгөөн нь пробацийг гэмт хэрэгтнүүдтэй харьцах хууль ёсны хүлээн зөвшөөрөгдсөн арга хэлбэр болоход ихээхэн хувь нэмэр оруулсан. 1899 онд Чикаго хотод насанд хүрээгүй хүмүүсийн анхны шүүх байгуулагдсан. Хүлээн авах үйл явцыг албан ёсоор Иллинойс мужийн насанд хүрээгүйчүүдийн шүүхийг үүсгэн байгуулагчдад тооцдог. Үүний дараахан 30 муж нь насанд хүрээгүй хүмүүсийн шүүх хуралдааны нэг хэсэг болгон тэнсэн харгалзах хугацааг нэвтрүүлжээ. Өнөөдөр бүх муж улсууд насанд хүрээгүй болон насанд хүрсэн хүмүүст тэнсэн харгалзах ял оноодог.

Английн хуульч Мэттью Дэвенпорт Хилл нь орчин үеийн пробацийн хөгжилд хувь нэмэр оруулсан гэж тэмдэглэв. Хилл залуу гэмт хэрэгтнүүдийг

нэг өдрийн хугацаатайгаар шийтгэж, тэднийг эцэг эх, асран хамгаалагчид нь нягт нямбай хянахаар буцааж өгөх болзолтойгоор гэрчилж байжээ. Эцэст нь тэрээр шүүхийн шуудангийн албан тушаал хашдаг Бирмингемийн бичигч болохдоо авлигад идэгдээгүй мэт санагддаг хүмүүст ижил төстэй практикийг ашигладаг байжээ. Хэрэв гэмт хэрэгтнүүд нөхөн сэргээх амлалтаа харуулсан бол тэднийг хариуцаж авсан өгөөмөр асран хамгаалагчдын гарт шилжүүлсэн. Хилл цагдаагийн алба хаагчдыг эдгээр асран хамгаалагчидтай үе үе очиж, гэмт хэрэгтний ахиц дэвшлийг хянах, бүртгэл хөтлөх зорилгоор ажиллуулж байжээ

АНУ-д ялангуяа Массачусетс муж улсад янз бүрийн дадал хэвшил боловсруулагдаж байв. "Сайн зан авирын аюулгүй байдал", "сайн зөрчил" гэж нэрлэдэг нь орчин үеийн барьцаатай адилхан, яллагдагч нь сайн зан үйлийн барьцаанд төлбөр төлдөг байв. Яаралтай шийтгэхийг шаардаагүй хэргүүдэд мэдүүлэг өгөх ажлыг мөн хийдэг байв.

Энэ процедурыг ашиглан яллах дүгнэлтийг "хавтаст хэрэгт хавсаргасан" эсвэл үл тоомсорлож байсан. Үндэслэлгүй албадлагын шийтгэлийг хөнгөвчлөхийн тулд шүүгчид ихэвчлэн бага зэргийн техникийн шинж чанарууд эсвэл процесст гарсан алдаануудыг үндэслэн цуцлах саналыг өгдөг байв. Америкийн эдгээр зан үйлүүд нь тэнсэн харгалзах урьдчилсан нөхцөл байсан боловч танилтын эрт ялалт, түр хугацаагаар түдгэлзүүлсэн ял нь орчин үеийн тэнсэн харгалзахтай шууд холбоотой юм.

Түдгэлзүүлсэн ялыг өргөн хэрэглэсэн ч гэсэн АНУ-ын Хууль зүйн яам энэ шийдвэрийг гүйцэтгэх засаглалын өршөөл үзүүлэх эрхэнд халдсан, иймээс Үндсэн хууль зөрчсөн гэж үзэн, үүнийг хэрэглэхийг үл зөвшөөрөв. АНУ-ын дээд шүүх 1916 онд холбооны шүүх ялыг тодорхойгүй хугацаагаар түдгэлзүүлэх эрхгүй бөгөөд дээд шүүх пробацийн тухай хууль тогтоомжийг эмчилгээний журмаар санал болгосон.

Холбооны шүүхүүдэд ял оноох хувилбар болгон пробаци тогтоох нь тийм ч хурдан, амархан байгаагүй бөгөөд Холбооны зарим шүүгчид үүнийг албадан ногдуулж байсан хатуу шийтгэлийн өөр хувилбар гэж үзэн тэнсэн харгалзаж байжээ.

Холбооны бусад шүүгчид тэнсэн харгалзах хугацааг хэтэрхий зөөлөн гэж үзэн эсэргүүцэж байв. Конгресс үндэсний төлөвлөгөөний талаар тохиролцоонд хүрч чадсангүй. Холбооны Пробацийн тухай хуулийн анхны төслүүдийг 1909 онд Конгресст өргөн барьж байжээ. Гэхдээ 1925 он хүртэл, мөн 30 гаруй хуулийн төслийг өргөн барьсны дараа Пробацийн тухай хууль батлагдсан байна.

Ерөнхийлөгч Калвин Кулиджийн гарын үсэг зурсан 1925 оны Туршилтын тухай хуулиар холбооны шүүхүүдэд (Колумбийн тойргоос бусад тохиолдолд)

тэнсэн харгалзах тогтолцоог бий болгосон. Энэ нь шүүхээс ял оногдуулах, биелүүлэхийг түдгэлзүүлж, шүүгдэгчдийг хамгийн сайн гэж үзсэн хугацаагаар, нөхцлөөр тэнсэн харгалзах эрхийг олгов. Хуулийн дагуу шүүхээс нэг буюу хэд хэдэн хүнийг нөхөн төлбөргүйгээр, цалинтай пробацийн офицероор томилогдох эрхийг шүүхэд олгов.

Анхны холбооны пробацийн ажилтныг 1927 онд Массачусетсийн дүүрэгт томилжээ.

Эхний ээлжинд холбооны тэнсэн харгалзах албыг АНУ-ын Хууль зүйн яамны Ерөнхий прокурорын газар хариуцдаг байв. Шууд хяналт нь шоронгийн аж ахуй эрхлэгчид, мөн хорих ангиудыг тэнсэн суллах ажлыг хариуцдаг байсан.

1940 онд пробацийн системийн ерөнхий хяналтыг Холбооны шоронгийн товчооноос АНУ-ын шүүхийн захиргааны албанд шилжүүлснээр энэхүү зохицуулалт өөрчлөгдсөн юм.

1974 онд Конгресс Түргэн Туршилтын тухай хууль батлав. Хуулийн II гарчигт АНУ-ын шүүхийн Захиргааны албаны захиралд шүүхийн 10 дүүрэгт "үзүүлэх" урьдчилсан үйлчилгээний агентлаг байгуулах эрх олгов.

Зорилго нь шүүх хурал хүртэл олон нийтэд суллагдсан хүмүүсийн гэмт хэргийг бууруулах, шаардлагагүй урьдчилсан хорих хугацааг багасгах явдал байв.

Агентлагууд жижиг гэмт хэргээс бусад хэрэгт яллагдагчаар татагдсан хүмүүстэй ярилцлага хийж, анхан шатны мэдээллээ баталгаажуулж, батлан даалтад гарах гэж байгаа шүүхийн ажилтанд тайлангаа танилцуулах ёстой байв. Агентлагууд нь шүүх хуралдаан болтол асрамжинд суллагдсан хүмүүсийг хянах, батлан даалтад гарч буй шүүгдэгчдийг олох, олон нийтийн үйлчилгээг ашиглахад нь туслах ёстой байв.

Агентлагуудын тавыг нь Захиргааны алба, тавыг нь дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчдийн томилсон итгэмжлэгдсэн зөвлөл удирддаг байв.

Ерөнхийлөгч Рональд Рейган 1982 оны Урьдчилан сэргийлэх үйлчилгээний тухай хуулинд гарын үсэг зурав. Энэхүү хууль нь шүүх хурлын арван шатны шүүхээс холбооны шүүх дүүрэг (Колумбын тойргоос бусад) хүртэл өргөжин тэлэх эрх олгов.

Шүүх тус бүрт урьдчилсан үйлчилгээний алба байгуулах, эсвэл пробацийн албаар дамжуулан урьдчилсан үйлчилгээ үзүүлэх эсэхээ шийдэх 18 сарын үнэлгээний хугацааг олгов. Үүний үр дүнд шүүх бүр эрүүгийн хэрэг, шүүхийн байршил зэрэг хүчин зүйлийг харгалзан түүний хэрэгцээг хамгийн сайн хангасан урьдчилсан үйлчилгээний байгууллагын хэлбэрийг сонгосон.

Урьдчилан сэргийлэх үйлчилгээг бүх дүүрэгт өргөжүүлснээр өнөөгийн “холбооны тэнсэн харгалзах болон урьдчилсан үйлчилгээний тогтолцоо” байсан чухал үйл явдал болов. Эдүгээ офицерууд хүнийг холбооны хэргээр баривчлагдахаас олон нийтийн хяналтыг дуустал эрүүгийн шүүх ажиллагаанд оролцдог байв.

1984 онд АНУ-ыг Барьцааны шинэчлэлийн тухай хууль нь шүүгчдийг нийгэмд учрах аюулыг шүүхийг хүлээж буй хүмүүсийг суллах, саатуулах эсэхийг шийдэх хүчин зүйл гэж үзэх боломжийг олгодог.

Энэхүү хууль нь холбооны хууль зөрчигчдөд шүүхээс оногдуулсан ялыг бүрэн өөрчилсөн юм. Энэхүү хууль нь АНУ-ын ял оноох комисс хэмээх холбооны шинэ агентлагийг үүсгэн байгуулж, холбооны бүх зөрчилд шийтгэл оноох удирдамжийг тогтоожээ. Холбооны ялын удирдамж 1987 оны 11-р сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхлэхэд шүүгчдийн ялын тогтоол, албан тушаалтнуудын танилцуулах мөрдөн байцаалтын тайлан, офицеруудын ялын үйл явц дахь ерөнхий үүрэг зэргийг ихээхэн өөрчилсөн.

Шийтгэх ялын шинэ схем нь офицеруудыг шүүх танхимд илүү өрсөлдөөнтэй орчинд байрлуулсан бөгөөд өмгөөлөгчид баримтаар маргаж, удирдамжийн тооцоонд асуулт тавьж, илтгэлд дурдсан мэдээллийг эсэргүүцэж болзошгүй юм. Хуулийн дагуу ял шийтгэл оногдуулах шинэ үйл явцыг хангахын зэрэгцээ хорих ялыг хугацаанаас нь өмнө сулласныг “хяналттайгаар суллах” -аар орлож, хорих ял эдэлж дууссаны дараа хоригдлуудад үйлчлэх олон нийтийн хяналт тавих хугацааны талаар зааж өгчээ.

1986 онд Холбооны шүүхэд гэрээс хорих хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Хорио цээрийн тусгай хөтөлбөр нь холбооны шүүхүүдийн гэрийн хориог анх хэрэглэсэн явдал байв. Энэ нь Туршилтын хөтөлбөрийн нэг хэсэг байсан бөгөөд Хорих ангиудын хорих анги, АНУ-ын тэнсэн суллах комисс, холбооны тэнсэн харгалзах систем зэрэг нь хорих ангиудын олон нийтийн эмчилгээний төв (СТС) -т хамрагдах боломжтой хоригдлуудын өөр байршил болох хувилбар байв.

Эдгээр хоригдлууд СТС байрлуулахын оронд хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан хугацааг хамгийн ихдээ 60 хоногоор сунгаж, хорио цээрийн дэглэм тогтоож, тэнсэн харгалзах ажилтантай долоо хоногт доод тал нь холбоо барина. Цахим хяналт нь хэдэн жилийн дараа байшин хорих хөтөлбөрийн нэг хэсэг болжээ.

1988 онд хорио цээрийн хөтөлбөрт хамрагдсан хүмүүсийг хянах цахим тоног төхөөрөмжийн ашиглалтыг үнэлэх зорилгоор хоёр дүүрэгт туршилтын хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Хөтөлбөрийг 1991 онд үндэсний хэмжээнд өргөжүүлж, тэнсэн харгалзах ялтай, хянан харгалзан суллагдсан, урьдчилсан

хяналтанд байгаа яллагдагчдыг цахим хяналтаар гэрийн хорионд байлгах боломжтой хүмүүсийг хамруулав.

Пробацийн ажилтнууд хяналтын журмаар суллагдсан хугацааг хянан харгалзахаар хүлээн авч эхэлнэ.

Өршөөлөөс чөлөөлөх, ялын шаардлагыг чангатгах нь олон нийтийн хяналтыг өөрчилсөн. Хяналтын журмаар суллаж, хар тамхины ял шийтгэл болон бусад ноцтой хэргүүдийг нэмэгдүүлсэн нь тэнсэн харгалзах хэргээс татгалзахад хүргэсэн. Үүний үр дүнд холбооны тэнсэн харгалзах алба хаагчдын хяналтан дор ирсэн хүмүүсийн ихэнх нь тэнсэн харгалзах ялаар шийтгэгдээгүй боловч хорих ялаар шийтгүүлж, дараа нь олон нийтийн хяналтад хамрагдахаар болжээ.

1.2 Пробагийн үйл ажиллагаанд хамаарах олон улсын хэм хэмжээ

Улс гүрнүүдийн эрх зүйн салбар дахь хамтын ажиллагааны гол зорилгын нэг нь өөрийн улсын иргэн болон хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хилийн чанадад хангах асуудал юм.

Аливаа улс газар нутгийн зарчмыг үндэслэн өөрийн нутаг дэвсгэрт болсон хэрэг маргааныг шийдвэрлэж болох боловч улс орон дамнасан, өөр улсын эрх ашгийг хөндсөн, гадаадын иргэн, хуулийн этгээд оролцсон, эсхүл гадаад улсын нутаг дэвсгэрт үүссэн хууль зүйн факттай хэрэг маргааныг дангаар шийдвэрлэхэд багагүй бэрхшээл учирдаг.

Энэ тохиолдолд улс гүрнүүд нэг талаас өөрийн иргэн, хуулийн этгээдийн эрх ашгийг хангах, нөгөө талаас нутаг дэвсгэр дээрээ бусад улсын шүүх эрх мэдлийн эрх ашгийг хангах шаардлагын улмаас эрх зүйн туслалцаа харилцан үзүүлдэг. Эл нөхцөл байдлаас үүдэн эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх явдал нь оролцогч улсуудын хувьд харилцан ашигтай байх, өөрийн эрх ашгийг хангуулахын тулд нөгөө улсын нийтлэг болон иргэний хувийн эрх ашгийг хүндэтгэх зарчим болон тогтжээ.

Түүх сөхвөл эртний Грек, Ромд хот улсууд үүсэж өөрийн бүрэн эрхт байдлыг зарлаж эхэлсэн тэр үеэс хөрш улсуудын хувьд нэг нь нөгөөгийнхөө бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч дотоод хэрэгт нь оролцохгүй байх олон улсын эрх зүйн анхны заншлын хэм хэмжээ тогтсон байдаг.

Гэтэл хил даван оргосон гэмт этгээд, боолын асуудлыг шийдвэрлэх, гадаад улсад зорчин яваа ихэс дээдэс, худалдаачдынхаа эрх ашгийг хамгаалах зэрэг асуудал босож ирсэн нь эрх зүйн салбарт харилцан биесээ хүлээн зөвшөөрч хамтран ажиллахыг шаардаж эхэлжээ.

Анхлан Хеттийн хаан Хеттушил Египетийн Фараон Рамзес II нар олон жилийн дайнаа зогсоох энхийн гэрээ байгуулахдаа оргосон боолыг барьсан тал харъяалах улсад нь хүлээлгэн өгч байхаар хэлэлцэн тохирсон түүхтэй гэдэг. Мөн эртний Грекчүүд эхэндээ хот улс хооронд зорчин явах язгууртан, ноёдод үйлчлэх "Проксени" хэмээх алба байгуулсан нь хожим худалдаа наймаа хөгжихөд чөлөөт иргэдэд үйлчилж арилжаа наймаа эрхлэхэд нь туслалцаа үзүүлдэг институт болон төлөвшсөн байна.

Хожим нь далайн тээвэр хөгжсөн газруудад өнөөгийн консулын албаны эх үүсвэр тавигдсан байна. Ийнхүү тусгаар улсууд өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ хөрш орныхоо эрх ашгийг хамгаалж, эргүүлээд өөрийн улсын нийтлэг болон иргэдийнхээ хувийн эрх ашгийг нөгөө улсаар хамгаалуулдаг буюу эрх зүйн туслалцаа харилцан үзүүлдэг жишиг анхлан тогтжээ.

Харин орчин үеийн зах зээлийн харилцааны үндэс суурь бүрэлдсэн XVII-XVIII зууны үеэс Европод гадаадын иргэдийн эрх зүйн байдлын талаарх хандлага үндсээрээ өөрчлөгдсөн байна. Анх цөөн тооны Европын хотуудад гадаад иргэн, үндэсний иргэдийн эрх зүйн байдал адил тэнцүү байхаар хуульчилж эхэлсэн юм. Ийнхүү хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх үзэл санаа бүрэлдэж хөгжсөөр 1948 онд НҮБ-ийн Ерөнхий Ассамблейгаас гаргасан Хүний эрхийн түгээмэл тунхаглалаар баталгаажсан байна. Тэгш эрхийн үзэл санаа олон улсын хамтын нийгэмлэгийн түвшинд хүлээн зөвшөөрөгдсөнөөр эрх зүйн салбар дахь улс гүрнүүдийн хамтын ажиллагаа идэвхжсэн юм.

Ингэснээр улс гүрнүүдийн тэгш, шударга хамтын ажиллагаа буюу түүнээс улбаалаад иргэн, хуулийн этгээд, оролцогч бүрийн тэгш, шударга оролцоог хангах тухай үзэл санаа олон улсын эрх зүйн хамтын ажиллагаа, харилцан туслалцааны үзэл санааны тулгуур хэм хэмжээ болон тогтоод байна.

Өөрөөр хэлбэл, хүн бүр өөрийн иргэний харьяалал, оршин сууж байгаа газраас үл шалтгаалан хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй бөгөөд тодорхой улсын шүүх эрх мэдлийн харьяалалд байгаа бүх этгээдэд тэгш үйлчлэх, гадаадын иргэдийн эрх зүйн байдлыг өөрийн харьяаллын иргэдтэй адил тодорхойлох ёстой гэсэн зарчим тогтжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван наймдугаар зүйлийн 18.1-д "Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно". 18.2-т "Монгол Улсын олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтлана" гэж, мөн 18.5-д "Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлалт тогтоож болно" гэж тус тус заасан байна. Үндсэн хуулийн эдгээр заалтууд нь Монгол Улс олон улсын эрх зүйн дэглэмд нэгдсэнийг илтгэж байна.

Монгол Улс анх Бүгд Найрамдах Унгар Улстай 1968 онд "Иргэн, гэр бүл болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ" байгуулж байсан ба үүнээс хойш хуучнаар социалист орон гэгдэж байсан 10 гаруй орнуудтай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг байгуулсан.

Энэ үед эрх зүйн туслалцааны асуудлыг багцаар нь буюу иргэний, гэр бүлийн, хөдөлмөрийн, эрүүгийн хэргийн асуудлуудыг нэгтгэн нэг гэрээнд багтааж зохицуулалтыг хийдэг байжээ. Тухайн үеийн социалист системийн

орнууд нэгэн загвар гэрээгээр ихэнхдээ эрх зүйн туслалцааны асуудлыг зохицуулдаг байсантай холбоотой юм. Тухайлбал, БНУУ-тай байгуулсан 1968 оны гэрээний бүтцийг авч үзвэл:

Тус гэрээ нь үндсэн 3 хэсэгтэй бөгөөд 1 дүгээр хэсэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх үндсэн зарчим, харилцах журам, хязгаар, даалгавар дахь баримт бичгийн бүрдүүлбэр зэрэг эрх зүйн туслалцааны үндсэн асуудлуудыг зохицуулсан байдаг бол 2 дугаар хэсэгт иргэний болон гэр бүлийн хэргийн талаархи эрх зүйн туслалцаа үзүүлэх хүрээ, шүүхийн бичиг баримтын бүрдүүлбэрийн талаар, харин 3 дугаар хэсэгт эрүүгийн хэргийн талаар болон эрүүгийн хариуцлагад татах зорилгоор гэмт этгээдийг шилжүүлэх асуудлыг зохицуулсан байдаг.

1990 оноос хойш Монгол Улсын нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт гарсан өөрчлөлтүүд, шинэ нөхцөл байдалд нийцүүлэн эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний агуулгыг дахин хянах, 1990-ээд оноос өмнө байгуулсан гэрээний зарим зүйл заалтыг өөрчлөн тодруулах шаардлага гарсан.

Иймээс 1988 онд ЗСБНХУ-тай байгуулсан эрх зүйн туслалцааны гэрээг шинэчлэн найруулж "Монгол Улс, ОХУ-ын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай Гэрээ"-г 1999 онд, 1971 онд БНПУ-тай байгуулсан "Иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай" гэрээг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилж 1998 онд "Монгол Улс, БНПУ-ын хооронд иргэн, гэр бүл, хөдөлмөр, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх болон эрх зүйн харилцааны тухай Гэрээ" нэртэйгээр тус тус байгуулсан байна.

Түүнчлэн гадаад улс орнуудын нийтлэг хандлагыг харгалзан зарим улстай эрх зүйн туслалцааны гэрээг салбар эрх зүй тус бүр байгуулж байгаа. Тухайлбал Монгол Улс нь БНСУ-тай "Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай гэрээ" /1999 онд/, "Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ" /1999 онд/, "Ялтан шилжүүлэх тухай гэрээ"-үүдийг /2007 онд/, "Иргэний болон худалдааны хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ" /2008 онд/ тус тус байгуулаад байна.

Одоогийн байдлаар Монгол Улс нь 20 оронтой эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ /иргэний, гэр бүлийн, хөдөлмөрийн, худалдааны, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай/, 4 оронтой гэмт этгээдийг шилжүүлэх өгөх тухай гэрээ, 2 улстай ялтан шилжүүлэх тухай гэрээтэй байна.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорих байгууллагаас суллагдсаны дараа хяналт тавих, тэдгээр хүмүүстэй харьцах үйл ажиллагааг зохицуулсан, өөрөөр

хэлбэл пробацийн үйл ажиллагаатай хамаатуулах заалт Олон улсын баримт бичигт дараах байдлаар туссан байна.

Нэг. Нэгдсэн Үндэсний байгууллагын Ерөнхий ассемблейн 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217A/III тоот тогтоолоор батлагдсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-д:

9 дүгээр зүйл.

Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй.

10 дугаар зүйл.

Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.

11 дүгээр зүйл.

1. Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй.

2. Тухайн үед үндэсний буюу олон улсын хуулийн дагуу гэмт хэрэгт эс тооцож байсан аливаа үйлдэл буюу эс үйлдлийг үндэслэж, хэнийг ч гэмт хэрэгт яллан шийтгэх ёсгүй. Түүнчлэн гэмт хэрэг гарсан тэр үед ногдуулж болох байснаас илүү хүнд ял тохоож болохгүй.

12 дугаар зүйл.

Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.

Хоёр. Нэгдсэн Үндэсний байгууллагын Ерөнхий ассемблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200A/XXI тоот тогтоолоор батлагдсан “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон пактад:

9 дүгээр зүйл.

1. Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй.

2. Баривчлагдсан шалтгааныг хүн бүрт баривчлах үед нь мэдэгдэхийн зэрэгцээ буруутгаж байгаа аливаа үндэслэлийг даруй мэдэгдэнэ.

3. Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан

тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй. Шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй бөгөөд шүүх хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны аль ч шатанд байлцах, шаардлагатай тохиолдолд, шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд байх баталгаа гаргаж өгсөн бол этгээдийг суллаж болно.

4. Баривчлагдаж эсхүл цагдан хоригдож эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр ийнхүү хорьж саатуулсан нь хууль ёсны эсэхийг шүүхээр даруй тогтоолгох, хууль бусаар хорьсон бол суллуулах шийдвэр гаргуулах эрхтэй.

5. Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.

10 дугаар зүйл.

1. Эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнтэй хүнлэг харьцаж, угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэнэ.

2. (а) онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд буруутнаар татагдсан этгээдийг ял шийтгүүлсэн этгээдээс тусгаарлаж, шийтгэгдээгүй этгээдийн эрх зүйн байдалд тохирсон жич дэглэмд байлгана.

(b) буруутнаар татагдсан насанд хүрээгүй этгээдийг насанд хүрсэн этгээдээс тусгаарлаж хэргийг нь аль болох богино хугацаанд шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

3. Хорих байгууллагын дэглэмийн нэн чухал зорилго нь хоригдлыг засан хүмүүжүүлж, нийгмийн хэвийн гишүүн болгох явдал байна. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүйчүүдийг насанд хүрэгсдээс тусгаарлаж, тэдний нас, эрх зүйн байдалд нийцсэн дэглэмд байлгана.

Гурав. НҮБ-ын Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэмд:

1. Үндсэн зарчим

1.1. Энэ үлгэрчилсэн дүрэм нь хорихоос өөр төрлийн арга хэмжээг ашиглахад тус дөхөм үзүүлэх үндсэн зарчмуудын эмхтгэл, түүнчлэн хорихоос өөр төрлийн ял хэрэглэж байгаа этгээдийн хувьд наад захын баталгааг агуулна.

1.2. Дүрэм нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэх, ялангуяа эрх зүйн зөрчил үйлдэгчидэд хандахад олон нийтийн илүү идэвхтэй оролцоог хангах, түүнчлэн эрхийн зөрчил гаргагчид нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх зорилгыг агуулна.

1.3. Дүрэм нь тухайн орны нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын байдал, түүнчлэн түүний эрүүгийн байцаан шийтгэх системийн бодлого зорилтыг харгалзан хэрэглэгдэнэ.

1.4. Гишүүн орнууд дүрмийг хэрэглэх явцдаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн аюулгүй байдлын тухайд нийгмийн сонирхол, хохирогчийн эрх, тухайн эрхийн зөрчил гаргагчийн эрхийн хооронд зүй зохистой харьцааг хангахад эрмэлзэнэ.

1.5. Гишүүн орнууд нь хорих ялыг хэрэглэх явдлыг багасгах замаар бусад боломжийг хангах, эрхийн зөрчил гаргагчийг нийгэмд хэвийн амьдралд эргэж орох хэрэгцээ, нийгмийн шударга ёсны шаардлага, хүний эрхийг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан эрүүгийн байцаан шийтгэх салбар дахь бодлогыг оновчтой болгох зорилгоор өөрийн эрхийн системийн хүрээнд хорихоос өөр төрлийн арга хэмжээг боловсруулна.

2. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх хүрээ

2.1. Энэ дүрмийн хамаарах заалтууд нь мөрдөн байцаалтанд шүүхийн хэлэлцүүлэг болон шүүхийн шийдвэр гүйцэтгэл зэрэг байцаан шийтгэх эрүүгийн л шатны бүх этгээдүүдэд хэрэглэгдэнэ. Энэ дүрмийн зорилгоор тэдгээр этгээдүүд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэн байхаас үл хамааран "эрхийн зөрчил гаргаж" гэж нэрлэнэ.

2.2. Дүрэм нь шашин шүтлэг, арьсны өнгө, нас, хүйс, хэл улстөрийн болон бусад үзэл, нийгмийн гарал үүсэл, эд хөрөнгийн байдал төрсөн газар зэргээр нь ялгаварлан гадуурхахгүйгээр хэрэглэгдэнэ.

2.3. Үндэслэлгүйгээр хорих ял хэрэглэх явдлыг гаргахгүй байх, эрхийн зөрчлийн хүнд хөнгөний түвшин, зөрчил гаргагчийн хувийн байдал нийгмийн хамгаалалтын сонирхолтой хамаарч илүү уян хатан байдлыг хангах зорилгоор үгийн байцаан шийтгэх систем нь шүүхийн өмнөхөөс эхлээд шүүхийн дараах шатанд хорихоос өөр төрлийн арга хэмжээг өргөн сонгох боломжийг тусгасан байх ёстой. Хорихоос өөр төрлийн арга хэмжээний хэлбэр болон тоо нь шийтгэлийг дахин хэрэглэх боломжтой байхаар тодорхойлогдсон байх ёстой.

2.4. Хорихоос өөр төрлийн шинэ арга хэмжээг хэрэгжүүлснийг хөхөөн дэмжих тэдгээрийг хэрэглэж байгаа практикийг нарийн хянан байнга дүгнэж байх ёстой.

2.5. Хууль болон эрхийн баталгаануудаас хамаарч шүүхийн болон албан ёсны хэлэлцүүлэг хийхгүйгээр зөрчил гаргагчид олон нийтийн хүчээр арга хэмжээ оногдуулах боломжийг анхаарвал зохино.

2.6. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг хамгийн бага оролцооны зарчимтай зохицуулан хэрэглэх ёстой.

2.7. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх явдал нь ялыг хүндрүүлэн өөрчлөх буюу дахин хэлэлцэхгүй байх замаар явах ёстой. Гэхдээ энэ чиглэлд тавигдаж буй хүч чармайлтанд саад болох, удаашруулах ёсгүй.

3. Эрхийн баталгаа:

3.1. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх тодорхойлох, гаргах нь хуулиар тогтоогдоно.

3.2. Хорихоос өөр төрлийн арга хэмжээний сонголт нь зөрчлийн хүнд хөнгөний түвшин, шинж чанар, зөрчил гаргагчийн хувийн байдал түүнчлэн хохирогчийн эрх, шийтгэлийн зорилгод нийцэн тогтоогдсон шалгууруудын үнэлгээн дээр үндэслэгдэнэ.

3.3. Шүүхийн болон бусад хараат бус бүрэн эрхт байгууллага нь зөвхөн хуульд нийцүүлэн, бүрэн тайлагнах явдлыг хангах замаар шүүхийн бүх шатанд өөрийнхөө үнэмлэхүй эрхийг хэрэгжүүлнэ.

3.4. Зөрчил гаргагчид ямар нэгэн үүрэг хүлээлгэдэг арга хэмжээнүүд нь албан ёсны мөрдөн байцаах ажиллагаа болон шүүхийн өмнөх шатанд хэрэглэгдэх ба зөрчил гаргагчаас зөвшөөрөл авах ёстой.

3.5. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг оноох шийдвэр нь зөрчил гаргагчийн өргөдлөөр шүүхийн болон бусад хараат бус бүрэн эрхт байгууллагаар хянагдана.

3.6. Зөрчил гаргагч нь хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх явцад түүнийг болон түүний хувийн эрхийг хөндсөн асуудлаар шүүхийн болон бусад хараат бус байгууллагад хүсэлт тавих, гомдол гаргах эрхтэй.

3.7. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийг мөрдөөгүйтэй холбоотой аливаа гомдлыг хангах, хэрэв боломжтой бол хамгаалах зохих механизм хангагдвал зохино.

3.8. Хорихоос өөр төрлийн арга хэмжээ нь зөрчил гаргагч дээр эмнэлгийн болон сэтгэл мэдрэлийн туршилт явуулах түүнд бие сэтгэл санааны гэмтэл учруулахыг хориглоно.

3.9. Бүх шатанд хорихоос өөр төрлийн арга хэмжээ авагдсан зөрчил гаргагчийн хүнийх нь нэр төрийг хүндэтгэн хангана.

3.10. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх явцад зөрчил гаргагчийн эрх нь анхны шийдвэр гаргасан бүрэн эрхт байгууллагын зөвшөөрснөөр илүү хэмжээгээр хязгаарлагдахгүй.

3.11. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх явцад зөрчил гаргагчийн гэр бүлийн болон зөрчил гаргагчийн хувийн амьдралын эрхийг хүндэтгэнэ. Таслах ажилд онцгой арга хэмжээ болон хэрэглэгдэнэ.

3.12. Зөрчил гаргагчийн хавтаст хэрэг нь 3 дахь этгээдэд хаалттай нууцаар хөтлөгдөнө. Зөрчил гаргагчийн хавтаст хэрэгтэй хэрэг хэлэлцэж байгаа болон бусад эрх бүхий этгээд л танилцана.

4. Тайлбар:

4.1. Эдгээр дүрэмд байгаа аль ч заалт хоригдож байгаа хүмүүстэй харьцах наад захын жишиг дүрэм, НҮБ-ын насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм /Бээжингийн дүрмүүд/, аливаа хэлбэрээр хоригдсон буюу саатуулагдсан хүмүүсийг

хамгаалах зарчмуудын цогц болон эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хандах болон тэдний хүний үндсэн эрхийг нь хамгаалахтай холбоотой олон улсын хамтын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрсөн бусад баримт бичиг, хэм хэмжээнүүдийг хэрэглэх явдлыг зогсоох байдлаар тайлбарлагдах ёсгүй.

II. Шүүхийн өмнөх шат

5. Шүүхийн өмнөх ажиллагааны ерөнхий шаардлага

5.1. Боломжтой бөгөөд эрхийн системтэй зохицож байгаа тохиолдолд цагдаа, яллагчийн алба болон эрүүгийн хэргийг шалгадаг бусад байгууллагууд хэрэв нийгмийг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эсхүл хуульт ёс, хохирогчийн эрхийг хүндэтгэх явдлыг хөгжүүлэн дэмжихэд заавал эрүү үүсгэх шаардлагагүй гэж үзвэл эрх зүйн зөрчил гаргасан этгээдийг хариуцлагаас чөлөөлөх эрхээр хангагдаж болно.

Хариуцлагаас чөлөөлөх болон процесс ажиллагаа явуулах шаардлагатай эсэхийг тодорхойлох шийдвэр гаргах зорилгоор эрхийн систем бүр тогтоогдсон шалгууруудыг боловсруулах ёстой. Яллагч боломжтой гэж үзвэл хөнгөн хэрэгт хорихоос өөр төрлийн хөнгөн арга хэмжээ оногдуулж болно.

6. Шүүхийн өмнөх шатанд хорьж саатуулахаас зайлсхийх

6.1. Тодорхой хэргийг мөрдөн шалгах хийгээд нийгэм, хохирогчийг хамгаалах зорилгоор шүүхийн өмнөх шатанд хорьж саатуулах явдлыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны онцгой арга хэмжээ болгож хэрэглэх ёстой.

6.2. Шүүхийн өмнөх шатанд хорьж саатуулахыг орлох бусад арга хэмжээг боломжийн хирээр аль болох эхэлж хэрэглэнэ. Шүүхийн хэлэлцүүлгээс өмнө хорьж саатуулах арга хэмжээ нь 5.1.-д заасан зорилтыг биелүүлэхэд шаардагдах хэмжээнээс хэтрэх ёсгүй бөгөөд хүний нэр төрийг нь хүндэтгэж энэрэнгүй байдлаар хэрэглэгдэнэ.

6.3. Эрх зүйн зөрчил гаргагч шүүхийн өмнөх шатанд хоригдож саатуулагдсан тохиоддолд шүүх болон бусад хараат бус эрх бүхий байгууллагад давж заалдах эрхтэй.

III. Шүүхийн шат ба тогтоол гаргах

7. Нийгмийн судалгааны тухай илтгэл

7.1. Хэрэв нийгмийн судалгааны тухай илтгэл хийх боломж байвал шүүхийн байгууллага нь эрх мэдэл бүхий албан тушаалтан байгууллагаар илтгэл бэлтгүүлэн ашиглаж болно. Илтгэл нь эрх зүйн зөрчил гаргагчийн болон зөрчлийн шинж байдлын тухай нийгмийн мэдээллийг агуулсан байх ёстой. Түүнчлэн илтгэл нь тогтоол гаргах журамд хамаарах зөвлөмж,

мэдээллийг агуулсан байж болно. Илтгэл нь бодит үнэн материалд үндэслэн зохиогдох ба саналууд тодорхой илэрхийлэгдсэн байна.

8. Шийтгэх тогтоол гаргах үндэслэл

8.1. Хорихоос өөр төрлийн арга хэмжээнүүдийг сонгох бололцоотой нөхцөлд шүүхийн байгууллага шийдвэр гаргахдаа эрх зүйн зөрчил үйлдэгчийг засан хүмүүжүүлэх шаардлага, нийгмийн болон хохирогчийн ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг анхааралдаа авбал зохих бөгөөд хохирогч этгээдтэй шаардлагатай тохиолдолд зөвлөлдөж байгууштай.

8.2. Шийтгэх тогтоол гаргаж байгаа байгууллагууд хэргийг дараах байдлаар шийдвэрлэж болно:

a/ Сануулах, зэмлэх, буруушаах зэрэг аман арга хэмжээ;

b/ Хариуцлагаас тэнсэн чөлөөлөх;

c/ Иргэний эрхийг нь хасах;

d/ Нэг удаагийн болон өдрийн торгуулиуд гэх мэт мөнгөн шийтгэлүүд, эдийн засгийн арга хэмжээнүүд;

e/ Хөрөнгө хураах болон эд хөрөнгө өмчлөх эрхийг нь хасах тогтоол;

f/ Хохирогчид эд хөрөнгийг нь буцааж өгөх болон хохирол төлөх тогтоол;

g/ Тэнсэн шийтгэл болон шийтгэлийг хойшлуулах;

h/ Хорихоос тэнсэн суллах болон шүүхийн хяналт;

i/ Нийгмийн тусгай хөдөлмөр хийлгэх тухай тогтоол;

j/ Тодорхой газар нутагт заавал ирж бүртгүүлж байх болзол тогтоох;

k/ Гэрийн хорио;

l/ Хорихтой холбоогүй бусад арга хэмжээнүүд,

m/ Дээр дурдсан арга хэмжээнүүдийг хослуулан хэрэглэх,

IV. Шийтгэх тогтоол гарсны дараах шат

9. Тогтоол гарсны дараах сонголт

9.1. Эрх бүхий байгууллага эрх зүйн зөрчил үйлдсэн этгээдүүд нийгэмд хэвийн амьдралд түргэн эргэж ороход нь туслах, хорихоос татгалзах түргэн эргэж ороход нь туслах, хорихоос татгалзах зорилгоор тогтоол гарсны дараа хорихоос өөр төрлийн арга хэмжээг сонгох өргөн боломжтой байна.

9.2. Шийтгэх тогтоол гарсны дараа дараах арга хэмжээг авч болно.

a/ Чөлөө олгох ба засан хүмүүжүүлэх хагас шоронгийн байгууллагад байлгах;

b/ Ажил сургалттай нь холбогдуулж чөлөөлөх;

c/ Хугацааг богиносгох;

d/ Уучлал үзүүлэх.

9.3. Тогтоол гарсны дараа хэрэглэх арга хэмжээний тухай шийдвэр нь уучлалаас бусад тохиодолд эрх зүйн зөрчил үйлдэгчийн хүсэлтээр шүүхээр болон эрх бүхий хараат бус байгууллагаар хянан хэлэлцэгдэнэ.

9.4. Хорихтой холбоогүй арга хэмжээтэй холбоотой хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд хорихоос чөлөөлөх аливаа хэлбэр нь аль болох түргэн хэлэлцэгдэнэ.

V. Хорихтой холбоогүй арга хэмжээг биелүүлэх нь

10. Хяналт

10.1. Дахин хэрэг зөрчил үйлдэх явдлыг багасгах, архаг болохоос сэргийлэх, түүнийг нийгмийн амьдралд түргэн оруулахад туслах замаар түүнийг дахин хэрэгт орооцолдох магадлалыг бууруулахад хяналтын зорилго оршино.

10.2. Хэрэв хорихтой холбоогүй аль нэг арга хэмжээ нь хяналттай байна гэвэл тэр нь хуулиар тодорхойлогдсон тодорхой нөхцлийн доор эрх бүхий байгууллагаар гүйцэтгэгдэнэ.

10.3. Хорихтой холбоогүй тодорхой арга хэмжээний тухайд зөрчил гаргагчид туслахад чиглэсэн хяналтын болон харьцааны илүү үр ашигтай хэлбэрүүдийг тохиолдол бүрт тодорхойлж байвал зохино. Хяналт болон харьцаа хандпагыг үе үе хянан хэлэлцэж шаардлагын хэмжээгээр засч залруулах хэрэгтэй.

10.4. Эрх зүйн зөрчил гаргагчдад хэрэгцээтэй үед нь сэтгэл санааны, нийгмийн эд хөрөнгийн туслалцаа үзүүлэх ёстой ба нийгэмд хэвийн амьдралд эргэж орохыг -ь хөнгөвчлөх нийгэмтэй харьцаа холбоогоо бэхжүүлэхэд нь боломж олгох ёстой.

11. Үйлчлэх хугацаа

11.1. Хорихоос өөр төрлийн арга хэмжээний үйлчлэх хугацаа хуульд зааснаар эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанаас илүү байх ёсгүй.

11.2. Хэрэв үр дүнгээ өгч байвал авсан арга хэмжээг хугацаанаас нь өмнө югсоож болно.

12. Болзол, нөхцөл

12.1. Хэрэв эрх бүхий байгууллага нь зөрчил гаргагчид болзол тогтоосон бол тэр нь хохирогчийн болон зөрчил гаргагчийн эрх ашиг, нийгмийн сонирхлыг тооцох ёстой.

12.2. Биелүүлбэл зохих болзлууд нь бодитой, тодорхой бололцооны хирээр аль болох цөөн байх ёстой бөгөөд эрх зүйн зөрчил үйлдсэн этгээд гэмт хэргийн зам руу буцаж орох магадлалыг багасгах ба түүний засран хүмүүжих нийгэмдээ нэгдэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байхын сацуу хохирогч этгээдийн эрэлт хэрэгцээг бодолцсон байвал зохино.

12.3. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх эхний үе шатанд эрх зүйн зөрчил үйлдэгч этгээдэд түүний эрх үүргийг оролцуулан тухайн арга хэмжээг хэрэглэх явдлыг зохицуулах болзлын талаар амаар болон бичгээр ойлгуулж тайлбарлана.

12.4. Болзол нь эрх зүйн зөрчил нь үйлдэгчийн олж буй үр дүнгээс хамаарч хуульд зааснаар эрх бүхий байгууллагаар өөрчлөгдөж болно.

13. Харьцах ажиллагаа

13.1. Ганцаарчилсан ажил, хамтарсан арга хэмжээ, эрх зүйн зөрчил үйлдсэн олон янз ангиллын этгээдүүдийн оршин суугаа газраар нь хэрэгжүүлэх хөтөлбөрүүд ба тусгайлсан харьцаа гэх зэрэг төрөл брийн аргыг эрх зүйн зөрчил үйлдэгчийн эрэлт хэрэгцээнд илүү тохируулахын тулд боломжтой хэргүүд дээр хорихоос өөр төрлийн тухайн арга хэмжээнд тааруулан боловсруулбал зохино.

13.2. Зохих бэлтгэлтэй, ажлын туршлагатай мэргэжлийн ажилтнаар уг харьцаа гуйцэтгэгдэнэ.

14. Болзлыг зөрчих ба сахилга бат

14.1. Эрх зүйн зөрчил үйлдсэн этгээд мөрдвөл зохих болзлоо зөрчсөн тохиолдолд хорихоос өөр төрлийн арга хэмжээг өөрчлөх буюу хүчингүй болгож болно.

14.2. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг өөрчлөх буюу хүчингүй болгох шийдвэрийг эрх зүйн зөрчил үйлдэгч болон хяналт тавьж байсан ажилтнаас гаргаж өгсөн баримт сэлтийг сайтар судалсны үндсэн дээр эрх бүхий байгууллага гаргана.

14.3. Хорихоос өөр төрлийн арга хэмжээ нь амжилтгүй болбол энэ нь хорих ял хэрэглэхэд шууд хүргэхгүй.

14.4. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг солих буюу өөрчлөх тохиолдолд эрх бүхий байгууллага нь өөр төрлийн хорихоос бусад зохих арга хэмжээ тогтоохыг эрмэлзэнэ. Хорихтой холбоогүй өөр төрлийн арга хэмжээ олдоогүй тохиолдолд хорих арга хэмжээг хэрэглэж болно.

14.5. Болзлыг зөрчсөн тохиолдолд эрх зүйн зөрчил үйлдэгчийг баривчлах болон хяналтын дор хорьж саатуулах эх мэдлийг хуулиар тогтоох ёстой.

14.6. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг өөрчилсөн хүчингүй болгосон тохиолдолд эрх зүйн зөрчил үйлдэгч шүүхийн болон эрх бүхий хараат бус бусад байгууллагад гомдол гаргах эрхтэй.

VI. Боловсон хүчин

15. Боловсон хүчнийг ажилд авах нь

15.1. Боловсон хүчнийг ажилд авахдаа шашин шүтлэг арьсны өнгө, хүйс, нас, хэл, улс төрийн болон бусад үзэл, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, эд хөрөнгийн байдал төрсөн газар нутаг болон бусад байдлуудаар ялгаварлан гадуурхах ёсгүй. Боловсон хүчнийг авч ажиллуулах бодлого нь үндэсний

зөвшилцөх бодлого ба хяналтанд байвал зохих эрх зүйн зөрчил үйлдэгсдийн төрөл ялгааг тооцож үзсэн байвал зохино.

15.2. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий этгээд нь амьдралын туршлагатай боломжийн хүрээр мэргэжлийн зохих бэлтгэлтэй, хувийн шинж чанараар тохирох хүн байвал зохино. Эдгээр шаардлагууд нь нарийн тодорхойлогдсон байх ёстой.

15.3. Мэргэшсэн боловсон хүчнийг тогтоон барихын тулд ажлын зохих нөхцөлд нь таарсан цалин хөлс, хөнгөлөлтөөр хангаж өгөх ба мэргэжлээрээ өсөх, албан тушаал дэвших өргөн боломжийг олгох ёстой.

16. Боловсон хүчнийг бэлтгэх

16.1. Мэргэжлийн бэлтгэлийн зорилго нь нийгмийг хамгаалах, эрх зүйн зөрчил гаргагчийн эрхийг хангах, түүнийг засан хүмүүжүүлэх үүрэг хариуцлагыг боловсон хүчинд ойлгуулахад оршино. Түүнчлэн зохих байгууллагуудтай хамтран ажиллах шаардлага болон тэдгээрийн хувьд зохицуулалт хийх талаар сургалтаар ойлголт өгвөл зохино.

16.2. Боловсон хүчин үүргээ гүйцэтгэж эхлэхээсээ өмнө хорихоос бусад төрлийн арга хэмжээний онцлог, хяналтын зорилго болон хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх олон янзын хувилбарын талаар зохих сургалт хийсэн байвал зохино.

16.3. Ажилд орсныхоо дараа боловсон хүчин нь мэргэжил дээшлүүлэх курс, үндсэн ажлаас хөндийрөхгүйгээр оролцох сургалтанд хамрагдаж өөрийн мэдлэг, мэргэжлийн арга барилаа дээшлүүлж төгөлдөржүүлнэ. Үүний тулд зайлшгүй нөхцөлөөр хангагдана.

VII. Сайн дурынхан ба олон нийтийн боломж

17. Олон нийтийн оролцоо

17.1. Олон нийтийн оролцоо нь хорихоос өөр арга хэмжээ авагдсан эрх зүйн зөрчил гаргагч, түүний гэр бүл, нийгмийн хоорондох холбоог бэхжүүлэх чухал хүчин зүйл ба гол нөөц бололцоо мөн учир олон нийтийн оролцоог урамшуулбал зохино. Энэ нь эрүүгийн байцаан шийтгэх байгууллагын хүчин чармайлтыг сэлбэх ёстой.

17.2. Олон нийтийн оролцоог нийгмийн сонирхлыг хамгаалах хэрэгт нийгмийн ишүүдээс оруулж байгаа хувь нэмэр гэж үзвэл зохино.

18. Нийгмийн ухамсар ба хамтын ажиллагаа

18.1. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг дэмжихэд нь засгийн газрын байгууллагууд, хувийн сектор болон иргэдийн хөхүүлэн дэмжвэл зохино.

18.2. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэг хэрэгт олон нийтийн оролцоо зайлшгүй чухал гэдгийг ухамсарлуулах зорилгоор онол практикийн бага хурал, семинар, симпозиум бусад арга хэмжээг байнга зохион байгуулж байгууштай.

18.3. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг өргөн хэрэглэх болон эрх зүйн зөрчил үйлдэгсдийг нийгэмд буцаж ороход чиглэгдсэн үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн игэдийн ажил хэрэгч үзэл хандлага бий болгохын тулд олон нийтийн мэдээллийн бүх төрлийн хэрэгслийг ашиглах ёстой.

18.4. Олон нийтийн байгууллага нь хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг нь олон нийтэд ойлгуулахын тулд бүх хүчээ төвлөрүүлэх ёстой.

19. Сайн дурынхан

19.1. Сайн дурынханыг сайтар сонгож тухайн ажил дахь сонирхол тэдний хүсэл эрмэлзлийг харгалзан ажилд авна. Тэд тодорхой үүрэг гүйцэтгэхийн тулд зохих ээлтгэл хийх ёстой ба эрх бүхий байгууллагад хандаж заавар, зөвлөмж, туслалцаа звах боломжоор хангагдсан байвал зохино.

19.2. Сайн дурынхан өөрийнхөө боломж, эрх зүйн зөрчил гаргатиин хэрэгцээнээс хамаарч тэдэнд зайлшгүй туслалцаа үзүүлж зөвлөгөө өгч, нийгэмтэй утга төгөлдөр харьцаа тогтооход нь эрх зүйн зөрчил үйлдэгчийг болон тэдний гэр бүлийг хөхүүлэн дэмжих учиртай.

19.3. Сайн дурынхан өөрийнхөө үүргийг биелүүлэх үеийн нийгмийн хариуцлагын болон бие эрхтэн нь гэмтэх, гэнэтийн ослын эсрэг даатгагдсан байх ёстой. Тэдэнд өөрсдийнхөө ажил үүргийг гүйцэтгэж байхад учирсан зөвшөөрөгдсөн зардал эргэж төлөгдөнө. Тэд нийгмийн тусын тулд хийж буй ажлынхаа төлөө нийгмийн зүгээс талархал хүлээнэ.

20. Судалгаа шинжилгээ, төлөвлөлт, бодлого боловсруулах ба дүгнэх нь

20.1. Төлөвлөлтийн ажлын чухал хэсэг гэдэг талаас нь эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хорихоос өөр төрлийн арга хэмжээ хэрэглэх талаар судалгаа шинжилгээ явуулахыг зохион байгуулах болон хөгжүүлэн дэмжихэд иргэд болон хувь хүн байгууллагыг хамруулах талаар хүчин чармайлт гаргавал зохино.

20.2. Үйлчлүүлэгчид практик ажилтнууд, нийгмийн зүтгэлтнүүд болон удирдах ажилтнуудын өмнө тулгарч буй асуудлуудыг тогтмол судлан шинжилж байх ёстой.

20.3. Эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хорихоос өөр төрлийн арга хэмжээ хэрэглэж байгаа талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийхийн тулд судалгаа шинжилгээ-мэдээллийн тогтолцоог эрүүгийн байцаан шийтгэх системийн дотор нь байгуулбал зохино.

21. Бодлого ба хөтөлбөр боловсруулах

21.1. Хорихоос өөр төрлийн арга хэмжээнүүдийн хөтөлбөр нь үндэсний хөгжлийн хүрээн дэх эрүүгийн байцаан шийтгэх системийн салшгүй элементийн шинж чанартайгаар төлөвлөгдөн хэрэгжиж байх ёстой.

21.2.Хорихоос өөр төрлийн арга хэмжээг илүү үр дүнтэйгээр хэрэглэх зорилгоор тогтмол дүгнэх нь зүйтэй.

21.3. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэж буй практик, үр дүн, түүний зорилгыг үнэлж дүгнэхийн тулд үечилсэн тойм хийж байх нь зүйтэй.

22. Холбогдох байгууллага ба арга хэмжээний холбоо харилцаа

22.1. Хорихоос бусад төрлийн арга хэмжээг хариуцан хэрэгжүүлдэг албад эрүүгийн байцаан шийтгэх системийн бусад салбар болон эрүүл мэнд, орон байр, боловсрол, ажил хөдөлмөр эрхэлэлт ба олон нийтийн мэдээллийн хэрэгсэл зэрэг салбар дахь засгийн газрын болон засгийн газрын ба засгийн газрын бус нийгмийн хөгжил халамжийн байгууллагуудын хооронд янз бүрийн түвшинд холбоо харилцаа тогтооход тулсах зохих тогтолцоог хөгжүүлбэл зохино.

23. Олон улсын хамтын ажиллагаа

23.1. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх салбарт шинжлэх ухааны хамтын ажиллагааг улс хооронд хөгжүүлэхэд хүчин чармайлт тавих ёстой. НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хандах хүрээлэнгүүдээр дамжуулах НҮБ-ын Ерөнхий нарын бичгийн дарга нарын газрын Нийгмийн хөгжил ба хүмүүнлэгийн төвийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгсдтэй харьцах салбартай нягт хамтран ажиллаж хорихоос бусад төрлийн арга хэмжээний талаар судалгаа шинжилгээ, сургалт болон мэдээлэл солилцоог гишүүн улсуудын дунд бэхжүүлбэл зохино.

23.2. Хорихоос өөр төрлийн арга хэмжээнүүдийг хэрэглэх хүрээг өргөсгөх тэдгээрийг тэнссэн болон тэнсэн суллагдсан эрх зүйн зөрчил үйлдэгсдэд тавих хяналтыг шилжүүлэх тухай үлгэрчилсэн гэрээний дагуу үндэсний хил хязгаар дамжуулан хэрэглэхийг хөхүүлэн дэмжих үүднээс хууль тогтоомжийн байдлыг харьцуулан судлах, зөвшилцөх ажлыг үргэлжлүүлж хийх нь зүйтэй³¹.

Дөрөв. Тэнсэн болон тэнсэн суллагдсан эрх зүйн зөрчил үйлдэгчдэд тавих хяналтыг шилжүүлэх тухай үлгэрчилсэн гэрээ³²-нд:

Аливаа улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй, хуулийн харъяалал үндэсний тусгаар тогтнолыг хүндэтгэх зарчмыг үндэслэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны салбарт улс орнуудын хоорондын харилцан туслалцах, хамтран ажиллах явдлыг цаашид бэхжүүлэхийг эрмэлзэн: энэ

³¹ Д.Баярсайхан.Олон Улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл.УБ.,2012он,159-167 дах тал

³² Ерөнхий Ассамблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 45/118 тоот тогтоолоор батлав.

хамтын ажиллагаа нь хохирогчийн эрх ашгийг хамгаалахын зэрэгцээ эрх зүйн зөрчил үйлдэгчийн нийгмийн хэвийн амьдралд буцаан оруулах хууль цаазын зорилгыг хангахад чиглэгдсэн байх хэрэгтэй гэж үзэн: тэнсэн болон тэнсэн суллагдсан эрх зүйн зөрчил үйлдсэн этгээдүүдэд тавих хяналтыг шилжүүлэх нь хорихоос өөр төрлийн ялын хэлбэрийг өргөн хэрэглэхэд дэм болно гэдгийг анхааран: хууль зөрчигчид тавих хяналтыг шилжүүлэх нь хорихоос өөр төрлийн ялын хэлбэрийг өргөн хэрэглэхэд дэм болно гэдгийг анхааран: хууль зөрчигчид тавих хяналтыг өөр оронд явуулахын оронд тухайн этгээдийн эх оронд нь шилжүүлвэл түүнийг нийгмийн хэвийн амьдралд түргэн эргэж ороход нь ашигтай нөхцөл байж болзошгүйг ухаарч тэнсэн болон тэнсэн суллагдагсад тавих хяналтыг өөрийн нь эх оронд явуулах боломжийг хангасан арга хэмжээнүүд нь эрх зүйн зөрчил үйлдэгчдийн нийгмийн хувьд хүмүүжих байдал, хорих ялаас бусад төрлийн ялын хувилбарыг ашиглах боломжийг өргөжүүлэхэд туслана гэдэгт итгэл тавин доорх зүйлүүдээр зөвшилцөв.

Нэгдүгээр зүйл. Хэрэглэх хүрээ

1. Энэ гэрээ нь ямар нэгэн этгээд шүүхийн эцсийн шийдвэрээр гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь нотлогдсон бөгөөд:

а/ Түүнд шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолгүйгээр туршилтын хугацаа тогтоосон бол,

б/ Хорих ял оноож тэнсэн харгалзсан бол,

с/ Ял оногдуулсаныг гүйцэтгэлгүй өөрчилсөн /амлалтаар чөлөөлсөн/ болон ял оноох үед, эсхүл дараа нь бүрнээр нь эсхүл хэсгийг нь түдгэлзүүлсэн бол,

2. Уг шийдвэрийг гаргасан улс /таслан шийдвэрлэсэн улс/ уг шийдвэрийн нөхцөлүүдийг биелүүлэхэд хяналт тавих үүрэг хүлээхийг /хяналтыг шилжүүлэх/ өөр улсаас /хяналтыг хэрэгжүүлэгч улс/ хүсч болно.

Хяналтыг шилжүүлэх тухай хүсэлтийг бичгээр гаргана. Хүсэлт, түүнд зэсаргасан баримт бичиг, мэдээ, мэдээлэл нь тухайн орнуудын хууль зүйн ямаар буюу гэрээлэгч талуудын нэр заасан бусад байгууллагаар дамжин: дипломат шугамаар шилжих болно.

Гуравдугаар зүйл. Бүрдүүлэх шаардлагатай баримт

1. Хяналт шилжүүлэх хүсэлтэд шийтгэгдсэн этгээд мөн болох гэрчлэх болохыг гэрчлэх болон хувь хүн иргэний харъяалал, оршин суух хаяг зэргийнх нь талаар бүх шаардлагатай мэдээлэл байх ёстой. Энэ хүсэлтийг гэрээний дүгээр зүйлд заасан ямар ч шүүхийн шийдвэрийн эх хувь болон хуулбар, уг шийдвэрийг эцэслэн тогтоосон гэдгийг батлах нотолгоо зэргийг хавсаргана.

2. Хяналтыг шилжүүлэх тухай хүсэлт, түүнд хавсаргасан баримтууд нь хүсэлтийг хүлээн авах улсын эх хэл дээр буюу тухайн улсад албаны хэл гэж хүлээн зөвшөөрөгдсөн өөр хэл дээр орчуулагдсан байх ёстой.

Дөрөвдүгээр зүйл. Бодит байдлыг нотлох, тогтоох

Талууд өөрөөр тохироогүй бол үндэсний хууль тогтоомжинд хамааруулахгүйгээр хяналтыг шилжүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт, нэмэлт мэдээллүүдийн үнэн бодит байдлыг тогтоох буюу гэрчлэх нэмэлт нотолгоо шаардлагагүй гэж үзнэ.

Жич: Зарим улсын хууль тогтоомж бусад улсаас шилжин ирсэн баримт шүүхэд шилжихээс өмнө тэдгээрийн жинхэнэ гэрчийг нь гэрчлэх нотолгоог шаарддаг. Иймд гэрчлүүлэхийг шаардаж болох юм.

Тавдугаар зүйл. Хүсэлтийн мөрөөр гаргах шийдвэр

Хяналтын хэрэгжүүлэгч хүсэлтийг хүлээн авсны дараа эрх бүхий байгууллага өөрийн хууль эрх зүйн хэм хэмжээнд уг хүсэлтийг аль болох бүрэн гүйцэлдүүлэх боломж байгаа эсэхийг судалж хяналт тавих тухай лавлагаатай холбогдуулан ажиллагаа явуулах эсэх талаар хариуг таслан шийдвэрлэсэн улсад нэн даруй мэдэгдэнэ.

Зургаадугаар зүйл. Эрүүгийн давхар хариуцлага

Хэрэв хянагч улсын нутаг дэвсгэр дээр уг үйлдэл үйлдэгдсэн бол эрх зүйн зөрчилд тооцогдох зөвхөн тийм тохиолдолд л хяналтыг шилжүүлэх хүсэлтийг хангаж болно.

Жич: Энэ үлгэрчилсэн гэрээний үндсэн дээр талууд тохиролцохдоо эрүүгийн давхар хариуцлагыг тооцохгүй байж болно.

Долдугаар зүйл. Татгалзах үндэс

Хэрвээ хяналтыг хэрэгжүүлэгч улс хүсэлтийг хүлээн авахаас татгалзвал татгалзах болсон шалтгаанаа таслан шийдвэрлэсэн улсад мэдэгдэнэ. Дараах нөхцөлд татгалзаж болзошгүй:

а/ Ял шийтгүүлсэн этгээд хяналтыг хэрэгжүүлэгч улсын байнгын оршин суугч биш бол,

б/ Уг үйлдэл нь ердийн эрүүгийн гэмт хэрэгт эрх зүйн зөрчилд тооцогдохгүй, харин цэргийн хуулиар гэмт хэрэгт тооцогддог бол,

с/ Уг эрх зүйн зөрчил нь татвар, албан татвар, гаалийн хураамж болон валютын гүйлгээтэй холбоотой бол,

д/ Уг эрх зүйн зөрчлийг хянагч улс төрийн шинжтэй гэж үзвэл,

е/ Өөрийн хууль тогтоомжийн дагуу хөөн хэлэлцэх хугацаа дууссаны учир хянагч улс хяналт тавих буюу ялыг гүйцэтгэх боломжгүй болсон бол,

жич: Энэ үлгэрчилсэн гэрээний үндсэн дээр талууд гэрээ байгуулахдаа жишээлбэл уг эрх зүйн зөрчлийн хүнд хөнгөний байдал, хүний үндсэн эрхийг хамгаала, эсхүл нийгмийн дэг журмын шаардлагын дагуу татгалзах бусад үндэслэлүүд болон нөхцлүүдийг энэ жагсаалтанд нэмж оруулахыг хүсч болно.

Наймдугаар зүйл. Шүүгдэгчийн эрх

Шүүгдэгч буюу шүүхээр шийдвэрлүүлэхээр хүлээж байгаа этгээд хяналтыг шилжүүлэх сонирхолтой байгаа хийгээд өөрт тавигдах ямарч нөхцлийг биелүүлэхэд бэлэн байгаа тухайгаа таслан шийдвэрлэсэн улсад илэрхийлж болно. Үүний нэгэн адилаар уг хүсэлтийг түүний хууль ёсны төлөөлөгч болон ойрын төрөл төрөгсөд гаргаж болно. Шаардлагатай тохиолдолд хэлэлцэгч улсууд энэ гэрээний дагуу ийм боломж байгаа талаар эрх зүйн зөрчил үйлдэгчид болон түүний ойрын төрөл төрөгсдөд нь мэдээлэх ёстой.

Есдүгээр зүйл. Хохирогчийн эрх

Хяналтыг шилжүүлснээр хохирогчийн эрх, тухайлбал хохирлоо арилгуулах болон бүрэн бүтэн байдлаа нөхөн сэргээлгэх эрхэнд сөргөөр нөлөөлөхгүй байх завдлыг таслан шийдвэрлэгч болон хяналтыг хэрэгжүүлэгч улсууд хангах ёстой. Хохирогч нас барсан тохиолдолд энэ заалт хохирогчоор тэжээлгүүлэгчдэд хамаарна.

Аравдугаар зүйл. Хяналтыг шилжүүлэх нь таслан шийдвэрлэгч улсад нөлөөлөх нь

Шийдвэрийн нөхцлүүдийг биелүүлэх хариуцлага хүлээхээр хяналтыг орегжүүлэгч улсын өгч буй зөвшөөрөл нь таслан шийдвэрлэгч улс ялыг гардан гүйцэтгэх бүрэн эрхийг хязгаарлана.

Арваннэгдүгээр зүйл. Хяналтыг шилжүүлэх нь хяналтыг хэрэгжүүлэгч улсад нөлөөлөх нь

1. Хэлэлцээрээр шилжсэн хяналтын ажиллагаа нь хяналт тавих ажиллагааг хэрэгжүүлэгч улсын хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгдэнэ. Тус улс цуцлах ээхийг бие дааж эдэлнэ. Хэрэв шаардлагатай гэж үзвэл таслан шийдвэрлэсэн улсын хууль тогтоомжид заасан хэм хэмжээнээс хэтрүүлэлгүйгээр хяналтыг хэрэгжүүлэгч, улс ялын шинж байдал ба үргэлжлэх хугацааны талаарх нөхцлүүд болон ялыг өөрийн хууль тогтоомжид нийцүүлж болно.

2. Хяналт тавих ажиллагааг гүйцэтгэгч улс тэнсэн харгалзах болон тэсэн суллах ялын хэмжээг өөрчлөх болбол таслан шийдвэрлэгч улсын хууль тогтоомжид заасан хэм хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр гүйцэтгэнэ.

Арван хоёрдугаар зүйл. Хэргийг магадлан үзэх, уучлал өршөөл үзүүлэх нь

1. Хэргийг магадлан үзэх эрхийг таслан шийдвэрлэгч улс эдлэнэ.
2. Гэрээслэгч талууд өөрийн улсуудын үндсэн өөрийн улсуудын үндсэн хууль, бусад хуулийн дагуу аль аль нь ялыг уучлах, өршөөх, хөнгөрүүлэх эрх эдэлнэ.

Арван гуравдугаар зүйл. Мэдээлэл солилцох

Хэрэгцээ гарсан үед гэрээлэгч талууд таслан шийдвэрлэх тогтоолд хяналт тавих ажлын гүйцэтгэлд гарч буй өөрчлөлт, яллагдагчийн байдлын ■галаар харилцан мэдээлэл солилцоно.

Хяналтын хугацаа дууссаны дараа хяналтыг хэрэгжүүлэгч улс хяналтанд байсан этгээдийн зан байдал, түүнд оногдуулсан ялыг хэрхэн эдэлсэн талаар эцсийн таилан итгэлийг таслан шийдвэрлэгч улсын хүссэнээр явуулна.

Арвандөрөвдүгээр зүйл. Зардал

Хэрэв таслан шийдвэрлэгч улс ба хяналтын ажиллагааг хэрэгжүүлэгч улс хоёулаа өөрөө хэлэлцэн тохироогүй бол хяналт тавих болон ялыг гүйцэтгэхтэй холбогдсон хяналтыг хэрэгжүүлэгч улсаас гарсан зардал нөхөн төлөгдөхгүй.

Арван тавдугаар зүйл. Төгсгөлийн заалт

/Баталсан, хүлээн зөвшөөрсөн эсхүл сайшаан дэмжсэн/ тухай баримтыг солилцсоноос хойшхи 30 хоногоос эхлэн уг гэрээ хүчин төгөлдөр болно. Уг гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш гарсан хүсэлтүүдийг гэрээ батлагдахаас өмнө гэмт үйлдэл үйлдэгдсэн эсэхийг харгалзахгүйгээр хүлээн авна.

Гэрээлэгч талын аль нэг нь гэрээ цуцлах саналыг гэрээлэгч нөгөө талдаа бичгээр илэрхийлж болно. Эсрэг тал гэрээ цуцлах саналыг хүлээн авснаас 6 сар өнгөрсний дараа гэрээ цуцалсанд тооцогдоно³³.

Тав. Нэгдсэн Үндэсний байгууллагын нэгдүгээр хуралдаанаар 1957 оны 7 дугаар сарын 31-ний 663 С/ХХ1Ү тогтоолоор батлагдсан "Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм"-д:

Суллагдсан хоригдолд тавих хяналт ба бусад хариуцлага

79. Хоригдол түүний гэр бүлийн хоорондын харьцааг бэхжүүлэхэд онцгой анхаарал тавина.

80. Хоригдлыг ял эдэлж эхлэх үеэс түүний ирээдүйн талаар бодох ёстой. Ийм учраа хоригдлыг ял дуусаад суллагдсаны дараа түүнийг нийгмийн амьдралд татан оролцуулах, гэр бүлийн ашиг сонирхлыг хамгаалах хувь

³³ Д.Баярсайхан.Олон Улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл.УБ.,2012он,167-171 дэх тал

хүмүүс албан газар нэгжтэй харилцаа холбоо тогтоон бэхжүүлэхэд туслалцаа үзүүлнэ.

81.1 Суллагдсан хоригдолд туслах Засгийн газрын болон бусад байгууллага нийгэмд байх ёстой. Эдгээр байгууллага нь тухайн хүмүүст орон сууц авах ажилд орох зэрэгт зайлшгүй шаардлагатай бичиг баримтыг олж авах, улирлын хувцсаар хангах, очих газрын тээврийн хөлс болон тодорхой хүрэлцэхүйц мөнгө олгоно.

2. Дээрх байгууллагын эрх бүхий төлөөлөгчид хорих ангид ирж хоригдолтой уулзаж түүний ирээдүйн амьдрал төлөвийн талаар зөвлөлдөж байвал зохино.

3. Эдгээр байгууллагын ажлын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд боломжийн хүрээнд үйл ажиллагаа зохицуулагдсан төвлөрсөн байвал зохино.

Зургаа. Нэгдсэн Үндэсний байгууллагын нэгдүгээр хуралдаанаар 1990 оны 12 дугаар сарын 14-ний 45-111 дүгээр тогтоолоор батлагдсан "Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд"-д

1. Хоригдлууд хорих-газар байгаагаас үүдэж гарсан шаардлагатай хязгаарлалтаас бусад Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тухайн улс оролцогч болсон тохиолдолд Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт, Иргэний болон улстөрийн эрхийн тухай олон улсын Пакт, энэ Пактын нэмэлт протокол зэрэгт заасан хүний эрх, эрх чөлөөг, түүнчлэн НҮБ-ын бусад пактад дурдсан эрх, эрх чөлөөг эдлэнэ.

2. Бүх хоригдол бие хүнийг бүх талаар хөгжүүлэхэд чиглэсэн соёл, боловсролын үйл ажиллагаанд оролцох эрхтэй.

3. Ял шийтгэлийн журмаар ганцаарчлан хорих явдлыг хүчингүй болгох буюу түүнийг хязгаарлах хүчин чармайлт гаргаж түүнийг хөхүүлэн дэмжиж байвал зохино.

4. Хоригдлуудад өөрийн орны хөдөлмөрийн талбарт эргэн ажиллахад нь хялбар байх, өөртөө болон гэр бүлдээ санхүүгийн тусламж үзүүлэх боломж элгөх цалин хөлстэй ажил хийх нөхцөл боломжийг бий болгох шаардлагатай.

5. Хоригдлууд эрх зүйн байдлаасаа үл шалтгаалан тухайн оронд байдаг эмнэлгийн тусламж авах ёстой.

6. Хорих ял эдэлсэн хүмүүс олон нийтийн болон нийгмийн оаигууллагуудын оролцоо тусламжтайгаар, хохирогчийн ашиг сонирхлыг хохироохгүйгээр аль болох зохистой байдлаар нийгмийн амьдралд эргэн орох таатай нөхцлийг бий болговол зохино гэжээ.

Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх болон нийгэмд амжилттай эргэн нэгтгэх нь эрүүгийн процессын тогтолцооны суурь зорилтын нэг юм. Хүний эрхийн талаарх олон улсын гэрээ конвенцуудад тухайлбал, ИБУТЭТОУП-д "Хорих байгууллагын дэглэмийн нэн чухал зорилго нь хоригдлыг засан хүмүүжүүлж,

нийгмийн хэвийн гишүүн болгох явдал байна. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүйчүүдийг насанд хүрэгсдээс тусгаарлаж, тэдний нас, эрх зүйн байдалд нийцсэн дэглэмд байлгана³⁴ гэжээ. Цаашилбал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон эрүүгийн процессын талаарх НҮБ-ын олонх стандарт, хэм хэмжээ нь гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэхэд дэмжин тусалснаар улс орон нийгмээ хамгаалж, цаашид үйлдэгдэх олон гэмт хэргээс урьдчилан сэргийлж чадах ач холбогдлыг чухалчлан тусгасан байдаг.

Тухайлбал, Хоригдлыг засан хүмүүжүүлэх НҮБ-ын наад захын жишиг дүрэм буюу Нелсон Манделагийн дүрэм (НМД)³⁵ нь хоригдлыг засан хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх хөтөлбөр бүхий хорих менежментийг хэрэгжүүлэх зарчмыг тусгаж, рецидивизмыг бууруулж, нийгмийн аюулгүй байдлыг хангах талаарх хамгийн сүүлийн төдийгүй өндөр ач холбогдол бүхий олон улсын стандарт баримт бичиг юм. Түүнчлэн НМД-д гэмт хэрэгтэнд хэрэгцээтэй байгаа боловсрол, мэргэжлийн сургалт, ажлын байр, бусад халамжийн үйлчилгээ, туслалцааг онцлоод тэдгээрийн талаар хорих ангийн удирдлага, бусад эрх бүхий байгууллагууд анхаарч ажиллан хоригдлыг нийгэмд эргэн нэгтгэх явдлыг бүх талаар дэмжих ёстои гэжээ³⁶.

НҮБ-аас гаргасан дараагийн нэг нийтлэг жишиг баримт бичиг бол Эмэгтэй хоригдлыг засан хүмүүжүүлэх ба эмэгтэй гэмт хэрэгтэнд хорихоос өөр төрлийн ял хэрэглэх тухай Бангкокийн дүрэм (2010) буюу эмэгтэй гэмт хэрэгтэнд тусгайлан хэрэглэх олон улсын хэм хэмжээ юм. Тус дүрэмд хорих ангийн удирдлага, пробацийн алба, нийгмийн халамжийн үйлчилгээ, орон нутгийн нийгэмлэг, ТББ-ууд хамтран ажиллаж, суллагдахын өмнө болон дараагаар нийгэмд эргэн нэгтгэх хөтөлбөрийг цогц байдлаар хэрэгжүүлж, эмэгтэй хоригдлын хүйсийн онцгой хэрэгцээг тусгайлан анхаарах ёстойг тусгажээ³⁷.

Хүүхдийн эрхийн конвенцод нэгдэн орсон улсуудын хувьд “хүүхдийг баривчлах, цагдан хорих, хорих зэрэг нь хамгийн сүүлийн арга хэмжээ байх ба хамгийн боломжит богино хугацаанд хэрэгжинэ” гээд хүүхдийг нийгэмд нэгтгэх явдлыг дэмжиж, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийг анхааралдаа авах талаар заажээ.³⁸

Түүнчлэн хүүхэд, өсвөр насны хүнд зориулсан олон улсын дараагийн жишиг баримт бичиг бол НҮБ-ын Насанд хүрээгүй хүний талаарх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны наад захын жишиг дүрэм³⁹ (Бээжингийн дүрэм) юм.

³⁴ ИБУТЭТОУП-ын 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

³⁵ Nelson Mandela Rules_E_Book

³⁶ НМД-ийн 4 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэг

³⁷ Бангкокийн дүрэм 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

³⁸ НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц. 37.40 дүгээр зүйл

³⁹ НҮБ-ын Ерөнхий Ассемблей 1985 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр баталсан.

Дүрэмд эрх чөлөө нь хязгаарлагдсан хүүхдийг сургах, засан хүмүүжүүлэх зорилт тавьж, тэднийг халамжлан хүмүүжүүлэх, боловсрол болон мэргэжлийн чадвар олгох зэргээр нийгэмд эргэн нэгтгэх үйл явцыг дэмжих тухай заасан. Мөн насанд хүрээгүй хүний зүгээс үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын удирдамж нь хүүхэд, өсвөр үеийг нийгэмшүүлэх ажиллагааны талаарх чухалчилсан заалтуудыг агуулсан байдаг.⁴¹

Насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх удирдамжид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга ажиллагааг өргөн хүрээнд авч үзэж, гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэхэд туслах болон бусад урьдчилан сэргийлэх механизмыг хэрэгжүүлснээр рецидив гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай өгүүлжээ.

Эцэст нь НҮБ-ын Хорихоос өөр төрлийн арга хэмжээний наад захын жишиг дүрэм (Токиогийн дүрэм)⁴⁰ нь гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх, эргэн нэгтгэх талаарх олон улсын баримт бичгийн нэг бөгөөд дээрх дүрэм, удирдамж зэрэг олон улсын нийтлэг зарчмуудын нэгэн адилаар гэмт этгээдийг нийгэмшүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдлыг дурдахаас гадна хорих ял болон түүнтэй дүйцэхүйц хүний эрх чөлөөг хязгаарласан арга хэмжээг хэрэглэх явдлыг бууруулах, олон ургалч хандлагаар хандахыг чухалчилснаараа онцлогтой юм. Түүнчлэн энэхүү дүрэмд гэмт хэрэгтнийг эргэн нэгтгэхийн ач холбогдол, түүнд олон нийтийн оролцоо ихээхэн чухал болохыг, ингэснээр иргэд нийгмээ хамгаалах, хувь нэмрээ оруулах том боломжтой болохыг нь онцолсон байдаг.⁴¹

⁴⁰ НҮБ-ын 8 дугаар Конгрессоор Хорихоос өөр төрлийн арга хэмжээний наад захын жишиг дүрэм(Токиогийн дүрэм) 1990 он.

⁴¹ Токиогийн дүрэм. 1.5, 17.2, 18.3, 18.4 дэх заалт

ХОЁР. ДЭЛХИЙН УЛС ОРНЫ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СИСТЕМ ДЭХ ПРОБАЦИЙН ТОГТОЛЦООНЫ ОНЦЛОГ

2.1. Дэлхийн улсуудын эрүүгийн эрх зүйн системийн шинж, ангилал

Эрх зүйн тогтолцоо бүхий дэлхийн улс, орон бүр өөрийн эрүүгийн хууль тогтоомжтой, түүндээ тохирсон шүүхийн практик, ялын бодлоготойн дээр нийгэм, үндэсний ёс заншил, түүхэн хөгжил, онцлогийг тусгасан байдгийг харж болно.

Эрүүгийн эрх зүйн систем нь дэлхий дахины эрх зүйн системийн орон зайд томоохон байрыг эзлэх бөгөөд харьцуулсан эрх зүй судлалын нийтлэг арга зүйд үндэслэсэн шалгуурыг харгалзахаас гадна эрүүгийн эрх зүйч-эрдэмтдийн дэвшүүлж буй типологичиллын үзэл баримтлалыг мөн адил анхаарч тусгах шаардлагатай байдаг.

Эдүгээ сонгодог компаративист хандлагын үндэслэгчдийн нэг Р.Давидын (Франц) онолыг дэмжигчдийн (Ю.А.Тихомиров, А.Х.Саидов, АВ.Наумов, О.Н.Ведерников, Ж.Спиноз (Франц), Ж.Флетчер (АНУ), Расса (Франц) зэрэгцээ либерал кампаративист үзлийн шинэ урсгалыг бий болгохыг эрмэлзсэн зарим судлаачид өөрсдийн онол, номлолыг тайлбарлан сурталчлах болжээ.

Эрх зүйн тогтолцоо, соёл болон Иргэн, Үндсэн хууль, Төр, захиргааны эрх зүйн салбарын хүрээнд ангилж ирсэн системийн хэв, маяг, бүлийн шалгуур нь зарим талаар эрүүгийн эрх зүйн хувьд тэр бүр нийцэхгүй харин өөрөөр авч үзэх ёстой гэж үздэг судлаачид бий.

Оросын эрдэмтэн А.А.Малиновский эрүүгийн эрх зүйн нөлөөлөгч байр суурь, чиг үүргийн онцлог шинжээр нь хүнлэг ёсны эрүүгийн эрх зүйн бүл, залхаалтын эрүүгийн эрх зүйн бүл, хязгаарлалт- нөлөөлөл бүхий эрүүгийн эрх зүйн бүл гэж ангилах санаа дэвшүүлжээ⁴².

Түүнчлэн Францын эрүүгийн эрх зүй судлаач Жан Прадель үзэхдээ: "... Эх газрын ба Англо-Саксоны гэж ангилж ирсэн уламжлалт хандлага нь эрүүгийн эрх зүйн эх сурвалжийн ялгааг нээн илрүүлэх талаасаа байж болох боловч эрүүгийн материаллаг эрх зүйн агуулга, зарчмын шалгуураар авч үзвэл төдий л оновчтой биш, тэр тусмаа социалист болон шашны гэж үзэх нь өнөөдөр ач холбогдлоо алдсан..." харин эрүүчлэл болон эрүүдэн шүүлтийн мөн чанар, агуулга зорилгын шинж байдлаар нь авторитари эрүүгийн эрх зүй, либерал эрүүгийн эрх зүй гэсэн 2 системд авч үзэх нь орчин үед илүү зохимжтой чиглэл байж болох юм" гэж бичжээ⁴³. Хэдийгээр уламжлалт бус либерал үзлийг баримтлагчид гарч ирж, өөр өнцгөөс шинээр авч үзэх, шинэ

⁴² А.А.Малиновский. Сравнительное правоведение в сфере уголовного права. 2002 он., 17 дахь тал

⁴³ Pradel. J. Droit penal compare. 2002 он 113 дахь тал

ангилал дэвшүүлэх оролдлого бий болж байгаа хэдий ч нийт судлаачдын харьцангуй олонхи нь уламжлалт реформист чиглэлийг илүү хүлээн зөвшөөрөх хандлагатай байна⁴⁴.

Харьцуулсан эрх зүйн судлалыг үндэслэгчдийн нэг Францын судлаач А.Леви-Ульманы ангиллаар эх газрын, англо- саксоны, мусульманы гэсэн 3 тогтолцоо болгон авч үздэг хандлага эдүгээ ихээхэн өргөн дэмжлэг авсаар байна. Түүнчлэн сүүлийн үед К.Осакве (АНУ), Жон Бриэрли (Англи), П.Круз (Англи), Х.Эберт (Герман), Г.Кётце (Герман), П.Флетчер (АНУ), Г.Есаков (Орос), Г.Созерхолл (Швейцарь) нарын зэрэг олон эрдэмтэд хосолсон, холимог, нийлмэл, заримдаг зэрэг онцлог шинж бүхий зарим системийн тухай үзэл санааг дэвшүүлжээ⁴⁵.

Дээрх байдал, хандлагаас үзэхэд дэлхийн улс орнуудын эрүүгийн эрх зүйн системийг дараах байдлаар ангилан үзэж болно. Үүнд:

1. Англи- Америкийн эрүүгийн эрх зүйн систем;
2. Эх газрын эрүүгийн эрх зүйн систем;
3. Мусульманы эрүүгийн эрх зүйн систем;
4. Хосолсон ба холимог эрүүгийн эрх зүйн систем;

Дээрх ангиллын гол чиг хандлага нь харьцангуй хүлээн зөвшөөрөгдсөн баримтлал мөн бөгөөд дараах шалгуур шинж, арга зүйн үндэслэлд тулгуурласан байдаг⁴⁶. Үүнд:

- а) эрүүгийн эрх зүйн эх сурвалж
- б) эрүүгийн эрх зүйн зарчим, зорилго
- в) эрүүгийн эрх зүйн түүхэн уламжлал
- г) хүн амын соёл, ёс заншил
- д) шүүхийн практик, төрийн бодлого гэх мэт.

Хэдийгээр систем, хүрээлэл бүхэнд өөрийн гэсэн ялгагдах шинж, онцгойрох байдал илэрч туссан байдаг ч бүхэлд нь авч үзвэл дэлхийн улсуудын эрүүгийн эрх зүйн систем нь аль ч улсад дараах шинжүүд нийтлэг байдгийг харж болно. Үүнд:

-Гэмт хэрэг, ялын асуудлыг эрүүгийн хууль, тогтоомжоор тусгайлан зохицуулж тогтоосон;

-Хүний амь хохироох, хүчирхийлсэн буюу хүч хэрэглэсэн, бусдын өмчийг хулгайлах, дээрэмдэх, завших, танхайрах болон албан тушаалаа хууль бусаар урвуулах, хээл хахууль авах өгөх, бусдын биед гэмтэл учруулах, хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, үймээн самуун дэгдээх, зам тээврийн болон

⁴⁴ Современные уголовно-правовые системы: типы, модели, характеристика. Государство и прова. 2004 он., 74 дэх тал

⁴⁵ Intetnational Encycloedia of Comparativ Law. 1999 он

⁴⁶ Г.А.Есаков, Н.Е.Крылова, АВ.Серебренникова Уголовное право зарубежных стран. 2009 ., 22 дахь тал

үйлдвэрлэлийн аюул, осол гаргах, цэргийн болон төрийн эсрэг гэмт хэрэг гэх мэт наад захын гэмт хэргийн төрлүүдийг жагсаан хуульчилж, тус бүрд нь оногдуулах ялын төрөл, сонгох санкцыг тогтоосон;

-Ялын үндсэн ба нэмэгдэл төрөл, зүйлийг ялган хуульчилсан;

-Торгох, хорих, баривчлах, нийгмийн тустай ажил хийлгэх, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах зэрэг ялыг сонгох боломжтойгоор тогтоосон;

-Ялыг зөвхөн гэмт хэрэг үйлдсэн нь хуулийн дагуу тогтоогдсон этгээдэд гагцхүү шүүхээс оногдуулах журмыг тогтоосон;

-Гэмт хэргийг хор аюул, сэдэл санаа, үйлдлийн шинж байдлаар нь хүнд, хүнд бус гэж ангилсан ба гэмт буруугийн санаатай ба санамсаргүй хэлбэр, хүсэл зоригийн илрэл, онцлогийг шалгуур шинж болгон тогтоосон;

-Хөнгөн хэрэгт хөнгөн ял, хүнд хэрэгт хүнд ял оноох зарчим, бодлогыг ихэнх орны эрүүгийн хуулиудад тусгасан;

-Ял хөнгөрүүлэх, хүндрүүлэх болон ялаас чөлөөлөх, ял хойшлуулах, ял тэнсэх зэрэг эрх зүйн дэглэмийн зохицуулалтыг нийтлэг байдлаар хуульчилсан;

-Гэмт хэргийн субъектын насны болон хэрэг хариуцах чадварын шалгуурыг жишгийн дагуу адил төстэйгээр тогтоосон зэрэг түгээмэл шинжүүд илэрсэн байдгийг дурьдаж болно.

Эрүүгийн эрх зүйн системийн хооронд интеграцчилал явагдаж, зарим хүрээнд интервенц, рецепци хийгдэж хосолсон хэв маягийн бүлүүд нэмэгдэж байгаа хэдий ч Эх газрын ба Англи-Америкийн гэсэн үндсэн хоёр системийн онцлог (давтагдашгүй) дүр төрх улам бүр тодорч, эрх зүйн дифференциациллын үйл явц явагдаж, хоорондын зааглагдсан харилцааны хамааралт бус хэлбэрүүд бий болж эхэлснийг анхаарах ёстой.

2.2. Англи-Америкийн эрүүгийн эрх зүйн систем дэх пробацыйн үйл ажиллагааны онцлог

Жам ёсны эрх зүйн үнэт зүйлсийг шудрага ёсны шүүхийн практик жишигтэй нягт холбон хөгжүүлж гарч ирсэн Английн нийтийн эрх зүй (**common law**) нь Америкийн жишгийн эрх зүй (**case law**)-гээр баяжиж Англи-Америкийн эрүүгийн эрх зүйн системийг бүхэлд нь бий болгон төлөвшүүлжээ. Энэ системд эдүгээ Англи, Шотланд, АНУ, Канад, Австрали, Шинэ Зеланд, Умард Ирланд, Энэтхэг, Нигер, Гана, Гамби, Сьерра-Леоне, Пакистан, Бангладеш зэрэг 60 шахам орон хамаарагдаж байна.

Энэхүү системийг бүрдүүлэгч тулгуур эх сурвалжийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь шүүхийн прецедент⁴⁷ (**precedent of law**) мөн бөгөөд 800 шахам жилийн урт удаан түүхийн практик, амьдрал. туршлагаар баяжиж хөгжсөөр эдүгээгийн үетэй золгожээ.

Шүүхийн прецедент нь тодорхой хэрэг, асуудлыг шийдвэрлэсэн шүүхийн шийдэл бүхий акт нь дараагийн (олон жилийн дараа) адил төстэй тохиолдлыг шийдвэрлэхэд баримтлах үндсэн эх сурвалж болж буй тэрхүү үндэслэл, зарчмуудыг хэлнэ.

Англи-Америкийн системд шүүхийн прецедент өнөө хэр голлох үүрэгтэй байсаар байна. Шүүхийн прецедент анх үүсч хөгжсөн гол шаардлага нь шудрага шүүхээр шийдвэрлэсэн аливаа хэрэг, түүнийг үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэрт адил төст жишиг, зарчмыг тогтоох, ингэснээрээ нийгмийн хөгжлийн тухайн цаг үеийн гэхээсээ илүү амьдрал практикаар шалгагдсан, үндэстэн, ард түмний нийгмийн хэрэгцээнд тулгуурлах гэсэн нөхцөл үндэслэлээс улбаатай ажээ.

Шүүхийн прецедентийг албан ёсны болгон системчлэн, хэвлэн нийтлэх, улмаар эрүүгийн эрх зүйн хэрэглээнд хуульчлагдсан эх сурвалж болгон оруулж тооцох ажил Англид 1865 оноос эхэлсэн гэж үздэг. Өмнө нь урсгал байдлаар нэгдмэл бус түвшинд хэрэглэгдэж байжээ. Түүнчлэн энэ системийн нэг салшгүй эх сурвалжид нэрт хуульч, шүүгч, эрүүгийн эрх зүйчдийн гаргасан онол, номлол, тайлбар, гаргалгаа, хэлсэн үгнүүд багтана. XVII-XIX зууны үеийн Англид анх Уильям Блекстон, Э.Ист, М.Хэйл, И.Хоук нарын тайлбар ном

⁴⁷ Шүүхийн прецедент (**Precedent of law** & **Precedent of court**) гэдэг ойлголт нь латины "**praecedens** & **Praecedentis**"-өмнөх, урьдах буюу өмнө тогтсон зүйл гэсэн утгатай агаад орчин үеийн агуулга нь нийтлэг хэм хэмжээг тогтоосон| шүүхийн шийдэл бүхий акт гэсэн утгатай ажээ. Адил төст хэргийг адил төст практикаар буюу аргаар шийдэх, жишгийг тогтоох гэсэн зориулалтыг хангаж 13-р зууны дунд үед анх Англид үүсчээ.

их үүрэг гүйцэтгэж байсан бол Жонс, Кросс, Кард, Кенни, Смит, Г.Уильямс нарын номлол хүлээн зөвшөөрөгдсөн эх сурвалж⁴⁸ болж хэрэглэгдэж байна

Гэмт хэргийн төрлийг ангилахдаа гэм буруу, хор хохиролын байдлаар нь бус харин тухайн гэмт үйлдлийн илрэх хэлбэр, арга болон функционал шинжийг гол шалгуур болгон **de-jure** үндэслэгээнд тулгуурласан **Felony** буюу хүнд гэмт хэрэг; **de facto** нөхцөлт шинжид үндэслэсэн **Misdiminory** буюу хүнд бус (жижиг) гэмт хэрэг гэж авч үздэг.

1967 оноос Англид дээрх ангиллыг хүчингүй болгосон боловч АНУ-д уг ангилал хэвээр хадгалагдан хэрэглэгдэж байна. Англи- Америкийн эрүүгийн эрх зүйд шүүхийн прецедентийн зэрэгцээ Үндсэн хууль, Үндсэн хуульчилсан актууд, Статутын болон Төлөөллийн хууль, нэг бүрчилсэн ба процессын хуулиуд зэрэгцэн үйлчилдгийг харж болно. Жишээ нь: Англид гарсан эрүүгийн чиглэлийн зарим хуулиудыг нэрлэвэл: Хүний амины гэмт хэргийн тухай 1967 оны хууль, Гэмт хэргийн завдалтын тухай 1981 оны хууль, Бэлэгсийн гэмт хэргийн тухай 2003 оны хууль, Хэв журмын зөрчил болон гэмт хэргийн тухай 1998 оны хууль г.м.

Түүнчлэн 1787 оны АНУ-ын Үндсэн хууль, 1962 оны АНУ-ын үлгэрчилсэн эрүүгийн хууль, 1948 оны АНУ-ын хуулиудын эмхэтгэлийн 18-р дэвтрийн эрүүгийн хууль тогтоомжийн хэсэг 1967 оны Нью-Йорк мужийн эрүүгийн хууль, 1973 оны Пенсилвани мужийн эрүүгийн хууль г.м.

Уг системийн эрүүгийн эрх зүйд гэм буруугын хэлбэр нь гэмт хэргийн шалгуур шинж болдоггүй бөгөөд эх газрын систем дэх **"Nullun sine lege, Nulla poena sine lege"** гэсэн зарчмыг хэрэглэгддэггүй.

Эрүүгийн төрөлжсөн нэгдмэл хууль байхгүй дээр гэмт хэргийн институци нь олон янзын харилцан адилгүй статус бүхий хуулиуд, тэрчлэн шүүхийн прецедентээр зохицуулагдсан байх нь олонтаа.

"Actus non facit reus, nisi mens sit rea" гэсэн зарчим уг системийн эрүүгийн эрх зүйн үндсэн зарчим болж мөрдөгдөнө. Утгачилан авч үзвэл нэг талаас "Үйлдэл нь гэмт санаа агуулаагүй бол гэмт хэрэг гэж үзэхгүй", нөгөө талаас "Үйлдэл нь бүхий л бодол санааны илрэл биш, бөгөөд гэмтний санаа бодлоор ажилласан бол тухайн үйлдэл нь гэмт хэрэг биш" гэсэн агуулгыг тусгасан байдаг.

Энд ялын болон ялын бус хариуцлага хүлээлгэхэд **"Actus reus"** ба **"Mens rea"** гэсэн хоёр үндэслэлийг авч үздэг бөгөөд Эрүүгийн шинжтэй хориотой үйлдэл, Эрүүгийн хориг, зан төрх "ухаан бодол" гэсэн утгаар ойлгогдох ажээ. Энэ нь юуны өмнө эхлээд тухайн этгээдийн хийсэн үйлдлийг

⁴⁸ K.Kenny. Outlines of Crininal Law 1965, Card, Cross and Jones Introduction to Crininal Law 1998, G.Williams Criminal Law The General Part 1961, J.C.Smith and B.Hogan Criminal Law.1.1996

нь авч үзэх, дараа нь зан төрхийн субъектив хүчин зүйл буюу сэтгэлзүйн талыг нь тодорхойлно гэсэн үг юм. Энэ системийн зарим судлаачид гэмт хэрэг нь объектив (*биеийн*) болон субъектив (*сэтгэл зүйн*) үйлдлийн шудрага бус, негатив зан үйлийн илрэл гэж үзэх нь бий.

Англи-Америкийн эрүүгийн эрх зүй нь хувь хүн өөрөө үйлдлээ бүрэн хариуцах тухай индивидын эрх чөлөөний онолд тулгуурласан байх ба ялын хариуцлага нь хувь хүний ёс зүйн болон индивидын хариуцлагатай холбоотой байдгийг харж болно.

Тухайлбал: Аливаа этгээд бусдын эрх чөлөөнд халдсан бол нэгэнт учруулсан хохирол, оногдох ялаа сайн дураараа хүлээж, пгүүх дээр өмгөөлөгч, яллагч нараар дамжуулж, ялын тохиролцоо (**Penal bargaining**) хийж болно.

Түүнчлэн бусдын халдлагаас өөрийгөө болон гэр бүл, тэрчлэн гэр орон, хувийн өмчөө хамгаалахын тулд зэвсэг хэрэглэх, өөрийн амьдрал, жам ёсны эрх чөлөөгөө хамгаалах хүрээнд өргөн дэлгэр эрхийг олгосон зэрэг нь эрүүгийн эрх зүйн харилцаанд уян хатан нээлттэй шудрага оролцох боломжийг нэмэгдүүлдэг байна.

Англи-Америкийн эрүүгийн хууль тогтоомжуудад эрүүгийн хууль үйлчлэх цаг хугацааг заадаггүй, тэрчлэн хөөн хэлэлцэх хугацаа гэж институт байдаггүй. Гэмт хэргийн төрлүүдийн хоорондын ялгааг нийтлэг, тогтвортой байх шинжээр харьцангуй нээлттэй буюу шүүхээс нөхөн тайлбарлах боломжтой байдлаар томъёолсон байдаг.⁴⁹

Энэ системийн орнуудын тархан суурьшсан болон рецепци хийгдсэн байдал нь Английн шүүхийн прецедентийн уламжлалаас гадна Английн эрүүгийн эрх зүйн зарим бичмэл эх сурвалж, үзэл баримтлалыг шууд ба шууд бусаар хуулбарласан буюу тусгасан шинжтэй. Жишээ нь: Английн нэрт хуульч Д.Стифений боловсруулсан 1879 оны Английн эрүүгийн загвар хуулийн төсөл нь Канадын 1892 оны Эрүүгийн хууль, Энэтхэгийн 1860 оны Эрүүгийн хууль зэрэгт бүрэн тусгалаа олсон байдгийг харж болно.

Тэгвэл 1860 оны Энэтхэгийн Эрүүгийн хууль нь Малайзын (1906), Сингапурын (1872), Шри-Ланкийн (1883), Брунейгийн (1952) Эрүүгийн хуулиудад шууд тусгагдаж, рецепци болж тогтсон байна.

Хэдийгээр “Эрүүгийн хууль” (**Criminal legal act**) гэж нэрлэн буулгаж буй боловч энэ нь бүрэн төрөлжиж, системчлэгдсэн хууль биш бөгөөд ихэнхдээ гэмт хэргийн институцийг ерөнхий байдлаар хуульчилсан шинжтэй

⁴⁹ “Burglary”-бусдын эзэмшил, өмчид шөнийн цагаар нэвтэрч, халдан довтлох (Felony), “Public nuisance”-Нийтийн тээвэр, үйлчилгээний газар зэрэг олон нийтийн орчинд ая тухтай, хэвийн тайван байдлыг алдагдуулах (Misdiminory)

байдаг. Энэ системийн Холбооны улсуудын хувьд зарим онцлог зохицуулалттай байдгийг дурьдах нь зүйтэй. Жишээ нь: Австралид 1935 онд "Эрүүгийн эрх зүйн тусгаар байдлын тухай актыг гаргасан ба муж бүр гэмт хэргийн асуудлаар өөрсдийн мужийн онцлогт нийцүүлж хууль, дүрмээ тогтоох, ингэхдээ нийтийн эрх зүйн жишгийг харгалзахаар зохицуулсан нь бий. Тухайлбал: Викторий мужид 1958 онд гэмт хэргийн тухай актыг гаргасан бол Тасмани мужид 1924 онд Эрүүгийн хууль, Өмнөд Уэльст 1900 онд гэмт хэргийн тухай акт зэргийг баталжээ. АНУ-ын нэг мужид гэмт хэрэг гэж тооцдог зүйлийг өөр бусад мужид нь гэмт хэрэг гэж үзэхгүй байх тохиолдол ч бий.

Тоймлон дүгнэвэл Англи-Америкийн эрүүгийн эрх зүйн систем нь Эх газрын системээс ялгарах дараах онцлог шинжүүдтэй. Үүнд

- Эрүүгийн эрх зүйн үндсэн гол эх сурвалж нь шүүхийн прецедент болох бөгөөд зарим тохиолдолд нэр хүнд бүхий эрдэмтэн, хуульчдын эрх зүйн тайлбар, онол, номлол, тэрчлэн шүүхийн жишгийн зарчим, заншлын норм, хэм хэмжээнүүд эх сурвалж болдог;

- Эрүүгийн хууль тогтоомж нь нэгдмэл хууль болж төрөлжөөгүй, бүрэн системчлэгдээгүйн дээр зарим статутын болон төлөөллийн, тэрчлэн загвар хууль, хуульчилсан акт нь гэмт хэрэг, ялын асуудлыг хэд хэдэн актыг гаргах замаар тухайчлан ерөнхий нийтлэг байдлаар зохицуулж, тогтоосон шинжтэй;

- Эрүүгийн эрх зүйн эх сурвалжууд нь он удаан жил зохицуулалтын чадвараа алддаггүй бөгөөд ихэнхдээ уян хатан, нээлттэй, түгээмэл хэм хэмжээг өөртөө агуулсан;

- Гэмт хэрэг, ялын тухайд казусийн буюу кейсийн шийдлийг шууд хангахад чиглэгдсэн эрүүгийн эрх зүйн нэг бүрчилсэн (деталчилсан) зохицуулалтыг бий болгосон;

- Эрүүгийн эрх зүйн зохицуулалт нь процессийн эрх зүйн журмыг өөртөө багтаан хамааруулсан;

- Эрүүгийн эрх зүйд төсөөтэй хэрэглэх явдлыг хангаж, ялын санкцийг сонгох, хэрэглэх талаар шүүгчдэд бүрэн итгэл хүлээлгэсэн;

- Тэгш эрхийн, шудрага шүүхийг хүндэтгэх, шүүхээр нотлогдоогүй бол гэмт хэрэг биш гэж үзэх, чөлөөтэй, нээлттэй мэтгэлцэх, хувь хүний эрх чөлөөг хангах, нийтийн эрх зүйг дээдлэх зэрэг нь эрүүгийн эрх зүйн үндсэн зарчим болж тусгагдсан;

- Гэмт хэргийн бүрэлдэхүүний ойлголтыг огт хэрэглэдэггүйн дээр гэмт хэргийг ангилах, төрөлжүүлэх, гэмт хэрэг ба адил төст эрх зүйн зөрчлийг ялгах шалгуур, үнэлэмж, арга зүй нь Эх газрын системийн зарчим, аргачлалаас эрс ялгаатай г.м.

Англи-Америкийн эрүүгийн эрх зүй нь өөрийн гэсэн ялгарах онцлог, мөн чанарыг илэрхийлж, давуу ба сул талын аль алиных нь шинжийг өөртөө агуулж, дэлхий дахины эрүүгийн эрх зүйн ертөнцөд зохих байрыг эзэлж, нэр, нөлөөгөө хадгалсаар байна.

Английн пробагийн үйл ажиллагаа:

Англи нь нийтийн эрх зүйн системийн /common law/ анхны үр хөврөл нь болсон газар бөгөөд 1066 оноос хойш сүм хийдийн шүүхийн (canon law) жишгийн практик хөгжлөөр дамжин 1485 оноос эхлэн албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн шүүхүүдийн өрсөлдөөн, тэмцлийн үр дагавар болж "Common law" буюу жишгийн эрх зүйн тогтолцоо бүрэлдсэн⁵⁰ гэж үздэг. Харин XIX зууны эцэс XX зууны эхэн үеэс парламентын статут (statute)-ын актууд олноор гарч (Statute Law) шүүхийн жишгийн эрх зүйг тайлбарлан зохицуулах болсноор "precedent" буюу шүүхийн жишгийн эрх зүй жинхэнэ утгаараа үйлчлэх болсон.⁵¹

Эх газрын эрх зүйн системтэй харьцуулахад Нийтийн эрх зүйн систем өөрийн гэсэн ялгагдах шинж, өвөрмөц онцлогтой бөгөөд энэ нь эрүүгийн эрх зүйн системээс тодорхой харагдах хэдий ч "бүхэлд нь авч үзвэл дэлхийн улсуудын эрүүгийн эрх зүйн систем нь аль ч улсад байдаг нийтлэг шинжүүдийг олж харж"⁵² болно. Тухайлбал, гэмт хэрэг, ялын асуудлыг эрүүгийн хууль, тогтоомжоор тусгайлан зохицуулж тогтоосон, ялын үндсэн ба нэмэгдэл төрөл зүйлийг ялган хуульчилсан, торгох, хорих, баривчлах, нийгмийн тустай ажил хийлгэх, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах зэрэг ялыг сонгох боломжтойгоор тогтоосон, хөнгөн хэрэгт хөнгөн, хүнд хэрэгт хүнд ял оногдуулах зарчим, бодлогыг эрүүгийн хуулиудад тусгасан, ял хөнгөрүүлэх, хүндрүүлэх болон ялаас чөлөөлөх, ял хойшлуулах ял тэнсэх зэрэг зохицуулалтыг нийтлэг байдлаар хуульчилсан байна.

Английн ялын тогтолцоо нь харьцангуй уян хатан шүүхээс ял шийтгэлийг сонгон хэрэглэх нөхцөлөөр хангагдсан байдаг. Өөрөөр хэлбэл эрүүгийн төрөлжсөн хуульгүй байдгаас үүдэн олон хууль, хуульчилсан актуудад ял оноох бүрэн эрхийг шүүхэд олгодог⁵³.

Ялын зорилго, зарчим, ойлголтыг 2003 онд батлагдсан Эрүүгийн шүүх цаазын тухай хууль (Criminal Justice Act 2003, с 44) –д томъёолсон байдаг. Тухайлбал уг хуулийн 142-р зүйлд⁵⁴ ял оногдуулах, эдлүүлэх нь дараах зорилгыг хангана: а/ гэмт хэрэг үйлдсэн этгээдэд залхаалт, цээрлүүлэлт үзүүлэх, б/ гэмт хэргийг багасгах тогтоон барих, в/ гэмт хэрэгтнийг өөрчлөн нийгэмшүүлэх, төлөвшүүлэх г/ нийгмийг гэмт халдлагаас хамгаалах д/ гэмт хэрэгтний бусдад учруулсан хохирлыг арилгах, нөхөн төлүүлэх.

Английн ялын тогтолцоо нь дараах гурван төрөл хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Хорих ял (custodial sentence);

⁵⁰ Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2010. 108 дахь тал

⁵¹ Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2017. 222 дахь тал

⁵² Дурдсан бүтээлийн 41 дэх тал

⁵³ Гэмт хэргийн тухай 1967, 1977 оны хууль, Гэмт хэрэгт завдсан үйлдлийн тухай 1981 оны хууль, Ялын тухай 1997 оны хууль, Эрүүгийн болон хэв журмын зөрчлийн тухай 1998 оны хууль, Гэмт хэрэгт шийтгэгдсэн этгээдийг засан төлөвшүүлэх тухай 1974 оны хууль, Ял хэрэглэх болон шүүхийн эрх хэмжээний тухай 1973 оны хуулийг дурдаж болно.

⁵⁴ 142. Purposes of Sentencing

2. Эрх, эрх чөлөөг хасах, хязгаарлах (community sentence);
3. Тогрох (Fine sentence).

Эрх, эрх чөлөөг хасах, хязгаарлахад чиглэсэн хорихоос өөр төрлийн ял нь нийгмийн ашиг сонирхол эрх ашгийн дагуу нийгмийн нөлөөлөл үзүүлэх зорилгыг агуулдаг. Үүнийг “Нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэх ял буюу “community sentence” гэж нэрлэдэг⁵⁵. Энэхүү ялын төрлүүдийг 2003 оны хуулийн 199-211-р зүйлд⁵⁶ дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Үнэ төлбөргүй ажиллуулах: Энэ 40-300 цаг хүртэлх хугацаатай цалин хөлсгүй ажиллуулахад чиглэгдэнэ. Ялын хэрэгжилтэд пробацийн алба болон ажилтан хяналт тавьж зохих үйлчилгээ үзүүлэхээр заасан.

2. Болзолтойгоор хянан харгалзах. Шүүхээс тогтоосны дагуу тусгайлсан газар байлгаж (нийгэмшүүлэх болон халамжийн үйлчилгээ үзүүлэх төв⁵⁷) тодорхой хугацаанд, тодорхой үйл ажиллагаа явуулах (хохилогчийн нөхцөл байдлыг ойлгуулах, уулзуулах, үйлдсэн гэмт хэрэгтээ гэмшиж ойлгож байгаа эсэх) талаар үүрэг гүйцэтгүүлж ажиллуулахад чиглэгдэнэ. Үүнийг хэрэгжүүлэхэд орон нутгийн пробацийн албаны ажилтан эсхүл энэ төрлийн үйлчилгээ үзүүлж буй ажилтан оролцдог. Хугацааны хувьд 60 хоногоос дээшгүй байна (Criminal Justice Act 2003, Chapter 4, section 201).

3. Оршин суух газраас өөр тийш явахыг хориглох. Энэ нь 2 жилээс дээшгүй байна.

4. Эрх бүхий байгууллагаас баталсан хөтөлбөрт (accredited programme) хамрагдах /202/. Хөтөлбөрийг Төрийн нарийн бичгийн даргын алба баталдаг бөгөөд энэхүү хөтөлбөр нь гэмт хэрэгтэнд засрал төлөвшил олгох, нийгэмшүүлэхэд чиглэгдэнэ. Уг хөтөлбөр явуулах газар, орчин нөхцөл, хариуцан хэрэгжүүлэх албан тушаалтныг тодорхой заасан байна.

5. Тодорхой ажил үүрэг, үйл ажиллагаа, явуулахыг түр хугацаагаар хориглох. Үүний онцлог нь зөвхөн ажил үүрэг мэргэжилтэй хамааралтай болон хамааралгүйгээр тодорхой үйлдэл, үйл ажиллагааг хориглодог. Тухайлбал шүүхээс тогтоосон хугацаанд биедээ галт зэвсэг авч явах, ашиглах, ан хийх эрхийг нь хязгаарлах зэрэг багтдаг байна /203/.

6. Тодорхой тогтоосон газар, хугацаанд хөл хорих буюу зөрчих эрхийг хязгаарлах. Энэ нь 12 сараас дээшгүй байна. Энэ хугацаанд пробацийн ажилтан хяналт тавин ажиллана /204/.

7. Зарим газар байршилд нэвтрэхийг хориглох. Энэ нь 2 жилээс дээшгүй байна /205/.

8. Гэр амьдарч буй орчинд нь байлгах буюу гэрийн хорио тогтоох. Энэ нь пробацийн ажилтан эсвэл пробацийн үйлчилгээ үзүүлж буй ажилтны

⁵⁵ Орос хэлэнд “Наказание в интересах общества” гэж томъёолдог.

⁵⁶ Requirements available in case of all offenders
<https://www.legislation.gov.uk/ukpga/2003/44/contents>

⁵⁷ Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон хугацаанд түр байлгах, хүмүүжлийн болон нөлөөллийн сургалт зохион байгуулах, хохилогчтой уулзуулан эвлэрүүлэх үйлчилгээ явуулах, халамжийн үйлчилгээ үзүүлэх тусгайлсан төвүүд байдаг бөгөөд энэхүү төвүүдийн орчин нөхцөл, үйл ажиллагаа, төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн дарга / Secretary of State/ баталдаг. Энэ нь засгийн газрын гишүүн бөгөөд сайдууд, яамдын үйл ажиллагааг хариуцан ажилладаг засгийн газрын кабинетын сайд юм.

зөвшөөрөлгүйгээр тогтоосон газраас гадагш явахыг хориглох /206/ болон гадаадад зорчих эрхийг 12 сар хүртэлх хугацаагаар хориглох /206A/ талаар тусгасан.

Мөн хуулийн 207-д сэтгэцийн эрүүл мэндийн эмчилгээ явуулах эмч, лицензтэй сэтгэл зүйчийн үзүүлэх үйлчилгээ 208-д зохион байгуулах газар зэргийг тодорхой тусгасан зохицуулалт байна. Харин хуулийн 209-212 –т Мансууруулах бодис болон архинд донтсон хүмүүст үзүүлэх нөхөн сэргээх эмчилгээг хэрхэн, хэн, ямар нөхцөлд явуулах талаарх тодорхой тусгасан.

Эрүүгийн шүүх цаазын тухай хууль 213-т ял хойшлуулсан этгээдийг уг хугацаанд хэрхэн хянан харгалзах, нийгэмшүүлэх болон хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэх үйлчилгээний онцлогийг тус тус тусгажээ.

Насанд хүрээгүй буюу залуу гэмт этгээдэд (Youth offenders) онц ноцтой болон онц хүнд гэмт хэрэг үйлдэхээс бусад тохиолдолд ихэнхдээ хорихоос өөр төрлийн ял онгодуулдаг. Ингэхдээ хүмүүжлийн тусгай төв, нийгмийн тустай ажлын төв, хөдөлмөр, сургалт, зан үйлд нөлөөлөх, төлөвшлийн эерэг хандлага олгох төв зэргийг олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллуулах ба хугацааны хувьд 15-18 насны хүмүүсийн хувьд 2 сар, 18-21 насныхны хувьд 21 өдөр байна. Дээрх төвүүдээр дамжин хэрэгжих сургалт нөлөөллийн ажлын дээд хугацаа нь 12 сар байх бөгөөд сургалт хүмүүжлийн төвүүдээс суллагдсан хүмүүс 22 нас хүртэл нь хяналт тогтооно⁵⁸.

Англи улсад пробацийн алба 1807 онд анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх чиглэлийн хүрээнд бий болсон гэж үздэг бөгөөд 1907 онд “Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх тухай хууль” батлагдан гаргаснаар албан ёсоор тус улсын эрүүгийн эрх зүйн салбарт хэлбэрээ олж хөгжсөн байна. Улмаар 1948, 1957 оны эрүүгийн хууль тогтоомжид илүү өргөн хэлбэрээр тусгалаа олсон бөгөөд 1965 онд “Пробацийн дүрэм” батлагдсан байдаг.

Англи улсын пробацийн алба нь 2001-2006 оны хугацаанд Дотоод хэргийн яамны бүтцэд ажиллаж байгаад өнөөдрийн байдлаар “Эрх зүйн зөрчил гаргасан этгээдтэй харилцах үндэсний алба” /NOMS/ болон өөрчлөгдөн зохион байгуулагдсан байна. Англи улсын хэмжээнд 42 алба ажиллан, 7000 орчим ажилтантайгаас нийт ажилтны 30 гаруй хувь нь тусламж, үйлчилгээний чиглэлийн чиг үүрэг хэрэгжүүлдэг. Нийт ажилтан, сайн дурын ажилтны 44 орчим хувийг эмэгтэй ажилтнууд эзэлж байна. Ажилтнуудын дийлэнх хувийг хуульч болон сэтгэл зүйч мэргэжлийн ажилтнууд эзэлдэг ба нэг ажилтанд дунджаар 15 хүн ногдог байна.

2017 оноос хорих ба пробацийн алба болон өөрчлөгдөн зохион байгуулагдан Хууль зүйн яамандаа харьяалагдан үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү албаны чиг үүргийг товч байдлаар авч үзье. Үүнд:

- Төрийн болон хувийн гэсэн хоёр чиглэлд хуваагдан үйл ажиллагаа явуулдаг.

⁵⁸ Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2017. 233 дахь тал

- Төрийн пробацийн алба нь бэлгийн хүчирхийлэл бүхий гэмт хэрэг үйлдсэн болон 12 сараас дээш хугацаагаар ял шийтгэгдсэн, хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хяналт тавьдаг.

- Пробацийн албаны үйл ажиллагаа нь аливаа хүн гэмт хэрэгт сэжиглэгдэн баривчлагдсан буюу шалгагдсан үеэс эхэлдэг.

- Шүүн таслах ажиллагаа хүртэлх хяналт, дэмжлэгийн үүргийг хэрэгжүүлдэг.

- Оногдуулах ял шийтгэлийн талаар зөвлөмж бэлтгэж шүүхэд танилцуулдаг ба тус улсын статистик мэдээгээр шүүхийн практикт шийтгэх тогтоолын 70 хувь нь пробацийн албаны зөвлөмжийн дагуу ял шийтгэдэг байна.

- Гэмт хэрэгт холбогдсон этгээдийн шүүн таслах ажиллагаа хүртэлх нөхцөл байдлын талаарх тайланг шүүхэд танилцуулах, энэ чиглэлээр хэлэлцүүлэг явуулах, албан мэдээлэл солилцох хэлбэрээр хамтран ажилладаг.

- Суллагдсаны дараах үйлчилгээ, дэмжлэгийг үзүүлэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг энгийн амьдралд шилжихэд туслах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэ ажлын хүрээнд суллагдсан иргэнд үзүүлэх нөлөөллийн ажил буюу олон нийтийн оролцоог хангах, бусад ахуй нөхцөлийг тогтворжуулах дэмжлэгийг үзүүлдэг бөгөөд тус чиг үүргийг хэрэгжүүлэх үндэсний комисс хэлбэрийн бүтэц ажилладаг.

Английн Үндэсний пробацийн алба нь олон нийтэд аюул учруулж болзошгүй өндөр эрсдэлтэй гэмт хэрэгтнийг хянадаг, хуулийн дагуу үйлчилгээ үзүүлдэг шүүх эрх мэдэл, хууль сахиулах тогтолцооны байгууллага юм. Пробацийн алба жил бүр 30,000 орчим гэмт хэрэгтэнтэй ажиллаж, тэднийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулснаар олон нийтийн амар амгаланг хангаж, гэмт халдлагаас хамгаалан ажилладаг байна.

Үндэсний пробацийн алба 2014 оны 6-р сарын 1-нд байгуулагдсан ба бүрэлдэхүүнд нь 21 “Нөхөн сэргээх олон нийтийн нийгэмлэг” (community rehabilitation companies) багтдаг. Үйл ажиллагааны үндсэн чиглэл нь бага болон дунд түвшингийн эрсдэлтэй өөрөөр хэлбэл хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн дунд нийгэмшүүлэх, засан хүмүүжүүлэх, зан үйлийн эерэг өөрчлөлт үзүүлэх ажлыг зохион байгуулдаг. Эдгээр “Нөхөн сэргээх олон нийтийн нийгэмлэг” нь шүүх, цагдаа, хувийн болон олон нийтийн байгууллагуудтай нягт хамтран тэдний төлөөллийг оролцуулан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмд нь байлгаж дахин олон нийтэд аюул учруулахгүй байхад чиглэсэн үр дүнтэй нөлөөллийн ажлыг удирдан зохицуулна.

Үндэсний пробацийн алба болон нийгэмлэгүүд байгуулагдсанаар өмнө үйл ажиллагаа явуулж байсан 35 пробацийн итгэмжлэгдсэн төлөөллийн байгууллагыг (Probation Trusts) өөртөө нэгтгэсэн байна. Өөрөөр хэлбэл Үндэсний хэмжээний пробацийн алба үүсч шинэ бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлсэн.

Уг алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- шүүхийн шийдвэр гарахаас өмнө тухайн гэмт хэрэгтний талаарх мэдээллийг шүүхэд гарган өгч шүүхээс тохирсон ял шийтгэл түүнд оногдуулахад туслалцаа үзүүлэх

- шийтгэх тогтоолоор тухайн этгээдийн оршин суух хаягийг тодорхойлж ял эдлэх нөхцөл /орчин/-ийг тогтоох, шийдвэрлэхэд туслах

- хорих ял эдлээд суллагдаж байгаа хүмүүсийг нийгэмд эргэн нэгтгэх, шаардлагатай тохиолдолд хяналтыг хэн, хэрхэн үргэлжлүүлэн тавих талаарх бэлтгэл ажлыг зохион байгуулах

- шүүхээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх, эрх чөлөөг хасах, хязгаарлах замаар нийгэмд нь ял эдлүүлэх талаарх гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, тэдэнд туслах

- бэлгийн болон хүчирхийллийн ноцтой гэмт хэргийн хохирогчдын эрх ашгийг нэн тэргүүнд хангах, 1 жил түүнээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн болон сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад хоригдож буй этгээдтэй харилцаа тогтоон хяналтад байлгах.

Уг байгууллага нь өөрсдийн тэргүүлэх чиглэлээ “эрсдэл өндөртэй гэмт хэрэгтнүүдийг үр дүнтэй өөрчлөн нийгэмшүүлэх замаар олон нийтийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэрэг үйлдэж буй шалтгааныг олж, дахин гэмт хэрэг үйлдэхийг таслан зогсоох” гэж тодорхойлжээ.

Английн Үндэсний пробацийн алба нь бүтцийн хувьд хэд хэдэн бүсэд хуваагддаг. Тухайлбал Зүүн болон зүүн өмнөд бүс (8 муж багтана), баруун өмнөд болон төвийн өмнөд бүс (6 хот болон муж багтана), зүүн хойд бүс (5 муж болон хот багтана), баруун хойд бүс (7 муж багтсан) төвийн бүс (6 муж багтана), Лондон болон Вуэлс зэрэг болно.

Пробацийн үйл ажиллагааны хүрээнд хяналтад байгаа хүмүүст 7 хоногт 1 удаа 10.00-15.00 цагийн хооронд тусгайлсан хөтөлбөрийн дагуу нөлөөллийн арга хэмжээг бүлгийн болон ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулдаг бөгөөд үйл ажиллагааны зардлыг төсвөөс хариуцдаг.

Энэхүү хөтөлбөр 10 сарын хугацаатай хэрэгждэг бөгөөд хөтөлбөрт эрүүл мэнд, хууль ёс, гэр бүлийн асуудал, согтууруулах, мансууруулах зүйлсийн буруу хэрэглээ, төрөл бүрийн хүчирхийллээс зайлсхийх, ажил мэргэжлээ сонгох, олон нийттэй харилцах, өөрийгөө үнэлэх асуудал, арьс өнгөний болон бусад хэт явцуу үзэл хандлага гэх мэт сэдвүүдээр лекц, ярилцлага, хэлэлцүүлгийг багтаасан байдаг. Хөтөлбөрт хамрагдаж буй 5 хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэй хүүхэдтэйгээ ирсэн тохиолдолд хүүхдийн хичээлийн пробацийн албаны ажилтан хариуцан ажилладаг.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт нь хуульд заасны дагуу тасралтгүй хэрэгждэг ба удаа дараа санаатай тасалсан, зөрчсөн тохиолдолд хорих ялаар солих саналыг шүүхэд гаргадаг. Харин тодорхой тохиолдолд хөтөлбөрөөс чөлөөлөх ба үүнд эмчийн албан ёсны магадалгаа болон бусад хуулиар зөвшөөрсөн хүндэтгэн үзэх тохиолдлыг багтаана. Хөтөлбөрийн явцад согтууруулах болон мансууруулах төрлийн зүйл хэрэглэх, тамхи татах, зэвсэг

болон зэвсгийн чанартай зүйл биедээ авч явах, мөрийтэй тоглох, бусдыг үл хүндэтгэх, хүч хэрэглэсэн үйлдэл гаргахыг хориглодог.

Английн пробацийн албаны үйл ажиллагааны нэг онцлог нь байнгын хэрэгжүүлж буй үндсэн арга хэмжээнд "OASYS" хэмээх мэдээллийн тогтолцоог ашигладаг явдал юм. Энэхүү мэдээллийн систем дахь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн бүхий л мэдээллийг тодорхой үе шат, дарааллын дагуу багц асуултын хэлбэрээр пробацийн албанаас бөглөж бүрдүүлдэг. Энэ системийг гэмт хэрэг үйлдсэн этгээдийн талаарх тайланг шүүн таслах ажиллагаанд хүргүүлэх, эрүүл мэнд, сэтгэл зүйн онцлог, хувийн нөхцөл байдлын талаарх тодорхойлолтыг боловсруулахад ашигладаг бөгөөд тухайн этгээдийн дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй эсэх түвшин, эрсдэлийн үнэлгээг агуулж байдаг. Гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаарх магадлалыг хувиар тооцох аргачлал ашигладаг ба энэ лавлагаа нь хоёр жилийн хугацаанд хүчинтэй ашиглагддаг.

Түүнчлэн Английн пробацийн албаны зүгээс хэрэгжүүлдэг нэг гол үйл ажиллагаа нь гэмт хэрэг үйлдсэн этгээд нь зан үйлийн сөрөг хандлагатай, хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, бэлгийн хүчирхийллийн болон хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдсэн бол суллагдахаас 6-8 сарын өмнө хорих байгууллагын захиргааны санаачилгаар тусгай хяналтад авах талаар хууль сахиулах байгууллагуудтай мэдээлэл солилцон, урьдчилан сэргийлэх, хяналт тогтоох чиглэлд хамтран ажилладаг. Үүнийг "Нийгмийн аюулгүй байдлыг хангахад төрийн байгууллагуудаас хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ" буюу MAPPA хэмээн томъёолдог.

MAPPA-н хүрээнд жилд дунджаар 10,000 хоригдлын хувийн мэдээллийг хянан магадалдаг бөгөөд үүнээс нийгмийн хор аюул, гэмт зан үйл бүхий хоригдлыг сонгон авч хамтарсан комиссоор 2-3 сар тутам хэлэлцэн цаашдын хяналтын чиглэлээр шийдвэр гаргадаг. MAPPA нь Лондон зэрэг томоохон хотын бүхий л дүүрэгт салбартай бөгөөд хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн хүн бүртэй тусгайлсан төлөвлөгөөний дагуу ажилладаг.

MAPPA-н үндсэн зорилго нь давтан гэмт хэрэг үйлдсэн хүмүүст хяналт тавих, тэдгээрийн дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулах явдал юм. Харин энэхүү хамтын ажиллагааны онцлог хэлбэрийн тогтолцооны үндсэн чиг үүрэг нь төрийн байгууллага, албадын хооронд гэмт хэрэгтний талаарх мэдээллийг солилцох, давтан гэмт явдлын эрсдэлийг үнэлэх, нийгэмд чиглэсэн гэмт явдлын хор уршгийг бууруулах төлөвлөгөө боловсруулах зэрэг болно.

Пробацийн алба, түүний ажилтан нь дээрх төрлийн гэмт хэрэгтний нөхцөл байдлыг судлахаар хорих байгууллагад ажилладаг бөгөөд MAPPA-н хүрээнд учирсан хохирлын хэмжээ, хохирогчийн саналыг мөн хамтатган судалдаг. Түүнчлэн Англи улсын нэг онцлог нь хугацааны өмнө тэнсэн суллах асуудлыг хэлэлцэх тусгай хороо ажилладаг ба үүнд пробацийн албаны ажилтнууд голлон ажиллахын зэрэгцээ шүүгч, хуульч, сэтгэл зүйч, нийгмийн зүтгэлтнүүд мөн бүрэлдэхүүнд нь багтдаг. Энэхүү хороо пробацийн албаны

ажилтны тайлан, лавлагаанд тулгуурлан тэнсэн суллах эсэх асуудлыг шийдвэрлэдэг ба Англи улсад байдаг нэг онцлог орчин болох түр байр /Hostel/-д байршуулах, цахим гав хэрэглэх, тодорхой чиглэл, газруудад зорчихыг хориглох зэрэг эрхийн хязгаарлалтуудыг мөн шийдвэрлэдэг байна.

Английн туршлагаас харахад нийгмийн хор аюул бага, болгоомжгүй байдлаар болон хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорихоос өөр төрлийн ялаар шийтгэж, тэднийг нийгэмшүүлэх, нийгэм, сэтгэл зүй, гэр бүлийн харилцааны тусгайлсан сургалтад хамруулах, нийтэд тустай ажил хөдөлмөр эрхлүүлэх, шаардлагатай тохиолдолд улс төрийн болон нийгэм, эдийн засгийн эрхэнд хязгаарлалт хийх, чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлаж хянан харгалзах зэргээр эдийн засгийн хувьд чирэгдэл багатай (Cost-effective) ялыг шийтгэлийг оногдуулах, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, хорих ял эдлээд суллагдсан хүнийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлд ихээхэн анхаарч ял шийтгэлийг үр нөлөөтэй эдлүүлэх тогтолцоог бий болгожээ.

Английн эрүүгийн ялын бодлого, хэрэгжилт нь өөрийн орны онцлог, уламжлалаа хадгалсан, уян хатан шинжтэй бөгөөд эрүүгийн ялын санкцыг сонгон хэрэглэх талаар шүүхэд бүрэн итгэл хүлээлгэсэн болох нь харагдана.

Дээрхээс үзэхэд Английн эрүүгийн эрх зүйн тогтолцоо ял шийтгэлийн бодлого, ял эдлүүлэх ажиллагаа нь бусад улсуудтай харьцуулахад эртний арвин баялаг туршлагатай бөгөөд эдүгээ өөрийн баялаг туршлага, уламжлал үнэт зүйлсээ хадгалан өвлүүлж ирснийг зүй ёсоор үнэлэн авч үзэх ёстой. Ялангуяа пробацийн тогтолцоог бүрдүүлэхэд тэдний туршлагаас суралцан, харьцуулан судалж өөрийн орны онцлог, уламжлалд нийцүүлэн нутагшуулах нь ихээхэн ач холбогдолтой юм.

2.3. Эх газрын (Ром-Германы) эрүүгийн эрх зүй дэх Пробацийн үйл ажиллагааны онцлог

Ромын эрх зүйн уламжлалд тулгуурласан позитив эрхийн үнэт зүйлсийг Франц, Германы эрүүгийн хуулийн жишиг, практиктай нягт холбон гарч ирсэнээрээ энэхүү систем Баруун Европ болон Эх газрын орнуудад өргөн тархсан юм. Энд Франц, Герман, Испани, Итали, Португали, Швейцари, Австри, Грек, Турк зэрэг Европын ихэнх орон Латин Америк, Хойд Африк, Ойрхи Дорнод, Азийн зэрэг 100 шахам орон хамаарагддаг. Хууль тэргүүлэх үүрэгтэй бөгөөд эрүүгийн эрх зүйн үндсэн гол эх сурвалж болдгоороо уг систем ялгарч харагддаг. Энэ систем XIX зууны дунд үеэс бүрэлдэн тогтсон хэдий ч үзэл, баримтлал нь XIII зууны 60-аад оны үеэс бий болж хөгжсөн гэж үздэг.

Түүхээс үзэхэд Ромын эрх зүйн эх сурвалж дахь гэмт хэрэг, ялын талаарх эрүүгийн эрх зүйн уламжлалыг XII-XIV зуунд Италийн Их Сургуулиудад судалж, улмаар XV-XVI зуунд Францын шүүхийн практикт дэлгэрүүлэн баяжуулж хэрэглэж иржээ.

XVII зууны 2-р хагасаас хууль тогтоомжийг төрөлжүүлж гаргах, нийтийн болон хувийн эрх, хүсэл зоригийг зааглан ялгах үзэл санаа дэлгэрч, эдгээр нь XVIII-XIX зууны үеийн бичмэл хуулиудад тусгагдах болжээ. 1810 онд батлагдан гарсан Францын Эрүүгийн хууль нь Эх газрын эрүүгийн эрх зүйн систем үүсч бүрэлдэх анхны үр хөврөл нь болсон юм.

Улмаар 1871 онд Германы Эрүүгийн хууль, 1852 оны Италийн Эрүүгийн хууль, 1870 онд Испаний Эрүүгийн хууль, 1867 онд Бельгийн Эрүүгийн хууль, 1879 онд Люксембургийн Эрүүгийн хууль батлагдан гарч, үйлчилж эхэлсэнээр уг системийн орнуудын адил төст загвар бий болж хөгжих эхлэл тавигджээ.

Анхлан Франц, Герман, Итали, Испанид батлагдан гарсан Эрүүгийн хуулийн загвар нь шинэ үеийн болон эдүгээгийн Эх газрын системийн орнуудын эрүүгийн хуулийн чиг баримтлал нь болж хөгжсөн ажээ. Нийтлэг шинжүүдийг нь авч үзвэл гэмт хэргийн ойлголт, ангилал, төрлийг хуульчлан томъёолсон, хамтран оролцох болон эрүүгийн хууль үйлчлэх нөхцлийг заасан, ялын төрлийг хорих, албадан хүмүүжүүлэх, цаазаар авах, торгох зэргээр ангилан зааглаж хуульчилсан зэргийг дурьдаж болно.

Эдүгээгийн 1994 оны Францын Эрүүгийн хууль, 1987 оны Германы Эрүүгийн хууль, 1995 оны Испаний Эрүүгийн хууль, 1974 оны Австрийн Эрүүгийн хууль, 1930 оны Италийн Эрүүгийн хууль, 1982 оны Португалийн Эрүүгийн хууль зэрэг актуудыг бүхэлд нь шинжиж үзвэл анхны эрүүгийн хуулиудын загварыг устгаж, гээлгүй, харин ч өвлөн авч, баяжуулж хөгжүүлсэн, улам сайжруулсаныг харж болно. Энэ системд **"nullum crimen,**

nulla poena sine lege” (хуульд заагаагүй бол гэмт хэрэг биш, гэмт хэрэг биш бол ялгүй) гэсэн зарчим үйлчилдэг.

Үндсэн хууль бол эрүүгийн эрх зүйн тулгуур эх сурвалж болох бөгөөд эрүүгийн хууль болон эрүүгийн хуульчилсан актууд нь Үндсэн хуулинд захирагдсан байдаг. Хэдийгээр Францын ба Германы гэсэн хоёр дэд хэсэгт хуваагдаж харьцангуй тусдаа жижиг бүлүүдийг бий болгосон байдаг ч нилээд зүйлээр адил төстэй бөгөөд нийтлэг жишгийн зарим шинжүүдтэй. Үүнд:

- Эрүүгийн ерөнхий төрөлжсөн хуультай боловч гэмт хэргийн болон ялын үндэслэл, нөхцлийг эрүүгийн ерөнхий хуулиар зохицуулсан байх ба эрх зүйн журам зөрсөн гэмт хэргийн тухайд холбогдох эрүүгийн эрх зүйн институци нь өөр өөр зэрэгцсэн болон төрөлжсөн хуулиудаар зохицуулагдсан;

- Ялыг оногдуулах журам, ялаас чөлөөлөх, ял хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл, дэглэмийг эрүүгийн процессийн хуулиар голчлон зохицуулсан;

- Гэмт хэргийг ерөнхий шинж, ойлголтын хувьд эрүүгийн гэмт хэрэг, эрүүгийн бус гэмт хэрэг гэж авч үзэх бөгөөд хүнд, хүнд бус гэж ялгахгаас гадна эрүүгийн эрх зүйн тусгай ангид гэмт хэргийн төрлүүдийг тусгайлан жагсааж хуульчилсан;

- Гэмт хэрэг үйлдэх үе шатын бэлтгэл, завдалт, үргэлжлэл, төгсгөл гэж авч үзэхээс гадна гэмт хэрэгт хамтран оролцогч (гүйцэтгэгч, хатгагч, хамжигч, зохион байгуулагч, захиалагч), гэмт хэргийг үгүйсгэх байдал гэх мэт институтийг Эрүүгийн ерөнхий хуулиар томъёолж хуульчилсан;

- Эрүүгийн хууль нь бүтцийн хувьд ерөнхий (нийтлэг) ба тусгай (ялгарах) гэсэн хэсэгтэй ба хуулийн заалтууд нь нийгмийн харилцааны цаашид гарч болох тохиолдлыг хийсвэрлэн тодорхойлж томъёолсон шинжтэй ба хэм хэмжээнүүд нь хоорондоо шатлан уялдаж, маш нарийн холбогдож зохицуулагдсан;

- Гэмт хэргийн бүрэлдэхүүний дөрвөн элемент бүхий онол нь Эх газрын системд шууд хэрэглэгддэггүй (Оросынхтой яг адилаар) бөгөөд харин гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруугийн шинж, шалгуурыг тусгайлан авч үзсэн;

- Ялын хувьд төрөл, зүйл, нөхцөл, журам нь Эрүүгийн хууль тогтоомжуудад нарийвчлан хуульчлагдсан байх ба хорих ялын доод хязгаарыг ихэнхдээ тогтоогоогүй буюу 1 сараас хэтрэхгүйгээр хуульчилсан;

- Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг тусгайлан зохицуулсан байх г.м.

Эх газрын системийн эрүүгийн эрх зүйд хууль ёсны, гэм буруугийн төлөө хариуцлага хүлээх, энэрэнгүй ёсны, хуулийн өмнө эрх тэгш байх, гэмт хэрэг нь оногдуулах ялтайгаа тохирсон байх, шудрага ёсны зэрэг зарчмууд тусгалаа олжээ. Түүнчлэн шүүхийн болон шүүгчийн эрх мэдлийг хуулиар хязгаарлан, ял оноох нөхцөл, боломж, журам нь ихэнхдээ хууль буюу хуульчилсан актаар зохицуулагдсан байна. Шүүхийн прецедент, шүүхийн жишиг энэ системд үйлчлэхгүй. Энэ системийн эрүүгийн эрх зүйн онолд “гэмт хэргийн эрх зүй”

(Droit criminal), ялын эрх зүй (droit penal) гэсэн нэр томъёо түгээмэл хэрэглэгддэг бөгөөд органик эрүүгийн эрх зүйг бүрдүүлэгч бүрдэл хэсгүүд нь нийтлэг сэжмээр адил төст, харилцан хамааралт харилцааг зохицуулдагаараа нийтлэг нэг салбарын хүрээнд багтаж ойлгогдоно.

Уг системд ялын залхаах, цээрлүүлэх тал нь эрүүгийн эрх зүйн хамгаалах чиг үүрэг болсон байхаас гадна криминализацийн хатуу чанд процедурыг маш нарийн томъёолж хуульчилсан байдгаараа онцлогтой.

Эрүүгийн эрх зүйн зарим харилцаанд императив арга тусгагдсан байдгаас үүдэн гэмт хэргийг зүйлчлэх болон ялын хэрэглээнд уян хатан бус, хатуу чанд зарчим, зарим хэм хэмжээнд тусгалаа олсон байдгийг харж болно.

Орчин үеийн Франц, Герман, Италийн эрүүгийн эрх зүй нь постсоциалист орнуудын болон Орос, Монголын эрүүгийн эрх зүйтэй зарим талаар төстэй боловч нилээд зүйлээр буюу институцийн ихэнх асуудлаар ялгаатайг тэмдэглэх нь зүйтэй.

Эх газрын эрүүгийн эрх зүйн систем нь дэлхийн хэмжээнд зонхилох байрыг эзэлж чадсан бөгөөд дэлхийн өнцөг булан бүрт өөрийн бүлүүдийг үүсгэн, нөлөөлөх хүрээ нь улам бүр өргөжин, хөгжиж байна.

Францын пробацийн үйл ажиллагаа:

Франц улсын пробацийн үйл ажиллагаа нь өөрийн гэсэн онцлогтой хэрэгждэг бөгөөд хяналт, хязгаарлалтыг хорих ялын хугацаанаас үл хамааран тогтоодог. Ингээд Францын пробацийн үйл ажиллагаанд хамаарах чиглэлийг авч үзье:

- Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тавих хяналтын болон нөлөөллийн арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх /нөлөөллийн арга хэмжээ гэдэгт хяналтад орсон хүнийг нийгэмшүүлэх буюу нийгмийн харилцаанд дасгах, төлөвшүүлэх бүхий л үйл ажиллагаа хамаардаг/.

- Шүүхийн шийдвэрт заасан нэмэлт хязгаарлалт тогтоосон, заавал гүйцэтгэх үүргүүдийн биелэлтийг хянах, хэрэгжүүлэх нөхцөлийг хангах гэсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Францын эрүүгийн ялын гүйцэтгэлийн болон пробацийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжоор зохицуулж буй нэг онцлог зохицуулалт нь пробацийн хяналт, нөлөөллийн арга хэмжээг хэрэглэж буй практикийн дийлэнх тохиолдол нь хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд хамаардаг явдал юм.

Түүнчлэн тус улсын мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн зохицуулалтад хяналтад байгаа этгээд нь шүүх, пробацийн албаны хуулийн дагуу зохион байгуулах арга хэмжээнээс зайлсхийсэн, нуугдсан, тогтоосон хязгаарлалтын хүрээнд биелүүлбэл зохих үүргийг биелүүлээгүй тохиолдолд түүнийг эрэн сурвалжлах, баривчлах, улмаар хүндрүүлсэн нөхцөл байдалд

хяналтад шилжүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллагад шилжүүлэх захирамжийг шүүхээс гаргах талаар заасан байдаг нь пробагийн албаны үйл ажиллагааг хэвийн хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн зохицуулалт болжээ.

Үүнээс гадна пробагийн үйл ажиллагааны явцад ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс зайлсхийсэн тохиолдолд 5 хүртэл хоногоор баривчлах, хорих ялыг биечлэн эдлүүлэх захирамж гаргах эрхийг шүүхэд олгосон зохицуулалт мөн хэрэгждэг. Гэхдээ пробагийн хугацаа, нөхцөлийг өөрчилсөн шүүхийн шийдвэрт прокурор болон хяналтад байгаа этгээд өөрөө гомдол гаргах эрхийг нээж өгсөн байдаг.

Францын хууль тогтоомжоор пробагийн албаны үйл ажиллагааны гол чиглэл нь хяналтад байгаа этгээдийн хувийн байдлыг харгалзан зохих хяналтыг хэрэгжүүлэхэд чиглэдэг бөгөөд энэхүү мэргэжлийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжих гол үндэс нь тусгайлан мэргэшсэн пробагийн ажилтан болох талаар эрх зохицуулалтдаа тусгаж өгсөн байдаг⁵⁹.

Францын хуулиар эрүүгийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг бүтцийг “Пробагийн хороо” хэмээн нэрлэдэг бөгөөд дараах бүрэлдэхүүнтэйгээр чиг үүргээ хэрэгжүүлдэг. Үүнд:

- Ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шүүгч;
- Хорооны дарга;
- Хорооны ажилтнууд;
- Нийгмийн ажилтан, сургагч багш;
- Сурганы болон боловсролын чиглэлээр зөвлөгөө өгөх зөвлөгч ажилтнууд;
- Нарийн бичгийн дарга зэрэг бүрэлдэхүүнтэй ажилладаг байна.

Түүнчлэн Францын муж нутгуудын пробагийн хороо бүрийн дэргэд тусгай зөвлөл ажилладаг бөгөөд түүнд сайн дурын, буяны, сайн үйлсийн байгууллагын төлөөлөл багтдаг. Энэхүү тусгай зөвлөл нь хяналтад байгаа этгээдийн хорих байгууллагаас суллагдсаны дараа үүсдэг ахуйн болон материаллаг бэрхшээлүүдийг шийдвэрлэх, нийгмийн асуудалд туслах, энэ чиглэлээр боломжит нөхцөл байдлыг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Францын пробагийн хорооны үйл ажиллагаан дахь бас нэг онцлог нь өөрийн үйл ажиллагаанд иргэдийг сайн дурын үндсэн дээр татан оролцуулдаг явдал юм. Эдгээр иргэд нь пробагийн хорооны ажилтанд үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, хяналтад байгаа хүний өмнө үүссэн аливаа бэрхшээлийг шийдвэрлэхэд зохих тусламжийг үзүүлэх зохицуулалттай.

Францын пробагийн хорооны мэргэжлийн ажилтныг сонгон шалгаруулах асуудал хуульд зааснаар өөрийн гэсэн онцлогтой хэрэгждэг. Юуны өмнө хорих байгууллагад таваас доошгүй жил ажилласан нийгмийн

⁵⁹<https://cyberleninka.ru/article/v/suschnost-organizatsii-probatsii-vo-frantsii-velikobritanii-i-shvetsii> 2018.10.17.

ажилтан, сурган хүмүүжүүлэгчийн дундаас сонгон шалгаруулж авдаг бөгөөд ажилласан хугацааны 2-с доошгүй жилд нь сурган хүмүүжүүлэх чиглэлээр ажилласан байхыг шаарддаг. Шаардлага хангасан ажилтныг Хууль зүйн сайдын тогтоолоор пробацийн хорооны ажилтнаар томилдог байна.

Финляндын пробацийн үйл ажиллагаа:

Финлянд улс нь 1990-д оны үед дэлхийн зарим улс орны нэгэн адил пробацийн үйл ажиллагаанд төдийлөн ач холбогдол багатай хандаж ирсэн бөгөөд хувийн хэвшлийн байгууллагаар хэрэгжүүлэх зарчим баримталж байжээ⁶⁰. Гэсэн хэдий ч эрх зүйн болон нийгмийн хөгжлийн шаардлагаар 1999 онд хувийн хэвшлийн зүгээс гүйцэтгүүлж буй пробацийн үйл ажиллагаанд тусгай хүч хэрэгсэл ашиглах, хүний эрхийг хязгаарлах албадлагын асуудал нь эрх зүйн хувьд боломжгүй талаар Финляндын Үндсэн хуулийн 124 дүгээр зүйлд тусгасан байна.

Ийнхүү албадлагын шинжтэй пробацийн үйл ажиллагааны чиглэлийг төрийн байгууллага гүйцэтгэх эрх зүйн орчин бүрдсэнээр 2001 онд Хууль зүйн яамны Ял эдлүүлэх агентлагийн харьяанд анхны пробацийн хэлтсийг байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлжээ. Өнөөдрийн байдлаар тус нэгж нь Хууль зүйн яамны харьяа Эрүүгийн бодлогын департаментын харьяанд Пробацийн алба болон өргөжиж хорих байгууллагын хамт ял эдлүүлэх агентлагт харьяалагдан чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Финляндын пробацийн алба нь өнөөдрийн байдлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Нийгэмд тустай хөдөлмөр эрхлүүлэх;
- Насанд хүрээгүй хүний ял шийтгэл болон хяналтыг хэрэгжүүлэх;
- Тэнсэн хянан харгалзсан шийтгэлийг хэрэгжүүлэх;
- Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд хяналт тавих чиг үүргийг 21 дүүрэг, орон нутгийн 11 нэгжийн хүрээнд хэрэгжүүлж байна.

Финляндын пробацийн албаны нэг онцлог нь ажилтнуудын дийлэнх буюу 90 гаран хувийг энгийн ажилтнууд эзэлдэг явдал юм. Түүнчлэн салбар газруудын харьяанд насанд хүрээгүй хүнд тавих хяналт, тэнсэн хянан харгалзсан, хорих байгууллагаас суллагдсан хүнд үзүүлэх нийгмийн тусламж зэргийг хэрэгжүүлэхэд хувийн пробацийн нэгжийг ажиллуулж хамтран ажилладаг.

2 жил хүртэл хоригдох ял шийтгүүлсэн этгээдийг 1-3 жил хугацаагаар хойшлуулж хянан харгалзаж болдог байна.

Финлянд улсын хууль тогтоомжоор хорих ял эдэлж байгаа хүн бүр хугацааны өмнө тэнсэн суллагдах эрх зүйн боломжтой байдаг. Хууль тогтоомжид заасны дагуу хорих ял эдэлж байгаа этгээд нь урьд нь гэмт хэрэг үйлдэж байсан ялын 2/3-г эдэлсэн, анх удаа хорих ял шийтгэгдсэн бол ялын

⁶⁰ Probation and Probation service: A European Perspective (ed by A Van Kalmthout & J Derks). Wolf legal publishers. 2000., p 18.

тал хувийг эдэлсний дараа хорих байгууллагын захиргаанд хугацааны өмнө тэнсэн суллагдах хүсэлт гаргах эрх нээгддэг. Харин 21 насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдэж, тусгай байгууллагад ял эдэлж байгаа хүн ялын 1/3-г эдэлсэн тохиолдолд тэнсэн суллагдах эрх үүснэ.

Хорих байгууллагаас суллагдсан хүнд тавих пробацийн албаны хяналт, нийгмийн аливаа дэмжлэг туслалцааг үзүүлэх үйл ажиллагааг ихэнх тохиолдолд тэнсэн суллагдсан хугацааны туршид хэрэгжүүлдэг бөгөөд хуулийн дагуу гурван сараас багагүй, дээд хугацаа нь гурван жил байхаар зохицуулжээ. Тус улсын нийгмийн хөгжил, эрх зүйн соёлоос хамааран хугацааны өмнө тэнсэн суллагдсан бүх хүн пробацийн хяналтад шилждэггүй бөгөөд өнөөдрийн байдлаар нийт тэнсэн суллагдсан хүмүүсийн 20 орчим хувь нь пробацийн албаны хяналт, дэмжлэгт байдаг тоон үзүүлэлт байдаг⁶¹.

Бусад улсын нэгэн адил Финлянд улс хорихоос өөр төрлийн ял шийтгэлийн хэрэгжилтийг хангахаас гадна насанд хүрээгүй хүнд үзүүлэх тусламж, хяналтын арга хэмжээг хэрэгжүүлдэг бөгөөд өөрсдийн үйл ажиллагааг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын оролцоотойгоор шийдвэрлэдэг байна.

Финланд улсын шийтгэлийн систем буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн систем нь нео-классик онол дээр суурилсан байдаг. Тухайн шүүхийн шийдвэрийн системийн үндэс болох шийтгэлийн хууль ёсны үр нөлөө нь анхдагч урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанаас ихэд хамааралтай. Ёс зүй болон итгэлцэл гэдэг зүйлс бол хамгаас чухал. Учир нь зарим нэг төрлийн гаж зан үйлдлийг зайлшгүй шийтгэх ёстой ба хэрвээ хэн нэгэн нь гэмт хэрэгт буруутгагдсан нь тогтоогдсон л бол шийтгэгдэж, хуулийн өмнө хариуцлага хүлээн хийсэн үйлдлийнхээ үр дагаврыг буюу хуулийн хариуцлага заавал хүртэх ёстой гэсэн итгэл хууль ёсонд нь байдаг. Ийм учраас ял шийтгэлийн үндсэн шинж чанар нь хүний ёс зүйг дээшлүүлэхэд оршдог. Ёс зүйн хувьд ямар ч бага зөрчлийн хувьд, жишээ нь замын хөдөлгөөний зөрчлийн үед гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд баривчлах явдал болж өгдөг юм.

Финляндын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны өөр бас нэг тулгуур бол гэмт хэргийн улмаас гарах зардлыг аль болох бага байлгаж, нөхөн төлбөрийг шударгаар хуваарилан хүний үндсэн эрхийг хангах явдал юм.

Ял шийтгэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь голдуу хоёрдогч урьдчилан сэргийлэх арга хэмжээ гүйцэтгэхийг хэлдэг. Энэ нь ял шийтгэлийг оногдуулснаар гэмт хэргээс татгалзахад хүргэх бус, ердөө давтан хэрэг үйлдэх эрсдэлийг буруулахад чиглэгдсэн байна. Хорих байрны доторх нөхцөл болон орчин яг л тухайн нийгмийн амьдралын нөхцөлтэй адил байх ёстой. Бусад төрлийн эрхийн хориглолтыг хорих байгууламжийн дэглэм болон зэрэглэлээс

⁶¹ Обзор законодательства скандинавских и балтийских стран по службе пробации (уголовному надзору). Санкт-Петербург., 2010. Стр 142-144.

шалтгаалан чангаруулдаг. Ял эдлүүлэх хэрэгжүүлэх явцад аль болох ялтныг буцаад нийгэмшүүлэхэд бэлддэг онцлогтой.

Эрх чөлөөгүй болсноор ямар нэгэн гаж нөлөөлөл гарч, тодорхой хор уршиг учрахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулдаг. Хорихоос өөр төрлийн ял шийтгэлд тодорхой нөхцөлтэйгөөр гэм буруутнуудыг суллах, залуучуудыг хяналттай чөлөөлөх, насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдийг шийтгэх болон нийтийн үйлчилгээнд татан оролцуулах арга хэмжээнүүд багтана. Эдгээр нь бүгд давтан хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулж өгдөг. Нийтэд тустай ажилд татан оролцуулах шийтгэлийн нэг зорилго нь гэм буруутныг тодорхой хүмүүстэй танилцуулан улмаар цаашид түүний ажлын байртай болгоход чиглэгддэг. Ял шийтгэлийг гүйцэтгэх газар нь цагдаа, нийгмийн үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ болон боловсролын байгууллагуудтай нягт хамтран ажилладаг. Харин тодорхой нөхцөлтэйгөөр гэмт хэрэгтнийг суллах ял, шийтгэлийн зорилго нь хяналтад орсон хүнийг нийгэмшүүлэх замаар нийтийн аюулгүй байдлыг хангаж, улмаар түүнийг давтан хэрэг үйлдэхээс сэргийлэхэд оршдог байна.

Ял шийтгэлийг гүйцэтгэх газар нь хохирогчдод туслалцаа үзүүлэх ямар нэгэн үүрэг хүлээдэггүй. Харин энэ үүргийг Финланд улсын Хохирогчийг дэмжлэг үзүүлэх газар гүйцэтгэдэг байна. Тухайн газар нь сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнээс гадна цагдаа нар мөн хохирогчдыг хамгаалах үйлчилгээ үзүүлдэг. Гэр бүлийн хүчирхийлэл, ноцтой бэлгийн хүчирхийлэл аль эсвэл хүнд хэрцгий гэмт хэргийн золиос болсон хохирогчдод дэмжлэг үзүүлэх ажилтныг томилж өгдөг байна. Түүнээс гадна хэрвээ хүсвэл гэмт хэргийн хохирогч зөвлөгөө авах боломжтой ба тодорхой нөхцөлийг хангасан тохиолдолд өөрийгөө өмгөөлүүлэх хууль зүйн туслалцаа авах бүрэн боломжтой. Ял шийтгэлийг гүйцэтгэх газар нь мөн гэмт хэрэгт эвлэрүүлэх зуучлан үйл ажиллагаа явуулдаггүй. Тухайн үйл ажиллагааг засгийн газрын санхүүжилтээр ажилладаг бүс нутгийн зуучлалын газрууд гүйцэтгэдэг байна. Ял шийтгэлийг гүйцэтгэх газар нь хохирогчидтой ямар нэгэн байдлаар харилцаж ажилладаггүй.

Нийтийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд гэмт хэргийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн аль эсвэл боловсролын чиглэлээр тодорхой туршлага хуримтлуулсан, мөн тухайн чиглэлээр сурч боловсорсон хүмүүс хамрагдаж, туслах ажилтны үүргийг гүйцэтгэдэг. Өөр бусад хүмүүсийг нийтийн үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай аль эсвэл бусад холбогдох шалтгааны дагуу томилох боломжтой гэж үзсэн тохиолдолд үйл ажиллагаанд хамруулж болдог. Хорихоос өөр төрлийн ял оногдуулан сулласан хэрэгтнийг хянах явцад гэмт хэргийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн аль эсвэл боловсролын чиглэлээр тодорхой туршлага хуримтлуулсан хүн ерөнхий хянагчид туслах үүрэг гүйцэтгэн ажилладаг байна. Өөр бусад хүмүүсийг туслах ажилтан үүргээ гүйцэтгэхэд хэрэгтэй гэж үзсэн тохиолдолд мөн томилох боломжтой. Хэн нэгнийг тодорхой нөхцөлтэйгөөр суллаж байгаа

тохиолдолд ял шийтгэлийг гүйцэтгэх газар гаднын хяналтын ажилтныг томилж болдог. Гол нь тухайн хүн тодорхой болзлыг заавал хангасан байх шаардлага тавьдаг.

Финландын эрх зүйн тогтолцоо нь Европын тэнсэн харгалзах тухай дүрмийн шаардлагуудыг хангасан байдаг. Алба хаагчдыг сонгон шалгаруулах ажиллагааны хувьд боловсрол болон ажлын байранд тохирох эсэх талаар дурдсан ерөнхий шалгуурууд бий. Түүнээс гадна нэр дэвшиж буй хүн багаар хамтран ажиллах өндөр чадвартай байх шаардлагатай ба захиалагчдын зүгээс өгөх асар их ачааллыг даах чадалтай байх хэрэгтэй. Нэр дэвшигч нь мөн ажлын байрны онцлогоос хамааран тусгай ур чадвар эзэмшсэн байх ёстой. Нэр дэвшигчдийг сонгосны дараагаар бүх сонгогдсон хүмүүс 4 хоногийн туршид сургалтад суух шаардлагатай.

Ажилтнаар томилогдсон тохиолдолд алба хаагчийн бүхий л ажлын замналыг тусгасан сургалтын төлөвлөгөөг гаргаж, үүнийг явц дунд ажлын байрны онцлогоос хамааран шинэчилдэг. Нэгэнт албан ёсны ажилтан болсон тохиолдолд алба хаагчдад мөн их сургуульд суралцах аль эсвэл мэргэжил дээшлүүлэх политехникийн коллежид суралцах боломжийг олгодог байна. Тэнсэн харгалзах албаны ажилчдад тодорхой хавтас хэргүүдийг өгдөг. Үүнийг ашиглан тэд ажилтайгаа танилцаж, улмаар ажлаа суралцдаг байна. Харин нэг хүнд өдөр бүр ноогдох үйлчлүүлэгчдийн тоо бүс нутгаас хамааран янз янз байгаа юм. Үүний хүрээнд тэнсэн харгалзах ялыг хариуцсан алба нь эрт дээр үеэс шүүхийн байгууллагуудтай сайн харилцаа тогтоож, эрүүгийн системийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагууд болох иргэний нийгэмлэгийн байгууллагууд болон тэдгээрийн салбаруудтай нягт холбоо тогтоон хамтран ажиллаж ирсэн. Хорихоос өөр төрлийн ял оноож буй тухай тайлан боловсруулах тэнсэн харгалзах албаны нэг том ажил бөгөөд энэ нь хуульд тусгагджээ. Гадаадын иргэдийг чухам яах талаар тодорхой эрх зүйн зохицуулалт одоохондоо Финландын хууль тогтоомжид байхгүй. Мөн Финландын иргэдийг гадаадад баригдсан тохиолдолд яах талаар тодорхой зохицуулалт байхгүй юм.

Тэнсэн харгалзах алба нь үндсэндээ ял шийтгэлийг гүйцэтгэх газрын нэг хэсэг бөгөөд Хууль зүйн яамны Эрүүгийн бодлогын хэлтэс доор харьяалагддаг. Эрүүгийн бодлогын хэлтэс нь Финланд улсын ял шийтгэлийн бодлогыг боловсруулж, ял шийтгэлийг гүйцэтгэх газрын ажлын гүйцэтгэлийг хянаж, тодорхойлдог. Ял шийтгэлийг гүйцэтгэх газар нь гурав нь салбартай. Төв захиргааны хэлтсээсээ гадна тухайн газар нь Хууль сахиулах хэлтэс, Эрүүл мэндийн хэлтэс болон Хорих, тэнсэн харгалзах албаны ажилчдыг бэлтгэх хэлтэстэй юм.

Бүтэц зохион байгуулалтын шинэчлэлтийг гүйцэтгэхийн хажуугаар Эрүүгийн шийтгэлийн ажилтан гэдэг ажлын байрыг бий болгосон. Энэ нь ял шийтгэлийг гүйцэтгэх ажилд хамааралтай бүхий л шатны алба хаагчдыг хэлнэ. Нийтэд тустай ажил хийлгэх газрын алба хаагчдыг дараах байдлаар

шатлалын дагуу хуваана: 1) захирал, 2) дэд захирал, 3) ахлах эрүүгийн шийтгэлийн ажилтан, болон 4) эрүүгийн шийтгэлийн ажилтан.

Нийтэд тустай ажил хийлгэх газрын үндсэн үүрэг нь төлөвлөсөн зорилтуудын дагуу ажил үүргийг зохион байгуулж гүйцэтгэх юм.

Захирал нь хүний нөөцийн ур чадвар болон хүчин чадал дээр үндэслэн ажил үүргийг хуваарилах ажлыг гүйцэтгэдэг. Дэд захирал нь ажил үүргийг удирдан зохион байгуулж, боловсруулах үүргийг гүйцэтгэдэг. Ахлах эрүүгийн шийтгэлийн ажилтан нь өөр өөрийн хариуцсан хэсгийн дагуу ажил үүргээ зохион байгуулж, жирийн эрүүгийн шийтгэлийн ажилчдыг удирдлагаар хангах үүрэгтэй.

Харин эрүүгийн шийтгэлийн ажилтан нь нийтэд тустай ажил хийлгэх ажлыг оногдуулан гүйцэтгэх үүрэг хүлээдэг байна. Ажил үүргийг гүйцэтгэхдээ хүн бүр хамтран ажилладаг ба тодорхой нэг ажлыг хариуцаж аль эсвэл ажилд мэргэшэх шаардлагагүй. Гэхдээ зарим нэг том салбар газрууд зөвхөн тайлан болон төлөвлөгөө боловсруулах тусгай нэгжтэй байх жишээний. Алба хаагчдыг мөн шийтгэлийн төрлөөс шалтгаалан багт хуваах боломжтой. Тухайлбал, нийтийн үйлчилгээний болон хяналтын баг зэргээр.

Насанд хүрээгүй гэмт хэрэгтнийг хорихын оронд хяналтад оруулах шийтгэлийг оногдуулахаас өмнө заавал тухайн сэжигтний нөхцөлийг тодруулах актын дагуу шалгадаг. 1 дүгээр хэсгийн дагуу залуу сэжигтэн гэдэгт 15-аас 20 насны хүүхэд болон залуус хамаарна. Үүнийг гүйцэтгэж буй үндсэн зорилго нь залуу сэжигтний нийгмийн нөхцөл байдлыг судалж, улмаар түүний давтан хэрэг үйлдэх боломжийг үнэлэн цаашид давтан гэмт хэрэг үйлэхээс хэрхэн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад оршиж байгаа юм.

2 дугаар хэсэгт мөн залуу сэжигтэн гэдэг нь ямарваа нэгэн хэрэгт буруутгагдаж буй 15-аас 20 насны хүмүүсийг хэлнэ гэж заажээ. Анх гэмт хэрэгт буруутгагдсанаас хойш 14 хоногийн дотор залуу сэжигтнийг шүүхээс өмнөх шатны байгууллагуудын мэдээллийн системд бүртгэж, үүний дараагаар хэргийг хариуцаж буй прокурор, ял шийтгэлийг гүйцэтгэх газар болон нийгмийн халамжийн байгууллагуудад мэдээлэлдэг. Гэхдээ дараах тохиолдолд мэдээлэл хийх шаардлагагүй байдаг. Үүнд:

1) шүүхийн өмнөх шатны явцад хэргийг шийдвэрлэх;

2) сэжигтэн 18-аас 20 насны этгээд бөгөөд харьцангуй хөнгөн гэмт хэрэгт буруутгагдан шийтгэгдэх гэх зэрэг тохиолдлууд багтана.

Залуу сэжигтний талаар мэдээлэл авснаас хойш 14 хоногийн дотор прокурор ял шийтгэлийг гүйцэтгэх газарт хүсэлт гарган хэргийн талаар урьдчилсан тайлан гаргуулан тухайн хэргийн зэрэглэлийг тогтоолгоно. Урьдчилсан тайлан нь хэрэгтэнд тулгах гэж буй ял шийтгэл хэр зохимжтой болох талаар тайлбарлах бөгөөд өөр бусад төрлийн сонголтуудыг харьцуулан санал болгосон байх ёстой. Ингээд прокурорын шийдвэрээр ямар төрлийн ял оногдуулах нь хамгийн зохистой болохын сонгодог.

Үүнд нийтэд тустай ажил хийлгэх ялыг татан оролцуулах шийтгэл багтана. Ял шийтгэлийг гүйцэтгэх газрын боловсруулсан урьдчилсан тайлан нь шүүх байгууллагуудад заавал биелүүлэх ёстой даалгавар болдоггүй. Гэхдээ бодит практик дээр тухайн тайлан нь тодорхой удирдамж буюу заавар болж өгдөг.

Түүнээс гадна нийтэд тустай ажил хийлгэхдээ заавал гэмт хэрэгтний зөвшөөрлийг авах шаардлагатай ба эс бөгөөс тухайн ялыг оногдуулах боломжгүй.

Нийтэд тустай ажил хийхээс татгалзсан тохиолдолд хэрэгтнийг хорино. Тухайн зохицуулалтын зорилго нь сэжигтний сонголтыг хүндэтгэн танилцуулах бөгөөд шийдвэрийн талаарх санал хүсэлтийг сонсох юм. Нийтэд тустай ажил хийлгэхдээ татан оролцуулж байгаа тохиолдолд хамгийн ихдээ 8 сарын шийтгэл оногдуулж болдог. Түүнээс гадна хорих болон нийтэд тустай ажил хийлгэх ял, шийтгэлийг хамтад нь оноох бүрэн боломжтой.

Хорих ялыг нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлээр солих боломжтой гэж үзсэн тохиолдолд прокурор ял шийтгэлийг гүйцэтгэх газарт хандан сэжигтний үр чадварт тохирох эсэхийг үнэлж, мөн түүнийг тухайн шийтгэлийг гүйцэтгэх хүсэл сонирхолтой болохыг тодруулж өгөх үнэлгээ хийдэг. Гол нь ямар нөхцөлтэйгөөр тухайн ял шийтгэлийг гүйцэтгэх талаар хангалттай мэдээлэл өгдөггүй нь нэг сул тал. Ингээд ял шийтгэлийг гүйцэтгэж эхэлснээр гэм буруутны амьдралын нөхцөл байдлыг авч үзэн тодорхой эрсдэл, хэрэгцээ, шаардлага болон нөөц хэрэгслийг үнэлэн гаргаж ирдэг. Ийнхүү үнэлгээ нь дээр үндэслэн ял шийтгэлийг гүйцэтгэх хугацаанд гэм буруутныг чухам хэрхэн хянах талаар ажлын төлөвлөгөө гаргаж, түүний зорилго болон аргачлалыг боловсруулдаг.

Гэм буруутан мөн ийнхүү төлөвлөгөөг боловсруулахад оролцож, юу хэрэгтэй болохоо тодруулж өгдөг. Үйл явц болон үр дагаврыг гэм буруутан бас тайлбарлаж өгөх шаардлагатай.

Ял шийтгэлийн хугацаа урт байх тусам үнэлгээг хянаж, шинэчлэх тохиолдол ихэсдэг. Ихэнх тохиолдолд гэмт хэрэгтний амьдралын нөхцөл байдал эрс өөрчлөгдөж, хяналтын явцад тодорхой хэмжээгээр ялын зэрэглэл болон хугацааг өөрчлөх шаардлага гарсан бол үнэлгээг дахин шинэчилдэг.

Ял шийтгэлийн төгсгөлд эцсийн тайланг заавал боловсруулдаг. Тэнсэн харгалзах шийтгэлийг гүйцэтгэх алба хаагчид бүгд энэ талаар сургалтад хамрагдах шаардлагатай. Алба хаагчид аль болох тэнсэн харгалзах үйл ажиллагааг харилцан ярилцаж тохиролцсоны үндсэн дээр гүйцэтгэх ёстой ба ялын төлөвлөгөө гэм буруутны амьдралын нөхцөл байдал болон зан авирт тохирч байгаа эсэхийг сайтар бодолцдог. Гэм буруутныг хянах ажиллагаа нь дахин нийгэмшүүлэх болон хязгаарлан тогтоох үйлдлийн хослол байдаг. Энэ утгаараа сүүлийн үед маш олон янзын хязгаарлан тогтоох болон дахин нийгэмшүүлэх аргачлалыг боловсруулсаар байгаа юм.

Тэнсэн харгалзах албаны ажилчид өнөөгийн байдлаар гэм буруутныг урамшуулан сэтгэл санааг нь өөдөн татах ярилцлагын арга эзэмшсэн байдаг бөгөөд дийлэнх нь гэмт хэрэгтнийг дахин нийгэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх чадвартай байдаг. Тэнсэн харгалзах үйл ажиллагааны мөн чанар нь Эрүүгийн шийтгэлийн ажилтан гэм буруутныг хянах ажлыг зохион байгуулж, төлөвлөж болон үнэлэх ёстой гэсэн зарчим дээр суурилдаг. Гэм буруутны амьдралын нөхцөл байдал болон гэмт хэрэгт дахин холбогдох явдлыг мэдээллийн санд бүртгэх зорилгоор тэнсэн харгалзах албаны ажилчид тогтмол тэдгээртэй уулзалт зохион байгуулдаг.

Тиймээс тэнсэн харгалзах алба шүүх болон прокурорын байгууллагуудад өөрсдийн улирал тутмын тайлан болон төлөвлөгөөний биелэлтийг хүлээлгэн өгдөг.

Тэнсэн харгалзах албаны үйл ажиллагааг эрүүгийн системийн хүрээнд хууль ёсны дагуу төрөөс санхүүжүүлдэг. Сүүлийн хэдэн жилд тэнсэн харгалзах албаны үйл ажиллагааг Финланд улсын парламентын омбудсман хянахаа больсон. Ял шийтгэлийг гүйцэтгэх газрын хэрэгжүүлж буй стратегийн гол зарчим нь удирдлага, менежментийн үр чадварыг дээшлүүлж хөгжүүлэх явдал юм. Үүнийг чухам янз бүрийн аргачлалаар хянаж. Алба хаагчдыг бас үүний адил ажлын биелэлтийг үнэлэх системийн дагуу үнэлж, урамшуулдаг.

Бусад алба хаагчидтай харьцуулбал тэнсэн харгалзах албаны ажилчид харьцангуй бага цалинтай. Нотолгоонд суурилсан аргачлалыг сүүлийн хэдэн жилд боловсруулахын тулд ихэд хичээж байгаа. Финланд улсын эрүүгийн эрх зүйн бодлого нь мэргэжилтний зөвлөгөөнд суурилсан. Өөрөөр хэлбэл тухайн бодлогын шинэчлэлт болон үйлчилгээг ерөнхийдөө шинжлэх ухаан болон экспертүүдийн мэдлэг дээр үндэслэн гүйцэтгэдэг.

Тэнсэн харгалзах албаны үйл ажиллагааг зөвхөн төрөөс зохицуулдаг тул хувийн хэвшлийн зүгээс ямар нэгэн сан байдаггүй. Жил бүр тухайн үйлчилгээний санхүүжилтийг засгийн газрын төсвөөс олгодог. Төсвийн саналыг боловсруулахдаа Хууль зүйн яам нь эрүүгийн эрх зүйн үйл ажиллагааны үр дүн, эдийн засгийн нөхцөл болон үр өгөөжийг тусган гаргадаг. Мэдээж хэрэг үндсэн үзүүлэлтүүдийг ашиглан үүнийгээ боловсруулдаг.

Тэнсэн харгалзах албаны үйл ажиллагааг жил бүр тайлагнадаг. Хэвлэл мэдээллийн байгууллагуудыг жил бүр уулзалтад урьж, тодорхой тайлан тавьдаг байна. Ял шийтгэлийг гүйцэтгэх газрын төв хэлтсийн Олон нийттэй харилцах алба тэнсэн харгалзах үйлчилгээ болон эрүүгийн шийтгэлийн талаар мэдээлэл бэлтгэдэг байна. Ял шийтгэлийг гүйцэтгэх газар нь их сургууль болон судалгаа шинжилгээний байгууллагуудтай маш сайн харилцаатай бөгөөд хамтран ажилладаг. Бодлогын шинж чанартай баримт бичиг болон бусад тэнсэн харгалзах үйл ажиллагаатай холбоотой материалд засгийн газрын нэгжүүд, иргэний нийгэмлэгүүд болон олон нийт бүрэн хандах

боломжтой. Эдгээр мэдээлэл нь үндэсний болон олон улсын хэмжээнд нээлттэй байдаг юм байна.

Тэнсэн харгалзахаар гарч буй гэмт хэрэгтний эрхийг дөрвөн түвшинд хуульчлан зохицуулж өгсөн байдаг. Нэгдүгээрт, нийтийн үйлчилгээнд татан оролцуулах гэж байгаа бол заавал гэмт хэрэгтний зөвшөөрлийг авах шаардлагатай, хоёрдугаарт, түүнд тэнсэн харгалзах ажлын төлөвлөгөөг заавал танилцуулах, гуравдугаарт, тэнсэн харгалзахаар чөлөөлөгдсөн байх явцад ямар нэгэн зөрчил илэрсэн тохиолдолд хэрэгт холбогдсон этгээдийн дуу хоолойг заавал сонсох хэрэгтэй. Хэрвээ шүүхээс илүү хатуу шийтгэл оноох хэрэгтэй гэж үзвэл түүнд сануулга өгөхөөс өөр хүнд шийтгэл оноох боломжтой. Хамгийн сүүлд буюу дөрөвдүгээрт, хяналтын ажилтны талаар гомдол хүсэлтийг ял шийтгэлийг гүйцэтгэх газарт аль эсвэл парламентын омбудсман болон Хууль зүйн сайдад мэдэгдэх эрх гэж бий.

Тэнсэн харгалзахаар чөлөөлөгдсөн этгээдийн эрх ял шийтгэлээс хамааран өөр өөр байдаг бөгөөд үүнийг тодорхой акт болон хуулийн тушаалаар зохицуулж өгсөн байдаг ба гол эрхүүдийг Финланд улсын эрх зүйн тогтолцоо хангасан байдаг ба Европын тэнсэн харгалзах тухай дүрмийн дагуу зохицуулж өгсөн байдаг.

Дани улсын пробацийн үйл ажиллагаа:

Дани улсын хувьд хорих байгууллага болон пробацийн албыг нэгтгэсэн төрийн байгууллага 1973 онд байгуулагдсан байна. Энэхүү нэгдсэн алба байгуулагдах хүртэлх хугацаанд 1951 оноос Данийн нийгмийн тусламжийн нийгэмлэг хорих байгууллагаас суллагдсан хүмүүст тусламж үзүүлэх пробацийн чиг үүргийг хэрэгжүүлж байжээ. Өнөөдрийн байдлаар энэхүү нийгэмлэг нь пробацийн албатай хамтран хяналтад авагдсан хүмүүст туслах чиг үүргийг хувийн хэвшлийн шинжтэйгээр хэрэгжүүлсээр байна.

Данийн пробацийн албаны зорилго нь бусад хууль сахиулах байгууллагын нэгэн адил гэмт явдлыг бууруулах, рецидив гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг бөгөөд энэхүү зорилгын хүрээнд 1993 онд үйл ажиллагааны зарчим, чиглэлийг эрх зүйн хувьд баталгаажуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, пробацийн үйл ажиллагааны чиглэл, үндсэн агуулгыг тусгайлан хуульчилсан байна. Үүнд:

- Хорих ял эдлүүлэх ажиллагааг суллагдсаны дараах хэвийн амьдралд шилжихэд нөлөөлөхөд чиглүүлэх;
- Хорих ял шийтгэгдсэн хүнийг ар гэр, нийгэмтэй байнгын уялдаа холбоотой, нээлттэй нөхцөлд байлгах;
- Суллагдсаны дараах хууль сахин биелүүлэгч, зөв иргэн болон төлөвших хариуцлагын мэдрэмжийг хөгжүүлэх;
- Хорих ял шийтгэгдсэн болон суллагдсан хүмүүст тавих хяналт, нөлөөллийн ажлын хүрээнд нийгмийн аюулгүй байдлыг хангах;

- Эрхийн хязгаарлалт, албадлагын арга хэмжээг хамгийн бага түвшинд хэрэглэх зэрэг зарчмыг удирдлага болгон чиг үүргээ нийцүүлэн зохион байгуулах;

- Дээрх чиглэлүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд боломжит бүхий нөөц, хүч хэрэгслийг ашиглах зэрэг болно.

Дани улсын хувьд пробацийн албыг хорих байгууллагатай нэгдсэн бүтцэд зохион байгуулдаг бөгөөд Хууль зүйн яамны харьяанд багтдаг. Тус улсад хорих байгууллагаас гадна пробацийн төв, түр байрлуулах байрууд бүсчилсэн хэлбэрээр ажиллаж хорих ялаас хугацааны өмнө суллагдсан болон хяналтад авагдсан хүмүүст тусламж, үйлчилгээг үзүүлдэг.

Дани улсын хувьд пробацийн албаны ажилтнуудыг тусгайлан бэлтгэж томилдог ба нийт албан хаагчдын 95 хувийг пробацийн нийгмийн ажилтан бэлтгэх тусгайлсан мэргэжлийн сургууль төгссөн мэргэжлийн нийгмийн ажилтан бүрдүүлдэг. Энэ мэргэжлийн сургалтын хүрээнд суралцагч нь сэтгэл зүй, нийгмийн бодлого, нийгэм судлал, иргэний эрх зүй, эрүүгийн эрх зүй, нийгмийн эмчилгээ, нийгмийн ажлын онол, арга зүй зэрэг мэргэжлийн хичээлүүдийг гүнзгийрүүлэн судалдаг.

Данийн пробацийн албанд бусад улсын нэгэн адил сайн дурын ажилтныг өргөнөөр ашигладаг. Сайн дурын ажилтан нь пробацийн албаны ажилтанд шүүхэд тайлан, мэдээлэл танилцуулахад туслахын зэрэгцээ нийгмийн тусламж, нөлөөллийн ажлыг хариуцан гүйцэтгэдэг. Сайн дурын ажилтны үйл ажиллагаанаас гарсан албан ёсны зардал, цалинг төрөөс санхүүжүүлдэг бөгөөд байгууллагатай албан ёсоор хөдөлмөрийн гэрээний харилцаа үүсгэдэггүй.

Данийн пробацийн албаны үйл ажиллагаа нь дараах үндсэн агуулгын хүрээнд хэрэгждэг. Үүнд:

- Пробацийн албаны ажилтан өөрийн чиг үүргийг эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааны анхан шатнаас эхлүүлэх;

- Хяналтад авсан хүнийг тухайн хүний нийгмийн орчин буюу гэр бүл, ойр дотны хүрээлэл, өөрийн үндсэн харьяалал бүхий газар оронд нийгэмшүүлэх;

- Пробацийн албыг орон нутгийн засаг захиргааны нэгжтэй уялдуулан зохион байгуулж, албаны мэргэжлийн ажилтнууд мөн адил үйл ажиллагаагаа байнгын нягт харилцаатай байдлаар зохион байгуулах;

- Пробацийн албаны үйл ажиллагааг мөрдөн шалгах, шүүн таслах, ял эдлүүлэх болон суллагдсаны дараах бүхий л хугацаанд тасралтгүй шинжтэйгээр зохион байгуулах;

- Пробацийн албаны үйл ажиллагааг хорих байгууллагын болон төрийн бусад байгууллага, орон нутгийн удирдлагатай нягт хамтын ажиллагааны үндсэн дээр хэрэгжүүлэх зэрэг зарчим, чиглэлийг удирдлага болгодог байна.

Данийн пробацийн албаны үндсэн чиг үүрэг нь шүүхээс тогтоож өгсөн хугацаанд хяналт тавьж, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэхээс гадна мөрдөн шалгах ажиллагааны явц дахь хувь хүний нөхцөл байдал, цаашид авч болох хязгаарлалтын арга хэмжээний саналыг тусгасан илтгэл, тайланг

шүүхэд танилцуулах ажлыг хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, Данийн пробацацийн алба нь шүүн таслах ажиллагаа хүртэлх хугацаанд сэжигтэн, яллагдагчид ажил эрхлэлт болон нийгмийн асуудалтай холбоотой бэрхшээлийг шийдвэрлэхэд туслах, хувь хүний нөхцөл байдалтай холбоотой сөрөг дүгнэлтийн үр нөлөөг бууруулах байдлаар авч болох ял шийтгэлийн төрлийг оновчтой сонгох нөхцөлийг бий болгоход хувь нэмрээ оруулдаг.

Данийн хууль тогтоомжийн хүрээнд хорих ял эдэлж байгаа хүн ялынхаа 2/3-г эдэлсний дараа тэнсэн суллагдах эрх үүсдэг бөгөөд пробацацийн албаны хяналт, дэмжлэгт байх хугацаа нь гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар үргэлжилдэг. Харин тэнсэн суллагдсан хүний эдлээгүй үлдсэн ялын хэмжээ хоёр жилээс их болон тухайн хүний хувийн байдлаас шалтгаалан урт хугацаагаар хяналтад байлгах шаардлагатай гэж үзвэл зөвхөн шүүхийн шийдвэрээр хугацааг уртасгадаг.

Пробацацийн албаны хяналтад оруулах асуудлыг шүүх шийдвэрлэдэг бөгөөд хяналтад авагдсан хүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн амьдралд дасан зохицох нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн дэмжлэг туслалцааг хэрэгжүүлдэг байна. Пробацацийн албанаас үзүүлж буй дэмжлэгийн гол чиглэл нь амьдрах орон байр, мэргэжил эзэмших сургалтад хамрагдах, ажлын байр олох зэрэгт чиглэгддэг онцлогтой.

Австри улсын пробацацийн үйл ажиллагаа:

Австрийн пробацацийн байгууллагын бүтэц, тогтолцоо нь Европын бусад орнуудтай харьцуулахад нэлээд онцлогтой. Австри улсын хэмжээнд "NEUSTART" байгууллага нь хохирогч, гэмт хэрэгтнүүдэд зориулсан нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлдэг ашгийн бус хувийн байгууллага юм.

1969 онд хяналтын үйлчилгээний тухай хууль батлагдсан ба энэ хуулиар дээрх нь байгууллага үйл ажиллагаа явуулах эрхээ авч байжээ. Анх төрийн үйлчилгээг бий болгох хүртэл энэ нь түр зуурын хугацаатай байсан хэдий ч хувийн байгууллагын хяналтын үйлчилгээний давуу тал удахгүй тодорхой болсон.

Хувийн байгууллагаас пробацацийн үүрэг гүйцэтгэх нь нийгмийн ажлын харьцангуй бие даасан мэргэжлийн чиг үүрэгтэй байх, шинэ үйлчилгээг хөгжүүлэх боломжийг турших, туршилтын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, нийгмийн өөрчлөлтөд хурдан хариу үйлдэл үзүүлэх уян хатан байдал, ажилчдын нийгмийн хамгааллын тогтолцоо зэрэгт төрийн албатай харьцуулахад бага зардалтай байсан. Пробацацийн албаны зохион байгуулалт, үйлчилгээ нь хувийн эсвэл төрийн байгууллагын харьяалалд байх гэсэн хэлбэртэй байна.

Австри улсын пробацацийн албаны түүхийг үечлэн авч үзвэл:

1. 1950-иад онд "эцэггүй нийгэм-босогч-өсвөр үеийнхэн"

1950-иад оны “эцэггүй” нийгэмд дайны үед эцэг, эхээ алдсан насанд хүрээгүй гэмт хэрэгтний тоо огцом нэмэгдсэн байна. Шорон, ажлын байр, түр орогнуулах газар, насанд хүрээгүй хүүхдийн хорих зэрэг нь тухайн асуудлыг шийдэх хэрэгсэл болж байв.

Kaiser-Ebersdorf-ын хаалттай байгууллагад 400 орчим насанд хүрээгүй хүүхдийн “бослого” бий болсон нь 1957 оны 10-р сарын 4-нд Dr. Schindler-ийн удирдлаган дор анх пробацийн албыг байгуулах талаар хуралдахад түлхэц болжээ.

2. 1960-аад оны “Нийгмийн байдал-шийтгэхийн оронд туслах”

Эдгээр жилүүдэд эдийн засаг, сэргээн босголт эрчимжиж, ажил эрхлэлт, хөдөлмөрийн хомсдол давамгайлж байв. Хууль зүйн шинэ сайд, Christian Broda нь насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг 1961 онд хуульчилж, тэр нь насанд хүрээгүй хүмүүст зориулсан хяналтын үйлчилгээ үзүүлэх талаар тусгасан. 1963 оны байдлаар Холбоо нь “Хяналтын үйлчилгээ, нийгмийн ажил” нийгэмлэгийн нэрээр, Элизабет Шилдерийг удирдах захирлаар томилон, “Шийтгэхийн оронд туслах” гэсэн үндсэн зарчмаар явагдаж эхэлсэн байна. 1969 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Үндэсний Ассамблейн санал нэгтгэйгээр Хяналтын тухай хууль баталжээ.

3. 1970-аад онд “Газрын тосны хямрал-мансууруулах бодисын асуудал-шийтгэлийн оронд эмчлэх”

1970-аад оны дундуур “газрын тосны хямрал” үүссэнээр эдийн засгийн өсөлт удааширч, ажилгүйдлийн хэмжээ өсч, “ажилгүйчүүдийн асуудал” олон нийтэд яригдаж байв. Үүний зэрэгцээ залуучуудын соёлын зарим хэсэгт мансууруулах бодис хэрэглэх явдал нийгмийн анхаарал татсан асуудал болж байв.

Пробаци, нийгмийн ажлын холбооны үйлчилгээ Венед эмийн зөвлөгөө өгөх нэртэйгээр байгуулагдаж “Өөрчлөлт” гэж нэрлэн, “Шийтгэлийн оронд эмчлэх” гэсэн уриатайгаар үйл ажиллагаа явуулж байв. Хууль тогтоох салбар дахь томоохон өөрчлөлтүүд 1975 онд Эрүүгийн хуулийн шинэчлэлийн хүрээнд гарч ирсэн.

4. 1980-аад он “Гэм буруугийн төгсгөл-гэр орон, шүүхийн арга хэмжээний хувилбар–хохирогчид туслах ”

Эдийн засгийн хувьд хүндхэн цаг хугацаа байв. Пробацийн албаны тухай хуульд 1981 онд нэмэлт өөрчлөлт оруулан хяналтын үйлчилгээг хувьчлах үндсийг тавьжээ. 1980 онд мансууруулах бодисын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа “шийтгэлийн оронд эмчилгээ” гэсэн зарчмыг баримталж Пробацийн албанд шинэ үүрэг хүлээлгэсэн байна. Гэмт хэргийн хохирогч нийгмийн ажлаар дамжуулан дэмжлэг авах боломж бүрджээ.

5. 1990-ээд он “Нээлттэй хил-хохирогчийг хамгаалах-олон нийтийн үйлчилгээ”

Австри улс бүх нийтийн санал асуулгын үндсэн дээр Европын Холбоотой нэгдсэн. 1994 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Хяналтын үйлчилгээний байгууллага болон яам хоёрын хооронд ерөнхий хэлэлцээр байгуулагдсан. Австрид гэмт хэрэгтнүүд үзүүлэх үйлчилгээ нь Европын бусад олон орнуудтай харьцуулахад хувьчлагдсан байна. Хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 1997 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд хохирогчийн хамгаалалт, хохирогчид туслах талаар NEUSTART-д илүү ач холбогдол өгч, дараа нь холбогдох төслүүдэд туршиж үзсэн байна.

6.2007 оноос хойшх үе “Олон улсын сүлжээ, цахим хяналт, зардал хэмнэх”

Пробацийн үйлчилгээ, шүүхийн туслалцаа, гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны эхлэл 2007 оны 1-р сарын 1-нд Badenwürttemberg дахь NEUSTART-д тавигдсан. Дараа нь шоронгоос суллагдан хоригдлуудыг дэмжих шинэ хэлбэрийг Австри улсад нэвтрүүлжээ. 2008 онд гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийн “цахим хяналт” төслийг эхлүүлсэн байна.

Олон жилийн туршид хоёр холбоо хяналтын ажлыг зохион байгуулж, гүйцэтгэж байсан бол (NEUSTART урьд нь /Хяналт, нийгмийн ажилтны холбоо-8 мужид, 9 дөх мужид Стирилид, “Реттет да Kind” хүүхдийн холбоо), 1999 оноос яам онцгой үүрэг гүйцэтгэгчээр NEUSTART-тай гэрээ байгуулахаар шийджээ.

Австри Европын Холбоонд элсэх үед Австрийн Хууль зүйн яам болон Австрийн парламент нь хувийн хяналтын байгууллагыг итгэмжлэхээр шийдвэрлэсэн нь NEUSTART юм. 1994 онд Хууль зүйн яам болон NEUSTART-ийн хооронд “Ерөнхий гэрээ” байгуулагдсан. Энэхүү гэрээ хэлэлцээрт Холбооны Яамны Хууль зүйн яам нь худалдан авагч, NEUSTART нь үйлчилгээ үзүүлэгч бөгөөд тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой тусгасан байдаг.

1961 оны насанд хүрээгүйчүүдийн шүүхийн тухай хуульд пробацийн ажилтан нь зөвхөн сайн дурын ажилтан байх тухай заасан байдаг хэдий ч мэргэжлийн сургалтад хамрагдсан, мэргэжлийн нийгмийн ажилтан шаардлагатай байгаа нь тодорхой болжээ. Өнөөгийн байдлаар хяналтын хэргүүдийн гуравны нэг орчим хувийг сайн дурын ажилтнууд гүйцэтгэж байна.

Мэргэжлийн нийгмийн ажилтнууд хяналтын бүх үйл ажиллагаанд оролцдог бол сайн дурын ажилтнуудыг зөвхөн нэг хяналтын ажилд томилдог.


Австри улсад шүүх, прокурор гэмт хэрэгтэнд ял шийтгэлийг оногдуулахаас гадна улсын прокурор шүүхийн өмнөх шатанд пробацийн байгууллагын үйлчилгээг санал болгоно. Энэ тохиолдолд гэмт хэрэгтний зөвшөөрөл шаардлагатай.

Бүх пробацгийн үйл ажиллагаа нь гэмт этгээдийн эрсдэл, хэрэгцээний талаар анхны үнэлгээний ярилцлагаас эхэлдэг ба үүний үндсэн дээр дараагийн ажлын үе шат, зорилгоо төлөвлөдөг байна.

1994 онд NEUSTART холбоо Австри улсын Холбооны Яамны төлөөлөлтэй ерөнхий гэрээ байгуулан улсын хэмжээнд хяналтын үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн ба тус ашгийн төлөө бус байгууллагын дээд байгууллагыг нь Ерөнхий Ассамблей бөгөөд хяналтын зөвлөлийг гурван жилийн хугацаагаар томилдог.

Хяналтын зөвлөлийг гүйцэтгэх захирал удирдах ба гүйцэтгэх захирлыг 5 жилийн хугацаагаар томилдог. NEUSTART өөрийн дотоод аудитын нэгжтэй бөгөөд гүйцэтгэх захиралд шууд тайлагнадаг. Аудитын газрын ажилтныг Хууль зүйн яамны зөвшөөрлөөр хөлсөлж ажиллуулдаг. Үүнээс гадна, Герман улсын Баден-Вюрттембергийн нутагт NEUSTART компанийн салбар үйл ажиллагаа явуулдаг.

NEUSTART байгууллагын бүтэц нь бүс нутгийн үүрэг, бизнесийн процессын загварт үндэслэдэг. Нэг талаас, үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагааг явуулах, хариуцах ажилтантай байх нөгөөтээгүүр, чанартай үйлчилгээ явуулахаар зохион байгуулагдсан байна.



Дээрх 9 салбар агентлагт нийгмийн ажилтнууд 25 хэлтэст хуваагдан зохион байгуулагддаг.

Хяналтын ажилчид:

Төвлөрсөн бус агентлагууд нь 2-4 албадтай. Бүс нутгийн хэмжээнээс хамааран агентлагууд үйлчилгээ үзүүлдэг бөгөөд агентлагууд нь үйлчилгээ нь үйлчлүүлэгчдэдээ хүрч чадахуйц хэмжээнд байхын тулд нэмэлт газруудыг ажиллуулж болно. Газар хэлтэс тус бүр оноосон 12-20 нийгмийн ажилтан байх ба хяналт шалгалт хариуцсан дарга удирдаж байдаг. Захиргааны ажилтнууд агентлагийн захиралд ажлаа шууд тайлагнадаг. NEUSTART нь үр чадвар болон хандлагад тохирсон арга хэрэгслийг ашиглан ажилд авах аргыг боловсруулсан. Бүх боловсон хүчний хөгжлийн систем нь байгууллагын онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн байх ёстой. Агентлагийн бүх мэргэжлийн хүмүүсийн дунд тогтмол уулзалт зохион байгуулдаг.

Шинээр ажилд орж буй ажилчдыг ажлын байранд нь сайтар дадлагажуулдаг. Улсын хэмжээнд шинэ ажилчид наад захын 3 долоо хоногийн үндсэн сургалтад оролцох үүрэгтэй. Ажлын байрны багш нар шинээр ажилд орогсдыг хоёроос доошгүй жил практик дадлагыг хийлгэдэг байна.

Пробацийн ажилд оролцдог бусад байгууллага:

Пробацийн албад тухайн бүс нутгийн бусад нийгмийн /халамжийн байгууллага/-уудтай нягт холбоотой ажиллаж байна. Үүнд: Олон нийтийн хөдөлмөр эрхлэлтийн алба, нийгмийн халамжийн газрууд, орон гэргүйчүүдийг асран хамгаалах газар, төсөл, эмчилгээ гэх мэт институцууд

NEUSTART нь Австри улсын харьяат гэмт хэрэгтнүүдэд үйлчилгээ үзүүлдэг ба бусад орны хүмүүст үйл ажиллагаа явуулдаггүй. Учир нь Хууль зүйн яамнаас ийм ажил гүйцэтгэх эрх өгөөгүй бөгөөд төлбөр төлдөггүй байна. Тиймээс энэ асуудлыг Гадаад Элчин сайдын яам, консулын газраар дамжуулан хийх хэрэгтэй.

Австри улсад гэмт хэрэг үйлдсэн гадаадын иргэний гэмт хэргийн хохирогч шүүхээс пробацийн үйлчилгээний захиалга хүлээн авч болох бөгөөд ингэснээр тэд NEUSTART-ийн үйлчлүүлэгч болно.

Эрүүгийн шүүхийн үйл явцын үе шат:

Хууль зүйн яам болон хувийн ашгийн төлөө бус, байгууллага болох NEUSTART-ын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд өргөн хүрээг хамарсан бие даасан байдлыг бий болгодог. Тиймээс өдөр тутмын үйл ажиллагааг NEUSTART зохион байгуулдаг хэдий ч хариуцлага нь төрийн эрх мэдэлтнүүдэд байдаг.

Хэдийгээр зөвлөмжийн ач холбогдлыг сайн дурын ажилтны албан тушаалтанд тавиагүй боловч, Австрийн хяналтын систем нь мэргэшсэн болон сайн дурын байцаагчийн үйл ажиллагаатай хосолсон байдаг.

- Урьдчилан шүүх /давтан шат дамжлага/:

Энэ бүлэгт туршилтын үйл ажиллагаа, шийтгэлийн асуудлаар зуучлах, шүүхийн өмнөх үе шатанд олон нийтэд үйлчлэх зуучлалын үйл ажиллагааг тодорхойлсон. Эдгээр нь мөрдөн шалгах ажиллагаа эсвэл шийтгэлийг хүчингүй болгох боломжийг бий болгодог нийгмийн ажлын арга хэмжээ юм. Нийгмийн ажлын бүх үйлчилгээнүүд нь ажлын байрны тодорхойлолт, тухайн салбарт нийгмийн ажилд тодорхойлсон дээд, доод хэмжээний стандартууд хамаарна. Австри улсад насанд хүрээгүй сэжигтэнд зориулсан урьдчилан шатны тайланг бэлтгэж болно. Энэ нь зайлшгүй биш бөгөөд Австрийн NEUSTART нэг бүс нутагт (Vorarlberg-д) энэ тайланг бэлддэг.

- Хохирогч гэмт хэрэгтэнг эвлэрүүлэх:

Хохирогч, гэмт хэрэгтнийг эвлэрүүлэх ажиллагаа нь 1985 онд Австри улсад насанд хүрээгүй хүмүүст зориулсан загвар төслийг эхлүүлсэн.

Энэхүү эерэг туршлагыг үлгэр дууриал болгон загварчилсан хоёрдахь туршилтын төсөл 1992 онд насанд хүрэгчдэд зориулсан хохирогч, гэмт хэрэгтнийг эвлэрүүлэх ажиллагаа юм.

Үр дүн нь маш их сайн байсан тул 2000 онд Хохирогч, гэмт хэрэгтнийг зуучлах ажиллагааг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны дүрэмд зааснаар бусад арга хэмжээнүүдийн хамт хуульд багтааж өгсөн. Хохирогч, гэмт хэрэгтэнг эвлэрүүлэх ажиллагааг улсын прокурор эсвэл шүүхээс захиалж болно.

Дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- Хэргийн нөхцөл байдлыг хангалттай тодруулсан байх;
- Гэмт хэргийг нэг шүүгчийн харьяалалд багтаах ёстой (5 жилийн хамгийн их ялтай ихэнх гэмт хэрэгт хамаарна);
- Сэжигтнийг гэм буруутай гэж тооцох ёсгүй;
- Хүн амины гэмт хэрэгт хамаарахгүй.

Австри улсад хамгийн чухал, хамгийн түгээмэл хэрэглэгддэг нийгмийн ажлын арга хэмжээ бол хохирогч, гэмт хэрэгтнийг эвлэрүүлэх ажиллагаа юм.



Хохирогч гэмт хэрэгтэнг зуучлах ажиллагааны зорилт нь:

- Хохирогч сэтгэл санааны болон материаллаг нөхөн төлбөрийг авах боломжтой;
 - Хохирогчийн хэрэгцээ, сэтгэл хөдлөлийг нухацтай авч үзэх;
 - Сэжигтэн этгээдийг хэрхэн сайн хүн болгох талаар авч үзэх боломжтой;
 - Сэжигтэн нь шүүх хурлын үеэр хамгаалагдсан байр суурьтай биш боловч учирсан хор хохирлыг арилгахад идэвхтэй үүрэг гүйцэтгэх боломжтой;
 - Хохирогч, гэмт хэрэгтэнг эвлэрүүлэх ажиллагаа нь хувь хүний мөргөлдөөний тогтвортой байдлыг хангах, материаллаг хор хөнөөлийг арилгах зорилготой ;
 - Эерэг тайлбарын дараа хэргийг хэрэгсэхгүй болгох нь боломжит сөрөг үр дагавар бүхий гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх;
 - Сэжигтэн, хохирогчийн хэлэлцэн тохиролцсон боломжит хэлэлцээр нь нийгмийн амар амгалан болох боломж олгодог.
- Олон нийтийн үйлчилгээ /цалингүй ажил/:

2000 оны 1-р сараас Австри даяар олон нийтийн үйлчилгээг насанд хүрээгүй болон насанд хүрэгчдэд хэрэглэдэг болсон. 2010 онд прокурор, шүүх нийт 4325 хүнийг NEWSTART нийгэмлэгийн үйлчилгээг зуучлуулахаар шилжүүлсэн байна. Тэд хамгийн ихдээ 240 цаг (насанд хүрээгүй хүмүүсийн хувьд 120 цаг) ажиллаж төлбөрөө төлөх шаардлагатай болжээ.

NEUSTART нь прокурор буюу шүүхээс эрүүгийн хэргийг хүлээн авч, нийгмийн ажилтны хамгийн чухал ажил бол аль болох хурдан гэмт хэрэгтний хувийн болон үйлдсэн гэмт хэрэг, хохиролд тохирсон байгууллага, ажлыг сонгон, түүнд зөвлөх, дэмжлэг үзүүлэх явдал юм.

Олон нийтийн үйлчилгээг хийх нь олон нийтийн ашгийн бус байгууллага эсвэл орон нутгийн нийгэмлэгт төлбөргүйгээр ажил хийхийг хэлнэ. Эдгээр цалин хөлсгүй ажил үйлчилгээ нь хэрэгтний учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилготой.

Нийгмийн ажилчид хохирогчид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхийн тулд гэмт хэрэгтнийг удирдаж, дэмжлэг үзүүлнэ. NEUSTART нь прокурор буюу шүүгчдэд хуулийн хэрэгжилтийн талаарх асуудал, олон нийтийн үйлчилгээний захиалга болон учирсан хохирлыг нөхөн төлөх талаар мэдэгдэх ёстой.

Шүүх хурлаа хүлээж байгаа хүмүүсийг шүүхийн тогтоолоор чөлөөлөх боломжтой бол цагдан хорихоос илүү хяналтын ажилтан шүүх хурлын дуусах хүртэл үйлчлүүлэгчийг хянадаг. Энэ үе шат нь гэмт хэрэгтний гэр бүлд дэмжлэг, зөвлөгөө, мэдээллийг санал болгодог бөгөөд ажил эрхлэх боломж, эмчилгээ, эрсдэлийн оролцооны сургалт гэх мэт холбогдох бусад үйл ажиллагаатай хослуулдаг.

Цахим хяналтын хугацаа (цахим хяналт):

2010 онд нийгмийн дэмжлэгээр Австри улсын хуулийн дагуу цахим хяналтыг хэрэгжүүлсэн. Электрон хяналт нь шоронд хоригдох нэг төрөл гэж үздэг. Цагдан хоригдсон этгээдийг цагдан хорих шийдвэрийн оронд цахим хяналттай байцаан шийтгэх ажиллагаанд оролцуулж болно.

Нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчдийн бие даан амьдрах чадварыг хөгжүүлэхэд чиглэн эрчимжүүлсэн дэмжлэг, дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, холбоо тогтоох гэсэн үйл ажиллагааг явуулдаг.

1. Эрчимжүүлсэн дэмжлэг. Олон төрлийн асуудалтай, өндөр эрсдэлтэй хүчин зүйлүүд, бэлгийн зөрчилтэй үйлчлүүлэгчид голчлон эрчимтэй дэмжигч гэж ангилагдана. Эхний 6 сарын туршид үйлчлүүлэгч бүрийг эрчимжсэн дэмжлэг эсвэл дэмжлэгийн давтамжтайгаар хянаж байх болно. Насанд хүрээгүй үйлчлүүлэгчид (нас < 21) дэмжлэг үзүүлэхдээ эхний жилд эрчимжсэн дэмжлэг эсвэл дэмжлэгийн давтамжтайгаар хяналт тавина. Эрчимт дэмжлэгийн шатанд холбоо барих давтамж нь дунджаар 2-3 сарын хувийн харилцаа холбоо байна.

2. Дэмжлэг. Нийгмийн нөхцөл байдал, аюулыг тодруулж дэмжлэг үзүүлэх ба туслан, холбоо барих давтамж нь 1.5-2 сар байдаг.

3. Зөвлөгөө өгөх. Бага асуудалтай бөгөөд туслан, холбоо барих давтамж нь сард нэг удаа байна.

4. Холбоо барих.Эрсдэл багатай үйлчлүүлэгчид байдаг.

Суллагдсаны дараах тусламж:

Суллагдсаны дараах тусламж нь ялаа эдэлж дууссан хүмүүст л үйлчилдэг үйлчилгээ юм. Австрийн 9 мужийн 7-т нь энэ үйлчилгээ үзүүлдэг. Австри улсад Хууль Зүйн Яам болон NEWSTART-ын хооронд байгуулсан ерөнхий гэрээний үндсэн дээр тус үйл ажиллагаа нь гэмт хэрэгтэнд үзүүлэх тусламжийн хараат бус салбар гэж тодорхойлогддог.

Суллагдсаны дараах тусламж нь зөвлөгөө, дэмжлэг, суллагдахын өмнөх зөвлөгөө өгөх, хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө, ажлын байрны сургалт явуулах зэрэг үүрэгтэй.

- Зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх: Суллагдсаны дараа тусламж авна гэдэг нь тусламж хайж буй хүний нийгмийн байдлыг үнэлж, туслалцаа хэрэгтэй эсэхийг тодорхойлох явдал юм. Энэ нь хууль зүйн зөвлөгөө өгч, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн загвар боловсруулах, бэлэн байгаа нөөцийн талаарх мэдээлэл, эдгээр эх сурвалжид нэвтрэх боломжийг олгодог. Зөвлөгөө өгөх үйл ажиллагааны зорилго нь материаллаг хэрэгцээг хангах (баримт бичиг болон тухайн этгээдийг хянах арга хэмжээг эхлүүлэх), байр барих, мөн эмчилгээнд шилжүүлэх явдал юм.

- Суллагдахын өмнө зөвлөгөө өгөх: Тус зөвлөгөө нь суллагдахын өмнө эсвэл суллагдсаны дараа хоригдлыг бэлэн байлгах, гамшгаас зайлсхийх, нөөцийг үнэлэхэд туслах гэх мэт үүрэгтэй. Ялангуяа орон байр олох, орлогоо баталгаажуулах, ажилд ороход нь эргэн нийгэмшүүлэх г.м

- Ажил эрхлэлтийн зөвлөгөө: Нийгмийн ажилчид үйлчлүүлэгчдийг ажил хайхад туслалцаа үзүүлж, төрийн ажил эрхлэлтийн албатай холбоо тогтоож өгдөг. Үйлчилгээ нь сургалтын хөтөлбөрийн талаарх мэдээллийг агуулдаг.

- Ажлын байрны сургалт явуулах: Австрийн хоёр агентлагт хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө өгөхөөс гадна мэргэжлийн сургалтад үйлчлүүлэгчид оролцон семинарыг явуулдаг ба уг хөтөлбөр нь зургаан сар хүртэлх хугацаанд үргэлжилнэ. Энэ төрлийн хөтөлбөр нь цаг хугацаа, найдвартай байдал, уян хатан байдал, ажлын уян хатан байдал гэх мэт ажлын цаг хугацааны үндсэн шаардлагыг үйлчлүүлэгчдэд аажмаар нэвтрүүлэх зорилготой.

Итали улсын пробацийн үйл ажиллагаа:

Италид пробаци нь нь ял, шийтгэлийг гүйцэтгэх үйлчилгээнд ордог хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрөгдсөн төрийн болон төрийн бус байгууллага юм.

1975 оны 7-р сарын 26-нд батлагдсан Хувийн эрх чөлөөг хязгаарлах, тухай хууль нь нийгмийн үйлчилгээнд зориулсан төвүүдийг байгуулах үндэс тавигджээ.

Пробацийн албаны зохион байгуулалт нь үндэсний, бүсийн, орон нутгийн гэсэн гурван түвшинд байна. Үндэсний түвшинд "Гүйцэтгэлийн ерөнхий чиглэл"-ээр илэрхийлэгдэнэ. Үндэсний алба нь Италид насанд хүрэгчдэд зориулсан олон нийтийн үйлчилгээг үзүүлдэг хууль зүйн яамны харьяа ерөнхий газар юм.

Пробацийн албаны дотоод зохион байгуулалт нь:

- Нийгмийн ажлын салбар;
- Нарийн бичгийн газар;
- Захиргааны хариуцлагыг хэрэгжүүлэх алба гэсэн тогтолцоотой байна.

Пробацийн албанд нягтлан бодогч, сэтгэл судлаач, нийгмийн ажилтан гээд олон мэргэжилтнүүд ажилладаг.

Пробацийн алба нь дараах чиг үүргийг гүйцэтгэдэг. Үүнд:

- хорих байгууллагуудтай хамтран ажиллах;
 - мэргэшсэн нийгмийн ажилтныг цалинтай ажилтнууд ажиллуулах;
 - сэтгэл судлалын мэргэжилтний мэргэжлийн туслалцааг авах;
 - сайн дурын байгууллага, ажилтнуудтай хамтран ажиллах;
 - орон нутгийн иргэдийн оролцоог дэмжих;
 - гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тусламж үзүүлэх, хяналт тавих;
 - гэмт хэрэгтний нийгэм, гэр бүлийн асуудлыг судлах;
 - гэмт хэрэгтний нөхөн сэргээлтийн хөтөлбөрийг тоймлох;
 - гэмт хэрэгтэнд тооцох олон нийтийн арга хэмжээг хэрэгжүүлэх;
 - шүүхийн байгууллагад өгөх эмчилгээний хөтөлбөрийг санал болгох шүүх хуралдаанд томилогдох, өргөдөл гаргахаар өргөдөл гаргасан хоригдлуудад гэрийн хорионд байлгах;
 - хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах;
 - шүүхээс томилогдсон этгээдэд хяналт тавьж, туслах;
 - гэрээр хоригдсон хүмүүст дэмжлэг үзүүлэх;
 - эрх олгогдсон хүмүүст туслалцаа үзүүлэх;
 - нөхөн сэргээлтийн хөтөлбөрийн үр дүнгийн талаарх мэдээллээр хангах;
 - тэнсэн суллагдсан этгээдүүдэд туслах;
 - гэмт хэрэгтний харилцаа, тэдгээртэй харилцах харилцааг зохицуулж, бэрхшээлийг арилгах нийгмийн амьдралд эргэн ороход нь тусламж үзүүлэх ;
 - хоригдлыг суллагдах хугацаанд гэр бүлд туслах;
 - хууль тогтоомж, дүрэм журмаар зохицуулагдах бусад үйл ажиллагаа.
- /номын сангийн үйл ажиллагаа, соёл, амралт зугаалгад зориулсан спортын арга хэмжээ/

Швед улсын пробацийн үйл ажиллагаа:

Эрх зүйн өндөр хөгжил бүхий улс орнуудын дундаас пробацийн албыг оновчтой хөгжүүлж буй улс нь Швед юм. Тус улс нь анх 1918 оноос пробацийн албыг байгуулан хөгжүүлж ирсэн бөгөөд 1998 оноос хорих байгууллагатай нэгтгэн Хууль зүйн яамны харьяанд үйл ажиллагаагаа зохион байгуулж байна. Шведийн пробацийн төв байгууллагын харьяанд 6 бүс нутгийн байгууллага багтдаг.

Судлаачдын үзсэнээр Швед улсад нэг хоригдолд ногдох зардал өдөрт 200 америк доллар, цагдан хоригдож буй яллагдагчид өдөрт 185 америк доллар зарцуулдаг бол пробацийн албаны хяналтад буй нэг хүнд өдөрт 15 америк доллар зарцуулагддаг гэсэн тооцоо гарчээ. Энэ нь пробацийн албыг хөгжүүлэх нэг үндэслэл болж өгчээ.

Шведийн пробацийн алба нь ялын болон хяналтын чиглэлээрх дараах шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Нийтэд тустай ажил хийлгэх ял;
- Тусгай хөтөлбөрийн дагуу эмчилгээ хийх шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах;
- Хорихоос гадуур тэнсэн хянан харгалзах;
- Хүч нэмэгдүүлсэн цахим хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Хорих газраас хугацааны өмнө суллагдсан хүмүүст тавих хяналтыг хэрэгжүүлэх зэрэг болно⁶².

Шведийн орон нутгийн пробацийн алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Дээр дурдсан ял, хяналтын арга хэмжээний хэрэгжилтийг хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдсон дэмжлэг үзүүлэх;
- Хэрвээ хяналтад байгаа хүн шүүхээс тогтоосон хязгаарлалт, журмыг зөрчсөн бол тусгай зөвлөлөөр асуудлыг хэлэлцэн шүүхэд хүргүүлэх;
- Яллагдагчийн хувийн амьдралын нөхцөл байдал, сэтгэл зүйн онцлог, дахин гэмт хэрэг үйлдэх магадлал зэргийг үнэлэн шүүхэд оновчтой ялын төрөл хэмжээг сонгон хэрэглэхэд туслалцаа үзүүлэх;
- Орон нутгийн захиргааны байгууллага, сайн үйлсийн төрийн бус байгууллагатай хамтран эмчилгээний болон нөхөн сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөлийг хангадаг.

Швед улсын хорих ялын хэмжээ 14 хоногоос 10 жил хүртэл байхаар хуульчлагдсан бөгөөд онцгой тохиолдолд 14 жил, бүх насаар хорих ялаар шийтгэдэг. Хууль тогтоомжийн дагуу хорих ял эдэлж байгаа этгээд нь эдэлбэл зохих ялын 2/3-г эдэлсэн тохиолдолд ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдах боломж үүсдэг. Энэхүү боломж нь үйлдсэн гэмт хэрэг болон хоригдлын хувийн байдлаас үл хамааран хэрэгжиж болдог онцлогтой.

Хоригдол хугацааны өмнө тэнсэн суллагдах өргөдөл гаргасны дараа уг асуудлыг тэнсэн суллах асуудал хариуцсан Үндэсний зөвлөл хэлэлцэн шийдвэрлэдэг. Улмаар тэнсэн сулласан хугацаан дахь хяналтыг пробацийн албанаас хэрэгжүүлдэг бөгөөд пробацийн албаны ажилтан тухайн хүний нийгмийн шинж байдал буюу хувийн зан үйл, сэтгэл зүйн онцлогийг тодорхойлсны үндсэн дээр тухайлсан хяналтаа хэрэгжүүлдэг.

⁶² Указ.изд. стр 172-177.

Швед улсын хууль тогтоомжийн дагуу хорих байгууллагаас тэнсэн суллагдсан хүнд тавих пробацацийн албаны хяналт 1 жил байдаг бөгөөд цаашид үргэлжлүүлэн хянах туршилтын хугацаа 3 жил байдаг. Хуулийн энэхүү хугацаанд пробацацийн албаны ажилтан хяналтад байгаа хүн байнгын харилцаатай ажиллаж хяналт болон хичээл, сургалт, нийгмийн бусад асуудлыг шийдвэрлэх чиглэлээрх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Хуулийн дагуу хяналтад байгаа хүний нийгмийн шинж байдлын талаарх тодорхойлолт нь пробацацийн албаны ажилтны дүн шинжилгээ, мэдээллийн боловсруулалтын бодит илэрхийлэл байх ёстой. Энэхүү тодорхойлолтыг боловсруулахдаа татвар, улсын бүртгэл, харьяатын алба болон бусад нийтийн албанаас зохих мэдээллийг цуглуулан нэгтгэдэг.

Дээрх хяналтын үйл ажиллагааны хажуугаар пробацацийн албанаас хяналтад байгаа хүнд чиглэсэн сургалтын хөтөлбөрийн хэрэгжүүлдэг бөгөөд энэ хөтөлбөрт согтуурах, мансуурах донтой, хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдсэн, давтан гэмт хэрэг үйлдэж байсан, үйлдэж болзошгүй хүмүүс хамрагддаг.

Энэ хөтөлбөр нь пробацацийн албаны хяналтад авсан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн өдрөөс хэрэгжиж эхэлдэг. Хөтөлбөр цөөнгүй 7 хоног үргэлжилдэг бөгөөд 7 хоногт 2 ба түүнээс дээш цаг, нийт цагийн доод хэмжээ 84 байх ба хяналтад байгаа хүний хувийн байдлаас хамааран өөрчлөгддөг. Тухайлбал, согтуурах донтой этгээдэд 75 чиглэл бүхий хөтөлбөр /ADDIS/ хэрэгждэг бол мансуурах донтой хүмүүст зориулсан "Хамтын ажиллагааны гэрээ" гэсэн төсөл хэрэгждэг байна.

Шведийн пробацацийн алба нь ганцаарчилсан буюу хүн бүрт чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлдэг ба бүх хөтөлбөрийн хүрээнд сайн дурын ажилтантай хамтран ажилладаг. Сайн дурын ажилтан нь пробацацийн алба ба хяналтад байгаа хүний хоорондын соёлын, хувь хүний хөгжлийн, ахуйн тусламжийн зэрэг бүхий л чиглэлд холбож зуучлах хэлбэрээр хамтран ажилладаг.

Хуулийн дагуу пробацацийн албаны сайн дурын ажилтан нь 18 насанд хүрсэн, харилцаа, ёс зүйн шаардлагыг хангасан байхаас гадна тодорхой ажлыг зохион байгуулах, гүйцэтгэх чадвар өндөртэй байх учиртай. Түүнчлэн сайн дурын ажилтан нь шийтгэлийн хугацаа дуусахаас өмнө хяналтад байгаа хүнтэй харилцаж нөлөөллийн болон нийгэмд дасан зохицох ажлын үр дүнгийн талаар илтгэл бичиж сар бүр тогтсон хугацаанд пробацацийн албанд өгч мэдээлэл солилцох, цаашдын төлөвийг хэлэлцэх зэргээр хамтран ажилладаг.

Шведийн пробацацийн албаны заавал хэрэгжүүлдэг бас нэг үйл ажиллагаа нь цахим төхөөрөмжтэй хүч нэмэгдүүлсэн хяналт байдаг. Энэхүү цахим хяналтын арга хэмжээ нь 1993 оноос туршилтын журмаар хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд 2001 оноос тогтмол хэрэгжиж байна. Цахим төхөөрөмжийг зөвхөн хоригдол өөрөө болон гэр бүлийн гишүүн зөвшөөрсөн тохиолдолд хэрэглэдэг

бөгөөд 3 сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэгдсэн хүн цахим төхөөрөмжийн хяналтаар солих тухай хүсэлт гаргаж шийдвэрлүүлдэг.

Хүсэлт гаргасан этгээдийн хувийн байдал, сэтгэл зүйн онцлог, зан үйлийг пробацийн албаны ажилтан судалж гаргасан дүгнэлтэд тулгуурлан орон нутгийн хорих болон пробацийн албаны удирдлагаас шийдвэрлэдэг бөгөөд хяналтад орох этгээд нь байнгын оршин суух хаягтай байх ёстой байхын зэрэгцээ ажиллаж сурч болдог. Цахим хяналтад оруулах шийдвэр гарсны дараа пробацийн албаны ажилтан хяналтад орсон хүний өдөр тутмын цагийн хуваарь, маршрутыг гарган хяналтыг эхлүүлэх бөгөөд цахим төхөөрөмжийг тогтмол биедээ зүүнэ.

Түүнчлэн хяналтад байгаа хүн пробацийн албанд тогтмол хугацаанд ирж зохих зөвлөгөө, сургалтад хамрагдах ба согтууруулах болон мансууруулах төрлийн зүйл хэрэглэх, хүч хэрэглэсэн үйлдэл гаргах хориотой. Хэрвээ ажилтны шаардлагыг зөрчсөн, хориглосон хязгаарлалт, үүргийг биелүүлээгүй бол эхний удаад сануулах, улмаар давтан зөрчигдвөл хорих ялаар солих арга хэмжээг авдаг.

2.4 Мусульманы эрүүгийн эрх зүйн онцлог

Лалын ертөнцөд томоохон байр эзэлдэг Исламын⁶³ шашны хатуу дэг жаяг, дүрэм, зарчимд үндэслэгдсэн Мусульманы эрх зүй нь VIII-X зууны үед буюу Арабын Халифатын ноёрхлын хөгжил дэвшлийн оргил үед анхлан үүсч, бүрэлдэн тогтжээ. Анх гарч ирэхдээ хамгийн ариун, төгс төгөлдөр бурхан Алладын өөрсдийн хүмүүст зориулж хүргэсэн “чандлан дагаж, үнэнчээр сүсэглэн мөрдөх зан үйлийн бичээс” буюу Шариатын дэг ёсноос эх үндэс авч цаашид хөгжсөн байдаг.

Энэ системд Иран, Саудын Араб, Афганистан, Ирак, Ливи, Оман, Эмиратын Вант улс, Судан, Бруней, Катари, Маракко, Иордани зэрэг 40 шахам орон хамаарагдана.

IX зууны сүүлч үеэс Мусульманы эрх зүйд холбогдох Исламын шашны олон янзын үзэл, номлол хүчтэй дэлгэрсэн ба 10-р зуунаас эхлэн Ханифитийн, Маликитийн, Шафийтийн, Ханбалитийн зэрэг 4 үндсэн дэг сургууль (школ) бий болсон нь Ойрхи Дорнод, Төв Ази, Хойд Африк, Зүүн Өмнөд Азид түгэн тархжээ.

Шариатын хууль, дүрэм, мөрдлөгүүд нь Исламын шашинтан хэнд ч боловч заавал биелүүлэх үүрэг, тангараг болж, ухамсар сэтгэхүйд нь төлөвшсөн байдаг. Мусульманы эрх зүйн үндсэн эх сурвалжуудыг дурьдвал: нэг талаас зан үйлийн мөрдлөг, шүтлэг, тангараг, дэг ёсыг номлосон ариун судар **“Корани”**⁶⁴, түүнчлэн Алладын элч, түүний илгээгдсэн төлөөлөгч Мухаммедийн намтар, хэлсэн үг, айлтгал, номлолоос бүрдсэн **Сунна**, нөгөө талаас Мусульманы ашиг сонирхлоор нэгдсэн Исламын шашинт овог, нийтлэгүүдийн үүрэг, тангаргийн талаарх зөвшилцлийг илэрхийлсэн **“Иджма”**, тэрчлэн Корань, Суннад заагаагүй хэрэг маргааныг төсөөтэй хэрэглэх, жишгийн арга зарчмуудыг тогтоосон **“Кияс”** зэргийг нэрлэж болно.

Эрүүгийн эрх зүй нь Мусульманы эрх зүйн тогтолцоонд бие даасан байрыг эзэлдэг. Мусульманы эрүүгийн эрх зүйд ялын хэр хэмжээ, Шариатын хориг, дэг ёсны шаардлагыг гол шалгуур болгон гэмт хэргийг 3 үндсэн ангилалд авч үздэг. Үүнд:

“Хадд”-ын ял оноохоор заагдсан аюултай гэмт хэргүүд (1-р ангилал);

⁶³ Ислам нь Араб хэлтэн буюу Араб, Лалын иргэншлийн улс орнуудад түгээмэл тархсан төр ёсны хийгээд албан ёсны нөлөө бүхий шашы үндсэн гол урсгал бөгөөд бүтцийн хувьд дотроо Исламын ёс зүй (**Ахляка**), Исламын номлол (**Акида**), Исламын хууль, дүрэм (**Шариат**) гэсэн 3 хэсэгт хуваагдана.

⁶⁴ Корани (арабаар)- “ариун тангараг, ариун шүтээн” гэсэн утгатай. 644-656 онд бичигдэж дууссан ба 6219 шүлэг, зохиол, бичиг, 14 бүлгээс бүрд дэг. Эндээс 1800 шахам нь Шариатын дэг ёсны номлол, 500 шахам нь эрх зүйн ач холбогдол бүхий зан үйлийг тусгасан байхаас гадна 50 шахам нь эрүүгийн эрх зүйд холбогдох ажээ.

“Кисас”-ын ял оноохоор заагдсан хүнд гэмт хэргүүд **(2-р ангилал)**;

“Тазир”-ын ял бүхий аюулгүй гэмт хэргүүд **(3-р ангилал)** гэж ангилна.

Нэгдүгээр ангиллын (*Хадд*⁶⁵) гэмт хэргүүдэд *Исламын шашнаас урвах, шашинт төр, засгийг эсэргүүцэх, бослого, үймээн гаргах, согтууруулах ундаа хэрэглэн мансуурах, садар самуунаар явалдах, бусдыг хучиндсэн буюу завхайрсан, худал гутгэлэг мэдээ тараасан зэрэг 6 төрлийн гэмт хэргийг хамааруулжээ.*

Хоёрдугаар ангиллын (*Кисас*) гэмт хэрэгт бусдыг санаатай алах, бусдад хүнд гэмтэл учруулах, бусдын өмч, хөрөнгийг хулгайлах, дээрэмдэх, эвдэж сүйтгэх зэрэг гэмт хэргүүд орно.

Гуравдугаар ангиллын (*Тазир*) гэмт хэрэг гэдэгт танхайрах, доромжлох, залилан мэхлэх, татвар төлөхөөс зайлсхийх, мөрийтэй тоглох гэх мэт. Энэ төрлийн гэмт хэргийн төрлүүдийг тухайн цаг үеийн нөхцөлд нийцүүлэн төр, засаг нь тогтоох, хуульчлах эрхтэй байхаар заагджээ.

Ялын хувьд Исламын ёс заншил, шашны зан үйлийн хориг ба Шариатын шийтгэл, Мусульман хүний үүрэг, тангарагтай нягт холбон, төрөл зүйлийн зарим онцлог байдлаар тогтоосон байх ажээ. Тухайлбал: Бусдыг санаатай алсан этгээд цаазаар авах ялтай боловч хохирогчийн хүсэлт, саналыг шууд харгалздаг, ингэхдээ **“Дийа”**-гийн зарчим буюу алдсан амь насыг мөнгө, үнэт зүйлс, эд хөрөнгө төлөх замаар цаазын ялыг орлуулж болдог. 100 тэмээ эсвэл 1000 динар төлөх, зарим тохиолдолд цусан өшөө (яаж алсан түүн шиг алах)-г хүлээн зөвшөөрдөг. Хулгай хийсэн этгээдэд баруун гарын алгыг нь огтлох ба зүүн хөлийн өлмийг нь тайрах, бусдыг гүтгэсэн этгээдийг 80 удаа ташуурдах, нэг удаа архидан согтуурч агсан тавьсан этгээдийг бүдүүн олсоор 60 удаа ороолгох, завхайрсан ба хүчингийн хэрэг үйлдсэн этгээдийг 100 удаа ташуурдах буюу олон түмний дунд оруулж, чулуугаар нүүлгэх зэргээр тухайн ялыг гүйцэтгэж байв. Түүнчлэн эхнэр нь өөр хүнтэй явалдсантай холбогдуулан нөхөр нь эхнэрээ алсан бол цаазаар авах ял шийтгэхгүй, өөр ялаар шийтгэх зэрэг зарим зохицуулалт бий.

Дээр дурьдсан ял цаазын уламжлал XIX зууны 2-р хагас хүртэл хадгалагдаж ирсэн ба тэр үеэс Мусульманы эрх зүйн системийн ихэнх оронд Шариатын нөлөө хүчтэй хэвээр байв. XX зууны 70-аад оны сүүлч үеэс эхлэн Мусульманы бүх орнуудад Европын (Эх газрын) загвар бүхий эрүүгийн хуулиуд шинээр батлагдан гарч, мөрдөгдөж эхэлжээ.

⁶⁵ “Хадд”- энэ төрлийн гэмт хэргийг Шариатын ёсонд ихэд цээрлэн жигшиж, хамгийн нүгэлт (хар мөрийн) гэмт үйлдлүүд гэж үзэж 1-р ангилалд багтаан, маш хатуу цээрлүүлдэг ажээ.

1980-аад оны дунд үеэс энэ системнийн ихэнх орнууд Шариатын зарим хэт хуучинсаг зан үйлийн уламжлалаас татгалзах болсон ба цөөнгүй орнуудад Шариатын хууль дүрмүүдийг шинэчлэх замаар шинэ үеийн эрүүгийн хуулиудад тусгах буюу шүүхийн практикт шууд бус байдлаар хэрэглэх болжээ. Зарим орон Шариатын системийг эвдэлгүй уламжлалт байдлаар нь бүрэн авч үлдсэн байхад зарим нь эрүүгийн хууль тогтоомжийн зарим институцийн хүрээнд тусгаж үлдээсэн байх ажээ. Үлдсэн хэсэг нь хязгаарлагдмал түвшинд буюу шууд бус байдлаар шүүхийн практикт зарим үед хэрэглэж болох талаас нь авч үлджээ.

Дээр дурьсан байдлыг үндэслэн эрүүгийн хууль тогтоомж ба Шариатын үүрэг, нөлөөний хоорондын хамааралт байдлыг гол шалгуур болгон эдгээр орнуудыг дараахь 3 бүлэгт ангилан үзэж болно. Үүнд:

- Шариатын бүх ёс, дүрмүүд эрүүгийн эрх зүйн үндсэн гол эх сурвалж болж тооцогддог улсууд; (*Иран, СаудынАраб*)

- Шариатын зарим зарчим, хэм хэмжээнүүд эрүүгийн хууль тогтоомжийн тодорхой институтэд тусгагдаж, эрүүгийн эрх зүйн хэрэглээнд шариатын жишгийг хууль дээдлэх ёстой хослуулан хэрэглэдэг улсууд; (*Афганистан, Йемен, Лыви, Мавритани, Эмират, Оман, Судан*)

- Шариатын уламжлалыг маш хязгаарлагдмал хүрээнд, тухайлбал: хөнгөн гэмт хэрэгт ял оногдуулахад хэрэглэх ба эрүүгийн хууль тогтоомжуудын зарим актуудад хэлбэр төдий тусгагдсан байдаг; (*Катари, Марокко, Бруней, Аяжир, Иордани, Кувейт*)

Мусульманы эрүүгийн эрх зүйн системийн сонгодог төлөөлөгч нь Иран улс юм.

Энэ улсын 1979 оны Үндсэн хуулийн 4-р зүйлд: "Эрүүгийн хууль тогтоомжууд Исламын зарчмуудад нийцсэн байх ёстой" гэж заасан бол 156-р зүйлд "...Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ялыг оноохдоо Шариатын хэм хэмжээг хэрэглэх явдлыг дагаж мөрдөнө" гэж заажээ.

1981 онд Иранд Кисасын тухай Исламын хуулийг баталсан ба 199 зүйл бүхий энэ хуулинд хүнд гэмтэл учруулсан, хүн алсан зэрэг хүнд гэмт хэрэг ба тэдгээрт оногдуулах ялын төрөл, зүйлийг хуульчилжээ.

Эмиратын Нэгдсэн Ванд улын 1987 оны Эрүүгийн хуулинд: 'Ялыг оноох замаар эрүүгийн хуулийг хэрэглэхдээ Шариатыг шууд бус байдлаар хэрэглэх (хослуулан) боломжийг шүүхүүдэд олгосон байдаг.

Афганистаны 1976 оны Эрүүгийн хуулинд: "Хүн алах, дээрэмдэх, хулгайлах, садар самуун явалдах болон сонгож хэрэглэх ял бүхий гэмт хэргийг

зүйлчлэх, шийдэхдээ Ханифитийн жишиг, тайлбарыг харгалзан хэрэглэх боломжтой байх тухай заасан нь бий⁶⁶.

Мусульманы эрүүгийн эрх зүйн систем дэлхийн хүн амын зургааны нэгд хүрч үйлчилж чадсан хийгээд эдүгээ Исламын шашинтай орнуудад өнөө хир нөлөөтэй хэвээр байгаа нь уг тогтолцоо өөрийн гэсэн байр суурьтай, үүрэг рольтой байна.

⁶⁶ Муромцев.Г.Н. Конституций Арабских государств. М.,1993

2.5.Хосолсон буюу холимог эрүүгийн эрх зүйн систем дэх Пробацийн үйл ажиллагааны онцлог

Дэлхийн эрх зүйн системийн зонхилох гол загвар болох Англи-Америкийн ба Эх газрын системүүд нь хоорондоо зааг ялгаатай, онцлог хэв шинжийг тусгаж ирсэн боловч улс, үндэстнүүдийн соёл, түүхэн уламжлал тэдгээрийн өвөрмөц байдлаас хамаарч, янз бүрийн тогтолцоо бүлүүдийг бий болгон хөгжүүлсэнийг харж болно.⁶⁷ Ялангуяа хөгжингүй ба хөгжиж буй улс орнууд, тэрчлэн шинэ тутам болон хот улс, жижиг арлын орнуудад үндсэн ба зарим системийн хэв шинж, соёл, тогтолцооны хосолсон буюу холимог хэлбэр илэрч байгаа нь анхаарал татаж байна⁶⁸.

Эдүгээ системүүдийн харилцан шилжсэн, зээлдсэн, нутагшсан зэрэг хамааралт холбогдлын шинж байдлаар нь:

- хосолсон Эрүүгийн эрх зүйн тогтолцоо;
- холимог Эрүүгийн эрх зүйн тогтолцоо гэж ангилж болно.

Хосолсон эрүүгийн эрх зүйн тогтолцоо гэдэг нь өөрийн үндэсний соёл уламжлал эрх зүйн үнэт зүйлсийг бие даан хадгалж, олон жилийн турш хөгжүүлэх явцад Англи-Америкийн болон Эх газрын эрх зүйн системийн аль алиных нь хэв шинжийг бүгдийг нь биш, харин зарим зүйлийг нь хослуулан авч, хэрэглэсэн байдлыг хэлнэ. Энэ системийг дараах чиглэлээр ангилж болно. Үүнд:

- Скандиновын хосолсон эрүүгийн эрх зүй;
- Япон, Филиппины хосолсон эрүүгийн эрх зүй.

Холимог эрүүгийн эрх зүй гэдэг нь түүхэн сонголтын болон түүхэн цаг үеийн нөхцөлд өөрийн орны сонгосон аль нэг системийг хөгжүүлэх явцад Эх газрын болон Англи-Америкийн системээс зээлдэн авсан буюу өмнөх системээ халж, өөр системд шилжихдээ системүүдийн хэв шинж холилдсон буюу аль нэг систем нь давамгайлсан хандлага бий болсон байдлыг хэлнэ. Энэхүү тогтолцоонд:

- Постсоциалист орнуудын холимог эрүүгийн эрх зүй;
- Мусульманы шашинт зарим орны холимог эрүүгийн эрх зүй;
- Хятадын холимог эрүүгийн эрх зүй г.м.

Түүнчлэн дээрх 2 бүлэгт багтаагүй боловч арай өөр шалгуураар тусад нь авч үзэх шаардлагатай буюу холилдож тогтсон зарим “саармаг” систем байдгийг АНУ-ын Люизана муж улсын болон Канадын Квейбек мужийн жишээн дээр харж болно.

Скандиновын эрүүгийн эрх зүй нь Эх газрын системийнх шиг бүрэн төрөлжөөгүй боловч Англи-Америкийнх шиг шүүхийн прецедент

⁶⁷ Д.Баярсайхан. Эрх зүйн онол УБ.,2010 116-р тал

⁶⁸ Правовые системы стран мира. Энциклопедический справочник. Под. Ред.АЯ.Сухарева. М.Норма. 2003

үйлчилдэггүй. Гэхдээ гэмт хэрэг, ялын институцийг нэг бүрчилсэн буюу статутын хуулиар голчлон зохицуулсан байхын дээр шүүхийн прецедентийн зарим зарчим, жишгийг нилээд тусган хэрэглэсэн байдаг. Тухайлбал: Шведийг энд жишээ болгон авч үзье. Швед нь 1962 онд Эрүүгийн хууль тогтоомжийн акт, 1948 онд Шүүхийн байцаан шийтгэх ажиллагааны журмын тухай хууль, 1971 онд Захиргааны хэргийг процедурын тухай хууль, 1963 онд Шүүхийн статутын тухай хууль зэргийг гаргасан байна. 1971 оноос эхлэн Шведийн шүүхийн практикт Эрүүгийн хууль, актуудыг хэрэглэх, тайлбарлах, онцгой эрхийг Дээд шүүхэд олгосон бөгөөд им тохиолдолд эрүүгийн хуулиар зохицуулагдахгүй харилцааг гийн эрх зүйн зарчим, шудрага шүүхийн тайлбар, шийдвэрээр нөхөн шийдэж, зохицуулж байх явдлыг эрүүгийн эрх зүйн системд нэвтрүүлж эхэлжээ.

Шведэд эрүүгийн процесс, иргэний процесс гэж тусдаа хуульгүй, харин шүүхийн процессын нэгдмэл нэг хууль буюу хэд хэдэн юулиар зохицуулдаг аж. Чухамдаа эрүүгийн эрх зүй дэх либералчлах үйл явц, тэдгээрийн уян хатан хийгээд зохицон хувирах зарчим, жишгийг Скандиновын орнуудын шүүхийн практикаас харж болно.

Япон, Филиппины эрүүгийн эрх зүй нь материаллаг ба процессын талаасаа харьцангуй хосолсон шинжтэй зохицуулалт болдог ба аль алинд нь шүүхийн прецедент үйлчилдэггүй. Жишээ нь: Японд 1947 онд Эрүүгийн хуулиа Германы загвараар шинэчлэн тогтоосон ба хэд хэдэн эрүүгийн хууль тогтоомжийн актаар зохицуулагдсан байдаг. Тэгвэл эрүүгийн хуулийг хэрэглэх, ял оногдуулах журам, эрүүгийн процесс зэрэг нь Америкийн жишгийг гүн гүнзгий тусгасан байх ба материаллаг эрүүгийн эрх зүй өөрчлөлтөд бага өртсөн, тогтвортой, өөрчлөгдөхгүй удаан жил мөрдөгдөж иржээ.

Филиппины эрүүгийн эрх зүй Японыхтой төстэй боловч Дээд Шүүхийн зүгээс хуулийг төсөөтэй хэрэглэх, тайлбарлах эрх мэдэл маш өргөн, Дээд шүүхийн актууд нь эрүүгийн эрх зүйн чухал эх сурвалж болдог. 1930 онд шинэчлэн гаргасан Филиппины Эрүүгийн хуулинд Испаний эрүүгийн хуулийн уламжлал (гэмт хэргийн ангилал, зарчим, ерөнхий ангийн ихэнх институт) тусгагдсанаас гадна Америкийн эрүүгийн эрх зүйн голлох актуудтай адил төстэй олон арван институт, харилцааг зохицуулсан нь бий.

Эдүгээгийн эрүүгийн хууль тогтоомж нь хэд хэдэн актаас бүрдсэн 3 гол дэвтэр болдог бөгөөд ихэнхдээ Америкийн ба Испаний эрүүгийн эрх зүйн хэв шинж, зарчмуудыг уялдуулж, хослуулж тогтоосон байдгаараа онцлогтой. Япон, Филиппинтэй төстэй систем Египет, Ирак, Шотланд, Мальт, Камерун зэрэгт бий.

Постсоциалист орнуудын эрүүгийн эрх зүй нь гарал, үүслийн хувьд Визант, Словяны уламжлалд тулгуурласан Оросын эрүүгийн эрх зүйн дэг сургуульд үндэслэгдсэн бөгөөд социалист системийн үед тухайн салбарын мөн чанар нь социалист нийгмийн зорилго, агуулгыг тусган баяжиж хөгжсөн байдаг. 1990-ээд оны эхэн, дунд үеэс социалист систем задран унаж, оршин тогтох үндэс сууриа алдсан билээ. Тэр үеэс эхлэн хуучин социалист байсан орнууд бүхэлдээ Эх газрын эрүүгийн эрх зүйн систем рүү шилжих үйл явц эхэлсэн бөгөөд сүүлийн 20 жилд энэ нь алгуур удаан үе шаттайгаар явагдаж байна.

Уг системийн бараг бүх улсууд 1990 оноос хойш хуучин Эрүүгийн хуулиудаа халж, шинэчлэсэн буюу шинэ эрүүгийн хуулийг баталж гаргасан байна. Жишээ нь: Албани (1995), Азербайджан (1999), Армен (2003), Болгар (1992), Гүрж (1999), Унгар (1989), Орос (1996), Монгол (1994, 2002), Латви (1998), Киргиз (1997), Литви (2000), Польш (1997), Румыни (2004), Эстони (2001), Казакстан (1997) зэрэг орнууд Эх газрын болон Оросын эрүүгийн эрх зүйн уламжлалт загварыг иш үндэс болгон эрүүгийн хуулиудаа шинэчлэсэн байна.

Постсоциалист орнуудын эрүүгийн эрх зүй нь Эх газрын эрх зүйтэй олон талаар ижил төсөөтэй боловч нилээд зүйлээр ялгаатай ба харьцангуй бие даасан онцлог шинжүүдтэй. Үүнд:

- Эрүүгийн нэгдмэл нэг төрөлжсөн хуультай. Эх газрынх шиг эрүүгийн хууль тогтоомжийн хэд хэдэн акт байдаггүй. Ингэхдээ нэгдмэл эрүүгийн хууль нь бүрэн системчлэгдэж, кодификацилагдсан;

- Эрүүгийн эрх зүйн тусгай анги нь гэмт хэргийн бүрэлдэхүүний тухай Оросын материаллаг эрх зүйн онолын шалгуураар төрөлжиж, ангилагдсан боловч социалист системийн уламжлалын зарим хэв шинж хадгалагдаж үлдсэн;

- Эрүүгийн хуулийн Ерөнхий анги нь зорилго, зарчим, гэмт хэргийн ойлголт, эрүүгийн хариуцлага, ял зэргийг нэгтгэн багцалж нэгэн зохицуулалт болгож тогтоосон;

- Ихэнх оронд гэмт хэргийн бүрэлдэхүүний дөрвөн элементийн (*субъект, объект, субъектив тал, объектив тал*) тухай Оросын онолын зарчмыг уламжлан авч хуулиуддаа тусгасан ба Визант, Словяний эрүүгийн эрх зүй дэх материаллаг ба объектив хэм хэмжээний уламжлалт зохицуулалтыг өвлөн хөгжүүлж баяжуулсан;

- Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх явдлыг хориглох буюу хязгаарлаж, Улсын Дээд Шүүхээс тухайн хуулийг тайлбарлах боломж нь зөвхөн хуулийн хүрээнд хязгаарлагдсан г.м.

Постсоциалист зарим орнуудад өмнөх социалист системээс улбаатай ялын доод хэмжээг өндөр босгоор тогтоох, хорих ялын хувь хэмжээ өндөр, үндсэн ба нэмэгдэл ялыг уян хатан, нээлттэй сонгох боломж хязгаарлагдмал, гэмт хэргийн ангиллын хэт хатуу шалгуур харьцааг бий болгосон зэрэг зарим сөрөг тал оршсоор байгааг харьцуулан харж болно.

Энэхүү холимог системийн бас нэг онцлог нь эх газрын ба социалист гэсэн хоёр системийн аль алин нь холилдсон байдгаас гадна Орос, Славяны ба Эх газрын системийн хослон холбогдсон шинж илүү тод илэрсэн байдаг оршино.

Мусульманы шашинт зарим орны эрүүгийн эрх зүй нь харьцангуй холимог шинжтэй байдаг ба энэ нь мусульманы эрх зүйн онцлогийг хадгалахын зэрэгцээ Англи-Америкийн болон Эх газрын системийн аль нэг хэв шинж давуу тусгагдсан байдлаар илэрдэг⁶⁹. Жишээ нь: Английн эрүүгийн эрх зүйн систем ба мусульманы эрх зүйн аль алиных нь шинжийг илэрхийлсэн орнуудад Пакистан, Мудан, Нигери, Малайз зэрэг улсыг дурьдаж болно. Түүнчлэн Эх газрын систем ба мусульманы эрх зүйн систем хоорондоо холилдож, холбогдсон зарим оронд Ливи, Мавританы зэргийг нэрлэж болно.

Хятад улс нь эрүүгийн эрх зүйн системийн маш өвөрмөц онцлогийг тусгасан байдгийн дээр хэд хэдэн системийн шинжийг өөртөө хослуулан хадгалахын сацуу өөрийн гэсэн (Хятадын) эрүүгийн эрх зүйн бие даасан онол бодлого, практикийг бий болгон хөгжүүлж байна.

Хятад улс 1979 онд шинэ Эрүүгийн хууль баталсан ба Оросын эрүүгийн хуулийн загвар болон социалист эрүүгийн эрх зүйн зарчим мөн чанарыг бүхэлд нь тусгаж, оруулсан байдаг. Харин 1997 онд зарим өөрчлөлт, нэмэлт оруулж, шинэчлэн баталжээ. Ялын төрөлд цаазаар авах ялыг (60 төрлийн гэмт хэрэгт) өргөн хүрээнд хэрэглэдэгээрээ онцлогтой.

Хятадын онцлогт тохирсон ялын өвөрмөц бодлогыг тогтоосны дээр социалист байгуулалт, нийгмийн аюулгүй байлыг хамгаалахад эрүүгийн эрх зүй нь чиглэгддэг. Тэрчлэн эрүүгийн эрх зүйн ухамсарт Хятадын уламжлалт ял цаазын сэтгэлгээн дэх ("Фа", "Ксин", "Лю") үүрэг, ёс жаягийг эрхэмлэх төр шүүхийг хүндэтгэх, үг дуугүй захирагдах, болон зан үйлийн соёл, хүмүүжил гүнзгий тусгагдаж төлөвшсөн байдаг.

Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх явдлыг зарим хүрээнд зөвшөөрдөг ба маш хатуу хяналтад хэрэгждэг. Эдүгээ Хятадын эрүүгийн эрх зүй нь нэг талаас социалист хэв маягийн эрүүгийн эрх зүйн шинжийг илрэхийлэхийн сацуу шүүхийн практикт эх газрын системийн чиг хандлага зохих хэмжээнд тусгагдсан, нөгөө талаас дорно дахины уламжлалт ёс заншил, үнэт зүйлсийг

⁶⁹ Л.Р.Сюкияинен Мусульманское право Вопросы теории и практики. М. 1986

хамгаалж, Хятадын гэсэн бие даасан тогтолцоог хөгжүүлж байгаагаараа онцлогтой.

Хосолсон ба холимог эрүүгийн эрх зүйн систем нь шинэ тутам хөгжиж байгаа болон үндэсний уламжлал, соёл, зан заншил гүнзгий төлөвшсөн орнуудын хувьд үлгэр загвар, чиглэл болон хөгжиж байна.

Латви улсын пробацийн үйл ажиллагаа:

Латви улс бусад пост-социалист орнуудын нэгэн адил 1991 оноос эрх зүйн тогтолцооны шинэчлэлийг эхлүүлсэн байдаг. Түүн дотор хэт төвлөрсөн хорих ял эдлүүлэх ажиллагааны сөрөг үр дагавар, рецедив гэмт явдлын өсөлтийг бууруулах, гэмт зан үйл бүхий этгээдүүдээс бүрдсэн зохион байгуулалттай гэмт бүлэглэлтэй тэмцэх асуудал хурцаар тавигдаж эхэлсэн. 2000-д онд Латви улс хорих ял эдлэгсдийн тоогоор европын улс орнууд дунд тэргүүлэх үзүүлэлттэй буюу 100,000 хүн ам тутамд 360 хоригдол ноогддог байжээ.

Энэхүү эрх зүйн болон тогтолцооны шинэчлэлийн явцад эрүүгийн ялын бодлогод томоохон өөрчлөлт оруулж, эрх зүйн өндөр хөгжил бүхий зарим улс орны туршлагыг судалсны үр дүнд пробацийн үйл ажиллагааг нэвтрүүлэх үндэс тавигджээ. Тус улсын Сайд нарын танхим нь 2003 оны 10 дугаар сарын 07-ны өдөр "Пробацийн албаны удирдлагын журам"-ыг баталсан бөгөөд "Сейм" буюу парламентаар 2003 оны 12 дугаар сард "Төрийн пробацийн албаны тухай" хуулийг батлан хэрэгжүүлж эхэлжээ.

Латви улсын пробацийн албан үндсэн чиг үүргийг судалж үзвэл дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Хяналтад орсон хүний талаарх бүхий л мэдээллийг багтаасан урьдчилсан илтгэл бэлтгэх. Энэ нь шүүх болон хууль хяналтын байгууллага, түүнчлэн тухайн хүнд чиглэсэн нөлөөллийн болон хяналтын арга хэмжээг багтаасан хөтөлбөрийг боловсруулахад ашиглах;
- Хяналтад орсон хүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зан үйлийг засах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Албадан ажил хийлгэх ялыг хэрэгжүүлэх;
- Насанд хүрээгүй этгээдийн талаар шүүхээс гаргасан хязгаарлалтын шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Эрүүгийн хэрэг нь түдгэлзсэн этгээдэд туршилтын хугацаа тогтоосон шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Хорих байгууллагатай хоригдлыг суллагдахад бэлтгэхэд хамтран ажиллах;
- Ял тэнссэн болон хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд хяналт тавих;
- Хорих байгууллагаас суллагдсан этгээдэд туслалцаа үзүүлэх.

Эндээс зөвхөн хорих байгууллагаас суллагдсан этгээдэд чиглэсэн үйл ажиллагааны чиглэлээр:

- Суллагдах хүнийг урьдчилан судалгаанд авах;

- Тухайн хүнийг судалсны дараа түүнтэй бичгээр хэлцэл байгуулах;
- Ял эдлэх үеийн бүхий л зан төлөв, хувийн байдлыг үндэслэн зан үйлийг төлөвшүүлэх хөтөлбөр боловсруулах;
- Орон байргүй тохиолдолд түр амьдрах байранд зуучлах, мэдээлэл өгөх;
- Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус байгууллагатай суллагдагсдыг нийгэмшүүлэх талаар хамтран ажиллах;
- Хэрэгцээт мэргэжлийн сургалтад хамрагдах, сонгоход туслалцаа үзүүлэх;
- Хувийн бичиг баримттай болоход туслах;
- Нийгэмшүүлэх зорилго бүхий тодорхой туршилтын хөтөлбөрт хамруулах санал тавих;
- Нийгмийн амьдралд ороход шаардагдах бусад зөвлөгөө, тусламжийг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Латвийн пробацийн алба нь 2010 оноос өөрийн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор хяналтад байгаа болон нийгэм сэтгэл зүйн нөлөөллийн үйлчилгээ, дэмжлэг үзүүлсэн хүмүүс, бусад иргэдийн дотор тандалт, судалгааны ажил хэрэгжүүлж ажиллаж эхэлсэн. Тус судалгааны үр дүнд шинжилгээ хийх замаар үйл ажиллагааныхаа аргачлалд зохих шинэчлэлийг хийж ажиллаж байна.

Эстони улсын пробацийн үйл ажиллагаа:

Эстони улсад 1993 оноос эхэлсэн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд анх Хууль зүйн яамны захиалгаар пробацийн албыг байгуулах үндэслэл, шаардлага, эрх зүйн орчны талаар хэлэлцэж эхэлсэн байдаг. Улмаар 1996 онд хуулийн төслийг боловсруулсны зэрэгцээ улсын төсвөөс ажилтны тоо, зардлыг асуудлыг шийдвэрлэн тогтсон бөгөөд “Эрүүгийн хяналтын тухай хууль” 1997 онд батлагдан гарч 1998 оны 5 дугаар сараас хуулийн хүчин төгөлдөр үйлчилж эхэлжээ⁷⁰.

Уг алба нь анх байгуулагдахдаа гэмт явдал өссөн нийгмийн онцлог нөхцөл байдалд хоригдол болон хянан харгалзсан, суллагдсан хүмүүстэй ажиллах мэргэжлийн ажилтнаар хүний нөөцөө бүрдүүлэх томоохон шалгууртай тулгарсан бөгөөд анх 200 ажилтантай, нэг ажилтан 30 хүнд хяналт тогтоохоор байгуулагдаж өнөөдрийг хүртэл өргөжин хөгжсөөр иржээ. Тухайн цаг үеэс пробацийн албаны ажилтанд эрх зүйн болон хяналтын, нийгмийн ажлын, харилцааны, удирдлагын, сэтгэл зүйн зэрэг мэдлэг, үр чадварын шаардлага тавигдаж ирсэн бөгөөд 2001 оноос зарим их сургуулиудад пробацийн албаны мэргэжилтнүүдийг тусгайлан бэлтгэх ажил эхэлжээ.

Эстони улсын пробацийн алба нь шүүх эрх мэдлийн байгууллагад харьяалагдан үйл ажиллагаагаа явуулдаг. Тийм учраас Эстоний пробацийн

⁷⁰ Обзор законодательства скандинавских и балтийских стран по службе пробации (уголовному надзору). Санкт-Петербург., 2010. Стр 12-13.

албаны салбар, нэгж, хэлтсийн ажилтнууд бүх анхан шатны шүүхийн байгууллага дээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг бөгөөд хэлтсийн зохион байгуулалтын болон хяналтын удирдлагыг шүүхийн дарга хариуцан хэрэгжүүлдэг.

Эстони улсын пробацийн алба байгуулагдсан үндсэн нөхцөлийг хорих ялын түвшинг бууруулах, хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэлийг хангах зорилготой холбон тайлбарладаг. Энэхүү байгууллага нь тусгайлсан зорилтын хүрээнд байгуулагдахдаа хорих ялыг тэнсэн хянан харгалзах, нийтэд тустай ажил хийлгэх шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Тус улс нь пробацийн албыг байгуулсан зорилгоо дараах байдлаар тодорхойлсон байдаг:

“Хорихоос өөр төрлийн ял шийтгэлийн бодлогыг хөгжүүлэх, шүүхээс тодорхой хугацаагаар хяналт тогтоон нийгмээс тусгаарлахгүйгээр шийтгэсэн этгээдийн нийгмийн болон ахуй нөхцөлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд тусламж, дэмжлэг үзүүлэх замаар дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэм дэх гэмт явдлын түвшинг бууруулах”⁷¹ хэмээн үзжээ.

Ингээд Эстоний пробацийн албаны чиг үүргийг товч авч үзье:

- Прокурор болон шүүхэд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн нийгэм, сэтгэл зүйн хандлага, онцлог, хувийн шинж байдал, амьдралын буюу нийгмийн нөхцөл байдал, цаашид хяналтад авах туршилтын хугацаа, хүлээлгэвэл зохих үүрэг, хязгаарлалтын талаарх дүгнэлт, тайланг танилцуулах;

- Шүүхээс тогтоосон хугацаанд нийгмээс тусгаарлахгүйгээр зохих хяналтыг хэрэгжүүлэх;

- Пробацийн албаны ажилтан нь хяналтад буй хүнд сурах, мэргэжил эзэмших, ажлын байр, амьдрах орон байр олох зэргээр нийгэмд дасан зохицоход тусламж үзүүлэх, зөвлөгөө өгөх, нийгэмд тустай ажил хийхэд зуучлах, бие даан хувийн амьдралын аливаа асуудлаа шийдвэрлэх чадвар эзэмшихэд эерэгээр нөлөөлөх, чадваржуулах;

- Хяналтад байгаа хүний хувийн байдлын талаарх мэдээлэл, хяналт тогтоосон шийдвэрийн гүйцэтгэлийн талаар шүүхэд танилцуулах;

- Хяналтад байгаа хүн хяналт тавихад саад учруулсан эсхүл дахин гэмт хэрэг үйлдсэн, шүүхээс тогтоосон үүргийг биелүүлээгүй зэрэг тохиолдолд ээлжит бус илтгэл, дүгнэлтийг шүүхэд танилцуулах;

- Шүүхэд хугацааны өмнө тэнсэн суллагдах хүсэлт гаргасан хоригдлын талаар хорих байгууллагаас асуулга авч, мэдээлэл цуглуулах, шүүхэд тэнсэн суллагдах боломжийн талаар танилцуулах;

- Хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд хяналт тавих;

- Насанд хүрээгүй хүнд тавих хүмүүжлийн арга хэмжээг хэрэгжүүлэх, нийгмийн харилцаанд оролцох чадвар эзэмшүүлэх;

- Нийтэд тустай ажил хийлгэх шүүхийн шийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах г.м.

⁷¹ Закон об уголовном надзоре. Оф.опуб. Таллин., 1998.

Эстоний пробацийн алба нь хяналтад байгаа хүнийг нийгмийн амьдралд дасан зохицох, тогтвортой хэвийн амьдралд шилжихэд нь дэмжлэг үзүүлэх явцдаа нийгмийн асуудал эрхэлсэн бүхий л байгууллагатай нягт хамтран ажилладаг бөгөөд хуулийн дагуу төрийн болон орон нутгийн байгууллагууд пробацийн албанд чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой тусламжийг үзүүлэх үүрэгтэй байдаг.⁷²

Эстоний пробацийн албаны ажилтанд багагүй өндөр шалгуур тавигддаг бөгөөд эрх зүй, нийгэм, сэтгэл зүйн дээд боловсролтой, нийгмийн салбарт ажилласан дадлага, туршлагатай, ажлын нөхцөл байдлын онцлогоос үүдэлтэй ачааллыг даах чадвартай байх зэргийг дурдаж болно. Түүнчлэн сайн дурын ажилтныг ажиллуулахад мөн тодорхой шалгуурыг харгалзан үздэг бөгөөд ямар нэг мөнгө урамшуулалгүй ажиллуулдаг.

Япон улсын пробацийн албаны үйл ажиллагаа:

Япон улсад ял шийтгэсэн шүүхийн тогтоолыг хойшлуулах институт үйлчилдэг. Хэд хэдэн үндсэн нөхцөл хамаарагдах ба шүүгдэгч хөдөлмөрт албадан татан оруулахаар 3 жилээс илүүгүй хугацаагаар хорих, 500000 иенээр торгох ялаар шийтгэгдсэн байх, эсвэл өмнө нь албадан хөдөлмөрт татан оруулахаар хорих ялаар болон түүнээс хүнд ял шийтгэгдсэн ял эдэлсний дараа 5 жилийн турш дахин гэмт хэрэг үйлдэж шийтгэгдэж байгаагүй байх ёстой. Хянан харгалзах хугацаа 1-5 жил байна. Арга хэмжээний биелэлтийг цагдаагийн байцаагч хэрэгжүүлнэ.

Японы пробацийн албаны уламжлал:

Гэмт хэрэг үйлдэж байсан хүмүүсийг нөхөн сэргээх үйлчилгээний түүх нь 1888 онд байгуулагдсан Шизуока мужийн Чөлөөлөлттэй Хамгаалах компанитай (Одоо цагт “Шизуока мужийн Канзсайкай”, гэмт хэрэгтнүүдийн нөхөн сэргээлтийн эрх зүйн үндэстэй холбоотой юм. Тус компанийг олон нийтийн эрх ашгийн төлөө амьдралаа зориулсан бизнес эрхлэгч Meizen Kimpara, Kyoichiro Kawamura, Шизуоко шоронгийн захирагч болон бусад газруудтай хамтран үүсгэн байгуулжээ. Тус компани нь ял эдэлж байсан хүмүүсийг байр сууц, ажлын байраар ханган, 1700 гаруй ял эдэлж байсан хүмүүст дэмжлэг үзүүлэх үүрэг даалгасан байна. Ингэснээр үндэсний хэмжээнд ял эдэлж байсан хүмүүсийг дэмжих ижил төстэй холбоодыг хувийн хэвслүүдийн дэргэд байгуулах үндэс тавигджээ.




Meizen Kimpara
(1832-1923)

⁷² Обзор законодательства скандинавских и балтийских стран по службе пробации (уголовному надзору). Санкт-Петербург., 2010. Стр 12-13.

Нөхөн сэргээх ажиллагаа гэж юу вэ?

Нөхөн сэргээх гэдэг нь гэмт хэрэгтэнтэй зохистой харьцах, насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг арилгах хөтөлбөрийг хэлнэ. Үүнд: сөрөг зан үйлийг арилгах, нийгмийн халамж, хувь хүний сайн сайхан байдлыг хангах, гэмт хэрэгтний бие даан амьдрах чадварыг сайжруулах, нөхөн сэргээлтийг дэмжих, нийгмийн амьдрал дахь оролцоонд нь туслах, ард иргэдээс дэмжлэг авах зэрэг байна. Жирийн иргэдийн эерэг хандлага нь ял эдэлж байсан хүнд нийгэмд дасан зохицох эхний алхам болдог байна.

Засан хүмүүжүүлэгч





Тэнсэн харгалзах алба

Эдгээрийг орон нутгийн шүүхийн суудал бүр дээр байгуулж, нийгмийн нөхцөл байдлыг зохицуулах, яаралтай шийтгэл хүлээлгэн өгөх, уучлал хүсэх өргөдөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, нөхцөл байдлын улмаас ноцтой тохиолдлуудыг үүсгэсэн хүмүүсийг олон нийтэд түшиглэсэн эмчилгээ, гэмт хэрэгтнүүдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад чиглэсэн арга хэмжээ авах.

Тэнсэн харгалзагч

Сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухаан, нийгмийн хамгаалал, социологи, бусад гэмт хэрэгтнүүдийг нөхөн сэргээхтэй холбоотой талбарт мэргэшсэн байцаан шийтгэх ажилтан, гэмт хэрэг үйлдсэн эсвэл насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн этгээдийн нийгмийн нөхцөл байдлыг хянан, зохицуулах зорилгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа..

Нөхөн сэргээлтийн зохицуулагч

Нөхөн сэргээлтийн зохицуулагчид нь сэтгэл мэдрэлийн нийгмийн ажилтны мэргэшсэн үндэсний төрийн албан хаагчид юм. Сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлын талаархи мэдлэг туршлагаар тэд нийгмийн бүлгүүдийн эмчилгээ, нийгмийн нөхцөл байдлыг зохицуулахын тулд доройтлын нөхцөлд ноцтой хэрэг үүсгэсэн хүмүүст үйлчилдэг. Эмчилгээний тасралтгүй эмчилгээ, эмчилгээ үйлчилгээнд хамрагдах боломжтой хүмүүст эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасны дагуу дэмжлэг үзүүлэх, нөхөн сэргээх, нөхөн сэргээх ажлыг хөхиүлэн дэмжиж, холбогдох байгууллагуудын эвслийг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Сайн дурын туслалцаа, дэмжлэг туслалцаа үзүүлж буй хуулийн этгээдүүд

Сайн дурын тэнсэн харгалзагч

Сайн дурын ажиллагааны ажилтнууд нь ял эдэлж байсан болон насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн хүмүүст нийгмийн амьдралд дасан зохицуулах, бие даах чадвартай болгохын тулд дэмжлэг үзүүлдэг сайн дурынхан юм. Тэдгээр нь ихэвчлэн зөвлөгөө өгөх чиглэлээр ажиллах ба насанд хүрээгүй хүмүүст зориулсан сургалтын ирээдүйн нийгмийн нөхцөл байдлыг зохицуулах, нийгэмд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өгдөг байна. Одоогийн байдлаар тус улсад 50 000 гаруй сайн дурын ажилтан энэ чиглэлээр ажиллаж байна.

Байр суурь


Сайн дурын ажилтан хагас болон жирийн албан хаагч нартай адилхан цагаар ажилладаг. Тэд цалин авдаггүй.

Албан болон тэтгэвэрийн нас

Сайн дурын байцаагчдыг 2 жилийн хугацаагаар томилдог. 76 наснаас доош иргэн дахин томилогдож болно.

Нийцэх байдал

Сайн дурын ажилтнууд дараах шаардлагыг хангасан байх ёстой: (1) нийгмийн идэвхтэй, (2) эрх хүчтэй, сайн дурын ажилтнаар үйлчлэхэд хангалттай завтай байх, (3) өөрийн тогтсон амьдралтай байх (4) эрүүл мэндийн асуудалгүй байх.



Суллагдсан хоригдлуудад туслах төв

Тэд сайн дурын ажитны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, холбогдох байгууллагуудтай холбоо тогтоох замаар улсын хэмжээнд сүлжээг бий болгоно..

Сайн дурын ажилтныг ажилд авах

Сүүлийн жилүүдэд сайн дурын ажилтны тоо буурч, нийгмийн нөхцөл байдал өөрчлөгдсөн байна, учир нь иргэдийн харилцаа суларч, сайн дурын ажилчдын үйл ажиллагааг улам хүндрүүлж байна. Ирээдүйн сайн дурын ажиллагааны мэргэжилтэнг ажиллуулах нь гэмт хэрэгтнийг нөхөн сэргээх асуудлыг яаралтай шийдвэрлэх асуудал юм.

Иймэрхүү нөхцөл байдалд сайн дурын туршилтын ажилтан, эрдэм шинжилгээний шинжээчдээс бүрдсэн "Сайн дурын ажилтны ажлын байрны сайн тогтолцоог бий болгох ажлын байрны тоймыг хэлэлцэх нь 2011 оны 3-р сард эхэлсэн бөгөөд 2012 оны 3-р сард хянан шалгалтын уулзалтын тайланг гаргалаа. Хууль зүйн яамнаас туршилтын журмаар хохирогчдод эд хөрөнгийн хохирол учруулсан сайн дурын байцаагчид нөхөн олговрын тогтолцоог шинээр бий болгож, сайн дурын байцаагчдын ажилчдын холбоог "Сайн дурын ажилтны нэр дэвшигчийг шалгах ажилтнуудад шалгалт хийх хороо" -г байгуулсан. Зорилго нь олон нийтээс нэр дэвшигчийг элсүүлэх байв. Үүнээс гадна Хууль зүйн яам нь сайн дурын ажилтнуудыг ажиллуулах төвийн хохирогчдыг нөхөн сэргээх дэмжлэг үзүүлэх төвийг сайжруулах чиглэлээр ажиллаж байна.



Volunteer probation officers working at offenders rehabilitation support centers.

Нөхөн сэргээлтийн тусламжийн эмэгтэйчүүдийн холбоо

Эмэгтэйчүүдийн Нөхөн сэргээлтийн Тусламжийн Холбоо нь иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг сайн дурын бүлгүүдтэй. Мөн гэмт хэрэг үйлдсэн эсвэл насанд хүрээгүй гэмт хэрэгтэн үйлдсэн гэмт хэрэгтнийг нөхөн сэргээх үйл ажиллагааг дэмжиж ажилладаг..

Тэд орон нутгийн оршин суугчтай уулзаж, гэр бүлийн нөхцөл байдал, зөрчил дутагдлын асуудлуудад дэмжлэг үзүүлдэг, ял эдэлсэн хуулийн этгээдүүдийг илүү сайн нийгэмшүүлэх, нөхөн сэргээх, засч залруулах байгууллагуудад очиж ажилладаг. Одоогийн байдлаар 180,000 орчим гишүүн улс орон даяар эдгээр хөтөлбөрүүд дээр ажиллаж байна.



Women's Associations for Rehabilitation Aid badge



Нөхөн сэргээлтийн тусламжийн холбоо

Нөхөн сэргээлтийн холбоо нь суллагдсан хоригдолуудад дэмжлэг, зөвлөгөө өгдөг ашгийн бус байгууллага юм.

BBS Холбоо



BBS symbol

BBS-нь насанд хүрээгүй ял эдэлж байсан охид, хөвгүүдтэй "том дүү", "том эгч" мэт дотно харьцаатай байх замаар зөв замд нь чиглүүлж байдаг. BBS-ийн холбооны залуучууд сайн дурын бүлгийнхэнтэй хамтран ажиллаж, сургалт хийж, бусад нийгмийн хөдөлгөөнийг зохион байгуулдаг.

Тэд мөн орон нутгийн хэмжээнд урьдчилан сэргийлэх, нийгмийн оролцооны гэх мэт үйл ажиллагаан дээр ажиллаж байна. Одоогоор ойролцоогоор 5,000 BBS-ийн гишүүд эдгээр хөтөлбөрүүд дээр ажиллаж байна.

Ажил олгогч

Ажил олгогчид нь мэргэжлийн хүмүүсийг ажилд авдаг. Тэд гэмт хэрэгтэй тулгарч байсан тул тогтмол ажлын байр олоход бэрхшээлтэй байдаг учраас энэ ажлыг сонгодог



■ Нөхөн сэргээх байгууламж

Суллагдсан хоригдлууд бие дааж амьдрах чадваргүй, богино хугацаанд сэргэн босох боломжгүй байдаг учраас нөхөн сэргээлтийн байгуулагууд нь суллагдсан хоригдлуудад түр хугацаагаар байрлах байр болон хоолоор хангадаг.

■ Нөхөн сэргээх байгууламж

Түр зуурын орон байр, хоол хүнсээр хангаж гэмт хэрэгтний нийгмийн оролцоог хангахад чиглэсэн амьдралын хэв маягийн удирдамжаар хангаж, хоригдлуудыг нийгэмд дахин нэгтгэх боломжтой болгодог. Одоогийн байдлаар дэлхий дээр Японы нөхөн сэргээлт хийдэг 104 байгууллага байна. Эдгээр байгууламжуудийг Япон улсын Хууль зүйн сайдын баталсан бөгөөд хувийн хэвشلүүдийн удирдлаган дор ажиллуулдаг.




Гаднах үзэмж



Сургалт



Өрөө



Батлан даалтаар суллагдах

Эрүүгийн шүүн таслах ажиллагааны журам

Ял эдэлж байгаа насанд хүрээгүй хуулийн этгээдүүдийг тусгай сургуульд хамруулж, хэрхэн дахин нийгэмд оролцох талаар мэдээллээр хангадаг. Сургалтын явцад тэд батлан даалтан доор байдаг.




Нийгэм дээрх нөхцөл байдлыг зохицуулах зөвлөл

Нийгмийн нөхцөл байдлын зохицуулалт нь хорих анги, насанд хүрээгүй хуулийн этгээдийг засан хүмүүжүүлэх сургууль болон ямар нэгэн шоронд ял эдэлж байгаа хуулийн этгээдүүдэд суллагдсаны дараа нийгэмд хөл т авих, амьдрах газар, ажлын байраар хангах талаар туслалцаа үзүүлдэг юм.

Тусгай зохицуулалт

Тэнсэн зохицуулах алба нь “тусгай зохицуулалт” -ын үүрэг даалгаврыг биелүүлж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие дааж амьдрахад хүндрэлтэй байгаа хоригдлуудыг дэмжих зорилготой ажиллаж байна. Хорих анги эсвэл Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны “Нийгмийн амьдралыг тогтворжуулах төв” -тэй тэнсэн харгалзах алба хамтран ажилладаг. Хоригдлууд суллагдсаны дараа Нийгмийн халамжийн байгууллагаас халамжийн үйлчилгээг авах боломжтой байлгахын тулд шаардлагатай зохицуулалтыг хийдэг.

Хэрвээ суллагдсан хуулийн этгээд засч залруулах байгууллагаас суллагдсаны дараа халамжийн дэмжлэг авахад хүндрэлтэй байвал нөхөн сэргээлтийн байгууламж түр хугацаагаар хүлээн авч, халамжийн үйлчилгээнд илүү уян хатан үйлчилгээ үзүүлэх, нийгмийн



халамжид дасан зохицох заавар чиглэл өгнө.

Нийгмийн халамжийн мэргэжилтнийг эдгээр тусгайлсан гэмт хэрэгтнүүдийн нөхөн сэргээлтийн байгууламжид томилдог.

Тэнсэн

Зорилго ба тэнсэнгийн төрлүүд

Тэнсэн гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг нийгмийн сайн иргэн болгон нөхөн сэргээхийн тулд засгийн газрын харьяаллын дор заавар / хяналт, удирдамж / тусламж үзүүлэх үйлчилгээ үзүүлэх гэсэн үг юм. Дараах 5 төрлийн тэнсэн байдаг.


Тэнсэн харгалзагч	Тэнсэн харгалзах нөхцөл
Насанд хүрээгүй хуулийн этгээд (эцэг эхийн доор тэнсэн харгалзах)	Ялтан 20 нас хүртэл, эсвэл 2 жил
Насанд хүрээгүй хуулийн этгээдийн засан хүмүүжүүлэх сургуулиас тэнсэн харгалзах	Ялтан 20 нас хүртэл
Хорих ангиас тэнсэн харгалзах	Үлдсэн шийтгэлийн хугацаа
Шийтгэх тогтоолыг түдгэлзүүлж байгаа	Түдгэлзүүлсэн нөхцөл
Эмэгтэйчүүдийн удирдамжийн дагуу тэнсэн харгалзах	Үлдсэн залруулгын хугацаа



Тэнсэн харгалзагч Сайн дурын тэнсэн харгалзагч

Тэнсэн харгалзах арга байрлалууд

Тэнсэн харгалзах албан хаагч болон сайн дурын харгалзагч нар зааварчилгаа, хяналт, удирдамж, туслалцаа үзүүлэх зорилгоор хамтран ажилладаг.



Ялтны нөхөн сэргээлтийн үндэсний төв

Уг төв нь хүнд нөхцөл байдалтай урьд нь ял эдэлж байсан нийгэм, хувийн байгууллага болон хамаатан садангаасаа туслалцаа авах боломжгүй хуулийн этгээдэд туслалцаа болон заавар зөвлөгөө болон ажлын байраар хангадаг юм.

Ингэснээр дараагийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үндэсний аюулгүй, найдвартай бүс нутгийг бий болгоход түлхэц үзүүлж байна.

Суллагдсан хоригдолд туслалцаа үзүүлэх

Шүүгч, прокурор, цагдан хоригдож байгаа хүмүүсийг шийтгэх ажиллагаа, хамгаалалтад авах арга хэмжээ нь туслалцаа, хамгаалалт шаардагдах тохиолдолд дараах үйлчилгээг авах эрхтэй.

Төрөл	Шаардлага	Нөхцөл	Үйлчилгээ
	Урьдчилан сэргийлэх боломжтой байх	Нөхцөл	<ul style="list-style-type: none"> • Хоол болон зардлаар хангах • Амьдрах байраар хангах • Эмнэлэгийн туслалцаа үзүүлэх • Гэрт нь хүргэж өгөх • Мөнгөн туслалцаа • Ажлын байр, болон бусад зүйлээр хангана
	<p>Person falls under all of the requirements (1), (2), and (3)</p> <p>(1) Тухайн хүн шийтгэлийн журмаар эсвэл хамгаалалтын арга хэмжээ авах замаар бие махбодийн хязгаарлалтаас чөлөөлөгдөнө.</p> <p>(2) Тэр хүн хамаатан саднаасаа тусламж дэмжлэг үзүүлэх эсвэл нийгмийн эрүүл мэндийн байгууллагуудаас дэмжлэг авах боломжгүй</p> <p>(3) Шаардлагатай яаралтай тусламжийг яаралтай авах шаардлагатай.</p>	Онцгой тохиолдолд нэмэлт 6 сараас илүү хугацаагаар сунгаж болно.	

Ажлын тусламж

Ял эдэлсэн хоригдлуудыг дараагийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд тэднийг ажлын байраар хангах нь нэн чухал юм. Ийм учраас Хууль зүйн яам нь ажилд зуучлах үйлчилгээ үзүүлдэг. 2006 оны санхүүгийн жилээс эхлэн Хууль зүйн яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал хамтран “суллагдсан хоригдлуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнүүд” зохион байгуулж, ажилд зуучлах үйлчилгээ үзүүлдэг.


Ажлын байрны туслалцаа үзүүлэх

Засгийн газар тендерийн журмаар шинэ ажлын байрнууд гаргаж байгаа

Нийгмийн хэв журмыг сахиулах нь бүхэлдээ нийгэмд ашиг тусаа өгдөг учраас бизнесийн бүлгүүд бүхэлдээ ажлын байраар хангах, дараагийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд суллагдсан хоригдлуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ёстой. Энэ утгаараа 2009 онд “Ажил олгогчдыг ажилд зуучлах үндэсний байгууллага” (2009 онд батлагдсан АТББ-ыг томилсон) 2009 онд эдийн засгийн байгууллага, том корпорац оролцогч талууд байгуулагдсан. Ажлын байрны үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг 50 улсын хэмжээнд байршуулсан (муж бүрт 1 байгууллага, Хоккайдод 4 байгууллага)

Өршөөл


Талархал нь хоёр ангилалд хуваагдана. Үүнд: өршөөлийн хэрэгжилтийг жигдрүүлсэн Засгийн газрын танхимын дагуу уучлан, онцгой тохиолдлуудад тусгай этгээдэд олгогддог өршөөлийн өрийг хэлнэ.



Гэмт хэргийн хохирогчдын нөхөн сэргээлт

Засгийн газар 2007 оны 12-р сарын 1-нд гэмт хэрэгтний нөхөн сэргээлттэй холбоотой гэмт хэрэгт холбогдсон 4 арга хэмжээг эхлүүлсэн.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхдээ засгийн газар зөвхөн хохирогчийн асуудал хариуцсан ажилтнууд (гэмт хэргийн хохирогчийн асуудал хариуцсан ажилтан, гэмт хэргийн хохирогчдын асуудал хариуцсан ажилтан). Тэд албан тушаалд томилогдох үедээ хүчирхийлэл үйлдэгчдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдоггүй.



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Нийгэм дээр гарсан урьд нь гэмт хэрэг үйлдэж байсан хуулийн этгээдийн засарсан, өөрчлөгдсөн байдлын ойлгуулах



Сэтгэл санааны нөхцөл хүнд гэмтэл авсан хүмүүст зориулсан эмнэлгийн тусламж, эмчилгээний тухай хууль

Эмчилгээний систем нь 2005 оны 7-р сард эхэлсэн бөгөөд аллага, гал түймэр гэх мэт ноцтой хэрэгт өртсөн хүмүүсийг нийгэмд нөхөн сэргээхэд хүргэдэг. Асрамжийн багийн гишүүдийн хувьд эдгээр хүмүүсийн нийгмийн нөхөн сэргээлтийг дэмжиж, ийм төрлийн эмчилгээ хийлгэх зорилгоор сэтгэцийн эрүүл мэндийн халамжийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



БНСУ-ын пробацгийн албаны үйл ажиллагаа:

Солонгос улс дах пробац, тэнсэн харгалзах тогтолцоо

“Пробаци, тэнсэн харгалзах тогтолцоо нь гэмт хэрэг болон давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, шударга ёсыг тогтоох төрийн дэвшилтэт бодлого юм.”

Пробаци, тэнсэн харгалзах тогтолцоо гэж юу вэ?

Пробаци, тэнсэн харгалзах тогтолцоо гэдэг нь ялтныг тодорхой нөхцөлтэйгөөр пробацийн албаны офицерын хяналт дор олон нийттэй хамт амьдрах, ажиллах эрх, боломжийг олгодог хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа юм.



Пробаци, тэнсэн харгалзах тогтолцооны давуу тал

Хүний эрхийн төлөв байдлаас үүдэлтэй эрүүгийн шударга ёсны бодлого:

- Пробаци, тэнсэн харгалзах тогтолцоо нь ялтныг хорих ял эдлэх хугацаанд нийгмээс ангид байхаас урьдчилан сэргийлэхээс гадна, гэр бүлийн болон нийгмийн харилцаанд орох боломжийг олгодог. Ингэснээр ялтан, түүний гэр бүлийн санхүүгийн хүндрэл, сэтгэл санааны шаналлыг багасгана.

- Пробаци, тэнсэн харгалзах тогтолцоо нь ялтныг түргэн хугацаанд, амжилттай нийгэмшүүлэхэд нөлөөлж, шоронд хоригдохоос болж үүсч болзошгүй гэмт явдлын нөлөөнөөс урьдчилан сэргийлнэ.

- Пробаци, тэнсэн харгалзах тогтолцоо нь шоронгийн ачаалал, төсвийн зардал хэмнэсэн хорихоос өөр төрлийн ялын асуудлыг шийддэг.

Олон нийтийн оролцоо

- Пробаци нь олон нийтийн гишүүдийн идэвхтэй оролцоонд тулгуурласан учраас, сайн дурынхан болон иргэний нийгмийн бүлгүүдтэй хамтран тухайн ялтныг засан хүмүүжүүлэх, нөхөн сэргээх нь үр дүнтэй бөгөөд түлхүүр арга юм.

Пробаци, тэнсэн харгалзах тогтолцооны үүсэл, хөгжил

БНСУ-ын пробаци, тэнсэн харгалзах тогтолцооны түүх

1980 – 1990

1988 Пробацийн хуулийг баталсан.

1989 Насанд хүрээгүй ялтнуудад зориулсан пробацийн тогтолцоо хэрэгжиж эхэлсэн.

Насан хүрээгүй хүмүүст зориулсан ял шийтгэлийн мөрдөн байцаалт (цагдан хорих) хэрэгжиж эхэлсэн.

Пробаци, тэнсэн харгалзах чиг үүрэг бүхий 22 агентлагийг нээсэн.

1994 Бэлгийн хүчирхийлэл үйлдэн ял эдэлж буй ялтнуудад зориулсан пробацийн тогтолцоо хэрэгжиж эхэлсэн.

1995 Пробаци, тэнсэн харгалзах удирдлагын тогтолцоо (MSPP) бүтээн байгуулагдсан.

1997 Насанд хүрсэн ялтнуудад зориулсан пробацийн тогтолцоог бий болгож, өргөжүүлэв.

1998 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн ял эдэлж буй ялтнуудад зориулсан пробацийн тогтолцоо хэрэгжиж эхэлсэн.

2000 –

2001 Тэнсэнтэй ялтныг хянах зохицуулалтыг нэвтрүүлсэн.

2003 Тэнсэнтэй ялтныг эрчимтэй хянах хөтөлбөр /программ/-ийг хэрэгжүүлсэн.

2004 Бэлгийн мөлжлөг үйлдэн ял эдэлж буй ялтнуудад зориулсан пробацийн тогтолцоо хэрэгжиж эхэлсэн.

- 2005** John-School хөтөлбөр /биеэ үнэлэгчдээр үйлчлүүлэгчдэд чиглэсэн олон улсын боловсролын хөтөлбөр/ хэрэгжиж эхэлсэн.
Дуу хоолойг хянаж, баталгаажуулдаг систем /CVS/-ийг нэвтрүүлсэн.
- 2008** Цахим хяналтын системийн танилцуулга /Бэлгийн хүчирхийлэл үйлдэн ял эдэлж буй ялтнуудад зориулсан/
- 2009** Хуулиар хүлээсэн үүргээ үл биелүүлэгч нарт зориулсан олон нийтийн үйлчилгээний ажлын хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн.

2010 –

- 2010** Цахим хяналтын программ өргөжиж, хүний амь нас хүрсэн, бэлгийн хүчирхийлэл үйлдэж ял эдэлж буй ялтнуудад хэрэглэх боломжтой болсон.
- 2011** Бэлгийн хүчирхийлэл үйлдэн ял эдэлж буй ялтнуудад зориулсан нөхөн сэргээх эмчилгээг танилцуулсан.
- 2013** Нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан нийтийн үйлчилгээний зарим ажлыг захиалгаар гүйцэтгүүлж эхэлсэн.
- 2014** Цахим хяналтын программ өргөжиж, дээрэмдэх гэмт хэрэг үйлдэж ял эдэлж буй ялтнуудад хэрэглэх боломжтой болсон.
- 2015** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогын холбоонд өндөр-эрсдэлтэй ялтны удирдлагын хэлтсийг бий болгов.

Байгууллага


Пробаци, тэнсэн харгалзах тогтолцоо нь нийгмийн илүү аз жаргалтай газар болгохоор ажиллаж байна. Пробаци нь олон нийттэй идэвхтэй түншлэн ажиллана.

Пробацийн офицерууд ялтныг нийгмийн жинхэнэ гишүүн болоход нь туслахын тулд хяналт тавин чиглүүлж байна. Ёс суртахуунтай, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар амьдралаа удирдаж чаддаг болгохын тулд офицерууд ялтнуудыг байнгын хараа хяналтдаа байлгаж байна.


Агентлагуудын тоо

Нийт	Пробаци, тэнсэн харгалзах албаны комисс	Пробаци, тэнсэн харгалзах алба	Цахим хяналтын төв
63	5	56	2

Агентлагуудын тооны өөрчлөлт /1989-2015/




Томилсон алба хаагчдын тооны өөрчлөлт /1989-2015/



Байгууллагын бүтэц

- 5 пробаци, тэнсэн харгалзах албаны комисс
- 56 пробаци, тэнсэн харгалзах алба (18 төв, 38 салбар)
- 2 цахим хяналтын төв (Үндсэн төв, Даежеон төв)



Пробаци, тэнсэн харгалзах албад

Тэнсэн харгалзах тогтолцоо – шинэ эхлэл, эв нэгдэлтэй амьдрах боломж.

Пробаци, тэнсэн харгалзах тогтолцоо нь хууль зөрчигчдийг хянаж, тэднийг албадан нийтийн хөдөлмөр эрхлүүлж, сургалтад хамруулах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлж өгдөг юм. Бид хууль зөрчигчдөд “нийгэм” гэдэг зүйлийн онцлогийг ойлгуулж, эв нэгдэлтэй амьдрах үнэ цэнийг мэдрүүлдэг.

Пробаци, тэнсэн харгалзах албаны ерөнхий үйл ажиллагаа

Нийтийн хяналт тогтоох ажиллагааны хэрэгжүүлэлт

- Ялтнуудтай тогтмол харилцаж, хувийн хаяг, гэрт нь очиж хяналт тавих.
- Ялтнуудыг сургалтад хамруулж, ажил олоход тусалж, дахин нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх.
- Тэнсэн харгалзах нөхцөлийг зөрчсөн тохиолдолд ялыг хүчингүй болгож, дахин шийдвэрлүүлэх.

Цахим хяналт

- Бэлгийн хүчирхийлэл, хүний наймаа, хүн амины хэрэг болон хулгайн гэмт хэрэг үйлдсэн ялтнуудад 24/7 цагийн GPS хяналт.
- Эрчимтэй, тогтмол хяналт тавих замаар өндөр эрсдэл бүхий ялтнуудын дахин гэмт хэрэг үйлдэх магадлалыг бууруулна.

Албадан нийтийн үйлчилгээ эрхлүүлэх ажиллагааны хэрэгжилт

- Ялтнуудыг албадан хөдөлмөр эрхлүүлж, нийтийн үйлчилгээнд татан оролцуулах ажлыг хянаж, шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх.
- Орон нутгийн хэмжээнд туслалцаа үзүүлэн ажиллах. Тухайлбал, нийгмийн эмзэг буюу гадуурхагдсан анги давхарга болон хөдөө орон нутгийн алслагдсан гэр бүлүүдэд халамж туслалцаа үзүүлэх.
- Шүүхийн шийдвэрийн гол зорилго нь гэмт хэрэгтнийг шийтгэж, дахин нийгэмшүүлж, боловсруулах байдаг.

Ялтнуудыг сургах, эмчлэх ажиллагааны хэрэгжүүлэлт

- Бэлгийн гаж донтон болон мансууруулах бодист донтогчдыг заасан хугацааны дагуу сургаж, эмчлэх ажиллагааг гүйцэтгэх.
- Хувь хүний хариуцлага, харилцааны ур чадварыг дээшлүүлэх замаар хууль зөрчигчдийн нийгэмд дасан зохицох чадварыг хөгжүүлэх.

Мөрдөн байцаалт

- Шүүгч эсвэл прокурорын тогтоолоор гэмт хэрэгтнийг мөрдөж, хувийн хэрэг болон түүхийг судлан илрүүлэх.
- Ялтнуудад пробаци, тэнсэн харгалзах ял шийтгэл оноох нь тохирсон эсэхийг тодотгосон тайлан бэлтгэх.

- Прокурорын зүгээс ялтнуудад GPS-ээр хяналт тавих, эмчилгээнд хамруулах хүсэлтийг тавихад хэрэгтэй чухал мэдээллийг хангах.

Бэлгийн хүчирхийлэл үйлдсэн ялтнуудад үзүүлэх эмчилгээний хөтөлбөр

- Бэлгийн хүчирхийлэл үйлдсэн ялтнуудыг эмчилгээнд хамруулах тушаал гарсан тохиолдолд түүний дур хүслийг бууруулах, улмаар сэтгэцийн байдлыг хянаж, нөлөөлөх анти-андроген эм танг хэрэглүүлэх.

- Эм зүйн эмчилгээний хөтөлбөрийг ерөнхийдөө хувь хүний зан аашийг засах сэтгэл зүйн эмчилгээтэй хамт давхар хэрэгжүүлдэг.

Пробаци, тэнсэн харгалзах ажиллагааны хяналт

Ерөнхий танилцуулга

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахын тулд тэнсэн харгалзах албаны ажилчид байнга ялтнуудтай уулзалт зохион байгуулж, амьдралын орчинд нь дүн шинжилгээ хийн хяналт тогтоон ажилладаг. Тэнсэн харгалзах албаны ажилчид мөн ялтнуудыг дахин нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулан мэргэжлийн сургалт, хөдөлмөр эрхлэлт болон санхүүгийн туслалцаа үзүүлэн ажилладаг билээ.

Стандарт нөхцөл

- Ялтнууд бүртгэгдсэн хаягтай амьдарч, тогтмол хөдөлмөр эрхлэх шаардлагатай.

- Ялтнууд өөртөө өндөр хяналт тавьж, гэмт хэрэгт холбогдох магадлалтай хүмүүсээс хол байх.

- Ялтнууд тэнсэн харгалзах албаны ажилчдаас өгсөн аливаа зааварчилгааг нэг бүрчлэн биелүүлэх.

- Хаягаа өөрчилсөн эсвэл нэг сараас дээш хугацаагаар гадаадад аялах гэж байгаа тохиолдолд албаны ажилтанд мэдүүлэг өгч, зөвшөөрөл авах.

Тусгай нөхцөл

Тусгай нөхцөлийг шүүх, Пробаци, тэнсэн харгалзах албаны комисс аль эсвэл шүүхийн шинжилгээний сэтгэц эмгэгийн зөвлөлийн шийдвэрээр зааж өгдөг. Энэ нь тэнсэн харгалзах хөтөлбөрт хамрагдаж байгаа хэрэгтний хувь хүний хэрэгцээ шаардлага болон зан чанарыг тусгасан байдаг.

- Шүүхээс тогтоосон цагийн хуваарийг дагах (хөл хорих цаг);

- Шүүхээс тогтоосон тодорхой газрууд болон бүс нутгаар зорчихгүй байх (явахгүй байх);


- Шүүхээс зааж өгсөн тодорхой хүмүүстэй харьцахгүй байх. Жишээ нь, гэмт хэргийн хохирогч;

- Мөрийтэй тоглоом тоглохоос татгалзах;

- Архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэхгүй байх;


- Гэмт хэргийн хохирлыг аль болох бууруулахыг хичээх;
- Байнгын оршин суух хаяггүй бол хаягаа өөрчлөх хориглолтуудыг дагаж мөрдөх;
- Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэхээс татгалзах;
- Пробаци, тэнсэн харгалзах албаны ажилтны зааварчилгааны дагуу мансууруулах бодисын шинжилгээнд орох.

Үйл ажиллагааны хэрэгжилтийн үндсэн журам



Үр дүн

ЭХ-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс өмнөхтэй нь харьцуулбал GPS-ээр бэлгийн хүчирхийлэгчдийг хянаж эхэлснээс хойш давтан хэрэг 1/8-аар буурсан байна.



Цахим хяналтын системийг ашиглаж эхэлснээс хойш дахин бэлгийн хүчирхийлэл үйлдэх магадлал хэр буурсныг харуулсан дүрслэл

Албадан нийтийн үйлчилгээ эрхлүүлэх ажиллагаа

Ерөнхий танилцуулга

Энэ ялыг шүүхээс оноодог бөгөөд тухайн шийтгэлээр ялтан шоронд хоригдохын оронд ямар ч цалингүй нийгмийн үйлчилгээний ажлыг тодорхой цагаар хийж гүйцэтгэдэг. Тухайн ял шийтгэл нь ялтнуудад гэмших боломжийг олгож, улмаар өөрсдийн нийгэмд учруулсан хохирлыг барагдуулах бололцоог бүрдүүлж өгдөг.

Хэрэгжүүлэх аргачлал

- Долоон хоногийн турш өдөрт 9 цагаар албадан олон нийтийн үйлчилгээ эрхлүүлдэг.
- Ялтнуудад ажиллах боломж олгох үүднээс олон нийтийн үйлчилгээнд татан оролцуулах цагийн хуваарийг уян хатан байдлаар зохион байгуулж болдог. Тухайлбал тэд амралтын өдрүүдэд ажиллах эсвэл долоон хоногийн 2-3 хоногоор илүү бага цагаар ажиллах боломжтой.

Олон нийтийн үйлчилгээний ажлын төрөл

- Эмзэг, чадваргүй хүмүүст туслах (усанд орох, үс засах, цэвэрлэгээ хийх, хоолны үйлчилгээ болон гэр орны туслалцаа).
- Нийгмийн халамжийн байгууллагуудад туслалцаа үзүүлэх (өндөр настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах).
- Гэр орны засвар үйлчилгээ (засвар, цэвэрлэгээ болон засал чимэглэл ажил гүйцэтгэх).
- Газар тариалан болон загасны аж ахуй (хөдөө орон нутагт хэрэгтэй газруудад туслалцаа үзүүлэх).
- Байгалийн гамшигт үзэгдлийн дараах сэргээн засварлалтын ажил (Тухайлбал, гал түймэр, үер болон бусад гамшиг).
- Орон нутгийн болон олон нийтийн арга хэмжээний ажиллагаа (хүрээлэн буй орчин цэвэрлэх, олон нийтийн арга хэмжээнд туслах ажил гүйцэтгэх).

Ялтнуудыг сургах, албадан эмчлэх

Ерөнхий танилцуулга

Энэ ял шийтгэлийг хар тамхи мансууруулах бодис хэрэглэсэн, согтуугаар автомашин жолоодсон, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эсвэл бэлгийн хүчирхийлэл үйлдэгч нарт оноодог. Ийм төрлийн гэмт хэрэгтнүүд нь цаашид сэтгэл санааны асуудал, гажуудал болон зан авирын тогтворгүй байдлаас болж гэмт хэрэг дахин үйлдэх өндөр магадлалтай. Уг шийтгэлийг оногдуулснаар хэрэгтнүүд сургалтад сууж эсвэл эмчилгээнд тодорхой хугацаагаар хамрагдах шаардлагатай болдог. Эдгээр хөтөлбөрүүд нь тэдний чиг хандлагыг засаж, зан авирыг өөрчилж, улмаар дахин хэрэг үйлдэхээс сэргийлэхэд чиглэгдсэн байдаг.

Сургалт болон эмчилгээний төв

Бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, хар тамхи мансууруулах бодист донтсон болон архи согтууруулах ундаанд хамааралтай ялтнуудад өндөр мэргэжлийн туслалцаа үзүүлэх Пробац, тэнсэн харгалзах албаны чадварлаг ажилтнууд тус төвд ажилладаг.

❖ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх алба нь одоогоор 7 Сургалт болон эмчилгээний төвийг Сөүл, Сувон, Даегу, Гуанжу, Инчон, Даежун болон Бусанд байгуулсан.

Үндсэн хөтөлбөрүүд

Хөтөлбөрийн төрөл	Агуулга
Аюулгүй, хууль дээдэлдэг жолоочийн хөтөлбөр	<ul style="list-style-type: none">• Согтуугаар жолоо барьсан хүмүүст зориулсан тусгай архины эмчилгээ• Муу зуршлаас салгах зорилготой• Замын хөдөлгөөний дүрмийг сэргээж өгдөг• Авто ослын аюулыг ойлгуулдаг
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нарт зориулсан хөтөлбөр	<ul style="list-style-type: none">• Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэнээр гэмт хэргийн хор уршиг, хүндрэх нөхцөлийн талаар зааж, хариуцлагыг ойлгуулах• Гэр бүлийн хүчирхийллийн талаарх сэтгэл зүйн гаж ойлголтыг өөрчлөх• Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхэд хүргэдэг хүчин зүйлс болох уур хилэн, стресс болон архины хэрэглээ гэх зэрэг зүйлстэй тэмцэх стратеги боловсруулах
Бэлгийн хүчирхийлэл үйлдэгч нарт зориулсан хөтөлбөр	<ul style="list-style-type: none">• Бэлгийн гаж донтой холбоотой гажуудлыг арилгах• Хохирогчдын байр суурийг ойлгох чадварыг эзэмшүүлэх

	<ul style="list-style-type: none"> • Донтолтоос салах стратегийг зааж өгөх, нийгмийн харилцааны ур чадварыг эзэмшүүлэх
Хар тамхинд донтогчдод зориулсан хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> • Хар тамхи мансууруулах бодис хэрэглэснээс болж учрах бие физиологи, сэтгэл зүй болон нийгмийн хор уршгийг таниулах, мэдрүүлэх • Донтолтоос салгах урмыг өгөх • Хар тамхины хэрэглээнээс салах стратегийг зааж өгөх
Өсвөр насныханд зориулсан хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> • Асуудал шийдвэрлэх чадварыг эзэмшүүлэх • Бусдын байр суурийг ойлгож, өрөвдөх чадварыг харилцан дүрд тоглох замаар заах • Уур уцаар болон гэнэтийн үйлдлийг хянах аргыг заах • Гэр бүлийн эмчилгээ, зураг зурах сэтгэл зүйн эмчилгээ

John-School хөтөлбөр /биеэ үнэлэгчдээр үйлчлүүлэгчдэд чиглэсэн олон улсын боловсролын хөтөлбөр/

Танилцуулга

John-School хөтөлбөр гэдэг нь биеэ үнэлэгчдийг анх удаагаа зуучилсан эрэгтэй ялтнуудыг зөв замд оруулах зориулалттай хөтөлбөрийг хэлнэ. Энэхүү нэг өдрийн хөтөлбөрт зөвхөн сайн дураар хамрагдах хүсэлтэй байгаа ялтнуудад хэрэгжиж байна.

Сургалтын хугацаа: 16 цаг

Агуулга

Биеэ үнэлэх явдлын гэмт шинж чанар, урд нь биеэ үнэлж байсан хүнтэй уулзалт зохион байгуулах, биеэ үнэлэх явдлаас болж үүсдэг бие физиологийн болон сэтгэл зүйн асуудлууд.

Мөрдөн байцаалт

Ерөнхий танилцуулга


Пробаци, тэнсэн харгалзах албаны ажилчид шүүгч, прокурорын тогтоолоор гэмт хэрэгтний хувийн мэдээлэл, түүхийг шинжлэх ухаанч байдлаар судалж, илрүүлдэг.

Энэ мэдээллийг ашиглан шүүх, прокурорын байгууллагын ажилтнууд гэмт хэрэгтэнд тохирсон ял шийтгэлийг сонгож, ялын төлөвлөн боловсруулдаг. Өөрөөр хэлбэл тухайн бичиг баримт нь гэмт хэрэгтнийг тэнсэн харгалзах ажиллагаанд хэрхэн хамруулж, яаж хянаж, дахин нийгэмшүүлэх төлөвлөгөөний суурь болдог байна.

Мөрдөн байцаалтын төрөл

Төрөл	Хүсэлт гаргагч	Агуулга
Ялыг тогтоохоос өмнөх мөрдөн байцаалт /Урьдчилан мөрдөн байцаалт/	Шүүх	Хэрвээ яллагдагчийг тэнсэн харгалзах, олон нийтийн үйлчилгээнд хамруулах, сургалт, эмчилгээнд оруулах боломжтой гэж үзсэн тохиолдолд
Ял төлөвлөхийн өмнөх мөрдөн байцаалт	Прокурор	Хэрвээ GPS-ээр хянах эсвэл бэлгийн хүчирхийлэгчдэд зориулсан эмчилгээнд хамруулах боломжтой гэж үзсэн тохиолдолд
Шүүх хурлаас өмнөх мөрдөн байцаалт	Шүүх	Хэрвээ мөрдөн байцаалт хийх шаардлагатай гэж үзсэн эсвэл бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, биеэ үнэлэгчдийг зуучилсан болон насанд хүрээгүй бол
Яллагдахаас өмнөх мөрдөн байцаалт	Прокурор	Насанд хүрээгүй хэрэгтэнтэй холбоотой хэргийг цаашид өсвөр насны шүүх, прокурор аль эсвэл хойшлуулах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд
Төрөл садан, найз нөхдийн судалгаа, мөрдөн байцаалт	Засан хүмүүжүүлэх байгууллагын дарга	Хоригдогчдыг саатуулах төлөвлөгөө боловсруулж, тэдний орчныг сайжруулах аль эсвэл урьдчилан хугацаанаас нь өмнө суллах гэж байгаа тохиолдолд

Мөрдөн байцаалтын үе шатлал



Мөрдөн байцаалтын гүйцэтгэл

Хэрэгтний зан авир, сэтгэл зүйн байдал, гэмт хэрэг үйлдсэн шалтгаан, хөдөлмөр эрхлэлтийн байдал, амьдралын нөхцөл, хамсаатан, дахин нийгэмшүүлэх ажиллагааны нөхцөл болон давтан хэрэг үйлдэх магадлал гэх зэрэг зүйлсийг сайтар судалдаг.

Мөрдөн байцаалтын аргачлал

- Хэрэгтэнтэй ярилцлага хийж, сэтгэл зүйн шалгалт авахын тулд тэнсэн харгалзах алба дээр дуудан авчрах, гэр оронд нь зочлох аль эсвэл тэд нарын саатаж буй байгууламжид өөрсдийн биеэр очих

- Хэрэгтний гэр бүл, найз нөхөд, хамтрагчид, хамсаатнууд аль эсвэл хохирогчтой ярилцах. Хэргийн газар дээр биечлэн очих

- Хавтаст хэрэгт оруулсан мэдээллийг баталгаажуулах. Тухайлбал хэрэгтний гэмт хэргийн бүртгэл, байнгын оршин суух хаяг, гэр бүлийн харилцааны гэрчилгээ болон бусад бичиг баримтыг шалгах

Олон нийтийн үйлчилгээнд татан оролцуулж байсан хувийн бүртгэл, засан хүмүүжүүлэх байгууллагад байх үеийн хувийн бүртгэл, эрүүл мэнд буюу өвчтний түүх, ерөнхий боловсролын гэрчилгээ болон бусад бичиг баримтын бүртгэлийг шалгах.

Бэлгийн хүчирхийлэгчдэд зориулсан эм зүйн албадан эмчилгээ

Ерөнхий танилцуулга

- Тус таслан зогсоох хөтөлбөрийг 19 наснаас дээш бэлгийн гаж донтнуудад зориулсан. Тухайн хөтөлбөр нь хууль зөрчигчдийг цаашид дахин бэлгийн гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэхэд чиглэж, дахин нийгэмшүүлэх зорилготой.

- Бэлгийн хүчирхийлэл үйлдсэн ялтнуудын дур хүслийг бууруулахад чиглэгдсэн эмчилгээ юм. Өөрөөр хэлбэл, тухайн эмчилгээ нь ялтнуудын гормон буюу дааврыг хязгаарлах эм тариа болон сэтгэл зүйн эмчилгээний аргыг ашигладаг байна.

Эмчилгээний хугацаа: 15 жил хүртэл

Эм зүйн эмчилгээг хэрэгжүүлэх процесс



**Прокурорын
зөвлөгөө**



Шүүхийн шийдвэр



**Тэнсэн
харгалзах**

албаны гүйцэтгэл

<ul style="list-style-type: none">• Гэмт хэрэгтэн эхлээд сэтгэл зүйчтэй зайлшгүй уулзсан байх шаардлагатай.• Ялын төлөвлөгөөний өмнөх мөрдөн байцаалтыг хийлгэж болно.	Шийтгэл 15 жил хүртэл байж болдог. Эмчилгээний үеэр ялтан тэнсэн харгалзах хяналтад байх ёстой.	Эмчилгээ хэрэгжүүлэх тогтоолыг шоронгоос суллахаас 2 сарын өмнө хэрэгжүүлж эхэлсэн байх шаардлагатай.
---	--	---

• Тогтоолыг тэнсэн харгалзах албаны ажилтнууд гүйцэтгэх ба ялтан эмчилгээнд хамрагдаж байгаа бол заавал хяналтад байна.

• Хорих ял эдлэх, эмчилгээнд хамрагдах шийтгэлтэй ялтанд эхлээд хорих ялыг эдлүүлнэ. Дараа нь эмчилгээг хорих ял эдэлж дуусахаас 2 сарын өмнө хэрэгжүүлж эхлэх бөгөөд энэ үед тухайн эмчилгээ нь ялтанд тохирч байгаа эсэхийг тодруулж, мөн эмчилгээнээс үүдэн ямар нэгэн гаж нөлөө байхгүй байгаа болохыг тогтооно.

Сүүлд нэвтрүүлсэн бодлого

Пробаци, тэнсэн харгалзах тогтолцоо нь гэрэлт ирээдүйн амлалт юм.


Бид өндөр эрсдэл бүхий ялтнуудыг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж, хүчийг саармагжуулахын тулд шинэлэг тогтолцоог бүтээн байгуулж байна.

“Пробаци, тэнсэн харгалзах тогтолцоо нь 21-р зууны эрүүгийн шударга ёсны алсын хараа юм.”

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх холбоонд байгуулагдсан Өндөр эрсдэл бүхий ялтнуудын удирдлагын шинэ хэлтэс

Бэлгийн хүчирхийлэл, хүн амины хэрэг, хулгай, дээрэм үйлдсэн ялтнуудын тоо өсөж, мэргэжлийн, системчилсэн хяналт шаардлагатай болсон тул бид 2015 оны 6 дугаар сард өндөр эрсдэл бүхий ялтнуудын удирдлагын хэлтсийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх холбооны бүтцэд бий болгосон.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх холбоонд Өндөр эрсдэл бүхий ялтнуудын удирдлагын хэлтэс байгуулагдсанаар ажлын чиг үүргийн хуваарьт орсон өөрчлөлтүүд



Казакстан улсын пробацгийн үйл ажиллагаа:

Социалист тогтолцоонд хамаарч байсан улс орнууд дундаас пробацгийн албаны үйл ажиллагааг хөгжүүлж эхэлж байгаа улс бол Казакстан улс юм. Тус улс нь сүүлийн жилүүдэд эрх зүйн соёл өндөр хөгжсөн улс орнуудын жишгээр өөрийн орны хууль зүйн тогтолцоонд багагүй шинэчлэлийг хийж байна. Үүний нэг жишээг хорихоос өөр төрлийн буюу гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр ял эдлүүлэх явдал нэмэгдэж, энэ чиглэлээр эрх зүйн болон тогтолцооны шинэчлэл шинэчлэл байгаагаас харж болно.

Казакстан улсын хувьд бусад пост социалист орнуудын нэгэн адил рецидив гэмт явдал буюу гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгэгдсэн хүн дахин гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй, нийгмийн хор аюул нэмэгдэх бэрхшээлтэй тулгарсан бөгөөд энэ нь пробацгийн албыг хөгжүүлсэн бусад орны туршлагыг нэвтрүүлэх үндсэн шалтгаан болжээ.

Улмаар 2012 оны 4 дүгээр сарын 15-нд “Пробацгийн албаны чиглэлээр Казакстан улсын зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”, 2016 оны 12 дугаар сарын 30-ны өдөр “Пробацгийн тухай” хуулиудыг тус тус батлан гаргаж, гэмт явдлыг бууруулах, давтан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн ялын бодлогыг нийгмийн хөгжлийг дэмжих, суллагдсан хүнийг нийгэмшүүлэх чиглэлийг хөгжүүлэх үндсийг бүрдүүлжээ⁷³.

Казакстан улсын пробацгийн алба нь хорих байгууллагатай нэгдсэн бүтэцтэйгээр зохион байгуулагддаг ба Дотоод хэргийн яамны харьяанд үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг. Ингээд Эрүүгийн ял эдлүүлэх департаментын пробацгийн төв байгууллагын эрх хэмжээг товч авч үзье:

⁷³ <http://egov.kz/cms/ru/articles/probation> 2018.10.17.

- Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан тушаал эрхлэх эрхийг хасах, нийтэд тустай ажил хийлгэх ялын биелэлтийг хангах;
- Тэнсэн хянан харгалзсан этгээдэд хяналт тавих;
- Жирэмсэн болон бага насны хүүхэд бүхий эмэгтэй, бага насны хүүхдийнхээ үндсэн асран хамгаалагч эрэгтэй хүний эдлэх ялыг хойшлуулсан тохиолдолд хяналт тавих;
- Оршин суух хаягт хөдөлгөөн хязгаарласан шийтгэлийг хэрэгжүүлэх;
- Хорих ял эдлээд суллагдсан этгээдэд шүүхээс тодорхой хугацаанд хяналт тогтоох шийдвэр гарсан бол хяналт тавьж нийгэм-эрх зүйн туслалцаа үзүүлэх;
- Төрийн шагнал, баримт бичгийг хураах, олгох;
- Төрийн болон орон нутгийн бүхий л байгууллагатай хамтран ажиллах;
- Шүүхэд цагдан хоригдож байгаа, пробацацийн хяналтад авагдсан, ял эдэлж хүмүүстэй холбогдсон хяналт, хязгаарлалт болон урамшууллын бүхий төрлийн мэдээлэл, илтгэлийг гаргаж өгөх зэрэг болно.

Казахстан улсын пробацацийн албаны үндсэн зорилго нь сэжигтэн, яллагдагчийн хувийн байдалд эерэг өөрчлөлт оруулах, ял шийтгэгдсэн хүнийг дахин нийгэмшүүлэх, хорих байгууллагаас суллагдсан хүнийг нөхөн сэргээх, нийгмийн амьдралд дасан зохицох нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг.

Дээрх зорилгын хүрээнд пробацацийн алба нь дараах арга хэмжээг хуульд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Нийгэмшүүлэх ажлын хүрээнд нийгэм-эрх зүйн асуудлаар тусалж үзүүлэх. Тухайлбал, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэх, хөдөлмөр эрхлэхэд зуучлах, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, хуулийн дагуу зохих хөнгөлөлт, нийгмийн халамжид хамруулах;
- Нийгмийн харилцаанд орох чадварыг сэргээн хөгжүүлэх. Тухайлбал, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн харилцааг сэргээхэд туслах, эерэг нөлөөлөл бүхий нийгмийн бусад хэсгүүдтэй холбоо тогтооход дэмжлэг үзүүлэх;
- Нийгэм дэх ахуйн орчинд дасан зохицоход тусламж үзүүлэх. Тухайлбал, нөхөн сэргээх арга хэмжээнд хамруулах, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд туслах, соёл, урлагийн арга хэмжээнд оролцуулах;
- Төрөл бүрийн эрх зүйн болон нийгмийн асуудлаар зөвлөгөө өгөх зэрэг болно.

Казахстаны Пробацацийн тухай хуульд зааснаар пробацацийн үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байхаар зохицуулжээ. Үүнд:

- Шүүн таслах ажиллагаа хүртэлх пробацаци. Сэжигтэн, яллагдагчид эрх зүй, нийгмийн асуудлаар туслалцаа үзүүлдэг цогц арга хэмжээ;
- Шүүн таслах ажиллагааны дараах үеийн пробацаци. Тэнсэн хянан харгалзсан, эрх хязгаарлан этгээдэд тавих хяналт, тусламжийг багтаасан цогц арга хэмжээ;
- Ял эдлэх үеийн пробацаци. Хорих ял шийтгэгдсэн хүнийг дахин нийгэмшүүлэхэд чиглэгдсэн цогц арга хэмжээ;

- Суллагдсаны дараах пробацци. Хорих ял эдлээд суллагдсан хүнд нийгэмд дасан зохицох, нөхөн сэргээхэд чиглэгдсэн цогц арга хэмжээг тус тус багтаан хэрэгжүүлж байна⁷⁴.

Турк улсын пробаццийн үйл ажиллагаа:

Пробаццийн албаны үйл ажиллагаа нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд үзүүлж буй нийгэмшүүлэх, нөхөн сэргээх, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн нийгэм дэх, мониторингийн хяналт тавьж буй шийтгэлийн хэлбэртэй арга хэмжээ юм.

Туркийн Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн хүний эрхийг дээдлэх, сахих хүрээнд "Probation" системийг 2005 оны 8-р сарын 15-нд олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хохирогчдод учирсан хохирлыг нөхөн төлөх, гэмт этгээдүүдийг нийгэмд дахин оруулахад нь туслах зорилгоор байгуулсан байна.

Тус улсын пробаццийн алба нь зорилгоо гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмд дахин нийгэмшүүлэх, туршилтын журмаар гүйцэтгэх, бүх төрлийн хөтөлбөр, туршилт, төслийн хүрээнд төсөл, төлөвлөгөөний хүрээнд үйлчилгээ үзүүлэх явдал гэжээ.

Пробаццийн алба нь Хууль зүйн яамны бүтцэд багтан, Шоронгийн ерөнхий газар, цагдан хорих байртай хамтран ажилладаг.

Пробаццийн төв алба нь нөхөн сэргээлтийн үйл явцыг хянан шалгах, энэ чиглэлээрх бодлогыг сайжруулах чиглэлээр дараах үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:

- туршилтын хөтөлбөр, нөхөн сэргээлтийн ажлыг хэрхэн гүйцэтгэж буйд хяналт тавих;
- туршилтын процессыг хянаж шалгах;
- хэрэгжиж буй гүйцэтгэл, нөхөн сэргээлтийн ажил, материалыг үнэлэх;
- шинэ арга, материал боловсруулах;
- бодлогыг боловсруулах.

Пробаццийн салбарын чиг үүрэг нь:

- туршилтын ажлын орон нутгийн зохион байгуулалтын төлөвлөлтийн үйл явцыг мөрдөх;
- туршилтын ажлын төлөвлөлт, төлөвлөлтийн талаарх шинэ бодлого боловсруулах;
- төлөвлөлтөд тулгарч буй асуудлуудын шийдлийг олох;
- шалгуурын стандартыг хангах;
- үнэлгээ ба төлөвлөлтийн хэрэглээний статистик мэдээ, албан хэрэг хөтлөлтийн статистик мэдээллийг цуглуулах.

Хамгаалах зөвлөл, хохирогчдод туслах үйлчилгээ хариуцсан салбар нь:

- ерөнхий зорилго, бодлогын хүрээнд хамгаалах зөвлөлийг тогтмол, үр ашигтай ажиллах явдлыг хангах;

⁷⁴ <http://duisastana.kz/department/probation/> 2018.10.17.

- гэмт хэрэг үйлдсэн этгээдийг дахин нийгэмшүүлэх үйл ажиллагааг явуулах;

- бүх сонирхогч талуудтай хамтран ажиллах, шүүх, бусад яамд, төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллах.

Өсвөр үеийнхний байцаан шийтгэх ажиллагаа хариуцсан салбар:

- хүүхдэд оногдуулсан ялыг тэнссэн тохиолдолд гүйцэтгэлийг хэрэгжүүлэх;

- нийгмийн доторх насанд хүрэгчдийн шүүн таслах ажиллагааны нөхөн сэргээлтийн ажлыг дагаж мөрдөх;

- насанд хүрээгүй хүүхдийн туршилтын ажил хийлгэж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

- насанд хүрээгүй гэмт хэрэгтнийг дахин нийгэмшүүлэхэд туслах;

- бүх сонирхогч талуудтай хамтран ажиллах.

- электроник хяналт-шинжилгээ хариуцсан алба нь:

- хяналтын электрон багаж хэрэгсэл ашиглан хяналт тавих;

- орон нутгийн албадад цахим хяналт хийж буй хэрэгжилтийн явцыг хянах;

- зөрчсөн мэдээллүүдийг пробацийн албанд мэдээлэх;

- мэдээлэл цуглуулах, үнэлэлт өгөх, дүн шинжилгээ хийх зэрэг чиг үүргүүдийг гүйцэтгэдэг байна.

Пробацийн албанд менежер болон орлогч менежер, тэнсэн харгалзах мэргэжилтнүүд (сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, социологич, багш нар) ажилладаг байна.

ОХУ-ын пробацийн үйл ажиллагаа:

ОХУ-ын хувьд сорилт бие даасан пробаци байгуулагдаагүй байгаа бөгөөд уг чиг үүргийг эрүүгийн ял шийтгэл гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлж байна.

Тус улсын эрдэмтдийн үзэж байгаагаар пробацийн алба гэдэг нь шүүхээс оногдуулсан эрүүгийн ял шийтгэлийг хорих байгууллагад бус нийгмийн дунд эдлүүлэх, мөн түүнчлэн хорих газраас суллагдсан этгээдийг эргэн нийгэмшүүлэх зэрэгт чиглэсэн нийгмийн аюулгүй байдлыг сахин хамгаалах чиг үүрэгтэй төрийн эрх бүхий байгууллага юм.

Тус албаны гол зорилт нь ял шийтгэл гүйцэтгэх ажиллагааг гардан зохион байгуулах, хорих газраас суллагдан этгээдэд эрх зүйн туслалцаа үзүүлэхэд оршино.

Сорилт туршилтын албыг дараах чиг үүрэгтэй байхаар төсөөлж байна:

- шүүхийн өмнөх шатны буюу бэлтгэл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

- шүүхийн шийдвэр гаргах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

- сэжигтэн, ялтныг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх;

- ялтанд хяналт тогтоох;

- эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх;

- ялтныг эргэн нийгэмшүүлэх;

- ялтныг засарч хүмүүжихэд дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- ял хэрэгжүүлэх ажиллагаанд олон нийтийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх.

Сорилт туршилтын албаны эдгээр чиг үүргийг криминологийн өнцгөөс авч үзвэл тус байгууллагын хяналтад байгаа этгээдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, засан хүмүүжүүлэх болон эргэн нийгэмшүүлэх гол хэрэгсэл болохоор байна. Иймд тус улсын эрдэмтдийн дийлэнхийн зүгээс сорилт туршилтыг хууль зүйн салбарт зайлшгүй нэвтрүүлэх нь зүйтэй бөгөөд үүний тулд юуны өмнө туршилт, судалгааны төсөл хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзжээ.

Пробацийн албыг дараах зарчмаар байгуулах нь оновчтой юм. Үүнд:

- бүтэц, зохион байгуулалт, санхүү болон үйл ажиллагааны хувьд бие даасан, хараат бус байх;
- хууль зөрчсөн иргэдэд эрх зүйн бүх хэлбэрийн туслалцаа болон зөвлөгөө өгөх;
- бусад байгууллагуудтай нягт уялдаатай байх.

Ач холбогдлын хувьд:

- ялтныг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлнэ;
- ялтныг эргэн нийгэмшүүлнэ;
- шоронгийн ачааллыг багасгана;
- гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тал бүрээс нь нарийвчлан судална;
- шүүхийн өмнөх шатны бэлтгэлийг хангах боломж бүрдэнэ;
- нийт гэмт хэргийн түвшин буруулах нөхцөл бүрдэнэ.

Дэлхийн улсуудын эрүүгийн эрх зүйн системийн цаашдын хандлага ямар байх нь үндэстэн, ард түмний түүхэн сонголт, уламжлал соёл төлөвшил хийгээд бүс нутаг, улс орнуудын харилцан нөлөөлөх хамаарал, зүй тогтлоос ихээхэн шалтгаалахын дээр дэлхийн глобальчлал, интеграцчилал интервенц болон дифференциацилалтай ихээхэн холбоотой.

Эцэст нь сорилт туршилтын албыг байгуулахын тулд юуны өмнө олон улсад хуримтлуулсан туршлага болон практикт тулгуурлах ёстой гэж үзжээ.

ГУРАВ. МОНГОЛ УЛСАД ПРОБАЦИЙН АЛБЫГ БАЙГУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

3.1. Монгол Улсын пробацгийн үйл ажиллагааны төрөл, хэлбэрт хамаарах эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ

Ял эдлүүлэх ажиллагааны бодлого нь төрийн эрүүгийн бодлого, ялын ойлголт, шинж чанартай шууд хамааралтай асуудал юм. Төрийн эрүүгийн бодлого гэдэг нь хүн, төр, нийгмийн байгууллага, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох, тэдгээрт оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ, тэдгээрийг хэрэглэх, эсхүл тэдгээрээс чөлөөлөх үндэслэл, журмыг тогтоох, түүнчлэн гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судалж тогтоох, энэ үндсэн дээр урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үр өгөөжтэй арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг төгөлдөржүүлэх талаар төрөөс баримталж буй чиглэл, удирдамж юм⁷⁵.

Эрүүгийн бодлого нь Үндсэн хуулийн агуулгаас шууд урган гарч, эрх зүйт төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тухайлбал, Үндсэн хуулийн 3-р зүйлд “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно”, 4-р зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил хязгаар халдашгүй дархан байна”, 5-р зүйлд “Төр нь нийгмийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, 6-р зүйлд “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалын бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна”, 11-р зүйлд “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, 16-р зүйлд “Монгол Улсын иргэн Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ гэж тус тус заасан нь Эрүүгийн бодлогын агуулга, чиглэл болдог.

Эрүүгийн бодлого нь төрийн бодлогод эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, нийгмийн үйл явцад нөлөөлөх аргаараа бусад салбарын бодлогоос өвөрмөц онцлогтой, өөртөө эрүүгийн эрх зүйн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн, эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй, криминологи зэрэг хэд хэдэн чиглэлийн тусгай бодлогыг багтааж байдаг. Үүнтэй уялдан эрүүгийн ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зөрчлийн зэрэг салбар хуулиудад төрийн эрүүгийн бодлогын агуулга хуульчлагдан хэрэгжиж байдаг.

⁷⁵ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. 2002. 24 дэх тал

Сүүлийн жилүүдэд хууль, эрх зүйн салбарын тогтолцоог боловсронгуй болгох, үр нөлөөг дээшлүүлэх, гэмт явдалтай тэмцэх, улмаар эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх шаардлага нийгмийн хөгжлийн чиг хандлагаар улам бүр өсөн нэмэгдэх боллоо.

Монгол улс Эрүүгийн хуулиар ялын төрөл, зорилгыг тодорхойлсон боловч хэрэгжих механизмыг эрх зүйн хүрээнд бүрэн хангаж чадаагүйн улмаас ялын зорилго нэг мөр хангагдахгүй, үр нөлөөгүй болж улмаар нийгэм, олон нийтэд сөрөг ойлголт бий болж байна.

Тэгвэл эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хорих ялын үр нөлөө нь төдийлөн өндөр байдаггүйг хүлээн зөвшөөрч аль болох хорихоос өөр төрлийн ялыг сонгож, гэмт хэргийн шинж байдлаас шалтгаалан ялыг ялгамжтай оногдуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, нийгэмд нь байлгаж, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг ухамсарлуулахад чиглэсэн ялын бодлогыг баримтлах хандлагатай болж байгаа энэ цаг үед бид хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилтийг “ял шийтгэл гарцаагүй байх” зарчмын хүрээнд бүрэн биелүүлэх шаардлага тулгарсныг анхаарах хэрэгтэй.

Монгол Улсад тэнсэн суллагдсан этгээдэд хяналт тавьж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэл:

1921 оноос хойших Эрүүгийн хуулиудад шүүхээр оногдуулсан ялын тодорхой хувийг биеэр эдэлсэн, засарч хүмүүжсэнээ зан байдал, үйлдлээрээ харуулж, учруулсан хохирлоо нөхөн төлсөн зэрэг нийтлэг шаардлагыг хангасан хорих ял шийтгүүлсэн этгээдийг хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллах талаар авч хэлэлцэн уг үйл ажиллагааг тухайн цаг үеүдийн хуулийг баримтлан хэрэгжүүлж байжээ.

Хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллах ажиллагаа нь ялтан оногдуулсан ялыг зөрчил гаргалгүйгээр өөрийн гэм буруугаа ойлгож ухамсарлан биеэр эдэлсэн байдлыг урамшуулах, цаашид нийгэмд тустай үйл хийх, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх илтгэл үнэмшлийг төрүүлэх, мөн улс орны төсөв санхүүг хэмнэх зэрэг олон талын ач холбогдолтой үйл ажиллагаа юм. Мөн тухайн этгээдийг нийгэмд гаргаснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дахин давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх, хохирогчийн эрх ашгийг хамгаалах зэрэг асуудлууд ундрэн гарч ирэх бөгөөд уг асуудлуудыг цэгцлэх боловсронгуй болгох талаар үе үеийн хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулж сайжруулсаар ирсэн байна.

Нэг. 1926 оны БНМАУ-ын Шүүх Цаазны бичиг:

Ардын хувьсгал ялснаар хуучин төрийн аппаратыг устгаж түүний хууль цааз, ёс суртахууныг халахгүйгээр ардчилсан өөрчлөлтүүдийг гүнзгийрүүлж болохгүй байв. Хувьсгалын анхны жилүүдэд Ардын Засгийн Газраас гаргасан эрүүгийн эрх зүйн хуульчилсан актуудын гол агуулга нь Манжийн болон Монголын хаант улсын үед хэрэглэж байсан эрүү шүүлтийг нэн даруй хүчингүй

болгох, Ардын төрийн эрүүгийн хууль цаазны үндсэн бодлого зарчмыг тогтоон түүнийг ард түмэнд ойлгуулан таниулах, хуучин төрийн шүүхийн системийг устгаж шинэ төрийн шүүхийн системийг боловсруулах урьдчилсан бэлтгэлийг хангах явдал байлаа.

Монгол Улсын анхны Эрүүгийн хууль нь “Шүүх Цаазны бичиг” гэдэг нэртэйгээр ерөнхий ангийг 1926 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 1-р хурлаар, тусгай ангийг 1936 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн Улсын III Их хурлаар тус тус батлагдсан.

Тус хууль цаазны бичиг нь 7 бүлэг, 40 зүйлтэй, VII бүлэгт ял тогтоохыг урьд хоригдсоныг ялд тооцох, хугацаа дуусахын урьд ялтныг гаргах ба ялыг нэгмөсөн өршөөн хэлтрүүлэх тухай заасан байдаг. Хугацаа дуусахын урьд гаргах тухай дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

Аливаа хоригдсон ба албадын үйлдвэр хийлгэж бүхий ялтны дотроос зарим нэгэн зан авир сайн, үйлдвэр дор хичээлтэй нь буй аваас түүнийг хугацаа дуусахаас өмнө тавьж гаргаваас зохино.

Аливаа ялтан хугацаа дуусахын урьд тавьж гаргахуй дор анх Шүүн таслах газраас тогтоосон ялын хугацааны нэгэн дундуур /хоёрны нэг/-ыг эдэлж өнгөрсний хойно тавин гаргаж болно.

Ялтны хугацаа дуусахын урьд тавин гаргах явдлыг эрэхүй дор шийдэхэд ялтан хүний өөрийн ураг төрөл буюу түүний ураг төрөл итгэмж бүхий хүн ба ард олноор байгуулсан нам эвлэл, хоршооны зэрэг газрууд буюу Шүүн таслах газраас удирдан гүйцэтгэн шийтгэвээс зохино.

Ялтны уг ялын хугацаа дуусахын урьд тавин гаргах тогтоолыг ялтны ялаа эдэлж буй газрын шүүн таслах газраас шийдэн гаргаваас зохино хэмээжээ.

Энэ нь Монгол Улсад эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааг хуульчлан зохицуулж уг харилцааг боловсронгуй болгон хөгжүүлэхэд ихээхэн нөлөөтэй алхмуудын нэг болсон юм.

Хоёр. 1929 оны БНМАУ-ын Шүүх Цаазны бичиг:

1929 оны БНМАУ-ын Шүүх Цаазны бичиг нь 30 бүлэг, 227 зүйлтэй бөгөөд өмнөх хууль цаазны бичигтэй, хугацаа дуусахын урьд ялтныг гаргах ажиллагаа нь адил боловч дараах зарчмын 2 ялгаатай. Энэ нь:

1. Ялын хугацаа дуусахын урьд тавин гаргах явдлыг эрхүй дор ялтан хүмүүн өөрийн буюу түүний ураг төрөл, итгэмж бүхий хүн ба ард олноор байгуулсан нам, эвлэл, хоршооны зэрэг газрууд буюу Шүүн таслах газраас удирдаж гүйцэтгэн шийтгэдэг байснаа бол энэ хуулиар ялын хугацаа дуусахын урьд тавин гаргах явдлыг эрхүй дор ялтан хүмүүн өөрийн буюу түүний ураг төрөл, итгэмж бүхий хүмүүн ба шүүх таслахаас удирдаж гүйцэтгэн шийтгэх;

2. Ялтны уг ялын хугацаа дуусахын урьд тарин гаргах тогтоолыг ялтны ялаа эдэлж буй газрын Шүүн таслах газраас шийдэн гаргаж байсан бол энэ

хуулиар уг тогтоолыг ялт хүмүүний ялаа эдэлж буй газрын шүүх таслах газар Ардын төлөөлөгчдийг суулцуулан шийтгэдэг болжээ.

Гурав. 1934 оны БНМАУ-ын Шүүх Цаазны бичиг:

Уг хууль нь 9 бүлэг, 174 зүйлтэйгээр батлагдсан ба зорилгыг нь ардын хувьсгалт засаг ба улс хийгээд тогтоосон эрх хэмжээнд харшлах олон нийт дор аюул бүхий хэргүүдээс хамгаалах явдал бөгөөд тийнхүү хамгаалахдаа уул үйлдсэн хүмүүст энэ шүүх цааз бичигт заасан ёсоор шийтгэх ялуудыг хэрэглэмой хэмээн тодорхойлжээ.

Хорих ял эдлэгсдийг хугацаанаас нь өмнө тэнсэн суллах тухай 6-р бүлэг, 41-р зүйлд:

Хорих ял ба хорихгүйгээр албадан ажил хийлгэх ял шийтгэгдсэн бөгөөд засрах төлөвийг илрүүлсэн этгээдээс уул эдлэх ялыг хугацааны нэгэн дундуур /хоёрны нэг/-ыг эдэлж дуусмагц суллан тавьж тэнсэж болно.

Хугацаа дуусахын өмнө тэнсэж тавих хэмээх нь нэг бол үйлдсэн ялын хугацааг цаашид эдлэхээс хэлтрүүлэн эсвэл үйлдсэн ялын оронд өөр хөнгөн ялыг хэрэглэх бөгөөд үүнийг гүйцэтгэхдээ ажил хөдөлмөрөөр засан сайжруулах хуульд тогтоосон журмын дагуу заан гүйцэтгэнэ. Хугацааны өмнө суллан тавьсан этгээдээс эдэлж гүйцээгүй үлдсэн хугацааны дотор урьд үйлдсэн гэмт хэргээс хөнгөн бус гэмт хэрэг үйлдвэл тэрхүү эдлээгүй үлдсэн хугацааг шүүн таслах газраас түүнийг дахин үйлдсэн гэмт хэрэгт тогтоосон ял дээр нэмэгдүүлэн явуулбал зохих боловч хорих ялын хугацаа нийлээд 10 жил, хорихгүйгээр албадан ажил хийлгэх ялын хугацаа нийлээд 6 сараас тус тус хэтэрч үл болно гэжээ.

Тухайн үед хугацаанаас нь өмнө суллахдаа үлдсэн ялыг тэнсэхээс гадна өөр хөнгөн ялаар сольдог байсан гэмт хэрэгтнийг ажил хөдөлмөр хийлгэн, хамт олны дотор хүмүүжүүлэх зорилготой холбож тайлбарлаж болох юм.

Дөрөв. 1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль:

1940-д оны үед Монгол Улсын нийгмийн амьдралд ихээхэн өөрчлөлт гарч мөн оны 6-р сард хуралдсан Улсын VIII Их Хурлаар шинэ Үндсэн Хуулийг баталсан. Түүний дагуу хууль дүрмийг шинэчлэн боловсруулах ажил явагдаж хэрэглэгдэж байсан Шүүх Цаазны Бичгийг 1942 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Улсын XV бага хурлаар Монгол улсын эрүүгийн эрх зүйн түүхэнд анх удаа "БНМАУ-ын Эрүүгийн Хууль" нэртэйгээр батлан гаргасан байна.

БНМАУ-ын Эрүүгийн Хууль нь 11 бүлэг 225 зүйлтэй ба Бүгд найрамдах улсын хөдөлмөрчин олны ардын хувьсгалт засаг, түүний тогтоосон хууль журам, Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтносон байдал, улс, нийтийн хийгээд хувийн өмч түүнчлэн ард иргэний хувийн, хөрөнгө хогшлын эрхийг нийтэд аюул бүхий явдлаас болон уул гэмт хэрэг өдүүлэгчдийг энэхүү хуульд заасан ёсоор шийтгэх аргаар хамгаалах зорилготой болно.

Хорих ял эдлэгсдийг хугацаанаас нь өмнө тэнсэн суллахдаа хорих ял буюу хорихгүйгээр засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх ял шийтгэсэн бөгөөд засрах төлөвийг илрүүлсэн этгээдээс уул эдлэх ялын хугацааны нэгэн дундуур /хоёрны нэг/-ыг эдэлж дуусмагц суллан тавьж тэнсэж болно. Хугацаа дуусахын өмнө тэнсэн суллан тавих явдал бол оногдсон ялын хугацааг цаашид эдлэхээс хэлтрэгдэх бөгөөд үүнийг гүйцэтгэхдээ засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн лагериудын дэргэдэх хянан харгалзах комиссуудын дүрэмд заасныг журамлан гүйцэтгэнэ.

Хугацаанаас өмнө ялаас суллагдсан этгээдээс үлдсэн хугацааны дотор урьд үйлдсэн гэмт хэргээс хөнгөн бус гэмт хэрэг дахин үйлдвэл дээрх эдлээгүй үлдсэн хугацааг шүүх таслах газраас түүний дахин үйлдсэн гэмт хэрэг тогтоосон ял дээр нэмэгдүүлэн явуулбал зохих боловч хорих ялын хугацаа нийлээд 10 жилээс хэтрэхгүй ба засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх ялын хугацаа нь 1 жилээс хэтэрч үл болно. Уг хууль нь өмнөх хуулийн зохицуулалттай зарчмын хувьд адил батлагдсан гарсан ч нэгэн гол онцлог бол хорих ял эдэлж буй насанд хүрээгүй хүүхдийг хугацаанаас нь өмнө тэнсэн суллах заалтыг бие даан оруулж өгсөн явдал юм.

Тус хуулийн 6-р бүлэг, 54-р зүйлд: Насанд хүрээгүй хүмүүсийг хорих засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн газарт суулгахаар ял шийтгэсэн байвал засрах хүртэл уул газарт байлгах боловч 18 наснаас хэтрүүлж үл болно. Хэрэв насанд хүрээгүй хүмүүс заасан хугацааг дуустал суугаагүй байхад 18 насанд хүрвэл хугацаа дуусахын өмнө суллан тавих буюу суллан тавьж болшгүй бол шийтгэгдсэн хугацааг бүрэн дуусах хүртэл засан хүмүүжүүлэх газарт шилжүүлнэ хэмээн заажээ.

Түүнчлэн 1952 оны 07 дугаар сарын 31-нд Шүүх яам, Улсын прокурор, Дотоод яамны сайдын хамтарсан шийдвэрээр "Аймгийн ба ардын хэсгийн шүүхүүд, аймгийн ба хэсгийн прокурорууд, ДЯЯ-ын харьяа лагерийн дарга нар ба колониудад хоригдлуудыг хугацаанаас өмнө тэнсэн суллах журмын тухай" заавар батлагдан гарч хоригдолд ажлын хоног олгох хугацааг нарийвчлан тооцох заалт оржээ.

Тав. 1961 оны БНМАУ-ын Эрүүгийн Хууль:

Өмнө үйлчилж байсан эрүүгийн хуулийг 1961 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хуралдсан БНМАУ-ын АИХ-ын II чуулганаар хүчингүй болгож, шинэ эрүүгийн хуулийг батлан гаргаж, мөн оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлжээ.

1942 оны эрүүгийн хуульд хэд хэдэн үндсэн өөрчлөлт хийх шаардлагатай болсон бөгөөд уг хуулиар гэмт хэрэгт тооцогдож байсан зарим нийгмийн үзэгдлийг нийгэмд аюултай шинжээ алдсан гэдэг үндэслэлээр эрүүгийн хуулиас хасч, зарим үзэгдлийг нийгэмд аюултай хэмээн үзэж шинээр гэмт хэрэгт тооцож эрүүгийн хуульд нэмэлт оруулсан.

Тус хуульд анх удаа гэмт хэргийн зүйлчлэлийн байдлыг харгалзан , шүүхээс оногдуулсан хорих ялыг биеэр эдэлсэн хугацаанаас шалтгаалан хугацаанаас өмнө тэнсэн суллах явдлыг авч үзсэн нь ихээхэн ач холбогдолтой болсон.

Хорих ял эдлэгсдийг хугацаанаас нь өмнө тэнсэн суллах ба өөр хөнгөн ялаар солих журмыг 4 дүгээр бүлгийн 41 дүгээр зүйлд хуульчилж өгсөн байна.⁷⁶

Энэхүү бүлэгт тус Эрүүгийн Хууль нь хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллахдаа гэмт хэргийн зүйлчлэлийг анхааран үзэж, оногдуулсан ялын эдэлсэн хугацаа болон давтан гэмт хэрэг үйлдэгчдийн үйлдлийн арга, учруулсан хохирлыг харгалзан үздэг болсон нь ихэд дэвшилттэй алхам болсон байна.

Зургаа. 1961 оны Эрүүгийн хуулийн шинэчлэл /1987, 1993/:

1961 онд батлагдан мөрдөгдөж байсан эрүүгийн хууль нийгмийн хөгжлийн явцад шинэчлэгдэх шаардлага гарсны улмаас 1987, 1993 онуудад шинэчлэгдэн найруулагдан, 2002 он хүртэл үйлчилж ирсэн байна.

Тус хуулиар хорих ял эдлэгсдийг хугацаанаас өмнө тэнсэн суллах ажиллагааг хуульчлахдаа гэмт хэрэгтний үйлдсэн хэргийн байдал, засрал хүмүүжлээс нь шалтгаалан ихээхэн ялгавартай хандах болсон. Уг хуулийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт:

1. Хорих, засран хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгүүлсэн этгээд болон мөн хуулийн 51 дүгээр зүйлд зааснаас бусад ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн суллаж буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар сольж болно.

2. Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих журмыг зөвхөн өөрийн засарч хүмүүжсэнээ үлгэр жишээ зан төлөв, үнэнч шударга хөдөлмөрөөрөө харуулсан ялтанд хэрэглэнэ.

3. Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих асуудлыг таслан шийдвэрлэх тогтоол биелүүлж байгаа байгууллага болон орон нутгийн Ардын Депутатуудын гүйцэтгэх захиргааны дэргэдэх хянах комиссын саналаар ялтны ял эдэлж байгаа газрын шүүх шийдвэрлэнэ.

4. Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих журмыг оногдсон ялын талаас доошгүйг эдэлсэн ялтанд хэрэглэж болно.

5. Гэмт хэрэг санаатай үйлдэж, гурван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, урьд гэмт хэрэг санаатай үйлдэж хорих газар ял эдэлж байсан бөгөөд ял шийтгэлгүйд тооцоогүй буюу ял шийтгэлгүй болоогүй байхад гэмт хэрэг санаатай дахин үйлдэж хорих ял шийтгүүлсэн түүнчлэн хорих газар ял

⁷⁶ Д.Адьяабазар. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1998.

эдэлж байхдаа гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ял шийтгүүлсэн этгээдэд ялаас хугацаанаас өмнө тэнсэн суллах буюу элдээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих журмыг оногдсон ялынхаа гуравны хоёроос доошгүйг эдэлсний дараа хэрэглэж болно.

6. Хар тамхи, мансууруулах болон хордуулах бодис, буу, зэвсэг хууль бусаар нэвтрүүлэх /74-р зүйл/, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх /112-р зүйлийн 2 дах хэсэг/, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах /179/1/ дүгээр зүйлийн хоёр дахь хэсэг/, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хээл хахууль авах /195 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг/, гэмт хэрэгт шийтгүүлсэн ялтанд ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу элдээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих журмыг оногдсон ялын дөрөвний гурваас доошгүйг эдэлсний дараа хэрэглэж болно.

7. Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу элдээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих үед ялтныг тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ялаас мөн чөлөөлж болно.

8. Элдээгүй үлдсэн хорих ялыг засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялаар солихдоо тэдгээрийн хугацааг уг төрлийн ялын хуулиар тогтоосон хэмжээ болон элдээгүй үлдсэн хорих ялын хугацаанаас хэтрүүлж болохгүй.

9. Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу элдээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солихдоо шүүх хугацааны өмнө тэнсэн суллагдсан буюу элдээгүй үлдсэн ял нь хөнгөн ялаар солигдсон этгээдийг элдээгүй үлдсэн ялын хугацаандаа хяналтдаа байлгах, хүмүүжүүлэх үүргийг хөдөлмөрийн тодорхой хамт олон буюу хүнд тэдний зөвшөөрснөөр даалгаж болно.

10. Ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээд элдээгүй үлдсэн ялын хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 38 дугаар зүйлд заасан журмаар ял оногдуулна.

Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу элдээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих журмыг дор дурдсан этгээдэд хэрэглэхгүй:

а) онц аюултай гэмт хэрэгтэн;

б) төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд /60-68 дугаар зүйл/;

в) Зандалчлах /73 дугаар зүйл/, бусдыг санаатай алах /86 дугаар зүйл/, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах /90 дүгээр зүйлийн хоёр дах хэсэг/, онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх /112 дугаар зүйлийн гурав дах хэсэг/, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг дээрэмдэх /125 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг/, цагдаагийн байгууллагын ажилтан буюу ардын нөхөрлөлийн гишүүний амь биед халдах /222 дугаар зүйл/, онц хүндрүүлэх байдалтайгаар танхайрах /9 дүгээр зүйлийн гурав дах хэсэг/, галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл болон тэсэрч дэлбэрэх бодисыг дээрэмдэх замаар ашиглан шамшигдуулах /245 дугаар зүйлийн гурав дах хэсэг/, агаарын хөлгийг авч зугтаах /268 дугаар зүйл/ гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд;

г) хуулиар тогтоосон журмын дагуу урдах гэмт хэрэгт ял шийтгэлгүйд тооцоогүй буюу ял шийтгэлгүй болоогүй байхад гэмт хэрэг санаатай үйлдэж хоёр буюу түүнээс дээш удаа хорих ял шийтгүүлсэн этгээд;

д) шүүхээс оногдуулсан ялаас хугацааны өмнө хорих газраас тэнсэн суллагдсаны дараа эдлээгүй үлдсэн ялын хугацаанд гэмт хэрэг дахин үйлдсэн этгээдэд хэрэглэхгүй байхаар зааж өгчээ.

Өмнөх Эрүүгийн хуулийг бодвол насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу хөнгөн ялаар солих тухай зүйл /53 дугаар зүйл/-ийг шинээр оруулсан байна. Энэ нь:

1. Арван найман насанд хүрэхийн өмнө үйлдсэн гэмт хэрэгт хорих буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгүүлсэн этгээд өөрийн засарч хүмүүжсэнээ үлгэр жишээ зан төлөв, хөдөлмөр, сурлагад үнэнч шударга ханддагаараа харуулбал ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар сольж болно.

2. Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих асуудлыг таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх байгууллага болон орон нутгийн Ардын Депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны дэргэдэх насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс буюу хянах комиссын саналаар ялтны ял эдэлж байгаа газрын шүүх шийдвэрлэнэ.

Арван найман насанд хүрэхийн өмнө үйлдсэн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд оногдсон ялын гуравны нэгээс доошгүйг эдэлсний дараа түүнийг ялаас хугацааны өмнө тэнсэн суллаж буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар сольж болно.

Дор дурдсан этгээд оногдуулсан ялын талаас доошгүйг эдэлсэн бол түүнийг ялаас хугацаанаас өмнө тэнсэн суллаж буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар сольж болно. Үүнд:

а/арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэгт санаатай үйлдэж таваас доошгүй жил хорих ял шийтгүүлсэн;

б/урьд нь гэмт хэрэг санаатай үйлдэж, хорих газар ял эдэлж байсан бөгөөд ял шийтгэлгүйд тооцогдоогүй буюу ял шийтгэлгүй болоогүй байхдаа арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг дахин санаатай үйлдэж хорих ял шийтгүүлсэн;

в/арван найман насанд хүрэхийн өмнө хорих газар ял эдэлж байхдаа гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ял шийтгүүлсэн.

5. Дор дурдсан этгээдэд оногдуулсан ялын гуравны хоёроос доошгүйг эдэлсэн бол түүнийг ялаас хугацааны өмнө тэнсэн суллаж буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар сольж болно.

а/ урьд нь гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ял шийтгүүлэн уг ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан буюу эдлээгүй үлдсэн ялыг өөр хөнгөн ялаар сольсон бөгөөд арван найман насанд хүрэхийн өмнө эдлээгүй үлдсэн ялын хугацаанд дахин гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ял шийтгүүлсэн;

б/ арван найман насанд хүрэхийн өмнө зандалчлах /73 дугаар зүйл/ бусдыг санаатай алах /86 дугаар зүйл/, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх /112 дугаар зүйлийн хоёр, гурав дах хэсэг/, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг дээрэмдэх /125 дугаар зүйлийн хоёр дах хэсэг/, цагдаагийн байгууллагын ажилтан буюу ардын нөхөрлөлийн гишүүний амь биед халдах /222 дугаар зүйл/, онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар танхайрах /9 дүгээр зүйлийн гурав дах/, агаарын хөлгийг авч зугатаах /268 дугаар зүйл/ гэмт хэрэг үйлдсэн этгээд;

6. Эдлээгүй үлдсэн хорих ялыг засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялаар солихдоо энэ төрлийн ялын хуулиар тогтоосон хэмжээний дотор оногдуулах боловч эдлээгүй үлдсэн ялын хугацаанаас хэтрүүлж болохгүй.

7. Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солихдоо шүүх хугацааны өмнө тэнсэн суллагдсан буюу эдлээгүй үлдсэн ял нь хөнгөн ялаар солигдсон этгээдийг эдлээгүй үлдсэн ялын хугацаанд хяналтдаа байлгах хүмүүжүүлэх үүргийг хөдөлмөрийн тодорхой хамт олон буюу хүнд тэдний зөвшөөрснөөр даалгаж болно.

8. Арван найман насанд хүрэхийн өмнө хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээд эдлээгүй үлдсэн ялын хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 38 дугаар зүйлд заасан журмаар ял оногдуулна хэмээн тус тус заасан байна.

Энэхүү хууль нь хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах асуудлыг өмнөх зохицуулалтаас онолын дэвшилтэт байдалд авч үзэн хуульчилснаараа уг ажиллагааг цаашид хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан байна. Тухайлбал, ялтныг хугацааны өмнө тэнсэн суллахдаа оногдуулсан ялын биеэр эдэлсэн хугацааг харгалзахаас гадна, урьд ял шийтгэлгүйд тооцоогүй буюу ял шийтгэлгүй болоогүй байхад, хугацааны өмнө тэнсэн сулласны дараа эдлээгүй үлдсэн ялын хугацаанд дахин гэмт хэрэг үйлдсэн эсэхийг харгалздаг болсноор ялтныг тэнсэн суллахад тавигдах шаардлагууд улам нарийсаж ирсэн байна.

Долоо. 2002 оны Эрүүгийн хууль:

2002-2017 оныг хүртэл хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллах тухай хуулийн зохицуулалт нь Эрүүгийн хууль /74-р зүйл/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /126¹ 1-р зүйл/ болон холбогдох дүрэм, журмаар зохицуулагдаж байжээ.

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах буюу ялыг хөнгөн ялаар солих үндэслэл нь ялтан засарч хүмүүжсэн байх өөрөөр хэлбэл ялтан дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх зан суртахууны хэмжээнд хүрсэн байх явдал мөн.

Үүнийг 2002 оны "Эрүүгийн хууль"-ийн 74 дүгээр зүйлд хорих ял

шийтгүүлсэн ялтан засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулж, гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг шүүх ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж болно хэмээн тусгажээ.

Ялтан засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулах гэдэг нь ял эдлүүлэх дэглэмийн нөхцөл, журмын хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлэхийн зэрэгцээ гэм буруугаа ухамсарлаж, гэмт хэрэг шинээр үйлдэхгүй байх итгэл үнэмшилтэй болсон түүнчлэн ял эдлэх хугацаандаа сахилгын шийтгэлийн арга хэмжээний хөөн хэлэлцэх хугацаа дууссан буюу арилгуулсан, хорих ангийн захиргаа, ялтны сайн дурын байгууллагаас зохиож байгаа хүмүүжлийн ажилд идэвхтэй оролцдог, боловсрол, мэдлэгээ дээшлүүлэхэд биеэ дайчлан ажилладаг, бусад ялтны хүмүүжилд сайн нөлөө үзүүлдэг байхаас гадна хуулиар тогтоосон албадан хөдөлмөрлөх журмыг биелүүлсэн байх шаардлагатай.

Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо төлсөн байх гэдэг нь хохирогчид учруулсан хохирлоо барагдуулж дуусахыг хэлнэ.

Шүүх ялтныг хугацаанаас нь өмнө тэнсэн суллахдаа эдлээгүй үлдэж байгаа ялын хугацаатай тэнцүү хянан харгалзах хугацаа тогтоож, түүнд тодорхой хугацаанд ажил, сургуульд орох, учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэм хорыг арилгах, ажлын газар сургуулиа өөрчилсөн тухайгаа оршин суугаа газрынхаа цагдаагийн газарт мэдэгдэж байх зэрэг түүний засрал хүмүүжилд дөхөм үзүүлэх үүргийг даалгаж, түүнийг хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон буюу төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл садангийн хүн, тодорхой иргэнд тэдний хүссэнээр буюу зөвшөөрснөөр хариуцуулах нөхцөл тавьдаг байна.

Хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэхэд заавал баримтлах урьдчилсан нөхцөл нь, ялтан оногдуулсан ялын Эрүүгийн хуульд заасан хэсгийг эдэлсэн, засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулсан, гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирлоо төлсөн байх зэрэг юм.

Хорих ял шийтгэгдсэн ялтан шүүхээс оногдуулсан ялын зохих хувийг биечлэн эдэлсэн тохиолдолд хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэнэ. Үүнд:

- хүндэвтэр гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг;
- хүнд гэмт хэрэг оногдуулсан хорих ялын гуравны хоёроос доошгүй хувийг;
- онц хүнд гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын тавны дөрвөөс доошгүй хувийг зэрэг болно.

Цаазаар авах ял шийтгүүлж уучлагдсан, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон, түүнчлэн гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлөөгүй этгээдэд ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэхгүй.

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах явдал нь зөвхөн хорих ялаас чөлөөлж байгаа бөгөөд ялтныг тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй. Мөн ялтан шүүхээс оногдуулсан ялын хуулиар оногдуулсан хэсгийг эдэлсэн байлаа ч засарч хүмүүжээгүй, хохирлоо төлөөгүй байвал хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллагдах үндэслэл болохгүй. Харин шүүхээс оногдуулсан ялын тодорхой хэсгийг эдэлсэн байх нь ялын ерөнхий урьдчилан сэргийлэх зорилгыг хэрэгжүүлэхэд нэн чухал нөлөө үзүүлнэ.

Ялтныг хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах асуудлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг үндэслэн гаргасан прокурорын дүгнэлтийн дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын оршин байгаа газрын шүүхийн шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.⁷⁷

Ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд цагдаагийн байгууллага, цэргийн алба хаагчид, цэргийн анги, нэгтгэлийн дарга нар захиргааны хяналт тавихаар хуульчилсан бөгөөд ялтан хянан харгалзах хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлэхээс зайлсхийсэн, захиргааны зөрчил гаргаж шийтгэгдсэн бол шүүгч Цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан шийдвэрийг хүчингүй болгож, үлдсэн ялыг эдлүүлэхээр захирамж гаргаж болно.

Ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээд хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдвэл бол шүүхийн сүүлчийн шийтгэх тогтоолоор оногдуулсан ял дээр өмнөх шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулснаас эдлээгүй үлдсэн ялыг бүгдийг буюу заримыг нэмж нэгтгэн уг этгээдийн биечлэн эдлэх ялыг тогтооно хэмээн хуульчилсан байна.

Найм. 2015 оны Эрүүгийн хууль:

Нийгмийн хэрэгцээний шалгуур болж эрүүгийн эрх зүйн салбарт хийгдсэн томоохон өөрчлөлтийн илрэл нь Улсын их хурлаас 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр шинээр баталсан Эрүүгийн хуулиар ял шийтгэлийн тогтолцоонд өөрчлөлт оруулж, шинэ төрлийн хэд хэдэн ял бий болгосон явдал юм.

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, 2017 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн онцлог нь хорих ял биечлэн эдлүүлэх явдлыг багасгах, хохирол нөхөн төлүүлэх чиглэлд анхаарч, зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ялыг тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах ялыг хөнгөрүүлэх, чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх, өсвөр насны хүнд болон хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх институтийг тусгасан.

⁷⁷ МУ-ын Эрүүгийн хууль. УБ., 2002. 74-р зүйл 5 дэхь хэсэг, ЭБШТХ-ийн 334-р зүйл

Аливаа хариуцлага⁷⁸ тэр тусмаа эрүүгийн хариуцлагын мөн чанар нь бие хүн, нийгэм ба төр хэмээх хоорондоо харилцан шүтэлцээ бүхий хүн төрөлхтний бодит ахуйгаар нөхцөлдсөн байдаг.

Хариуцлага гэдэг нь өргөн утгаараа өөрийнхөө хийсэн үйлдэл, хэрэг явдал, тэдгээрээс үүсэх үр дагаврыг өөрийн биеэр хариуцах хүн бүрийн бэлэн байдал, үүрэг юм.

Хариуцлага бол хувийн ухамсрын түгээмэл үзэгдэл юм. Хариуцлагын үндэс нь нийгмийн өргөн хүрээтэй харилцаа. Энэ харилцааны хүрээнд өрнөж буй үйл явцын гол шинж бол харилцан холбогдож буй субъектүүд нэг нэгнийхээ өмнө зан үйлийн тодорхой үүрэг хүлээх явдлаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл аливаа харилцаа, тэр тусмаа эрх зүйн харилцаанд орж буй субъектүүд тухайн нийгэмд тогтсон зан үйлийн заавал биелүүлэх шинжтэй журмыг дагаж, үүрэг хүлээж, хариуцлага хүлээнэ гэж үг юм.

Субъектийн зан үйлд нөлөөлсөн гадна нөхцөл байдал үгүйсгэгдэж байгаа нөхцөлд түүний бодит байдал дээр нийгэмд харш үйл ажиллагаа явуулсан шалтгаан нөхцөл, хүчин зүйлүүдийг нэг бүрчлэн тогтоох шаардлагатай болдог. Хууль зүйн хариуцлага нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйн төлөө үүсэх эрх зүйн үр дагавар байдаг.

Мөн хууль зүйн хариуцлага нь эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн этгээдийн хүлээх үүргийг тодорхойлж эд хөрөнгийн болон хувийн эрхэд хязгаарлалт тогтоох замаар буруутай этгээдийн үйл ажиллагаанд төрийн зүгээс үнэлэлт, дүгнэлт өгөх боломжийг олгодог ба эрүүгийн хариуцлага нь хамгаалах, цээрлүүлэх, урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээн тогтоох чиг үүргийн хэрэгжүүлдэг.

Эрүүгийн хариуцлага нь эрүүгийн эрх зүйн бие даасан ойлголт бөгөөд гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд хуульд заасны дагуу шүүхийн шийтгэх тогтоолоор хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын арга хэмжээ мөн⁷⁹.

Түүнчлэн эрүүгийн хариуцлага нь хууль зүйн хариуцлагын онцгой төрөл учраас эхлээд хууль зүйн хариуцлагын асуудлыг хөндөх шаардлагатай. Хууль зүйн хариуцлага нь:

- хариуцлагыг үзэл бодолд бус зөвхөн хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйд хүлээлгэх;

⁷⁸ Я.Цэвэл, “Хариуцлага гэдгийг а) хариуцах үйлийн нэр, хариуцсан үүрэг, хариуцаж биедээ хүлээсэн үүрэг, хариуцлага, б) хууль зөрчсөн хүнд хүлээлгэх хариуцлага” гэж тайлбарласан. “Монгол хэлний товч тайлбар толь”, УБ хот, 1966 он, 666 дахь тал

Г.Галиндэв, Г.Батжаргал нар, “Хариуцлага гэдэг нь өөрийнхөө хийсэн үйлдэл, хэрэг явдал, тэдгээрийн үр дагаврыг хариуцах субъектийн бэлэн байдал юм” гэж тодорхойлсон. “Орчин үе, онол”. УБ хот, 328 дахь тал

⁷⁹ Д.Мөрөн, Г.Ганбаатар нар, “Эрүүгийн эрх зүй (Ерөнхий ба тусгай анги), УБ хот. 2016 он, 15 дахь тал

- хариуцлагыг гэм буруутай эрх зүйн зөрчилд хүлээлгэх;
- хариуцлагыг шударга ёсонд нийцүүлж оногдуулах;
- хариуцлага зүй зохистой, гэмт хэрэг, зөрчлийн шинжид нийцсэн байх;
- хариуцлага маргаангүй байх;
- хууль зөрчсөн нэг үйлдэл, эс үйлдэхүйд зөвхөн нэг удаа хариуцлага хүлээлгэх зэрэг зарчимд үндэслэгдэх ёстой.

Эрүүгийн хариуцлагыг нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө хүлээлгэдэг учир түүний хууль зүйн үр дагавар нь ял оногдуулах байдлаар хэрэгждэг. Эрүүгийн хариуцлага нь Эрүүгийн хуулиар хүлээлгэсэн үүрэг, хэрэгжүүлэх бодит боломжтой, чөлөөт хүсэл зориг зайлшгүй шаардлагатай хэрхэн харьцаж байгаад нийгэм-эрх зүйн хяналтыг ямар нэгэн хэмжээгээр хэрэгжүүлж байдгаараа эрүүгийн эрх зүйн зохицуулалтын тогтолцоонд чухал байр суурь эзлэн оршдог. Эрүүгийн хуульд заасан заавал биелүүлэх бодит шаардлага нь нийгмийн амьдралын объект хуулиудаар ямагт нөхцөлдсөн байдаг эрүүгийн хариуцлагын объектив тал юм.

Тийм учраас эрүүгийн эрх зүй нь нийгмийн харилцааны субъектүүдийн хариуцлагатай, зүй зохист зан үйлийг урамшуулан хамгаалж байдаг. Эрүүгийн хариуцлага нь гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан үйлдэл, эс үйлдэхүй хийсэн гэм буруутай этгээдийн эрх зүйн байдалд хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын онцгой арга хэмжээ болох ойлгомжтой байна.

Эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг зөвхөн Эрүүгийн хуулиар тогтоох бөгөөд ял ба эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ гэсэн хоёр үндсэн хэлбэртэй байна. Эрүүгийн хариуцлагын хэлбэр нь гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон шүүгдэгчийн эрхийг хязгаарласан агуулгатай ялын төрлүүдийг хэрэглэх замаар хэрэгждэг.

Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь шүүгдэгчид гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайг тогтоож үнэлэлт өгсөн боловч биеэрээ болон эд хөрөнгийн хувьд ямар нэгэн хязгаарлалт шууд хүлээдэггүй онцлогтой эмнэлгийн болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээгээр хэрэгждэг онцлогтой.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт "...гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл, саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно" гэсэн заасан байдаг. Иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах нь эрүүгийн хариуцлагын анхдагч зорилго юм. Энэ зорилго нь Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлд нэрлэж заасан нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн амин чухал эрх ашгийг эрүүгийн хуулийн хамгаалалтад авах нь нэг талаас энэрэнгүй ёсны зарчмын тод илрэл байдаг бөгөөд нөгөө талаас хүн, түүний аюулгүй байдал, эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалж байгаагаар тухайн зорилго бодит байдлаар хэрэгжиж байдаг.

Гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх нь эрүүгийн хариуцлагын хоёр дахь зорилго юм. Энэ зорилго нь нийгмийн шударга ёсны илэрхийлэл бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулах болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ хэрэглэхийн зэрэгцээ гэмт хэрэг үйлдэж бусдад учруулсан эд материалын болон сэтгэл санааны гэм хорыг арилгуулах, төлүүлэхэд чиглэгдсэн олон хэм хэмжээ Эрүүгийн хуульд тусгагдан хэрэгжиж байгаагаар хангагдаж байдаг.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хүмүүжүүлэх нь эрүүгийн хариуцлагын дөрөв дэх бие даасан зорилго юм. Ялтныг цээрлүүлж, өөрөөр хэлбэл эрхийг нь хязгаарлах замаар үйлдсэн гэмт хэрэгт гэмшүүлж байгаа явдал нь агуулгаараа хүмүүжүүлэх зорилгыг хангахад чиглэгдэнэ. Ялтан үйлдсэн гэмт хэргийн хортой үр дагаврыг бүрэн ухамсарлан ойлгож, нийгэмд тогтсон хууль ёс, дэг журмыг чанд сахидаг, бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэдэг, иргэнийхээ үүрэгт хүндэтгэлтэй ханддаг, шударга, зарчимч нийгмийн идэвхтэй гишүүн болон хүмүүжсэнээр эрүүгийн хариуцлагын энэ зорилго хангагдах юм.

Гэмт хэрэг үйлдэхээс хоригдлыг болон бусад этгээдийг урьдчилан сэргийлэх нь эрүүгийн хариуцлагын тав дахь зорилго юм. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг түргэн шуурхай илрүүлж, түүнд шударга ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг цаг алдалгүй хэрэглэж чадвал сая эрүүгийн хариуцлага гарцаагүй байх эрүүгийн эрх зүйн зарчим хангагдана. Гэмт хэрэг үйлдсэн хүн бүрт хариуцлага тооцох нь гэмт хэрэг үйлдвэл эрт орой хэзээ нэгэн цагт төрийн цээрлэл амсдаг юм байна гэсэн итгэл үнэмшил, болгоомжлолыг ялтанд болон гэмт хэрэг үйлдэж болзошгүй бусад тогтворгүй хүмүүст төрүүлэх нь эрүүгийн хариуцлагын энэ зорилго хангагдаж байгаагийн илрэл болно. Иймд гэмт хэрэгтэй тэмцэх үүргийг хуулиар хүлээсэн төрийн тусгай байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хэвлэл, мэдээллээр өргөн сурталчлах зайлшгүй шаардлагатай юм.

Ялын үүслийн талаар баруун Европт "Итали Руссо" хэмээн алдаршсан, криминологийн сонгодог сургаалыг үндэслэгч Чезаре Беккариа (1738-1794): "...хуулийг үл хэрэгсэж хүй нэгдлийн эмх замбараагүй байдалдаа эргэж очих гэсэн хүмүүсийн дур зоргоороо байх хүсэл эрмэлзлийг хазаарлах мэдрэхүйг цочроогч бол хууль зөрчигчид хүлээлгэдэг ял болой, гэмт хэрэгт оногдуулах ялыг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд тэрхүү хуулийг бүтээх эрх мэдэл зөвхөн гэрээний үндсэн дээр байгуулагдсан нийгмийг төлөөлөгч болох хууль тогтоогчид хадгалагдах учиртай. Шударга ёсны зарчмын дагуу ямар ч шүүх өөрөө нийгмийн нэг хэсэг атлаа нийгмийн бусад гишүүдэд зориулан ял тогтоож болохгүй. Хуульд зааснаас хатуу болон хуулиар тогтоогоогүй ял

оногдуулсан нь шударга байвч түүнийг ял гэж лав болохгүй...⁸⁰ хэмээн тодорхойлжээ.

2015 оны Эрүүгийн хуульд заасан “Хууль ёсны зарчим”, “Шударга ёсны зарчим”, “Гэм буруугийн зарчим”-уудад “Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно”, “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна”, “Энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан нь Ч.Беккариагийн үзэл санаатай бүрэн нийцэж, хууль тогтоогчийн баталсан хуулийн дагуу шүүхээс ял оногдуулж, хуульд заасан хэмжээ хязгаараас хэтрэхгүй, тухайн ял, хариуцлагын асуудал нь гэмт хэрэг үйлдсэн хүний гэм буруу, бусад байдалд тохирсон байх гэсэн үзэл санааг хуульчилжээ.

Эрүүгийн хууль нь гэм буруутай этгээдэд ял оногдуулахаас гадна Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үнэт зүйлсийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг давхар агуулдаг.

Германы эрүүгийн эрх зүйг үндэслэгч, гүн ухаантан Иоганн Ансельм Фейербах (1775-1883)⁸¹ “Сэтгэл зүйн дарамт үзүүлэх” онолыг боловсруулсан. Түүний үзэж байснаар, хуулиар тогтоосон ял шийтгэл нь хүмүүст сэтгэл зүйн нөлөөлөл буюу дарамт үзүүлж, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлдэг байна. Өөрөөр хэлбэл, хүч чадал, эрх мэдлээ буруугаар, дур зоргоор ашиглах гэсэн хүчний эсрэг яг ийм хууль, эрх зүйн тогтолцоо үйлчилж байж нийгэмд тэнцвэртэй, тогтвортой байдал үүснэ. Ял шийтгэл нь гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруу, хувийн байдалд тохирсон, өөрөөр хэлбэл Эрүүгийн хуульд заасан шударга ёсны зарчимд нийцсэн байна.

Ял шийтгэлийн тухай асуудал гэмт хэргийн тухай ойлголттой салшгүй холбоотой. Шүүх гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн шинж,

⁸⁰ Чезаре Беккариа. “Гэмт хэрэг ба ялын тухай”. /Орчуулсан Г.Эрдэнэбат/

⁸¹ Иоганн Ансельм Фейербах /1775-1883/. И.Кантын эрүүгийн эрх зүйн салбар дахь гүн ухааны сонгодог урсгалыг нэрт төлөөлөгч А.Фейербах өвлөн авсан. Тэрээр өөрийн эрүүгийн эрх зүйн онолыг бүтээж, түүнийгээ 1813 оны Германы Баварын Эрүүгийн хуульд тусгуулж чадсан. Эрдэмтэн судлаачдын үзэж байгаагаар, А.Фейербахын маргаангүй гавъяа бол анх удаа эрүүгийн эрх зүйн үндсэн зарчмуудыг томъёолсон явдал. Үүнд:

а/“nulla poena sin lege” - хуульгүй бол ялгүй.

б/“nulla poena sime crimene” - гэмт хэрэг үгүй бол ял үгүй.

в/“nullit crimen poena legali” - хуулиар тогтоосон ялгүй бол гэмт хэрэг үгүй.

А.Фейербахын эрүүгийн эрх зүйн зарчмуудын түүхэн томъёолол олон орны эрүүгийн хуулийн үндэс болж өнөө үед хууль ёсыг баримтлах зарчмын гол агуулга болсоор байна. Эдгээр зарчмуудаас үндэслэн А.Фейербах нь гэмт хэрэг бол хуулиар хориглосон үйлдэл гэж тодорхойлсон. Энэ нь амьдрал дээр эрүүгийн хуульд шинж тэмдэг нь тусгагдаагүй үйлдлийн төлөө хариуцлага хүлээлгэхийг хориглоно гэсэн үг юм. А.Фейербах мөн үзэл бодол, итгэл үнэмшил биш харин бодитой үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлагатай гэж үзэж байв. А.Фейербах гэм буруу, завдалт, гэмт хэргийн шинж, гэмт хэрэгт хамтран оролцох зэрэг институцийг боловсруулах онолын үндсийг тавьсан.

ял оногдуулахад харгалзах хүндрүүлэх болон хөнгөрүүлэх бүхий л нөхцөл байдлыг бүрэн тогтоосны үндсэн дээр гэм буруутай этгээдэд хуульд заасан, тохирсон ялыг сонгон оногдуулна.

Эрүүгийн хариуцлага нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, нийгэмшүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой төрийн албадлагын арга хэмжээний хамгийн хатуу төрөл болохын хувьд эрх зүйн бусад албадлагаас ялгагдана.

Эрүүгийн хариуцлагыг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулж, хүний эрх, эрх чөлөөнд Эрүүгийн хуульд заасан хязгаарлалт тогтоодог. Эрүүгийн хариуцлага нь өөрөө зорилго биш, харин Эрүүгийн эрх зүйн зорилтод хүрэх хэрэгсэл юм. Ийм учраас эрүүгийн хариуцлагын зорилго нь Эрүүгийн хуулийн зорилтоос үүдэн гарна.⁸²

2002 оны Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагын зорилгыг “Иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх” гэж тодорхойлж байсан бол 2017 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль дээрх зорилгууд дээр хохирол нөхөн төлүүлэх зорилгыг нэмж хуульчилсан.

Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг шийтгэж цээрлүүлэхээс гадна нийгэмшүүлэх зорилгыг давхар агуулдаг.

2015 оны Эрүүгийн хуульд ялын эрүүгийн хариуцлагын зорилгод нийцүүлэн гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ял тэнссэн, эсхүл хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүнд шүүх үндсэн ялаас гадна тодорхой үүрэг хүлээлгэх, эрхийн хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэхээр заасан. Тухайлбал, гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах, зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах, тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх, тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах, галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох, тодорхой үйл ажиллагаа явуулахыг хориглох зэрэг болно.

⁸² С.Нарангэрэл, Г.Эрдэнэбат. Эрүүгийн эрх зүй гарын авлага. УБ., 2007.65 дахь тал

3.2. Хоригдлыг суллагдасны дараах хяналт-нийгэмшүүлэх ажилд хийсэн дүн шинжилгээ

Нэг. Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох үндэслэл, журам:

Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллах институт нь анх 1885 онд Францад үүссэн гэж үздэг. Энэ цагаас хойш Европын бусад орноор дэлгэрч улмаар одоог хүртэл хорих ялаас өмнө тэнсэн суллах институт нь дэлхийн бараг бүх оронд хэрэглэгдэж ирсэн байна⁸³.

Харин манай улсын хувьд 1921 онд хувьсгалт засаг ялж Монгол улс тусгаар тогтнолоо олж, анхны Үндсэн хуулиа баталсны дараа 1926 онд Бүгд Найрамдах Монгол Ардын Улсын Шүүх цаазын бичиг нь 31 бүлэг 227 зүйтэйгээр батлагдсан. Шүүх цаазын бичгийн 7 дугаар бүлэгт урьд хоригдсоныг ялд тооцох, хугацаа дуусахын урьд ялтныг гаргах ба ялыг нэгмөсөн өршөөн хэлтрүүлэх тухай заасан байдаг. Хугацаа дуусахын урьд гаргах тухай дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

Аливаа хоригдсон ба албадын үйлдвэр хийлгэж бүхий ялтны дотроос зарим нэгэн зан авир сайн, үйлдвэр дор хичээлтэй нь буй аваас түүнийг хугацаа дуусахаас өмнө тавьж гаргаваас зохино⁸⁴ гэж зааж өгсөн байна⁸⁵. Түүнээс хойш өөрчлөгдөн батлагдсан 1929, 1934, 1942, 1961, 2002, 2015 оны Эрүүгийн хуулиудад хорих ялаас тэнсэн суллах тухай оруулж өгсөн байна.

А.Эрүүгийн хуульд туссан байдал:

а. ялтан гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлсөн

б. зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулж ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй

в. оногдуулсан ялын дараах хувийг эдэлсэн бол прокурорын саналыг харгалзан шүүх хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохоор шийдвэрлэж болно:

1.таван жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг;

2.таван жилээс дээш арван хоёр жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын гуравны хоёроос доошгүй хувийг;

3.арван хоёр жилээс дээш хорин жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын дөрөвний гурваас доошгүй хувийг эдэлсэн бол.

Хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахдаа эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтооно.

⁸³ Додонов В. Н. Сравнительное уголовное право. Общая часть / под общ. ред. С. П. Щербы. — М.: Юрлитинформ, 2009. — С. 397. — 448 с. — ISBN 978-5-93295-470-6.

⁸⁴ 1926 оны БНМАУ-ын Шүүх Цаазын бичиг. 7 дугаар бүлэг, 36-дугаар зүйл.

⁸⁵ Д.Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойших Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт (I дэвтэр). УБ., 1998.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүн хяналтын хугацаанд түүнд хүлээлгэсэн үүргийг зөрчсөн бол прокурорын саналыг харгалзан шүүх хяналт тогтоосон шийдвэрийг хүчингүй болгож эдлээгүй үлдсэн ялыг эдлүүлэхээр шийдвэрлэнэ.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүн хяналтын хугацаанд санаатай гэмт хэрэг үйлдсэн бол шүүх эдлээгүй үлдсэн ял дээр шинээр үйлдсэн гэмт хэрэгт оногдуулсан ялыг өмнөх шийтгэх тогтоолоор оногдуулсан ялаас эдлээгүй үлдсэн ялыг нэмж нэгтгэн нийт эдлэх ялын хэмжээг тогтооно. Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүн хяналтын хугацаанд болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн бол ял оногдуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

Б. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд туссан байдал:

Ялтныг хорих ялаас хугацааны өмнө суллах асуудлыг шийдвэрлэх хуралдаан явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө прокурор хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу мэдэгдэнэ.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллах тухай асуудлыг хорих байгууллагын тодорхойлолтыг үндэслэн гаргасан прокурорын дүгнэлтийн дагуу хорих байгууллагын оршин байгаа газрын шүүх шийдвэрлэнэ.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүнд хяналтын хугацаанд үүрэг хүлээлгэж болох ба үүрэг хүлээлгэсэн тохиолдолд хүлээлгэсэн үүргийг зөрчсөн бол прокурорын дүгнэлтээр шүүх хяналт тогтоосон шийдвэрийг хүчингүй болгож, эдлээгүй үлдсэн ялыг эдлүүлэхээр тогтооно.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллах тухай шийдвэр гарсан бол уг ялтныг даруй суллаж, суллагдсан хүний оршин суугаа газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мэдэгдэж, хувийн хэргийг хүргүүлнэ.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллах тухай шийдвэрт өмгөөлөгч гомдол, прокурор эсэргүүцэл бичиж болно.


В. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд туссан байдал:

Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон ялтны бүртгэлийг түүний оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, нэгдсэн тоо бүртгэлийг хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хариуцан хөтөлнө.

Судалгаанаас харахад хорих ялаас хугацаанаас өмнө суллах ажиллагаа нь жил ирэх тусам өсөх хандлагатай байна. Сүүлийн 8-н жилийн байдлаар авч үзвэл 2014 онд 1585, 2015 онд 1167, 2016 онд 997, 2017 онд 1115, 2018 онд


1186, 2019 онд 2267, 2020 онд 2512, 2021 оны 09 сард 2563 ялтан тус тус суллагдсан байна⁸⁶.

Зураг 9. Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан этгээдүүдийн судалгаа /2014-2021 оны байдлаар/



Үүнээс өсвөр насны хүн 2017 онд 0, 2018 онд 16, 2019 онд 28, 2020 онд 12, 2021 оны 09 сард 4 этгээд хяналтад байсан байна.


Зураг 10. Хугацаанаас өмнө суллагдсан өсвөр насны хүний судалгаа /2017-2021 он/



Түүнчлэн хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоосон этгээдүүдээс тухайн жилд дахин гэмт хэрэг үйлдсэн байдлыг судлан үзвэл, 2017 онд 0, 2018 онд 6, 2019 онд 25, 2020 онд 37, 2021 оны 09 дүгээр сарын байдлаар 31 этгээд байна.

Зураг 11. Хугацаанаас өмнө суллагадаад дахин гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн судалгаа /2017-2021 он/

⁸⁶ Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын тайлан. Хоригдогчдын шилжилт хөдөлгөөн, дүн бүртгэлийн тасаг.



Хоёр. Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх үндэслэл, журам:

А. Эрүүгийн хуульд туссан байдал:

Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүн гэм буруугаа хүлээн зөвшөөрч гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж хор уршгийг арилгасан, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан тухайн зүйл, хэсэг, заалтад заасан хорих ялыг оногдуулахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар тэнсэж болно.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хэд хэдэн үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтооно. Тэнссэн хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, хязгаарлалтыг зөрчсөн бол шүүх тэнссэн шийдвэрийг хүчингүй болгож ял оногдуулна. Тэнссэн хугацаанд энэ хуулийн тусгай ангид заасан санаатай гэмт хэрэг үйлдсэн бол шүүх тэнссэн шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулна.

Тэнссэн хугацаанд болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн бол тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлсэн байдлыг харгалзан уг албадлагын арга хэмжээг хүчингүй болгох эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

Тэнссэн хугацаанд гэмт хэргийн хохирлыг бүрэн төлж шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй ба цаашид үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй гэж үзвэл прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацааг дуусахаас өмнө ялаас чөлөөлж болно.

Тэнсэх хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ял оногдуулахгүй. Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо төлөхөө илэрхийлж тэнсэгдсэн хүн хохирлоо нөхөн төлөх хугацааг шүүх тогтооно.

Б. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд туссан байдал:

Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина. Ялтан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шүүгч захирамж гаргана.

Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд ял оногдуулна.


Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.

В. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд туссан байдал:

Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн ялтны бүртгэлийг түүний оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, нэгдсэн тоо бүртгэлийг хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хариуцан хөтөлнө.


Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн 2017 онд 344, 2018 онд 2028, 2019 онд 3868, 2020 онд 4406, 2021 оны 09 сард 3874 этгээд хяналтад байсан байна.

Зураг 12. Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн этгээдүүдийн судалгаа /2017-2021 он/




Үүнээс өсвөр насны хүн 2017 онд 0, 2018 онд 25, 2019 онд 22, 2020 онд 16, 2021 оны 09 сард 10 этгээд хяналтад байсан байна.

Зураг 13. Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн өсвөр насны хүний судалгаа /2017-2021 он/




Үүнээс тухайн жил шинээр ирсэн ялтны тоог үзвэл 2017 онд 344, 2018 онд 1741, 2019 онд 2216, 2020 онд 2185, 2021 оны 09 сарын байдлаар 1408 этгээд шинээр ирсэн байна.

Зураг 14. Шинээр ял тэнсэгдсэн этгээдүүдийн судалгаа /2017-2021 он/



Түүнчлэн хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн этгээдүүдээс тухайн жилд дахин гэмт хэрэг үйлдсэн байдлыг судлан үзвэл, 2017 онд 0, 2018 онд 19, 2019 онд 45, 2020 онд 55, 2021 оны 09 дүгээр сарын байдлаар 26 этгээд байна.

Зураг 15. Тэнсэгдсэн этгээдүүдээс гэмт хэрэг үйлдсэн талаарх судалгаа /2017-2021 он/



Гурав. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах үндэслэл, журам:

А.Эрүүгийн хуульд туссан байдал:

Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина. Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно.

Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, эсхүл тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

Ялтан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг үйлдвэл шүүх ял оногдуулна.

Ял хойшлуулсан этгээд шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.

Б.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд туссан байдал:

Шийдвэр гүйцэтгэгч тогтоолын биелэлтийг хойшлуулсан шийдвэрийг хүлээн авч дараахь ажиллагааг гүйцэтгэнэ:

1.тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдэд хяналт тавих нөхцөл, журам, эрх, үүргийг нь тайлбарлаж, гарын үсэг зуруулах;

2.тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн хувийн бичиг баримт, онцлог содон тэмдэг, ялтны хувийн байдлын талаархи бусад мэдээллийг хувийн хэрэгт тэмдэглэж, ял эдлэлтийн байдалтай холбоотой бусад баримт бичгийг хавсаргах;

3.тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн ялтныг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэнийг дуудан ирүүлж, тэдгээрийн эрх, үүрэг,

тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдэд хууль, шүүхийн шийдвэрээр тогтоосон хязгаарлалт, даалгасан үүргийг танилцуулах;

4.тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн үүргээ биелүүлэх талаар шаардлага тавьж, биелэлтийг хангуулах;

5.тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн сахилга, засрал хүмүүжил, шүүхээс даалгасан үүргийн биелэлтийн талаар хяналтын хувийн хэрэгт 30 хоног тутам тэмдэглэл хийх;

6.шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусмагц энэ тухай прокурор, цагдаагийн байгууллага болон ял шийтгүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэх.

Шийдвэр гүйцэтгэгч тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн засрал хүмүүжлийн байдалд дараахь журмаар хяналт тавина:

1.гадаадад зорчих, цагаачлахыг хориглож, оршин суугаа засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийг 7 хоногоос дээш хугацаагаар орхин явах тохиолдолд зөвшөөрөл авах, 30 хоног тутам нэг удаа биечлэн ирж, бүртгүүлэхийг даалгах;

2.оршин суух газар болон эрхлэх ажил, албан тушаал өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр мэдэгдэж байх тухай баталгаа гаргуулах;

3.тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн этгээд болон сум, дүүргийн Засаг даргаас хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх харилцан мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

4.тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн эцэх, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хараа хяналтдаа байлгах хүсэлт гаргасан буюу хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэний хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулах;

5.тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээд шүүхээс тогтоосон хязгаарлалт, үүргийг биелүүлээгүй, эсхүл хяналтаас зайлсхийсэн тохиолдолд албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулах;

6.тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэх, эсхүл холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах;

7.гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх талаар тогтоолын биелэлтийг нь хойшлуулсан этгээдэд санамж, зөвлөгөө өгөх, ярилцлага зохион байгуулах;

8.хяналтад нь байгаа тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн зан байдал, үйл ажиллагааны талаар байгууллага, албан тушаалтнаас тодорхойлолт, лавлагаа авах;

9.тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээд хүндэтгэх шалтгаанаар оршин суух газраа өөрчлөх бол түүний хяналтын хугацааг тооцож, хяналтын

хувийн хэргийг шинээр оршин суух газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлэх.

Тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээд дараахь үүрэгтэй:

1.байнга оршин суух газраа очсоноос хойш ажлын 3 өдрийн дотор нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд мэдэгдэх;

2.сар тутамд шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд, оршин суугаа нутаг дэвсгэрт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгжгүй бол харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад бүртгүүлэх, шүүхээс хүлээлгэсэн үүргийн биелэлтийн талаар тайлбар гаргах;

3.байнга оршин суух хаягаа өөрчлөх тохиолдолд хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд, оршин суугаа нутаг дэвсгэрт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгжгүй бол харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэдэгдэх, шинээр суурьших нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд, эсхүл цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

4.байнга оршин суугаа газраасаа 7 хоногоос илүү хугацаагаар явах, гадаадад зорчих бол хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд, оршин суугаа нутаг дэвсгэрт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгжгүй бол харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

5.хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, цагдаагийн байгууллагын алба хаагч, шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг биелүүлэх.

Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан, тэнссэн хугацаанд ялтан засарч хүмүүжсэнээ үлгэр жишээ зан төлөв, сурлага, хөдөлмөрт үнэнч, шударга хандлагаараа харуулсан, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлсэн, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан ялтны хянан харгалзахаар тогтоосон хугацааны 50 хувиас багагүй хугацаа өнгөрсөн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч ялтныг ялаас чөлөөлүүлэх саналыг прокурорт гаргаж болно. Прокурор хяналтын хувийн хэрэгтэй танилцаж, шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгох, ялаас чөлөөлөх тухай дүгнэлтээ шүүхэд хүргүүлнэ.

Шийдвэр гүйцэтгэгч санал гаргаагүй, эсхүл прокурор гаргасан саналыг үндэслэлгүй гэж үзсэн бөгөөд шүүхийн тогтоолд заасан хянан харгалзах хугацаа дууссан боловч дараагийн шийдвэр гараагүй тохиолдолд уг хугацаа дуусмагц шийдвэр гүйцэтгэгч цаашид авах арга хэмжээний тухай саналаа хяналтын хувийн хэргийн хамт прокурорт хүргүүлнэ.


Ялтан тэнссэн, тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, эсхүл шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг 6 сарын хугацаанд хоёр, түүнээс дээш удаа зөрчсөн, эсхүл хориглолт, хязгаарлалтыг зөрчсөний улмаас хүн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолд хохирол учирсан, эсхүл үүргээ биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч 5 хоногийн дотор тэнссэн, тогтоол

биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгуулж, ял оногдуулах саналаа прокурорт хүргүүлнэ.

Прокурор шийдвэр гүйцэтгэгчийн саналыг хүлээн авч үндэслэлийг хянаж тэнссэн, тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгуулах, ял оногдуулах эсэхийг шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлнэ.


Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 2017 онд 25, 2018 онд 155, 2019 онд 420, 2020 онд 433, 2021 оны 09 сард 264 этгээд хяналтад байсан байна.

Зураг 16. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан этгээдүүдийн судалгаа /2017-2021 он/




Үүнээс өсвөр насны хүн 2017 онд 13, 2018 онд 90, 2019 онд 282, 2020 онд 271, 2021 оны 09 сард 143 этгээд хяналтад байсан байна.

Зураг 17. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны этгээдүүдийн судалгаа /2017-2021 он/




Үүнээс тухайн жил шинээр ирсэн ялтны тоог үзвэл 2017 онд 25, 2018 онд 133, 2019 онд 310, 2020 онд 182, 2021 оны 09 сарын байдлаар 77 этгээд шинээр ирсэн байна.

Зураг 18. Шинээр ирсэн шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны этгээдүүдийн судалгаа /2017-2021 он/



Түүнчлэн хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан этгээдүүдээс тухайн жилд дахин гэмт хэрэг үйлдсэн байдлыг судлан үзвэл, 2017 онд 0, 2018 онд 1, 2019 онд 9, 2020 онд 11, 2021 оны 09 дүгээр сарын байдлаар 12 этгээд байна.


Зураг 19. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан этгээдүүдээс үйлдсэн гэмт хэргийн судалгаа /2017-2021 он/



Дөрөв. Хорих ялын хугацаа дуусч суллагдах үндэслэл, журам:


Хорих ял эдэлж буй хоригдлоос 2017 онд хугацаа дуусч 396, 2018 онд 702, 2019 онд 1063, 2020 онд 1198, 2021 оны эхний хагас жилийн байдлаар 481 хоригдол суллагдсан байна.

Зураг 20. Хугацаа дуусч суллагдсан хоригдлын судалгаа /2017-2021 он/



Нийт хорих ял эдэлж буй хоригдлуудаас давтан гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж байсан хоригдлын тоог судлан үзвэл 2017 онд 1289 буюу 43.8%, 2018 онд 1614 буюу 45.7%, 2019 онд 1910 буюу 48.5%, 2020 онд 2371 буюу 52.8%, 2021 оны 09 дүгээр сарын байдлаар 1481 буюу 52.6% нь байжээ.

Зураг 21. Хорих ял эдлэгсдээс давтан гэмт хэрэг үйлдэн ял эдлэгсдийн судалгаа /2017-2021 он/



Хорих ял эдлээд хугацаа дуусч суллагдсан, хугацааны өмнө суллагдсан этгээдэд тавих хяналт ажиллагаа өнөөгийн байдлаар тодорхой үр дүнгүй байгаа нь дахин гэмт хэргийн тоо буурахгүй байгаатай шууд холбоотой юм.

3.3. Тэнсэн суллагдсан, ял хойшлуулсан этгээдэд тавиж буй хяналт-нийгэмшүүлэх ажилд хийсэн дүн шинжилгээ

Сүүлийн 5 жилд дунджаар 6500-12000 орчим хүн шүүхээс ял шийтгүүлдэгээс урьд ял эдэлж байсан хүн **2000- 2500** орчим байгаа ба нийт ял шийтгүүлэгчдийн **50-60 орчим хувь** нь эрхэлсэн тодорхой ажилгүй, боловсролгүй, сургууль завсардсан хүмүүс эзэлж байна. Шүүхээс ял шийтгүүлэгчдийн **3500-4500** орчим буюу 50% нь хорих ял эдэлж байна.

Улсын хэмжээнд жилд дунджаар хорих ял эдлээд **1800-2000** орчим хүн суллагддагаас **1000** орчим хүн хугацаанаас өмнө нь суллагдаж төрийн байгууллагын хяналтад орж байна.

Суллагдсан хүнийг нийгэмшүүлэх, тэдэнд хяналт тавих, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах чиглэлээр дараах эрх зүйн зохицуулалт үйлчилж байна.

1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль /2011 оны 6 дугаар сарын 17-ны өдөр/

3.1.7 дугаар зүйлд: “ажил олоход хүндрэлтэй иргэн” гэж ...хорих ангиас суллагдсан болон хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан иргэн, 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэнийг;

15 дугаар зүйлд: Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “15.1.2.хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн ажиллуулж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг нэг удаа олгох”,


15.1.5 дугаар зүйлд: Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангаж, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаар тодорхой санаачилга гаргаж, үр дүнд хүрсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл шалгаруулж, урамшуулах.

31.4 дугаар зүйлд: Хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэний талаарх мэдээллийг холбогдох байгууллагаас тухай бүр харьяалах аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад мэдэгдэж, уг байгууллага иргэний хүсэлтийн дагуу бүртгэж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамруулна.

Судалгаанд хамрагдсан 503 хоригдлын 14 буюу 2.7% нь инженер, 31 буюу 6.2% нь тогооч, 17 буюу 3.3% нь жолооч, 17 буюу 3.3% нь жолооч цахилгаанчин, 23 буюу 4.5% нь гагнуурчин, 10 буюу 1.9% нь малчин, 25 буюу 4.9% нь мужаан, 6 буюу 1.2% нь ойжуулагч, 45 буюу 8.9% нь сантехникч, 39 буюу 7.7% нь үсчин, 9 буюу 1.7% нь өрлөгчин, 3 буюу 0.5% арматурчин, 32 буюу 6.3% нь тодорхойгүй, 2 буюу 0.5% нь ОУХ Менежер, 1 буюу 0.1% нь


малын бага эмч, 21 буюу 4.1% нь засварчин, 28 буюу 5.5% нь барилгын засалч чимэглэлч, 180 буюу 35.7% нь мэргэжилгүй байна.

Зураг 22. Судалгаанд хамрагдагсдын мэргэжлийн судалгаа:



Судалгаанд хамрагдсан 503 хоригдлын 259 буюу 51.4% нь хөдөлмөр эрхэлж байсан, 244 буюу 48.5% нь хөдөлмөр эрхэлж байгаагүй байна.

Зураг 23. Судалгаанд хамрагдагсдын хөдөлмөр эрхлэлтийн судалгаа:



2.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль (2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр)

12 дугаар зүйл. Аюулгүй амьдрах, хөгжих орчныг бүрдүүлэх

12.1.4. гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлсэн залуучуудад боловсрол, мэргэжил олгох, хорих ангиас суллагдах үед ажлын байраар хангах талаар төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн гаргасан санаачилгыг дэмжих;

Судалгаанд хамрагдсан 503 хоригдлын 63 буюу 12.5 хөдөлмөр эрхлэхээр бүртгүүлж байсан, 299 буюу 59.4% нь бүртгүүлж байгаагүй, 33 буюу 6.5% нь бүртгүүлж хөдөлмөр эрхэлж байсан, 108 буюу 21.4% нь бүртгүүлсэн боловч хөдөлмөр эрхэлж чадаагүй гэж хариулсан байна.

Зураг 24. Давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдээс хөдөлмөр, халамж үйлчилгээний төвд хөдөлмөр эрхлэхээр бүртгүүлсэн талаарх судалгаа:



3.Нийгмийн халамжийн тухай хууль (2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр)

- 13 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тэтгэмжийн төрөлд:

13.5.3. хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;

- 18 дугаар зүйл. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ

18.1. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

18.2.5. хорих ангиас суллагдсан иргэн;


20 дугаар зүйл.Боловсролыг дэмжих үйлчилгээ

20.2. Боловсролыг дэмжих үйлчилгээнд дараах иргэнийг хамруулна:

20.2.6. хорих ангиас суллагдсан хүүхэд.


Судалгаанд хамрагдсан 503 хоригдлын 214 буюу 42.55% мэргэжил эзэмшсэн, 289 буюу 57.4% нь тийм, үгүй гэж хариулжээ.

Зураг 25. Судалгаанд хамрагдагсдын хорих ангид мэргэжил эзэмшсэн талаарх судалгаа:




Судалгаанд оролцсон 503 хоригдлын 126 буюу 25% нь тийм, 275 буюу 59.6% нь ажиллахгүй, 45 буюу 8.9% нь мэдэхгүй, 57 буюу 11.3% нь ажил олдвол ажиллана.

Зураг 26. Давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдээдүүс хорих ангид эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах талаар судалгаа:



Хорих ангиас суллагдсаны дараа төрөөс ямарваа нэгэн халамжид хамрагдаж байсан эсэх талаарх асуулгад 502 хоригдлын 427 нь буюу 85% нь хамрагдаж байгаагүй, 75 нь буюу 15% нь тодорхой хэлбэрээр хамрагдаж байсан гэж хариулсан байна.

Зураг 27. Хорих ангиас суллагдсаны дараа төрөөс үзүүлж буй халамжид хамрагдсан эсэх талаарх судалгааны дүн



4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль: (2019 оны 06-р сарын 06 өдөр)

- 9 дүгээр зүйл. Гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн чиглэлийг хэрэгжүүлэх

9.2.3. гэмт хэрэг үйлдэж болзошгүй нөхцөлд байгаа болон хорих ял шийтгүүлж, суллагдсан этгээдэд нийгэмд дасан зохицох, нийгмийн амьдралд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх;

9.2.5. гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийн зан байдалд нөлөөлөх, хуулийг чандлан сахих, дадал төлөвшүүлэх, хорих байгууллагад байх хугацаанд боловсрол, ажил хөдөлмөр эрхлэх дадал, туршлага олгох, суллагдсаны дараа нийгэмд дасан зохицох шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох зэргээр хуульчилсан байна.

Түүнчлэн тус хуулийн 28.1.1-д Нутгийн захиргааны бүх шатны байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах үүрэг хүлээнэ:

28.1.4.шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагаа, санал, санаачилгыг дэмжин туслах;

28.1.13.гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байр бий болгох, хөдөлмөрлөх дадал, туршлага олоход нь дэмжлэг үзүүлэх;

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хяналт тавих үндэслэлийг заахдаа:

1.Эрүүгийн хуулийн 10.1 /хүнийг санаатай алах/, 11.2 /санаа сэтгэл нь хүчтэй цорон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах/, 12.1 /хүчиндэх/, 12.3 /бэлгийн мөлжлөг/, 15.1 /эмнэлэгийн тусламж үзүүлэхгүй байх/, 15.5 /хууль бусаар үр хөндөх/, 15.6 /бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдолын вирус тараах/, 16.2 /хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах/, 17.1 /хулгайлах/, 18.6 /мөнгө угаах/, 19.2 /төрийн эрх мэдлийг хууль бусаар авах/, 19.5 /зэвсэгт үймээн дэгдээх/, 19.6 /хорлон сүйтгэх/, 19.8 /экстремист үйл ажиллагаа явуулах/, 20.3 /зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулах, түүнд элсэх/, 20.7 /мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/, 20.8 /мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэх орон байраар хангах/, 26.1 /цахим мэдээлэлд хууль бусаар халдах/, 26.2 /цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах/, 26.3 /хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах/, 29.8 /террорист үйлдэл хийх/, 29.10 /терроризмыг санхүүжүүлэх/ зэрэг 22 төрлийн гэмт хэрэг үйлдэж, хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлж суллагдсан.

2.Хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлж, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон, хорих, зорчих эрхийг хязгаарлах

ялаас өвчний учир чөлөөлөгдсөн, өршөөл, уучлал үзүүлж ялаас чөлөөлөгдсөн.

3.Шүүхээс хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахдаа эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтоох ба хяналтын хугацаа нь дууссан хүнд гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт тогтооно.


Түүнчлэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д Аймаг, дүүргийн Засаг дарга, орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралтай зөвшилцөн хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулах бөгөөд хороо нь дараа үйл ажиллагааг явуулна.

15.1.1.гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлсэн хүмүүжлийн чанартай арга хэмжээ авагдсан хүүхдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүлээн авах, шүүхээс хүүхдэд даалгасан үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг туслалцаа үзүүлэх;

15.1.2.сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх заалтыг хэрэгжүүлэх нь дахин гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдалд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж заажээ.

Судалгаанд хамрагдсан 513 хоригдлоос суллагдан гарсны дараа учирсан хүндрэл, бэрхшээлийн талаарх асуулга авахад 166 нь буюу 32,3% нь ажил олдоогүй, амьдрах байр байхгүй байсан гэж 74 нь буюу 14,4% нь, 19 нь буюу 3,7% хүлээж авах ар гэр, найз нөхөд байхгүй, 29 нь буюу 5,6% нь асуудлаа шийдвэрлүүлэх төрийн байгууллага, албан тушаалтан байхгүй, 225 нь буюу 43,8% нь хүндрэл байгаагүй гэж хариулсан байна.

Зураг 28. Хорих ангиас суллагдан гарсны дараа учирсан хүндрэлийн талаарх асуулгын дүн




3.3. Монгол Улсад хөгжүүлэх пробацийн тогтолцооны загвар

Монгол Улсад пробацийн тогтолцоог хөгжүүлэх хүрээнд юуны өмнө хорих ял эдэлж байгаад суллагдан гарсны дараа дахин гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж буй хоригдлуудад учирсан хүндрэл, бэрхшээлтэй холбоотой асуудлыг судлах нь зүйтэй гэж үзлээ.

1. Амьдрах орчны тухайд:


Судалгаанд хамрагдсан 503 хоригдлын 26 буюу 5.1% нь орон сууц, 94 буюу 18.6% нь хашаа байшин, 40 буюу 7.9% нь нийтийн байр, 261 буюу 51.8% нь монгол гэр, 29 буюу 5.7% нь түрээсийн байр, 53 буюу 10.5% нь амьдрах байргүй гэж хариулсан байна.

Зураг 29. Судалгаанд хамрагдагсдын гэмт хэрэг үйлдэхээс өмнө амьдарч байсан орчны судалгаа:




Суллагдан гарсны дараа амьдрах орон байр бий юу гэдэг асуултад судалгаанд хамрагдсан 497 хоригдлын 203 нь буюу 40,8% нь орон байртай, 220 нь буюу 44,2% нь орон байргүй, 58 нь буюу 11,6% нь хамаатан, садныдаа очно, 16 нь буюу 3,2% нь халамжийн газар эсхүл төрийн бус байгууллагад очно гэж хариулжээ. Судалгаанаас харахад 294 хоригдол буюу 59,1% нь суллагдан гараад амьдрах орон байргүй байна.

Зураг 30. Суллагдан гарсны дараа амьдрах орон байртай эсэх талаарх судалгааны дүн:



Судалгаанд хамрагдсан 502 хоригдлоос хорих ангиас суллагад амьдрах оронгүй тохиолдолд хэрхэн вэ гэсэн асуултад 40 буюу 7.9% нь төрийн байгууллагад хандана, 62 буюу 12.3% нь төрийн бус байгууллагад хандана, 37 буюу 7.3% нь асрамжийн газарт хандана, 37 буюу 4.1% нь гудамжинд амьдрана, 342 буюу 67.9% хамаатан садан, найз нөхдийндөө амьдрана.


Зураг 31. Хорих ангиас суллагад амьдрах оронгүй тохиолдолд амьдрах газрын судалгаа



2. Гэр бүлийн байдал:


Судалгаанд хамрагдсан 503 хоригдлын 92 буюу 18.2% нь гэрлэсэн хүүхэдтэй, 66 буюу 13.1% нь гэрлэсэн хүүхэдгүй, 76 буюу 15.1% нь гэрлээгүй хүүхэдтэй, 78 буюу 15.5% нь гэрлээгүй хүүхэдгүй, 102 буюу 20.2% нь салсан хүүхэдтэй, 60 буюу 11.9% нь гэрлээгүй, хүүхэдгүй, 4 буюу 0.7% салсан хүүхэдгүй, 25 буюу 4.9% нь бэлбэсэн хүүхэдтэй, 25 буюу 4.9% нь бэлбэсэн хүүхэдгүй гэж хариулсан байна.

Зураг 32. Давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэр бүлийн судалгаа:




Таныг хорих ангиас суллагдсаны дараа гэр бүлийнхэн тань хэрхэн хүлээж авсан бэ? гэсэн асуултад 505 хоригдлын 34 нь буюу 6,7% нь гэмт хэрэгтэн гэсэн байдлаар жигшиж байсан, 42 нь буюу 8,3% нь харьцахаас зугтаж байсан, 327 нь буюу 64,7% нь энгийн байсан, 102 нь буюу 20.1% мэдэгдээгүй гэж хариулсан байна.

Зураг 33. Суллагдан гарсны дараа гэр бүлийн гишүүдийн хүлээн авсан байдлын судалгаа



Таныг хорих ангиас суллагдсаны дараа найз нөхөд, хамт олон тань хэрхэн хүлээж авсан бэ? гэсэн асуултад 503 хоригдлын 20 нь буюу 3,9% нь найз нөхөд, хамт олонгүй болсон, 62 нь буюу 12,3% нь харьцахаас зугтаж байсан, 388 нь буюу 75,5% нь энгийн байсан, 33 нь буюу 6.5% мэдэгдээгүй гэж хариулсан байна.


Зураг 34. Найз, нөхөд, хамт олны харьцааны талаарх судалгааны дүн:



3. Амьжиргааны түвшин:


Судалгаанд хамрагдсан 503 хоригдлын 23 буюу 4.5% нь баян, 301 буюу 59.8% нь дундаж, 136 буюу 27% нь ядуу, 43 буюу 8.5% нь нэн ядуу гэж хариулсан байна.

Зураг 35. Давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн амьжиргааны түвшний судалгаа:




Та банк болон бусад санхүүгийн байгууллагад хадгаламжтай юу гэсэн асуултад 501 хоригдлын 32 буюу 6,3% нь байгаа, 449 буюу 89,6% нь байхгүй, 20 буюу 3,9% нь хамтарсан хадгаламжтай гэж хариулсан байна.

Зураг 36 . Банк болон бусад санхүүгийн байгууллагад хадгаламжтай эсэх талаарх асуулгын дүн:



Үйлдсэн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлын төлбөртэй эсэх талаарх судалгаанд 492 хоригдлын 264 буюу 53,6% нь төлбөртэй, 228 буюу 46,3% нь төлбөргүй гэж хариулсан байна.


Зураг 37. Гэмт хэргийн төлбөртэй эсэх талаарх судалгааны дүн:



4. Суллагдан гарсны дараах учирсан хүндрэл:


503 хоригдлоос суллагдсаны дараах хувь хүнд учирсан бэрхшээлийн талаарх асуулгад 271 буюу 53.8% нь хүндрэлтэй асуудал байхгүй, 18 буюу 3.5% нь сэтгэл зүй тогтворгүй байдаг, 126 буюу 25.6% нь ажил олдохгүй байдаг, 63 буюу 12.5% нь амьдрах орон байргүй, 12 буюу 2.3% нь гадаад явахад хэцүү байдаг, 7 буюу 1.3% нь цагдаагийн байгууллага хэрэг тохдог, 3 буюу 0.5% нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Зураг 38. Давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хорих ангиас суллагдахад тулгардаг бэрхшээлийн судалгаа:



Судалгаанд хамрагдсан 502 хоригдлоос та өмнө суллагдсаны дараа төрийн байгууллагаас халамжийн үйлчилгээнд хамрагдаж байсан уу гэсэн судалгаанд 75 буюу 14,9% нь хамрагдаж байсан, 427 буюу 85% нь хамрагдаж байгаагүй гэж хариулсан байна.

Зураг 39. Халамжийн үйлчилгээнд хамрагдсан эсэх талаарх судалгааны дүн




Судалгаанд хамрагдсан 503 хоригдлоос суллагдсаны дараа хөдөлмөр эрхлэхээр холбогдох байгууллагад хандаж байсан талаарх асуулга авахад 63 буюу 12.5 хөдөлмөр эрхлэхээр бүртгүүлж байсан, 299 буюу 59.4% нь бүртгүүлж байгаагүй, 33 буюу 6.5% нь бүртгүүлж хөдөлмөр эрхэлж байсан, 108 буюу 21.4% нь бүртгүүлсэн боловч хөдөлмөр эрхэлж чадаагүй гэж хариулсан байна.

5. Хорих ял эдлүүлэх ажиллагааны явц дахь нийгэмшүүлэх ажлын үр дүн:


Таныг хорих ял эдлэх явцад ар гэрээс тань холбогдож байсан уу гэсэн асуултад 519 хоригдлоос 74 буюу 14,2% нь эргэлтээр ирдэг, 327 буюу 63% нь холбоо байхгүй, 8 буюу 1,5% нь захиа ирүүлдэг, 34 буюу 6,5% нь илгээмж ирүүлдэг, 76 буюу 14,6% нь утсаар яридаг гэж хариулсан байна.

Зураг 40. Ар гэрийнхтэйгээ холбоотой байдаг талаарх судалгааны дүн




Судалгаанд хамрагдсан 503 хоригдлоос хорих ял эдлэх явцдаа мэргэжил эзэмшсэн эсэх талаарх судалгаанд 214 буюу 42.55% мэргэжил эзэмшсэн, 289 буюу 57.4% нь үгүй гэж хариулжээ.

Зураг 41. Хорих ангид мэргэжил эзэмшсэн талаарх судалгаа:



Судалгаанд оролцсон 503 хоригдлоос хорих ангид эзэмшсэн мэргэжлээрээ суллагдсаны дараа ажил, хөдөлмөр эрхлэх эсэх талаарх асуулгад 126 буюу 25% нь тийм, 275 буюу 59.6% нь ажиллахгүй, 45 буюу 8.9% нь мэдэхгүй, 57 буюу 11.3% нь ажил олдвол ажиллана гэж хариулжээ.

Зураг 42. Хорих ангид эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах талаар судалгаа:



Судалгаанд хамрагдсан 503 хоригдлоос суллагдан гарсны дараа өөрт холбогдох төрийн үйлчилгээг авч чадах эсэх талаарх асуулга авахад 247 буюу 49.1% нь төрийн үйлчилгээг авах чадвартай, 208 буюу 41.3% нь төрийн үйлчилгээг авч чадахгүй, 48 буюу 9.5% нь мэдэхгүй гэж хариулсан.

Зураг 43. Хорих ангиас суллагдаад төрийн үйлчилгээг авах чадварын судалгаа:




Хорих ангиас суллагдан бэлтгэхэд чиглэгдсэн ямар арга хэмжээ авбал зүйлтэй вэ гэсэн асуултад 501 хоригдол хамрагдсанаас 181 буюу 36,1% нь мэргэжил эзэмшүүлэх, 64 буюу 12,7% нь сургалтад хамруулах, 203 буюу 40,5% ажилд зуучлах, 47 буюу 9,3% ар гэртэй нь холбон зуучлах, 6 нь 1,1% нь бусад арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар санал гаргасан байна.

Зураг 44. Суллахад бэлтгэх ажиллагааны чиглэлээрх асуулгын дүн:



Судалгаанд хамрагдсан 503 хоригдлоос хорих ангиас суллагдсаны дараах зорилгын талаарх асуулга авахад 272 буюу 54% нь ажил хайна, 145 буюу 28.8% хувиараа бизнес эрхэлнэ, 17 буюу 3.3% нь гадаад явна, 72 буюу 14,3% нь зорилго байхгүй гэж хариулсан байна.

Зураг 45. Суллагдсаны дараа амьдралын зорилгын талаарх судалгаа:



Хоригдлыг суллагдсаны дараа төрийн зүгээс ямар арга хэмжээ авбал зохилтой вэ гэсэн асуултад 516 хоригдлоос 11 буюу 2,1% нь хяналтыг сайжруулах, 209 буюу 40,5% нь ажилд зуучлах, 122 буюу 23,6% нь амьдрах орон байртай болгох, 89 буюу 17,2% нь халамжийн үйлчилгээнд хамруулах, 82 буюу 15,8% нь мэргэжил эзэмшүүлэх, 3 буюу 0,5% нь бусад байдлаар дэмжих гэж хариулжээ.

Зураг 46. Суллагдсан иргэнд үзүүлэх төрийн үйлчилгээний санал:



Урьд гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж байгаад суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж буй хоригдлуудаас авсан судалгааны дүнг нэгтгэн үзвэл дараах асуудлууд байна гэж үзлээ. Үүнд:

1. Хорих ял эдлээд суллагдсаны дараа учирч буй гол хүндрэл бэрхшээл нь амьдрах орон байргүй болон ажлын байр олдохгүй байна.
2. Хорих ял эдлэх явцад хоригдлыг нийгэмд нэн хэрэгцээтэй байгаа мэргэжил эзэмшүүлэх талаарх сургалтын ажлыг явуулах шаардлагатай байна.
3. Хорих байгууллагад явуулж буй суллагдахад бэлтгэх ажиллагааны явцад нийгэмтэй холбон зуучлах, төрийн үйлчилгээг авах чадвар эзэмшүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай байна.

Эцсийн дүнд хоригдлыг ажилтай, орлоготой болгоход чиглэсэн төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааны үр дүнд дахин гэмт хэрэг буурна гэж үзлээ.

Хорих байгууллагаас суллагдсан хүмүүст халамж үзүүлэх асуудал дараах үе шатыг дамжин хэрэгжиж байна. Үүнд:

1. ШШГЕГ-ын тоо бүртгэлийн тасгаас суллагдсан талаарх тодорхойлолтыг ажлын 3 хоногийн дотор олгодог.
2. Аймаг, дүүргийн үл хөдлөх бүртгэлийн газраас үл хөдлөх хөрөнгийн бүртгэлгүй болохыг тодорхойлсон бичиг 10,000 төгрөг тушаан хариуг авахад ажлын 5 өдөр шаардлагатай болдог.
3. Улмаар халамжийн байгууллага ажилтанд өргөдөл, холбогдох материалыг өгч халамжийн ажилтан хүлээн авч 14 хоногт багтаан судалгаа хийнэ.
4. Шаардлага хангаж байна гэж үзвэл хуралд оруулж тэнцсэн тохиолдолд тухайн этгээд мөнгө хүлээж автал нэг сар буюу түүнээс дээш хугацаа шаардлагатай болдог байна.
5. Хурдан шийдвэрлэгдэх хугацаа 2 сар зарим тохиолдолд 1 жил хүртлэх хугацаа шаардагдана.

Гэвч өнөөгийн байдлаар хорих ял эдэлж буй хоригдлуудаас 100 гаруй хүн хаягийн бүртгэлгүй (орон гэргүй), бүртгэлтэй боловч амжиргааны төвшингөөс доод (200 мянган төгрөг) төвшинд хамаарагдах 1000 гаруй хүн ял эдэлж суллагдаж байна. Дээрх орон гэргүй, нийгмийн халамж шаардлагатай суллагдсан иргэн ажил хөдөлмөр, очих газаргүйн улмаас дахин гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр байна.

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт байрлах Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын харьяа "Зөв амьдрах ухаан төв"-д орон гэргүй хүмүүсийг байрлуулж байгаа хэдий ч уг төвийн орчин нөхцөл, үйлчилгээ нь хорих байгууллагын нөхцлөөс дор гэж суллагдсан хүмүүс үзэн очихыг хүсэхгүй байна.

Хэрвээ энэ халамжийн 1,2 сая төгрөгийг шуурхай шийдвэрлэж чадсанаар:

- 450.000 төгрөгийг 3 сарын түрээсний байранд
- 200.000 төгрөгөөр хөнжил гудас, амьдралын ойр зуурын хэрэгцээ
- 200.000 төгрөгийг хувцас хунарт
- 350.000 төгрөгийг ажилтай болж цалинд хүртэлх хэрэгцээндээ зарцуулж болохоор байна. Одоогоор хүсэлт гаргаад халамжийн мөнгө хүлээж буй олон жишээ бий. Тухайлбал:

Кейс 1. Цэдэндамба Тэгшбаяр (РД: ШЖ79122201) УБ хот, СХД-ийн 3-р хороо Бага Наран 13-р гудамж 7Б тоотод оршин суух, 2020 оны 02-р сарын 27-нд хорих ял эдлээд суллагдсан шаардлагатай материалаа бүрдүүлж 2020 оны 03-р сарын 27-ны өдөр нийгмийн халамжийн байгууллагад хандсан боловч одоог хүртэл шийдвэр гараагүй байна.

Халамжийн үйлчилгээ авч чадахгүй байгаа шалтгаан нь:

- хаягийн бүртгэлгүй
- үл хөдлөх хөрөнгийн дундын эзэмшигчээр бүртгэгдсэн боловч бүртгэлээс хасагдаагүй (бүртгэлийн системийн алдаатай байдал)
- шүүхийн шийдвэрээр үл хөдлөх хөрөнгө нь хураагдсан боловч үл хөдлөх хөрөнгө нь зарагдаагүй (улсын орлого болсон) зэрэг олон асуудлууд байна.

Монгол Улсад пробацийн үйл ажиллагааны хэрэгжилтийг өнөөгийн эрх зүйн зохицуулалт, нийгэм, эдийн засгийн тогтолцоотой уялдуулан дараах байдлаар хөгжүүлж болно гэж судалгааны дүнд үзэж байна. Үүнд:

Нэг. Пробацийн үйл ажиллагааны хувьд:

Монгол Улсад хэрэгжиж буй эрүүгийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад юуны өмнө дараах этгээдийг хяналт-нийгэмшүүлэх ажилд хамруулах нь зүйтэй гэж үзлээ.

1. Хорих ял эдлээд хугацаа дуусч суллагдсан;
2. Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан;
3. Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн;

4. Хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан.
Энэ тохиолдолд улсын хэмжээгээр жилд 2000 орчим этгээд энэхүү хяналтад байхаар тооцоолж байна.

Хоёр. Пробацийн үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагын оролцооны хувьд:

1. Шүүх- хоригдлыг суллах, тэнсэх, ял хойшлуулахтай холбогдуулан хяналтад байх хугацаа, хяналтыг хэрэгжүүлэх аймаг, орон нутгийн харьяалалыг шийдвэртэй зааж өгөх;

2. Прокурор- хяналтад байх хугацаанд төрийн байгууллага, албан тушаалтны хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж буйд хяналт тавих- ;

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага- шүүхээс тогтоосон хугацаанд суллагдсан, тэнсэгдсэн ял хойшлогдсон этгээдэд хяналт- нийгэмшүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллагын дэмжлэгээр явуулах;

4. Цагдаагийн байгууллага-шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;

5. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар-орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбар нэгж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хяналтад буй этгээдийн хооронд байгуулсан гурвалсан гэрээний үндсэн дээр ажилд зуучлах;

6. Аймаг, орон нутгийн засаг захиргааны байгууллага-орон нутгийн хэмжээнд хяналтын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн хувьд дэмжлэг үзүүлэх;

7. Аймаг, орон нутгийн боловсролын байгууллага- хяналтад буй этгээдэд боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэх зорилгоор сургалт явуулах;

8. Хувийн хэвшил-аймаг, орон нутгийн засаг захиргааны байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хяналтад буй этгээдтэй гэрээ байгуулсны дүнд ажил олгох;

9. Төрийн бус байгууллага- хяналтад буй этгээдийг нийгэмшүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх, оролцох;

10. Иргэд- хяналтад буй этгээдийг нийгэмшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

Гурав. Пробацийн үйл ажиллагааны хэлбэрийн хувьд:

1. Суллагдахад бэлтгэх:

Хорих байгууллага хоригдлыг суллагдахаас 3 сарын өмнө нийгмийн амьдралд бэлтгэх чиглэлээр "Суллагдахад бэлтгэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.

Энэхүү хөтөлбөрт сөрөг зан үйлийг засах, амьдрах ухаанд сургах, нийгмийн харилцааны зөв дадал эзэмшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх болон иргэний бүртгэлд хамруулах, ар гэртэй нь холбон зуучлах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2. Суллагдсаны дараах хяналт-нийгэмшүүлэх ажил:

Хорих ял эдлээд суллагдсан, ял хойшлуулсан, тэнсэгдсэн этгээдийг шүүхээс 2 жил хүртэл хугацаанд хяналтад байлгах талаарх шийдвэрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үүнд:

а. Амьдрах орон байртай болгоход туслалцаа үзүүлэх

б. Ажлын байранд зуучлах

в. Ар гэр, найз нөхөд, хамт олны хяналтад байлгах

г. Сургалтад хамруулах

д. Тухайн хүнд тохирсон нийгэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх

е. Хугацаанаас өмнө суллагдсан, ял хойшлуулсан, тэнссэн этгээд хяналтад байх хугацаанд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн тохиолдолд ял эдлүүлэх саналыг гаргах зэрэг болно.

3. Пробацийн хяналтаас гаргах:

Хяналтад буй этгээдийн шүүхээс тогтоосон хугацаа дууссан, эсхүл тогтоосон хугацааны 50 хувиас доошгүй эдэлсний дараа нийгэмшсэн байдлаа харуулсан бол хяналтын хугацааг дуусгана.

4. Хяналтад байх хугацаанд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн тохиолдолд авах арга хэмжээ:

Хугацаанаас өмнө суллагдсан, ял хойшлуулсан, тэнссэн этгээд хяналтад байх хугацаанд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн нь тохиолдолд эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч прокурорт хяналтыг зогсоон ял эдлүүлэх саналаа гаргана, шийдвэр гүйцэтгэгчийн санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүхээс ял оногдуулна.

Дөрөв. Пробацийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг:

1. Байгууллагын бүтэц, тогтолцоо:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас суллагдсан этгээдэд хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хяналт тавих үйл ажиллагааны нэгдсэн удирдлагаар хангах ажлыг улсын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, аймаг, орон нутгийн салбар зөвлөл хэрэгжүүлэх ба тухайн зөвлөлийн санхүүжилт, улсын төсөв, бусад дэмжлэг туслалцаатайгаар хэрэгжүүлэх нь зүйтэй болов уу. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1д зааснаар тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт

хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ гэж заасан байна.

2. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч, эрх хэмжээ:

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч хяналт-нийгэмшүүлэх ажлыг хариуцсан сум, баг, хорооны хэмжээнд гүйцэтгэх ба энэхүү ажилд цагдаа, халамж, бүртгэл зэрэг төрийн байгууллагууд дэмжлэг үзүүлбэл зохино.

Суллагдсан хүнийг нийгэмшүүлэх нь зөвхөн дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэсэн үндэслэлээр дуудаж уулзах, хянах байдлаар явагдаж байна. Өөрөөр хэлбэл “ХЯНАЛТ-НИЙГЭМШҮҮЛЭХ АЖИЛ”-ын харьцаа алдагдсанаар суллагдсан этгээдийг нийгэмшүүлэх ажил үр дүнтэй явагдахгүй байна.

Түүнчлэн суллагдсан этгээдийг нийгэмшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагаа, оролцоог хуульчилсан эрх зүйн зохицуулалт хангалтгүй, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхтэй холбоотой Цагдаагийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тус тусдаа өөр өөрсдийн хууль, журам, зааврын хүрээнд гүйцэтгэгдэгээс болж байна.

Улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарууд, тэр дундаа хууль зүйн салбарт хийгдэж буй тогтолцооны болон эрх зүйн шинэчлэл, өөрчлөлтүүд нь хүний хөгжлийг, улмаар нийгмийн зөв тогтолцоог дэмжин хөгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстойг бүх нийтээр хүлээн зөвшөөрч байна.

Хоригдлыг хорих байгууллагаас суллагдсаны дараа үзүүлэх нийгэмшүүлэх ажлын тогтолцоо байхгүй, нутгийн захиргааны болон хууль сахиулах байгууллагуудын хэмжээнд эрх зүйн зохицуулалтын хувьд хүлээсэн чиг үүрэг бүрэн тодорхойлогдоогүй, хэрэгжүүлэх нэгдсэн тогтолцоогүй байгаа нь бие даасан эрх зүйн зохицуулалтын болон бүтцийн шинэлэг арга хэлбэр шаардлагатайг илэрхийлж байгаа юм.

Өөрөөр хэлбэл, ял эдлүүлэх ажиллагааны тогтолцоо, хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын өсөлт, гэмт хэргийн гаралт, нөхцөл байдалтай холбон өөрчлөх, гадаадын бусад орны ижил чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааны туршлагад суурилан, олон улсын чиг хандлага, загварт нийцүүлэн хөгжүүлэх нь зүйтэй юм.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ-ЗӨВЛӨМЖ

4.1. Дүгнэлт

Улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарууд, тэр дундаа хууль сахиулах салбарт хийгдэж буй тогтолцооны болон эрх зүйн шинэчлэл, өөрчлөлтүүд нь хүний хөгжлийг, улмаар нийгмийн зөв тогтолцоог дэмжин хөгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстойг салбарын эрдэмтэд хүлээн зөвшөөрч байна.

Пробаци (probation) гэсэн нэр томъёо нь “probation” гэсэн латин үгнээс гаралтай, туршилт, ажиглалт явуулах гэсэн утга бүхий гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шүүхийн шийдвэрийн үндсэн дээр тодорхой хөтөлбөрөөр нийгэмшүүлэх үйл ажиллагаа юм. Анх 18 дугаар зууны дунд үеэс Английн эрүүгийн хуульд анх тусгагдсан Пробацийн үйл ажиллагаа нь дэлхийн олон орны шүүхийн болон хууль сахиулах үйл ажиллагаанд хэдийнээ өргөнөөр ашиглагдах болжээ.

Дэлхийн улс орнуудын шүүх, хууль сахиулах үйл ажиллагааны практикт пробацийн үйл ажиллагааг хорих ял эдлүүлэх үйл ажиллагааны явцад гэмт хэрэгтэн бие хүн болж өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн харилцаанаас тусгаарлахгүйгээр гэмт зан үйлийг өөрчлөх, нийгмийн амьдралд дасан зохицох, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх үйл явц гэж нийтлэг байдлаар тодорхойлсон байна.

Иймээс ч олон улсад пробацийг туршилтийн хугацаа, тэнсэн харгалзах, батлан даалт гэсэн нэршлээр тодорхойлж иржээ.

Пробацийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь:

- Гэмт хэрэг үйлдсэн хүнд аль болох хорих ял оногдуулахгүйгээр тэнсэн харгалзах ялаар шийтгэн, шийтгэл эдлэх үйл явцад хяналт тавих;

- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хор уршгийг ойлгуулах, ажил хөдөлмөр эрхлүүлэн, учирсан хохирлыг бүрэн төлүүлэх;

- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорих ангиас суллагдахын өмнө болон суллагдсаны дараа нийгмийн амьдралд дасан зохицоход тусламж үзүүлэх зэрэг байна.

Пробацийн үйл ажиллагааны ач холбогдлыг тодорхойлохдоо гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорих ял оногдуулахгүйгээр хүмүүнлэг нийгмийг бүтээх, гэмт хэрэгтнийг албадан хөдөлмөрлүүлж нийгмийн хөгжилд хувь нэмрийг оруулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорихоос өөр төрлийн ял оногдуулж эдийн засгийн хувьд харьцангуй бага зардал гарган гэж үздэг байна.

Дэлхийн улс орнууд өөрийн эрх зүйн тогтолцоо, нийгмийн хөгжлийн онцлогт нийцүүлэн пробацийн албыг нэршил, чиг үүрэг, харъяаллын хувьд

өөр өөр хэлбэрээр байгуулан ажиллуулж байна. Тухайлбал, АНУ, Англи, Швед, Латви, Гүржид бие даасан алба, Норвеги, Финлянд, Дани, Япон, Чех, Эстонид Хууль зүйн яамны харьяаны алба, Герман, Унгарт Шүүх байгууллагын харьяаны алба, Голландад Прокурорын байгууллагын харьяа алба, Казакстанд Хорих байгууллагын харьяа алба, Сингапурт Спорт, нийгмийн хөгжлийн яаманд тус тус харьяалагдан үйл ажиллагаагаа явуулдаг байна.⁸⁷

Гадаад орнуудын пробацийн үйл ажиллагааг судлан үзэхэд дараах 3 хэлбэрээр зохион байгуулж байна. Үүнд:

1. Гэмт хэрэг сэжиглэгдэж эхлэх үеэс тусламж үзүүлэх хэлбэр: /гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг тодорхойлох, хууль зүйн туслалцаа үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдох хүртэл ар гэр, хамт олны батлан даалтанд авах/

2. Нийгмийн хяналтын хэлбэр: /гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорихгүйгээр нийгэмд засах, хүмүүжүүлэх, ар гэр, хамт олны хяналтанд авах, чөлөөтэй зорчин явах эрхийг хязгаарлах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах/

3. Хорих эдэлсэн этгээдийг нийгмийн хэвийн амьдрал ороход туслалцаа үзүүлэх хэлбэр: /нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагаар дамжуулан ажилд зуучлах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран түр амьдрах орон байраар хангах/ зэрэг байна.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн судалгаагаар нийт 2017 онд 2942, 2018 онд 3522, 2019 онд 3933, 2020 онд 4489 хоригдол хорих ял эдэлж байжээ. Хорих ял эдэлж байсан нийт хоригдлуудын 40-50 орчим хувь нь урьд гэмт хэрэг үйлдэн ял эдэлж байсан этгээдүүд байх ба зөвхөн 2020 онд 2 удаа ял шийтгүүлсэн 1008, 3 удаа ял шийтгүүлсэн 548 хоригдол, 4 удаа ял шийтгүүлсэн 299, 5 удаа ял шийтгүүлсэн 205 хоригдол, 6 удаагийн ял шийтгүүлсэн 144 хоригдол, 7 удаагийн ял шийтгүүлсэн 79 хоригдол, 8 удаагийн ял шийтгүүлсэн 43 хоригдол, 9 удаагийн ял шийтгүүлсэн 24 хоригдол, 10 удаагийн ял шийтгүүлсэн 11 хоригдол, 11 дээш удаа ял шийтгүүлсэн 10 хоригдол тус тус ял эдэлж байжээ.

Сүүлийн 8-н жилийн байдлаар авч үзвэл 2014 онд 1585, 2015 онд 1167, 2016 онд 997, 2017 онд 1115, 2018 онд 1186, 2019 онд 2267, 2020 онд 2512, 2021 оны 09 сард 2563 ялтан тус тус суллагдсан байна⁸⁸. Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн 2017 онд 344, 2018 онд 2028, 2019 онд 3868, 2020 онд 4406, 2021 оны 09 сард 3874 этгээд хяналтад байсан байсан бол сүүлийн 5 жилд дунджаар 6500-12000 орчим хүн шүүхээс ял шийтгүүлдэгээс урьд ял

⁸⁷ Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны харьцуулсан судлал. Уб., 2018. 188 дах тал

⁸⁸ Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын тайлан. Хоригдогчдын шилжилт хөдөлгөөн, дүн бүртгэлийн тасаг.

эдэлж байсан хүн **2000- 2500** орчим байгаа ба нийт ял шийтгүүлэгчдийн **50-60 орчим хувь** нь эрхэлсэн тодорхой ажилгүй, боловсролгүй, сургууль завсардсан хүмүүс эзэлж байна. Шүүхээс ял шийтгүүлэгчдийн **3500-4500** орчим буюу 50% нь хорих ял эдэлж байна. Улсын хэмжээнд жилд дунджаар хорих ял эдлээд **1800-2000** орчим хүн суллагддагаас **1000** орчим хүн хугацаанаас өмнө нь суллагдаж төрийн байгууллагын хяналтад орж байна.

Урьд гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж байгаад суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж буй хоригдлуудаас авсан судалгааны дүнг нэгтгэн үзвэл дараах асуудлууд байна гэж үзлээ. Үүнд:

1. Хорих ял эдлээд суллагдсаны дараа учирч буй гол хүндрэл бэрхшээл нь амьдрах орон байргүй болон ажлын байр олдохгүй байна.
2. Хорих ял эдлэх явцад хоригдлыг нийгэмд нэн хэрэгцээтэй байгаа мэргэжил эзэмшүүлэх талаарх сургалтын ажлыг явуулах шаардлагатай байна.
3. Хорих байгууллагад явуулж буй суллагдахад бэлтгэх ажиллагааны явцад нийгэмтэй холбон зуучлах, төрийн үйлчилгээг авах чадвар эзэмшүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай байна.

Эцсийн дүнд хоригдлыг ажилтай, орлоготой болгоход чиглэсэн төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааны үр дүнд дахин гэмт хэрэг буурна гэж үзлээ.

Монгол Улсад хэрэгжиж буй эрүүгийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад юуны өмнө дараах этгээдийг хяналт-нийгэмшүүлэх ажилд хамруулах нь зүйтэй гэж үзлээ.

1. Хорих ял эдлээд хугацаа дуусч суллагдсан;
2. Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан;
3. Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн;
4. Хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан.

Энэ тохиолдолд улсын хэмжээгээр жилд 2000 орчим этгээд энэхүү хяналтад байхаар тооцоолж байна.

4.2. Зөвлөмж

1. Монгол Улсад эрүүгийн ялын гүйцэтгэлийн бодлогод пробацийн тогтолцоог хөгжүүлэхтэй холбоотой бодлогын баримт бичиг нэгэнт батлагдан үйлчилж буй өнөө үед пробацийн үйл ажиллагааны чиглэлээрх энэхүү анхдагч судалгааны ажлыг үргэлжүүлэн “ПРОБАЦИЙН АЛБАНЫ МОНГОЛ ЗАГВАР” суурь судалгааг эхлүүлэх;

2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд ял эдлээд суллагдсан болон ял хойшлогдсон, тэнссэн этгээдэд үзүүлэх нийгэмшүүлэх ажлын чиглэлээрх төрийн байгууллагуудын хүлээх үүргийг тодорхой тусгах;

3. Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын хүрээнд “Суллагдахад бэлтгэх хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлэх;

4. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх хүрээнд орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагч, олон нийтийн цагдааг хяналтын үйл ажиллагаанд ашигладаг тогтолцоонд шилжих;

5. Хувийн хэвшлийн байгууллага, ажил олгогчид хорих байгууллагаас суллагдсан иргэний ажилд олгосон тохиолдолд бизнесийн үйл ажиллагаанд нь бодитой дэмжлэг үзүүлдэг эрх зүйн зохицуулалтыг бий болгон хэрэгжүүлэх;

6. Гадаадын зарим орны Пробацийн албаны сайн туршлага, тухайлбал төрийн бус байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг бий болгох зэрэг болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль, тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
2. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга. 2017.
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017.
4. Цагдаагийн албаны тухай хууль. 1999; 2017.
5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. 1997 оны хууль болон түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд 2012.01.19-ны; 2013.07.05-ны; 2015.12.04-ны; 2016.12.22-ны; 2017.02.09-ны; 2017.05.18-ны.

Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага:

1. Ж.Амарсанаа. Англи-Орос-Герман-Монгол олон улсын эрх зүйн толь. УБ. 2004 он
2. Б.Алтангэрэл. Хорих ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2018 он
3. Б.Алтангэрэл. Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ. УБ., 2019 он
4. Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны харьцуулсан судлал. УБ., 2018 он
5. М.Алтан-Очир. Хорих ял эдлүүлэх дэглэм. УБ., 2020 он
6. А.Лхагва. МУ-ын Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүй. УБ., 2012.
7. С.Жанцан. "МУ-ын Эрүүгийн эрх зүйн онол" ялын тухай сургаал. УБ., 2014.
8. С.Жанцан. Хорих ял эдлүүлэх газраас суллагдсан хүмүүсийг рецидив гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал. УБ., 1989.
9. Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2012.
10. С.Жанцан. Эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2009.
11. С.Нарангэрэл. Монгол Улсын эрүүгийн эрх зүй. УБ., 1999.
12. Г.Совд. Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2002.
13. А.Думбарай, А.Лхагва, Л.Чүлтэмсүрэн. БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын талаар гарсан хууль, эрхийн баримт бичгийн эмхэтгэл. УБ., 1991
14. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон Улсын эрх зүй. УБ., 1999
15. А.Лхагва, Д.Даваа-Очир. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. УБ., 2011
16. А.Лхагва. Монгол Улсын Эрүү, иргэний хэрэгт холбогдох шүүхийн шийдвэрийг биелүүлэх хууль тогтоомжийн хөгжилт /1931-2005/. УБ., 2005 он
17. А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ., 2012
18. С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг" нэмж засварласан 2 дахь хэвлэл, УБ. 2008
19. О.Пүрэвсүрэн. Герман улсын хорих ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2014
20. Каратис Чех ТББ. Хорих байгууллага дахь нийгмийн ажил. УБ., 2015

21. ХЭҮК, Каратис Чех. Хорих байгууллагын ажилтнуудад зориулсан Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл. УБ., 2014

Гурав. Гадаад хэл дээрх материал:

1. Обзор законодательства скандинавских и балтийских стран по службе пробации (уголовному надзору). Санкт-Петербург., 2010.

2. Probation and Probation service: A European Perspective (ed by A Van Kalmthout & J Derks). Wolf legal publishers.

3. 2000. Обзор законодательства скандинавских и балтийских стран по службе пробации (уголовному надзору). Санкт-Петербург., 2010.

4. Probation and Probation service: A European Perspective (ed by A Van Kalmthout & J Derks). Wolf legal publishers. 2000.

Дөрөв. Судалгааны тайлан, бусад материал:

1. ХЗҮХ-ийн судалгааны төвөөс 2012 онд хийсэн судалгаа, тайлан.

2. ННФ-оос зарласан бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд "Шоронгоос суллагдсан хүмүүст нийгэмд дасан зохицоход үзүүлэх бодлогын судалгаа". 2011.

3. Model Codes for post – Conflict criminal Justice volume I model criminal code United states institute of peace press Washington D.C

4. Уголовно-Исполнительный кодекс Российской федераций. 1997.

5. АССРА 20 үн Conference ac report Австралийн Сидней хот. 2000.

Тав.Цахим хаяг:

1. www.cd.gov.mn

2. www.mojha.gov.mn

3. <http://didacts.ru/termin/socializacija.html>

4. <https://cyberleninka.ru>

5. <http://duisastana.kz/department/probation/>

6. <http://egov.kz>

7. <http://fsin.su/>

ХАВСРАЛТ

/давтан гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж буй хоригдлуудаас авсан асуулгын хуудас/

Зорилго: Энэхүү судалгааны асуулгаар хорих ял эдлээд суллагдах дөхсөн болон суллагдсан этгээдэд тавиж буй хяналт, нийгэмшүүлэх ажлын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийн, тулгамдсан асуудлыг нээн илрүүлж боловсронгуй болгоход чиглэсэн санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Анхааруулга: Энэхүү асуулгыг зөвхөн урьд хорих ял эдэлж байгаад дахин гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж буй хоригдлууд бөглөнө.

Жич: Асуулгад овог, нэр бичигдэхгүй ба судалгааны үр дүнг зөвхөн эрдэм шинжилгээний ажилд ашиглагдана.

НЭГ.АНКЕТИЙН ХЭСЭГ

1. Таны нас:

а. 18-24

б. 25-34

в. 35-39

г. 40-44

д. 45-49

е. 50-аас дээш

2. Хүйс

а. Эр

б. Эм

3. Үндсэн захиргаа (нөхөж бичих)

4. Боловсрол

а. дээд (доогуур зурах) /доктор, магистр, дипломын дээд/

б. тусгай мэргэжлийн дунд /техник мэргэжлийн/

в. бүрэн дунд

г. дунд

д. бага

е. боловсролгүй

5. Мэргэжил (мэргэжилтэй бол ямар мэргэжилтэйг нөхөж бичих)

а. мэргэжилтэй

б. мэргэжилгүй

б. Та дахин гэмт хэрэг үйлдэхээс өмнө ажил, хөдөлмөр эрхэлж байсан уу?

а. тийм

б. үгүй

7. Таны амьжиргааны түвшин?

а. баян

б. дундаж

в. ядуу

г. нэн ядуу

8. Гэр бүлийн байдал

- а. гэрлэсэн, хүүхэдтэй
- б. гэрлэсэн, хүүхэдгүй
- в. гэрлээгүй, хүүхэдтэй
- г. гэрлээгүй, хүүхэдгүй
- д. салсан, хүүхэдтэй
- е. салсан, хүүхэдгүй
- ж. бэлбэсэн /эхнэр, нөхөр нас барсан/, хүүхэдтэй
- з. бэлбэсэн /эхнэр, нөхөр нас барсан/, хүүхэдгүй

9. Таны хорих ял эдэлхээс өмнө амьдарч байсан орчин нөхцөл?

- а. орон сууц
- б. хувийн орон сууц /хашаа байшин/
- в. нийтийн байр
- г. монгол гэр
- д. түрээсийн байр
- е. амьдрах байргүй

ХОЁР. ГЭМТ ХЭРГИЙН БАЙДАЛ

1. Та Эрүүгийн хуулийн ямар зүйл ангиар шийтгэгдсэн бэ? (нөхөж бичих)

.....
2. Та хэдэн удаагийн ял шийтгэлтэй вэ?

- а. 2
- б. 3
- в. 4 ба түүнээс дээш

3. Таны хорих ял эдэлсэн нийт хугацаа (урьд ял эдэлж байсан бүх хугацааг оруулан тооцоод)?

- а. 5 жил хүртэл
- б. 10 жил хүртэл
- в. 15 жил хүртэл
- г. 20 жил хүртэл
- д. 25 жил хүртэл

ГУРАВ. ҮНДСЭН АСУУЛГА

1. Хорих ял эдлээд суллагдсаны дараа гэр бүлийнхэн тань хэрхэн хүлээн авсан бэ?

- а. гэмт хэрэгтэн гэсэн байдлаар жигшиж хүлээн авсан
- б. харьцахаас зугтаж байсан
- в. энгийн байсан
- г. мэдэгдээгүй

2. Таныг өмнө хорих ял эдлээд суллагдсаны дараа бусад хүмүүс хэрхэн хүлээн авсан бэ?

- а. найз нөхөд, хамт олон байхгүй
- б. харьцахаас зугтаж байсан
- в. энгийн байсан
- г. мэдэгдээгүй

3. Хорих ял эдлээд суллагдсаны дараа төрийн байгууллагаас ямар нэгэн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байсан уу?

- а. тийм
- б. үгүй

4. Танд өмнө хорих ангиас суллагдан гарсны дараах учирсан хүндрэл бэрхшээл?

- а. ажил олдоогүй
- б. амьдрах байр олдоогүй
- в. хүлээж авах ар гэр, найз нөхөд байхгүй
- г. асуудлаа шийдвэрлүүлэх төрийн байгууллага, албан тушаалтан байхгүй байсан

д. хүндрэл байгаагүй

5. Хорих ангийн зүгээс хоригдлыг суллагдахад бэлтгэх зорилгоор ямар ажил зохиовол зүйтэй гэж боддог вэ?

- а. мэргэжил эзэмшүүлэх
- б. сургалтад хамруулах
- в. ажилд зуучлах
- г. ар гэрийнхэнтэй нь холбон зуучлах
- д. бусад.....

б.Хорих ангиас суллагдсан иргэнд төрийн зүгээс ямар ажил хийвэл зүйтэй гэж боддог вэ?

- а. хяналтаа сайжруулах
- б. ажилд зуучлах
- в. амьдрах байртай болгох
- г. халамжийн үйлчилгээнд хамруулах
- д. мэргэжил эзэмшүүлэх
- е. бусад.....

7. Таны гэр бүлийн гишүүд тогтмол түр болон удаан хугацааны уулзалтаар ирдэг үү?

- а. хуулийн хугацаанд тогтмол ирдэг
- б. хааяа ирдэг
- в. ирдэггүй

8. Хорих ангид таны найз нөхөд, хамт олон ирж байсан уу?

- а. тийм
- б. үгүй
- в. захиа ирүүлсэн
- г. илгээмж
- д. утсаар ярисан

9. Та суллагдан гарсны дараа амьдрах орон байр бий юу?

- а. байхгүй
- б. байгаа
- в. ах, дүү хамаатан садангийн очно
- г. төрийн бус байгууллагад очно

10. Таныг банк болон банк бус санхүүгийн байгууллагад мөнгөн хадгаламж бий юу?

- а. байгаа
- б. байхгүй
- в. хамтарсан хадгаламж байгаа

11. Та бусдад төлөх төлбөртэй юу?

- а. тийм
- б. үгүй

12. Таны хорих ангиас суллагдсаны дараах зорилго?

- а. ажил хайна
- б. хувиараа бизнес эрхлэнэ
- в. гадаад явна
- г. мэдэхгүй
- д. бусад.....

13. Та хорих ангид ял эдлэх хугацаандаа хорих ангид мэргэжил эзэмшсэн үү?

- а. тийм
- б. үгүй

14. Та хорих ангид эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах уу?

- а. тийм
- б. үгүй
- в. мэдэхгүй
- с. ажил олдвол ажиллана

15. Та хорих ангиас суллагдаад очих газаргүй бол хаана хандах вэ?

- а. төрийн байгууллагад хандана
- б. төрийн бус байгууллагад хандана
- в. асрамжийн газарт хандана
- г. гудамжинд амьдрана
- д. хамаатан садан, найз нөхөддөө хандана

16. Та хорих ангиас суллагдаад төрийн үйлчилгээг биечлэн болон цахим хэлбэрээр авах чадвартай юу?

- а. тийм
- б. үгүй
- в. мэдэхгүй

17. Та хорих ангиас суллагдаад харъяа дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст хөдөлмөр эрхлэхээр бүртгүүлж байсан уу?

- а. тийм
- б. бүртгүүлж хөдөлмөр эрхэлж байсан
- в. бүртгүүлсэн боловч хөдөлмөр эрхэлж чадаагүй
- г. үгүй

18. Та хорих ангиас суллагдаад нийгмийн амьдралд дасан зохицоход хүндрэлтэй асуудал юу байсан вэ?

СУДАЛГААНЫ АЖЛЫН АСУУЛГА

Зорилго: Энэхүү судалгааны асуулгаар хорих ял эдлээд суллагдах дөхсөн болон суллагдсан этгээдэд тавиж буй хяналт, нийгэмшүүлэх ажлын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлыг нээн илрүүлж боловсронгуй болгоход чиглэсэн санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Анхааруулга: Энэхүү асуулгыг хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар бөглөнө.

Жич: Асуулгад овог, нэр бичигдэхгүй ба судалгааны үр дүнг зөвхөн эрдэм шинжилгээний ажилд ашиглагдана.

НЭГ.АСУУЛГА

1. Таны хорих байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйчээр ажилласан хугацаа?

- а. 1 жил хүртэл
- б. 1-3 жил хүртэл
- в. 3-5 жил хүртэл
- г. 5-10 жил хүртэл
- д. 10-аас дээш жил

2. Та хоригдлыг суллахад бэлтгэх ажилд юун дээр анхаарвал зүйтэй гэж үздэг вэ?

- а. хэрэгцээг тодруулж сургалтад хамруулах
- б. мэргэжил эзэмшүүлэх
- в. ажлын байранд зуучлах
- г. бичиг баримтжуулах
- д. ар гэртэй нь холбон зуучлах
- е. бусад.....

3. Та хоригдлыг хорих ангиас суллагдан гараад дахин гэмт хэрэг үйлддэг шалтгааныг дүгнэнэ үү?

- а. ажил хөдөлмөр эрхлэхгүйгээс мөнгөний хэрэгцээ гардаг
- б. архи дан согтуурч цагийг дэмий өнгөрөөдөг
- в. хүлээж авах орчингүй
- г. төрийн байгууллагын хяналт муугаас
- д. бусад.....

4. Та хорих анги бүрт суллагдах дөхсөн хоригдлыг тусад нь байлгах байрыг байгуулах нь зүйтэй гэж үздэг үү?

- а. тийм
- б. шаардлаггүй

5. Та хорих ангиас суллагдсан хоригдолд зориулсан нийгэмшүүлэх ажлыг явуулах хэрэгтэй гэж үздэг үү?

- а. тийм
- б. шаардлагагүй

в. төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааны хүрээнд байж болно

г. зөвхөн хяналт тавих хэрэгтэй

б. Та ямар хэлбэрээр суллагдсан хоригдлыг дийлэнхидээ дахин гэмт хэрэг үйлддэг гэж үздэг вэ?

а. хугацаа дуусч суллагдсан

б. хугацааны өмнө тэнсэн суллагдсан

в. бусад.....

ХОЁР. САНАЛ

1. Та хоригдлыг суллахад бэлтгэх ажиллагааны үр нөлөөг сайжруулах чиглэлээр ямар ажил хийвэл зүйтэй гэж үздэг вэ?

2. Та суллагдсан хоригдолд хяналт тавих, нийгэмшүүлэх чиглэлээр ямар ажил хийвэл зүйтэй гэж үздэг вэ?

3. Та хорих ангид явуулж буй нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг сайжруулах чиглэлээр ямар ажил хийвэл зүйтэй гэж үздэг вэ?